

# ЖЭЙМС ЖОЙС

## ДУБЛИНЧУУД



**Жэймс Жойс**

**Дүблинчүүд**

## Дублинд өнгөрүүлсэн өдрүүд

Ирландын нэрт зохиолч Жэймс Жойсийн алдарт “Үлисс” роман өнгөрсөн хавар Монголын уншигчдын хүртээл болж багагүй шуугиан дэгдээсэн билээ. Энэхүү бүтээлийг уншиж танилцах гэсэн уран зохиолын ном “идэгчид” олон байвч тэр бүр ойлгож, тунгааж, бүрэн хэмжээнд утгыг нь тайлж уншсан хүн өнөөг хүртэл тун цөөн байгаа болов уу.

Уран зохиолын өвөрмөц хэлбэр бүхий энэ бүтээлийг монголчуудын хүртээл болох учиртай гэдгийг миний бие тэртээ 2001 онд ухаарч хөрвүүлэхээр санаа шулуудаад байсан хэдий ч хоёр жилийн дараа их зохиолчийн төрсөн нутаг болох Дублин хотноо айлчлах ховорхон завшаан тохиосны ачаар “Үлисс” роман монгол хэл дээр хэвлэгдэх алтан боломж бүрдсэн юм.

Харин “Үлисс”-ийг уншиж танилцахаас өмнө оюун сэтгэл- гээний чамгүй “бэлтгэл” базааж, наад зах нь Ж.Жойсийн “Дублинчүүд” өгүүллэгийн түүврийг уншсан байх ёстой гэсэн бичигдээгүй хууль бий. Учир нь богино хэмжээний арван таван өгүүллэгээс бүрдсэн энэхүү түүвэрт тухайн үеийн Ирландын нийгмийн бугшмал амьдралыг олон талаас нь харуулснаас гадна тэдгээр өгүүллэгийн ихэнх баатрууд “Үлисс” романд үргэлжлүүлэн амьдардгаараа онцлог билээ. Нөгөө талаас энэ хоёр алдарт бүтээл нь өөр хоорондоо салшгүй холбоотой учир Жэймс Жойсийн “ертөнцийг” танин мэдэхийн эхлэл нь “Дублинчүүд” зохиол юм. “Дублинчүүд” түүвэрт орсон өгүүллэгүүд нь 1904-1907 оны хооронд бичигдсэн бөгөөд реалистчиглэлийн бүтээл болохыг эрхэм уншигч та төвөггүйхэн ойлгох биз ээ...

Жэймс Аугустин Алозиус Жойс 1882 оны 02-р сарын 02-нд Дублин хотноо мэндэлжээ. Түүний хүүхэд ахуй, идэр нас Ирландын түүхийн хүнд хэцүү үетэй давхацсан байна. Тухайн үеийн Ирландын сэхээтнүүдийн шүтээн нь Чарльз Стюарт Парнелл байсан юм. Тэрбээр Ирландын тусгаар тогтнолын төлөө уйгагүй эр зориг гарган тэмцэж байсан нэгэн билээ. Английн эрх баригчид тухайн үед өөрсдийгөө Ирландын бүрэн эрхт эзэд хэмээн мэдэрч байсан бөгөөд Парнеллыг жинхэнэ дайснаа хэмээн үзэж байв.

Түүний хувь заяа Ирландын бусад хувьсгалчдын нэгэн адил байснаас гадна Китти О’Ши гэгч нөхөртэй хүүхэнтэй хайр сэтгэлийн холбоо тогтоосон явдлыг албан ёсны шашны байгууллага Английн эрх баригчидтай сүлбэлдэн түүний эсрэг тун чадварлагшигласан ажээ. Ирландын католикшашинтнууд хийсэн нүглийнх нь төлөө Парнеллыг буруушааж, хамтран зүтгэгчид болоод ард түмэн нь утга учиргүй суртал ухуулгад автан түүнээс нүүр буруулжээ.

Ирландын либерал сэхээтнүүдийн хүрээлэлд хамаарч байсан Жойсын гэр бүлийнхэн Парнеллын үхлийг үндэсний эмгэнэл мэтээр хүлээн авч байлаа. Жойсын эцэг Жон Жойс их удирдагчийн үхлийн дараа сэхэл авсангүй. Тэрбээр Ирландын түүхийг огт хэрэггүй золиос, урван тэрслэлтийн үл тасрах гинжин холбоо мэтээр харж байхыг өөрийн хүүд зааж сургажээ. Жойс эхийнхээ уйгагүй шахалт шаардлагын дүнд иезуитын коллежид элсэн орж өндөр боловсрол эзэмшсэн байна.

Гүн ухаан, түүх, хэл, утга зохиолын салбарт шавхагдашгүй их авьяастай нэгэн байсны хүчинд Ж.Жойс тэр даруй багш нарын анхаарлыг өөртөө татаж чадсан аж. Коллеж төгссөний дараа түүнд шашны цол хэргэм санал болгосон авч Ж.Жойсын сэтгэлд үлдээсэн эцгийнх нь сургамж түүнд хүчтэй нөлөөлөл үзүүлсэн улмаас тэрхүү саналыг хүлээж авахаас татгалзжээ.

Ирландын католик шашинтнууд Парнеллын аминд хүрч, залуу Ж.Жойсын шүтээн болсон Ибсены зохиол бүтээлийг ч мөн хэвлэхийг хоригложээ. Тиймээс тэр шашинтай нэг мөр холбоо таслахад хүрэв. 1904 онд тэр өөрийн эхнэр Нора Барнаклын хамт сүмд албан ёсоор гэрлэлтээ батлуулах явдлаас татгалзаж, Ирланд орныг орхиход хүрчээ.

Ж.Жойс Ирландын чөдөртэй амьдралаас холхон байж өөрийн хүсэл зорилгыг биелүүлэн, гүн нойронд автсан ард түмнээ нойрноос нь сэрээж, эх орныхоо үнэн дүр төрхийг хэлж, бичихээс өөр арга алга гэдгийг анд нөхөддөө зарлан тунхаглажээ.

1912 онд Ж.Жойс Ирланд руу буцаж ирэх гэсэн авч түүний оролдлого бүтэлгүйтэв. Тухайн үед “Дублинчүүд”-ийг хэвлэх гэж байсан хэвлэлийн газрын эзэн гар бичмэлийг үзээд эцсийн мөчид залуу зохиолчийн номыг хэвлэхээс татгалзаад зогсолгүй хэвлэлийн өрдсийг хүртэл галдан шатаасан байна. Ж.Жойс хараал зүхэл болон эх орноо орхиход хүрэв.

Он жилүүд улиран одож Парис, Поло, Ром, Триест, эргээд Парис, Цюрих зэрэг хотуудад түүний амьдрал өнгөрнө. Ж.Жойс ядруухан байдалтай аж төрж, сонинд нийтлэл бичиж, банкинд бичиг хэргийн ажил эрхэлж, англи хэл заахын хажуугаар, зохиол бүтээлээ уйгагүй туурвисаар байлаа.

“Дублинчүүд” өгүүллэгийн түүвэр, “Зураачийн залуу насны хөрөг”, “Үлисс”, “Финнеганыг эргэн дурсахуй” зэрэг роман бичсэн он жилүүдэд тэр ойлгохгүй зүйлээ хэвлэхгүй хэмээсэн хэвлэлийн газрын эзэд, мөн утга зохиолын тогтоосон хэм хэмжүүрийн өнцгөөс Ж.Жойсийн зохиол бүтээлийг үнэлж, цэгнэх чадваргүй шүүмжлэгч нартай ширүүхэн тэмцэл өрнүүлэв.

Тэрбээр хорин таван жилийн турш, эх нутгаасаа хол амьдарч байхдаа “Үлисс”-ийг туурвижээ.

1930-1940 оны үед Жэймс Жойсын нэрийг (1882-1941 он) зохиолчийн нэгч мөрийг уншаагүй, түүний номыг гартаа барьж үзээгүй ч маш олон хүн мэддэг болсон байлаа. XX зууны хамгийн анхаарал татсан романы нэг болох “Үлисс”-т (1922 он) “оюун санааны урсгал” бүхий арга барилын тусламжтайгаар хүмүүний дотоод, нууцлаг бэлгийн амьдралыг Ирландын түүхийн дэвсгэр дээр тун чадварлаг, илэн далангуй байдлаар дүрсэлсэн явдал нь нэгэн цагт садар самуун зохиол мэт зарлагдаж, хориотой байсан үе бий.

Ж.Жойсын эх нутаг болсон католик шашинт Ирланд улсад сүм хийд хүчээ авч байсан агаад хэвлэлийн хяналт дээд цэгтээ хүрч, уг бүтээлийг шатаах шийдвэрийг хүртэл гаргаж байв. Англи, Америкт ч гэсэн “Үлисс”-ийн гэх хэргээр дуулиан тарьсан шүүх ажиллагаанууд явагдаж байсан аж. Тэр цагаас хойш бүхэл бүтэн нэгэн зууны шинэ хуудас эргэж, өдгөө Ж.Жойсыг Ирландын аугаа их зохиолч гэхээс гадна XX зууны дэлхийн сонгодог уран зохиолын нэрт төлөөлөгч гэдгээр олон түмэн мэддэг болж, өдгөө асар их хүндлэлийг хүлээж байна.

“Ингэхэд Ж.Жойсын шавь нар гэж байна уу? гэх асуултыг тавихад хүрвэл орчин үеийн Барууны ертөнцийн үргэлжилсэн үгийн томоохон зохиолчид болох Фолкнер, Хэмингуэй, Грин, Борхес, Набоков, Апдайк зэрэг олон ланжгар зохиолчдын нэрсийг ямар ч хэтрүүлэггүйгээр энд дурдаж болно.

Тэр ч бүү хэл, утга зохиолын ертөнцөд түүнээс адис хүртэж байсан залуу зохиолч Эрнест Хэмингуэй, Скотт Фицжеральд нар л гэхэд 25 жилийн дараа өөрсдөө сонгодог зохиолчид болж байсан түүхтэй. “Үлисс” роман Эйфелийн цамхаг, Парисын Дарь-Эхийн сүмээс дутуугүй олныг шуугиулсан алдар хүндийг түүнд авчирчээ.

Түүнчлэн тэс өөр ертөнц, дэндүү өөр утга зохиолын нэрт төлөөлөгч болох Оросын зохиолч Всеволод Вишневскийг Жойстой уулзахыг хүсэхэд тэр дуртай дургүй хүлээн зөвшөөрсөн гэдэг. Ж.Жойсын хувьд сонссоноос цаашгүй харь орны зохиолчтой юун тухай ярих нь тодорхойгүй байсан бөгөөд өөрийнх нь бичсэн ном зохиолыг ч бас мэдэхгүй гэдэгт тэр итгэл дүүрэн байлаа. Гэвч Всеволод Вишневский: Бусад улс оронд хэвлэгдэхээс өмнө таны зохиолыг манайд 1925 оноос орчуулж эхэлсэн” гэж хэлэхэд Жойс мэл гайхаж, цэл хөхөрсөн гэдэг.

Үнэхээр Жойсын зохиол 1925 онд “Барууны ертөнцийн шинэ дээжис” хэмээх уран зохиолын цоморлигт анх удаа Орост хэвлэгдэж байжээ.

Энэ бол “Үлисс”-ийн төгсгөлийн арваннаймдугаар хэсэг болох Пенелопа байв. 1930-аад оны дундуур И.Кашкины удирдлага дор Орчуулгын нэгдүгээр нэгдлийнхэн Ж.Жойсын “Дублинчүүд” өгүүллэгийн түүврийг хөрвүүлэх ажлаа эхэлж, 1937 онд олны хүртээл болгож байсан билээ. Энэхүү орчуулгын нэгдэл 1930-аад оны дундуур “Үлисс”-ийн арван хэсгийг орчуулсан байна. Ж.Жойсын шүлгүүд ч мөн хэвлэгдэж байлаа.

Гэсэн хэдий ч төдөлгүй Ж.Жойсын зохиол бүтээлийг хэвлэх явдлыг тас хориглов. Өөрөөр хэлбэл И.Кашкины багийнхны бэлтгэсэн “Дублинчүүд” өгүүллэгийн түүвэр 1937 онд орчуулагчдын нэр усгүй хэвлэгдэж байв. Тэр ч бүү хэл өмнөтгөлийг бичсэн хүн нууц нэрийн дор бичихэд хүрчээ. Тэдгээр орчуулагчдын нэрс 45 жилийн дараа буюу 1982 онд “Гадаадын уран зохиол” сэтгүүлд “Дублинчүүд”-ыг нийтлэх үед дөнгөж сая олонд ил болсон байна.

1904 оны 8 дугаар сарын 13-нд Ирландын яруу найрагч, жүжгийн зохиолч Жорж Расселлын хүсэлтээр Ж.Жойс “Эгч дүүс” хэмээх анхны өгүүллэгээ “The Irish Homestead”-д зориулж захиалгаар бичсэн байна. Чингээд Ж.Жойс өгүүллэгийнхээ дор Стивен Дедал хэмээх нууц нэр тавьжээ. Түүний дараахан “Эвэлин”, “Уралдааны дараа” зэрэг өгүүллэгүүд бичигдсэн аж. Жэймс Жойс хэдэн жил ийн турш “Дүбл инчүүд” хэмээн нэрлэсэн өгүүллэгийн түүврээ хэвлүүлэхийг оролдсон байдаг. Энэхүү ном хорвоод мэндлэхийн тулд нэлээд хэдэн жилийн нүүрийг үзэж, Ж.Жойс олон арван хэвлэн нийтлэгчдэд хандсан боловч татгалзсан хариу авсаар байжээ.

1905 оны сүүлээр арван өгүүллэг бичсэн хойно Ж.Жойс “Дублинчүүд” өгүүллэгийн түүврээ Английн хэвлэн нийтлэгч Гранд Ричардст хэвлүүлэхээр найдаж илгээсэн байна. Хэвлэн нийтлэх асуудал үргэлжилж байх хооронд Ж.Жойс бас дахин дөрвөн өгүүллэг нэмж бичээд “Эгч дүүс” өгүүллэгээ ч шинэчлэн засварлажээ. 1906 оны дөрөвдүгээр сард өгүүллэгийн түүврийг хэвлэхийн тулд зарим нэгэн өөрчлөлт оруулмаар байна гэж Г.Ричардс зохиолчид хандаж мэдэгдсэн ажээ. Ж.Жойс ямар нэгэн засвар хийхээс татгалзсан тул тэдний гэрээ талаар болсон гэдэг.

1906 онд “Дублинчүүд”-ийн талаар Гранд Ричардст хандан бичсэн Ж.Жойсийн нэгэн

захидалд: “Би эх орныхоо ёс суртахуун бүхий түүхийн бүлгийг бичих зорилготой байсан тул энэ бүхний болж өнгөрөх газраар Дублиныг сонгосон. Учир нь энэ хот надад саа өвчний гол цөм нь мэт санагдаж байна...” гэж онцлон дурдсан байдаг.

1907 онд Ж.Жойс “Үхэгсэд” өгүүллэгээ бичиж дуусмагц “Дублинчүүд” өгүүллэгийн түүврээ Элкин Мэтью хэмээх хэвлэн нийтлэгчид илгээсэн байна. Гэвч түүнийг бас л хэвлэхээс татгалзжээ. Дараа нь Ж.Жойс уг түүврээ Дублины “Maunsel and Co” хэвлэлийн газарт илгээж, 1909 онд гэрээ байгуулжээ. Гэвч дараа жил нь тус компанийн үүсгэн байгуулагчдын нэг Жорж Робертс зарим нэгэн өгүүллэгийн хэсгийг бага зэрэг зөөлрүүлж засварлахыг түүнээс хүсчээ. Энэ удаа Ж.Жойс Ж.Робертсын саналыг хүлээн зөвшөөрч, зарим нэгэн засварыг хийхээр тохиролцсон байна.

Энэ түүврийг хэвлүүлэхийн тулд Ж.Жойс хэсэг хугацаагаар Ирландад очжээ. 1912 онд номыг хэвлэлтэд шилжсэн хойно удахгүй гарах гэж буй уг номын талаар бөөн шуугиан дэгдсэн гэдэг. Ж.Робертсын хэвлэгч Жон Фальконер гэгч олон түмний таагүй уур амьсгалаас имээж, Ж.Жойст хадгалагдаж байсан ганц хувь номноос бусад мянга орчим номыг галдан шатаажээ.

1913 оны арваннэгдүгээр сард уг номыг хэвлэхээс татгалзаж байсан Г.Ричардс “Дублинчүүд” өгүүллэгийн түүврийг ямар нэгэн засваргүйгээр хэвлэх болсноо Ж.Жойст мэдэгдсэн байна. Ийнхүү явсаар байж 1914 онд тус өгүүллэгийн түүвэр анх удаа олны хүртээл болон хэвлэгдсэн ажээ.

“Дублинчүүд”-ийн хорвоод мэндэлсэн түүх “Үлисс”-ийг бодвол арай “хүндрэл” багатай байсан ч тухайн цаг үеийн нийгмийн харанхуй, бүдүүлэг дорой байдлыг шүүмжилсэн нэрт зохиолчийн бүтээл XX зуунд дэлхийн бусад оронд хэвлэгдэх гэж чамгүй хүндрэл бэрхшээлтэй замыг туулсан байдаг.

Миний бие Ирландад зорчиж явах үедээ тэнд ажиллаж, амьдарч байсан яруу найрагч, доктор Ж.Батбаатар андтайгаа учирч, түүний буянаар Ж.Жойсийн үүх түүх, гэр музей, Дублин хотын амьдралыг цөөн хэдэн хоногт чадах чинээгээрээ үзэж харж, сэтгэл зүрхээрээ мэдэрсэн явдал маань өдгөө та бүхний өмнө энэхүү түүвэр эх хэлнээ орчуулагдан очихын нэгэн үндэс болсон юм. Тиймээс эл номыг эрхэм нөхөр Ж.Батбаатараар хянан тохиолдуулах нь зүйтэй гэж шийдээд номынхоо эхийг шүүн тунгаах ажлыг түүнд даатгасан билээ.

“Дублинчүүд” өгүүллэгийн түүвэр нь Ж.Жойсийн хувьд хамгийн анхны төгс боловсорсон бүтээл юм. Энэхүү түүврийн ач холбогдол нь Европын утга зохиол, тэр тусмаа өгүүллэгийн хөгжилд шинэ уур амьсгал, шинэ үе шатыг авчирч чадсанд л оршином.

О.Чинбаяр 2010 оны 03 дугаар сарын 23

## Эгч дүүс

Эдүгээ ямар ч найдвар үлдсэнгүй. Энэ бол гурав дахь цохилт байлаа. Орой бүхэн би нэгэн байрны дэргэдүүр өнгөрч (амралтын үе) гэрэл тусах дөрвөлжин цонхыг сониучирхан харнам үдэш бүр тэр цонхны цаана урьдын адил нэгэн жигд бүүдгэр гэрэл тусна. Хэрэв тэр нас нөгцсөн бол бараан өнгийн хөшгөн дээр лааны гэрэл тусах нь надад харагдах ёстой гэж би бодож байв. Яагаад гэвэл бүрлээчийн тэргүүн тушаа хос лаа асаах учиртай байдгийг би сайн мэднэ.

“Хорвоогийн тоосыг хөдөлгөх боломж надад тун бага үлдсэн” гэж тэр надад үргэлж ярьдагсан. Гэвч түүний хэлсэн үгс хоосон мэт санагддаг. Харин одоо энэ бүхэн үнэн гэдгийг би ойлгов. Үдэш бүр тэрхүү цонх руу харах бүрийдээ “саа өвчин” гэж дотроо аяархан бувтнадаг байв. Тэрээр миний чихэнд Эвклидийн хувьд “Гномон”<sup>1</sup> мөн товч сургаалд гарах “Симоня”<sup>2</sup> гэх үгс тун гайхалтай сонсогддог байв. Харин одоо тэр миний хувьд ямар нэгэн хорон муу, завхай амьтны нэр лугаа адил сонсдоно. Надад тэр аймшиг төрүүлж, энэ үед нь би түүний аюултай ажлыг ойроос харахын тулд түүн рүү ойртохыг эрмэлзэнэ.

Намайг оройн хоол идэж байхад Коттер өвгөн гал ын дэргэд суун тамхиа шившиж байлаа.

Авга эгч минь аяганд агшаамал хийх үед, тэрбээр гэнэтхэн

1 Одон орны хэрэгслийн эртний төрөл - өдрийн шугамыг тодорхойлсон босоо багана

2 Гэгээн хэргэмийн шашны албан тушаалыг худалдах ба худалдан авах, мөнгөөр нүгэл наминчлах зэргийг Дундад зууны үед Ромын пап нар өргөн дэлгэр хэрэглэдэг байв

тасалдсан яриа руугаа эргэн орж буй мэт:

- Үгүй дээ, түүнийг би тийм байсан гэжхэлэхгүй... Гэхдээ л тэрний юу ч юм болоогүй... Тун гайхалтай... Би чамд санаагаа хэлье...

Тэрбээр бодолд автан гаансаа гүн соров. Уйтгартай хөгшин төгцөг! Түүнтэй танилцах үед тэр арай илүү сонирхолтой хүн шиг санагдаж байсан бөгөөд архи нэрэх олон аргын тухай бидэнд ярьсан ч эцэс төсгөлгүй ярианаас нь би залхаж орхисон юм.

- Чи ойлгож байна уу? Надад өөрийн гэсэн онол бий. Миний бодлоор энэ бол тэдгээр онцгой тохиолдлуудын нэг... Гэвч яг сайн хэлж мэдэхгүй байна. Тэрбээр өөрийнхөө онолыг бидэнтэй хуваалцалгүйгээр гаансаа аван дахин баагиулж гарлаа. Энэ үеэр авга ах гайхширсан нүдийг минь олж харав.

- Тун гунигтай мэдээ. Чиний эртний анд чинь нас барчихжээ гэж тэрбээр хэлэв.

- Хэн гэнэ ээ? гэж би асуув.

- Эцэг Флинн.

- Тэр нас барчихсан гэж үү?

-Тиймээ. Ноён Коттер дөнгөж сая энэ тухай дуулгалаа. Тэр манай хажуугаар явж таарсан юм. Намайг хэн нэгэн ажиглаад байгааг би анзаарсан тул, энэхүү мэдээ ер сонирхол татаагүй мэт дүр эсгэн үргэлжлүүлэн идсээр суув.

- Манай хүү тэр хоёр дотно найзууд байсан юм. Өвгөн түүнд их ч зүйл зааж сургасан даа; тэр түүнд маш дотно ханддаг байсан! гэж авга ах минь Коттерт тайлбарлав.

- Бурхан түүнийг ивээг! хэмээн авга эгч сүсэглэн өгүүлэв. Өвгөн Коттер хэсэг зуур намайг сонжив. Хар сондор лугаа адил түүний харц тун хичээнгүйлэн надад шингэж байхыг би мэдэрсэн ч сониучхан занг нь дэврээхгүйн тулд тавагнаасаа огтхон ч нүд салгахгүй байхаар шийдэв. Тэрбээр гаансаараа дахин оролдож, эцэст нь тун шийдэмгийгээр задгай зуух руу нулимж орхив.

-Үр хүүхдүүд минь тийм хүнтэй хамт байхыг би лав зөвшөөрөхгүй байсан гэж тэрбээр хэлэв.

- Ноён Коттер, та үүгээрээ юу гэх гэсэн юм бэ? хэмээн авга эгч асуулаа.

- Энэ бол хүүхдүүдийн хувьд тун хортой зүйл гэж би хэл мээр байна хэмээн Коттер тайлбарлав. Жаалхүү бол үеийнхээ хөвгүүдтэй гүйж харайж тоглох учиртай болохоос биш... Жэк, би зөв ярьж байна уу?

- Би ч бас тэгэж бодож байна хэмээн авга ах хэлэв. - Энэ нөхөрт ч гэсэн би үргэлж л хөдөлгөөнт дасгал хий, сайн хөдөлж бай! гэж үглэх юм. Би түүн шиг нусаа гоожуулсан амыан байхдаа өвөл зуны алинд ч өглөө эртлэн босоод хамгийн түрүүн хүйтэн усаар... Одоо харахгүй юу? Түүнийхээ хүчинд байж л байна. Боловсрол гэдэг тун чухал, ач тустай боловч... Ноён Коттерыг бага зэрэг шарсан хонины махаар дайлвал ямар вэ? гэж авга эгчид хандан тэр өгүүлэв.

- Үгүй ээ, үгүй. Хэрэггүй. Санаа зоволтгүй гэж Коттер хариулав. Авга эгч агуулахаас тавагтай хоол авчирч ширээн дээр тавив.

- Ноён Коттер, энэ бүхэн хүүхдэд муугаар нөлөөлнө гэдгийг та яаж мэдэв ээ? хэмээн тэрээр асуулаа.

- Хүүхдэд тун муу. Яагаад гэвэл хүүхдийн оюун санаа дэндүү эмзэг байдаг юм гэж Коттер хариулав. Ямар нэгэн болохгүй зүйл харсан хүүхдэд тэр бүхэн нөлөөлөхгүй гэж та бодож байна уу?

Өөрийнхөө уур уцаарыг ил гаргахгүйн тулд би амаараа дүүрэн овъёос чихэв. Уйтгартай, хөгшин, улаан хамартай новш! Тэр шөнө би нэлээд орой унтлаа. Намайг жаахан хүүхэд хэмээн нэрлэснийх нь төлөө би Коттерт уурлаж байсан ч түүний хэлсэн тасалдангуй үгсийн утга учрыг ойлгохыг хичээн толгойгоо гашилгав. Өрөөн доторх харанхуйгаас саа өвчтөний хөдөлгөөнгүй, цонхигор царайг би дахин олж харах шиг санагдана. Хөнжлөө толгой дээгүүрээ нөмөрч Зул сарын баярын тухай бодохыг хичээв. Гэвч цонхийсон царайт араас минь дагасаар байлаа. Тэр ямар нэгэн зүйл шивнэж, юунд ч юм гэмшиснээ илэрхийлэхийг хүсч буйг би ойлгов. Би өөрийгөө ямар нэгэн нүгэлт хийгээд амтат ертөнцөд умбаж байгаагаа



мэдрэхэд, намайг манаж байсан өнөөх царай тэнд бас л байж байв. Тэрбээр надад хандан нүглээ наминчлан, намуухан шивнэж эхэлмэгц, түүнийг яагаад зогсоо зайгүй инээмсэглэж, уруул нь чухам юунаас болж тийм чийглэг байгааг би ер ойлгож чадсангүй.

Дараа нь тэр саа өвчтөнийг нас барсныг эргэн санаад, түүний үйлдсэн аймшигтай нүглийг өршөөж, хариу инээмсэглэж байна даа гэж бодов. Маргааш нь өглөөний цайны дараа би Их-Британийн гудамжин дахь жижигхэн байшинг үзэхээр явав. Тэр нь “Жижиг бараа” хэмээх гандмал хаяг бүхий бүрсгэр лангуутай дэлгүүр ажээ. Гол төлөв тэнд янз бүрийн шүхэр, хүүхдийн гутал зарна. Жирийн үед цонхон дээр нь “Шүхэр засвар” гэсэн пайз өлгөөстэй байх авай. Өнөөдөр тэр хаяг байсангүй цонхны самбар хаалттай байлаа. Маруухан хувцасласан хоёр эмэгтэй, шуудан зөөгчийн хамт хаалганы хэвэнд тогтоосон пайзан дээрхийг уншицгаана. Би ч мөн дөхөж очоод:

1895 оны долоодугаар сарын 1.

Дээрхийн Гэгээн Жэймс Флинн

(Митийн гудамжин дахь Екатеринагийн сүмийн ламтан асан) 65 настай

R.I.P.1хэмээн пайзийг уншаад, нас барсныг нь мэдсэн агаад, болсон явдлыг сая л ухаарч, балмагдалд оров. Хэрэв тэр нас бараагүйсэн бол, лангууны ар дахь бяцхан өрөөнд нь орж, задгай зуухныхаа дэргэд зөөлөн сандал дээр хүрмээ нөмөрчихсөн сууж буйг нь харах байлаа. Авга эгч минь “Шилмэл” хамрын тамхи надаар дамжуулан илгээж, тэрхүү бэлэг унтаа байдлаас нь гаргах байсан даа. Түүний салга гар тамхиныхаа талыг ч асгалгүй хийж үл чадах тул хамрын тамхийг би саванд нь хийж өгнө. Салгалсан том гараа хамартаа ойртуулах үед тамхины үүрмэг гарынх нь салаагаар асгарч хувцсан дээр нь бужигнан унадаг байлаа.

Мөнхөд тамхи асгаснаас болж эртний ламын өмсгөл нь гандмал ногоон өнгөтэй болж, хувцсан дээр нь тогтсон тамхийг арчдаг байсан улаан өнгийн нусны алчуур тэр бүхнийг арилгаж үл дийлнэм.

Би дотогш орж түүн рүү харахыг хүсч байсан ч хаалга тогшихоос зайлсхийв. Гудамжны нарлаг талаар би тайвуухан явахдаа дэлгүүрийн шилэн хоргон дээрх бүхий л театрын зарыг гарчиглаж явав. Миний нэгэн адил тэр өдөр ч мөн эмгэнэн гашуудаагүй байсан нь надад сонин содон санагдаж байлаа. Гэнэтхэн би өөрийгөө эрх чөлөөтэй гэдгийг ойлгуут тун эвгүй байдлыг мэдэрч билээ. Түүний үхэл намайг ямар нэгэн зүйлээс чөлөөлсөн мэт санагдана. Урьд орой нь авга ахын хэлсэнчлэн, надад тэр их зүйлийг зааж сургасан гэдэг нь туйлын үнэн байсан болохоор энэ бүхэн намайг гайхшралд оршуулав. Ром дахь Ирландын коллежийг төгсөгч тэрбээр намайг латин хэлээр зөв уншиж сургасан юм. Хоргодох байр, Наполеон Бонапартын тухай ярьж, шашны янз бүрийн зан үйлийн ач тус хийгээд ламтан хүний элдэв янзын өмсгөлийн тухай тайлбарлаж өгдөг байв. Хүндхэн асуулт тавих нь түүнд таашаал өгдөг байснаас гадна аливаа тохиолдолд хэрхэн хандах, эсвэл учрыг нь яаж олох, аль нэгэн нүглийг байж болох хийгээд болохгүй талаар юу гэж бодож явдаг тухай үргэлж асуудагсан. Түүний тавьсан асуултууд сүмийн дүрэм журам ямар хүнд агаад нууцлаг болохыг мэдрүүлж байсан юм. Угтаа би тэднийг энгийн нэгэн зан үйл хэмээн тооцдог байв. Талархал хийгээд номлолын нууцад хандах лам хүний ажил үүрэг тун чухал мэт санагдаж байсан тул

тэдгээрийг өөр дээрээ хүлээн авах эр зориг хэн нэгэнд байгаа гэдэгт би тун их гайхдаг байлаа.

Сүмийн Гэгээн эцэг нар яг л сонинд нийтэлдэг шүүх ажиллагааны талаар зарлал мэт жижигхэн үсгээр хэвлэгдсэн, шуудангийн лавлах шиг зузаан номыг бичсэн тухай ярихад би ердөө ч гайхаж байсангүй. Ихэвчлэн түүнд би ямар ч хариулт өгч чаддаггүйгээс гадна хааяа нэг тээнэгэлзэж байж өгдөг тэнэг хариултыг минь сонсон, тэрээр толгой дохин инээмсэглэдэг байлаа. Заримдаа тэр цээжлэхийг шаардаж байсан шашны цуглааны үеийн хариултуудын талаархи миний мэдлэгийг Шашны цуглааны үеэр мөргөл үйлдэж буй хүмүүс ламтанд хандан хариулж буй үг, өгүүлбэр шалгадаг байв.

Намайг гацсан тохиолдолд дахин толгой дохин бодлогошронгуй инээмсэглэж, хамрын тамхинаасаа чимхэж аваад ээлжлэн сорно. Ламтанг инээх үед том шар шүд нь гялалзаж, хэл нь доод уруулаа налах тэрхүү зуршлыг нь хараад, түүнтэй ойр дотно болохоос өмнө ихээхэн эвгүйцдэг байлаа. Нар ээсэн замаар алхаж би Коттерын хэлсэн үгийг эргэн санаж, дараа нь зүүдэнд юу болсныг санах гэж оролдоно. Хамба хилэн хөшиг эртний хэлбэр бүхий өлгөдөг дэнлүүг эргэн санах. Би ямар нэгэн үл мэдэх ёс жаяг бүхий улс оронд оччихсон байлаа.

- Эртний Пэрст ч байж мэднэ. Гэвч зүүднийхээ төгсгөлийг би санах гээд чадсангүй. Орой нь авга эгч минь намайг дагуулан бүрлээчийн гэр рүү хамтдаа явцгаав. Наран хэдийнэ жаргаж, баруун тийш харсан байшингуудын цонхны шилэнд час улаан, алтадмал хэлхээ үүлс тусаж байлаа. Нэнни биднийг үүднийхээ өрөөнд угтаж авав.

Тэрээр хашгирах учиртай ч, энэ нь цагаа олоогүй явдал байсан тул авга эгч минь түүний гараас барин дуугүйхэн мэндчилнэ. Эмгэн тун гайхширсан байдалтай гараараа дээш заах үед авга эгч хариуд нь толгой дохиж, дээш хөтлөх нарийнхан шатаар биднийг дагуулсаар тэргүүнээ гудайлган өгсөв. Дээд давхрын талбай дээр гармагц тэр бүрлээчийн өрөө рүү орохыг зөвшөөрч дохив. Авга эгчийг орох үед миний зог тусахыг ажигласан, эмгэн над руу дахин даллав. Би өлмий дээрээ явж орлоо. Угалзан хөвөөтэй хөшигний завсраар жаргаж буй нарны гэрэл өрөөнд тусах агаад тэнд байсан лаанууд галын нарийнхан, бүүдгэр дөл лугаа адил тусна.

Тэрбээр авсанд хэвтэнэ. Нэннийгийн зөвлөсөн дагуу бид гурав бүрлээчийн өлмий дор өвдөглөн сууцгаав. Би залбирч байгаа дүр эсгэсэн ч сэтгэл санаа ер төвлөрч чадсангүй эмгэний буйтнаа яриа анхаарал сарниулна. Банзлынх нь ард талын оноо далий байх агаад цэмбэн шаахайных нь ул нэг тал руугаа элгэдсэн ажээ. Хөгшин ламтан авсанд хэвтэн инээмсэглэж буй мэт санагдана. Гэвч үгүй байлаа. Бид босч орны толгой руу дөхөх зуур түүний огт инээмсэглээгүй болохыг би олж харав. Чухал хийгээд албархуу тэр яг л Бурхан номын ажил үүргээ гүйцэтгэх гэж буй мэт хувцасласан байх агаад хорчгор том гарт нь хэлтгий аяга бариулжээ. Зэвхий даасан царай, хамрынх нь аймшигтай том хар нүх, тарчигхан ургасан буурал сахал зэргийг харахуй тун чиг сүрдмээр байв. Өрөөнд хүндхэн үнэр ханхийх нь цэцгийн үнэр ажээ.

Бид загалмайлан ёслоод өрөөнөөс гарцгаав. Доод давхрын бяцхан өрөөнд зөөлөн сандал дээр Элайза тун хүндэтгэлтэйгээр сууж байлаа. Намайг урьд нь суудаг байсан булан руугаа очихуйд, Нэнни галын өрөөний тавиураас лонхтой дарс, хэдэн хундагны хамт гаргаж ирэв.

Энэ бүхнээ ширээн дээр тавьж нэг нэг хундага дарс хүртэхийг санал болгов. Дараа нь эгчийг дохио өгмөгц, дарс хундагалж бидэнд барив. Үүнээс гадна тэрээр цөцгийтэй хатаамаг идэх үү гэж надаас асуусан ч дэндүү чанга хүржигнэх байх хэмээн бодоод би татгалзав. Тэрээр намайг татгалзсанд гомдсон бололтой эгчийнхээ сандлын арын буйдан дээр чимээгүйхэн суулаа. Хэн ч ямар ч үг үл хэлэх агаад бид бүгд гал үгүй задгай зуух руу ширтэцгээнэ. Элайзаг санаа алдахуйд авга эгч минь түүнд хандан:

- Тэр амар амгалангийн газар очсон доо гэв! - Элайза дахин санаа алдаж, түүнийг зөвшөөрч буй мэт тэргүүнээ гудайлгав. Авга эгн балгахаасаа өмнө дарстай хундагаа нааш цааш эргүүлж тойруулав.

- Тэр яасан... Зовоогүй биз дээ? хэмээн асуув.

- Ер зовоогүй ээ! гэж Элайза хариулав. - Түүнийг амьсгал хураахад хэлэх ч үг олдоогүй. Бурханы авралаар ер зовлонгүй явлаа даа.

- Тэгээд нөгөө?..

- Эцэг 0'Рурк мягмар гарагт ирж буяны ном хурсан.

- Тэгвэл мэдэж байсан байх нь ээ?...

- Тийм ээ. Тун тайван Бурхан болсон доо.

- Байгаа байдал нь ч гэсэн амар амгалан гэж авга эгч хэлэв.

- Угаал үйлдэхээр ирсэн эмэгтэй ч мөн тэгж хэлсэн. Яг л унтаж байгаа мэт царай зүс нь тун тайван амгалан байна гэж тэр хэлж байсан. Авсанд орсон хойно түүнийг ийм сайхан харагдана гэж хэн ч бодоогүй байх.

- Энэ ч үнэн шүү! гэж авга эгч бувтнав.

Тэрээр хундаганаасаа дахин нэг балгаад:

- За хатагтай Флинн, түүний төлөө та чадах бүхнээ хийсэн нь таны хувьд томоохон тайвшрал авчрах учиртай. Та хоёр хоёулаа л түүнийг байдгаараа халамжилсан. Элайза даашинзныхаа хормойг засав.

- Хөөрхий Жэймс! Бид түүний төлөө чадах бүхнээ хийснийг Бурхан харж байгаа даа хэмээн тэр өгүүлэв.

- Бидэнд хүндхэн байсан ч гэсэн шаардлагатай бүхнийг нь гүйцэлдүүлсэн. Нэнни буйдангийн дэргэд толгойгоо наан суух нь яг л унтах гэж байгаа мэт сэтгэгдэл төрүүлнэ.

- Тийм ээ, Нэнни ч басхөөрхий амьтан, сүүлдээ ч бүр ядарч гүйцсэн шүү! гэж Элайза хэлээд түүний зүг харц чулууудав.

- Угаал үйлдэх эмэгтэйг олох, хувцас салтийг нь сольж, ширээн дээр тавих, сүмд буян ном хурах асуудлыг зохицуулах гээд бүхий л юмыг өөрсдөө хийхээс өөр аргагүй байлаа. Эцэг 0'Рурк байгаагүйсэн бол яаж ч зохицуулах байсан юм бүү мэд. Тэр бас энэ цэцэгсийг сүмийн хоёр лааны суурьтай хамт явуулж "Freeman Journal"-д эмгэнэлийн зар өгч, хөөрхий Жэймсийн даатгалын буянд оршуулгынх нь ажлыг өөрөө хариуцахаар болсон.

- Тун сайн хүн юм даа! гэж авга эгч дуу алдав.

Элайза нүдээ аниад толгойгоо аажуухан савлана.

- Тийм ээ! Эртний анд гэдэг л үнэнч нөхөр байх юм даа! хэмээн тэр хэлэв.

- Үнэнийг хэлэхэд талийгаачийн найз нөхөд гэж ямар хүмүүс байсан бэ?

- Юу үнэн, тэр үнэн гэж авга эгч хэлэв.

- Одоо тэр нөгөө ертөнцөд оччихсон өөрийнх нь төлөө та нарын хийсэн бүхнийг дурсч байгаа болов уу.

- Хөөрхий Жэймс! хэмээн Элайза давтан өгүүлэв.

- Түүнтэй хамт байхад ямар ч асуудал байгаагүй дээ. Үгүй болсон хойноо ч гэсэн байгаа байхгүй нь мэдэгдэхгүй тийм л дуугай хүн байж дээ.

Мэдээж түүнд...

- Тийм ээ. Бүх зүйл өнгөрсөн хойно, та нарт тэр үгүйлэгдэх л болно гэж авга эгч хэлэв.

- Мэдэж байна аа! хэмээн Элайза хариулав.

- Одоо түүнд сайхан шөл аваачиж өгөх шаардлагагүй боллоо. Хатагтай, одоо түүнд хамрын тамхи явуулах шаардлагагүй боллоо. Хөөрхий Жэймс!

Тэрээр өнгөрсөн амьдралдаа авган дуугүйхэн сууж байснаа:

- Сүүлийн үед түүний нэг л сонин байх болсныг би анзаарсан. Шөл аваачиж өгөхөд уншлагын номоо шалан дээр унагачихсан, амаа ангайн зөөлөн сандал дээр хэвтэж байхыг нь би нэг бус удаа харсан гэв.

Тэрээр хамраа арчин хөмсөгөө зангидсанаа:

- Зун дуусахаас өмнө нэг хоног ч болов "Irish town" -нд очиж өсч торнисон хуучин байшингаа нэг харах юмсан гэж үргэлж ярьдагсан гэж яриагаа үргэлжлүүлэв. Нэнни бид хоёртой хамт явах тухайгаа байнга л ярьж байсан. Хамгийн гол нь эндээс холгүй байдаг Жонни Рашаас ямар ч дуу чимээгүй шинэ хийцийн сүйх тэрэг түр авах хэрэгтэй гэж Эцэг 0'Рурк түүнд ярьж байсан. Тэгээд л бүтэн сайн өдрийн орой гурвуул гараад давхина даа...

Энэ бүхэн түүний толгойд гүн суусан байж дээ... Хөөрхий Жэймс!

- Бурхан минь! түүнийг тайван нойрсуул даа! гэж авга эгч хэлэв. Элайза нүдээ арчихаар нусны алчуураа гаргав. Дараа нь тэр алчуураа халаасандаа эргүүлж хийгээд хэсэгхэн зуур хоосон задгай зуух руу дуугүйхэн харав.

- Тэр ямар нямбай хүн байсан гэж санана хэмээн тэрээр хэлэв.

- Сүмийн хэргэм түүнд хүнддэж байснаас гадна, амьдрал нь ч бас амар байгаагүйг хэлэх хэрэгтэй.

-Тийм ээ, их л гутранги хүн байсан даа! гэж авга эгч хэлэв.

- Түүнийг харахад л андашгүй байдагсан.

Умгар өрөөнд нам гүм ноёлмогц энэ хүү боломжийг ашиглан би ширээ рүү очиж хундагатайгаас нэг том балгаад, булан руугаа чимээгүйхэн эргэж очив. Элайза нэлээдгүй манарсан байдалд умбасан мэт санагдана. Энэхүү нам гүмийг тэр хэдийд зөрчих вэ гэдгийг бид хүндэтгэлтэйгээр хүлээж байлаа; урт1 Дублины тохойн эрэг дээрх ядуусын хороолол удаан завсарлага авсны дараа тэр алгуурхан ярьж эхлэв:

- Энэ бүхэн түүний хагалсан аяганаас л болж байгаа юм... Үүнээс л хамаг юм боллоо. Дотор нь юу ч байгаагүй юм чинь айх аюулгүй гэж ярьж байсан.

Гэсэн хэдийч... Үйлчлэгч бүсгүйг буруутан мэт ярьцгаана. Гэвч хөөрхий Жэймс тун их бухимдах болсон. Бурхан өршөөг!

- Тийм юмнаас болсон гэж үү? хэмээн авга эгч асуув. - Би арай л өөр юм сонссон...

Элайза толгой дохив.

- Үүнээс болж түүний оюун ухаан муудсан! гэж тэр хэлэв.

- Үүний дараа тэр янз бүрийн юм бодож, хэнтэй ч ярихгүй ганцаар холхидог болсон. Нэгэн орой хоолоо иднэ үү хэмээн дуудахаар очоод, хаанаас ч эрж хайгаад олж чадаагүй юм. Тэд хаа сайгүй хайсан ч тэр ор сураггүй алга байлаа. Тиймээс л сүмээс эрж хайхыг зөвлөсөн юм. Эцэг О'Рурк, сүмийн ажилтан, мөн тэдний хамт байсан лам нар сүмийн хаалгыг онгойлгон бамбар барьсаар тийш орсон гэдэг. Гэтэл юу болсон гэж бодож байна? Тэнд нүгэл наминчилдаг харанхуй өрөөнд ганцаархнаа суучихсан нэгэн зүг рүү цоо ширтэж, өөрийгөө шоолж буй мэт сууж байсан гээд бод!

Тэрээр гэнэтхэн юу ч юм сонссон мэт дуугүй болов. Би ч мөн чих тавин сонсов. Байшинд ямар ч чимээ үл сонсдох агаад хөгшин ламтан бидний түрүүн харсан шиг энгэртээ хоосон аяга барьсаар, догшин бас тун албархуу байдалтай авсанд хэвтэж байгаа гэдгийг би мэдэж байлаа.

- Нэгэн зүг рүү цоо ширтэж, өөрийгөө шоолж байгаа мэт...

Мэдээж хэрэг тэд түүнийг харуугаа л ямар нэгэн болохгүй юм болсныг олж мэдсэн байх аа гэж Элайза давтан хэлэв.

## Учрал

Жо Диллон биднийг Зэрлэг Баруунтай танилцуулсан юм. “Британийн далбаа”, “Чин зориг”, “Адал явдлын хямдхан номын сан”-гийн хуучин дугаараас бүрдсэн багашаархан номын сан түүнд байв. Хичээл тарсаны дараа үдэш бүр бид тэдний гадаа уулзаж, индианчууд болж тоглоно. Тэрбээр багадүү Леохэмээх тарган, залхуу бандийн хамт адууны жүчээн дээрх дээврийн хонгилыг хамгаалж, харин бид тийш дайрч, довтолдог байлаа; нэг бол бид шалбааг дээр цуст дайн өрнүүлнэ.

Хичнээн хичээдэг ч бид байлдаан юм уу, отолтод хэзээ ч ялж байсангүй. Бидний бүхий л тулаан Жо Диллоны ялалтын бүжгээр өндөрлөдөг байлаа. Түүний эцэг, эх өдөр бүр Гардинерын гудамжин дахь сүмийн өглөөний цуглаанд явдаг байсан агаад тэдний байрны үүдний өрөөнд хатагтай Диллоны амгалан үнэр ноёрхоно. Гэвч түүнийг бодвол бид насаар дүү, аймхайдуу байсан тул тэр дэндүү хатуу тоглож байх шиг санагдана. Үнэн хэрэгтээ тэр цэцэрлэгээр гүйж, харайж байхдаа данхны хуучин хөлчлөг толгой дээрээ дарж өмсчихөөд, атгасан гараараа лааз цохин:

- Ия-як-як! хэмээн орь дуу тавих нь индиантай тун төстэй санагддаг байв.

Түүнийг лам болно гэж шийдсэнийг сонсоод, хэн ч үүнд нь итгэхийг хүссэнгүй. Гэсэн хэдий ч энэ үнэн байлаа. Үгэнд үл орох байдал бидний хэв маяг болж түүний нөлөөн дор соёл болон аливаа сонирхлын ялгаа арилдаг байсан юм. Зарим нь тун халуухан, нэг хэсэг нь тоглоом шоглоомын, нөгөөдүүл нь бөөн айдас хүйдэстэй янз бүрийн бүлэгт багтана; хамгийн сүүлчийн эргэлзээнд автсан индианчуудын бүлэгт миний бие багтаж байв. Зэрлэг Барууны тухай номд өгүүлэх адал явдлууд сэтгэлд минь юу ч үл өгүүлэх авч энэхүү амьдралаас аль болох холхон шиг байх тухай мөрөөдөх боломжийг олгоно. Цаг үргэлж аймшиггүй чин зоригт, эрх чөлөө бүхий гоо бүсгүйчүүдийн тухай өгүүлэх хувийн мөрдөгчдийн тухай Америкийн адал явдлууд надад хамгаас илүү таалагдана. Эдгээр адал явдалд ямар ч тэнэгзүйл байхгүй ч, утгазохиолынхувьдымар нэгэн шаардлага хангахгүй зүйл үгүй ч сурагчид түүнийг бие биедээ нууцхан дамжуулна. Нэгэн удаа Эцэг Батлер Ромын түүхээс гэрт өгсөн дөрвөн хуудас даалгавраа асуух үед болхидуухан Лео Диллон “Адал явдлын номын сан”-гийн нэгэн дугаарыг уншиж байгаад баригдав.

- Энэ чинь хэддүгээр хуудас вэ? Энэ аль хуудас нь вэ? За алив Диллон минь босдоо! “Тэрхүү өдрийн үүрийн цолмон дөнгөж гийж эхлэхэд...”

За алив үргэлжлүүлээрэй! Ямар өдрийн гэнэ ээ? "Тэрхүү өдрийн үүрийн цолмон дөнгөж гийж эхлэх тэр үед..." Та үүнийг цээжилсэн үү?

Тэр халаасанд чинь юу байгаа юм? Лео Диллоныг номоо сарвайхад бүгд зүрхээ чагнан ямар ч гэмгүй мэт царайлна. Эцэг Батлер хөмсөг зангидан түүнийг эргүүлж үзэв.

- Энэ чинь юу вэ? гэж тэр хэлэв.

- “Апачи омгийн ахлагч”. Ромын түүх судлахын оронд юун балай юм уншдаг юм! Ийм хогийн ном дахин миний нүдэнд бүү үзүүл! Иймэрхүү юмыг аяга дарсны мөнгө олох гэсэн

өчүүхэн амьтан л бичсэн байжтаарна. Ийм соёлтой хөвгүүд новшийн юм уншиж байгаад би гайхаж байна. Үндэсний сургуулийн1 хөвгүүд байсан бол ч... Диллон,1 Ядууст зориулсан сургуулийг хэлж байна

би таныг хичээлдээ анхаарлаа хандуулахыг зөвлөж байна. Ойлгож байна уу?

Эс бөгөөс... Энэхүү ял намайг эрүүлжүүлж, Зэрлэг Баруунд хандах дур сонирхлыг минь буруулсан бол, Лео Диллоны гайхширсан бандгар царай хүн чанарыг минь сэрээж билээ.

Гэвч сургуулиас хол байхад эрх чөлөөт амьдралын тухай эдгээр адал явдлууд л мөрөөдөлдөө умбахад минь тусалдаг байлаа. Орой үдэш байлдаж тоглох нь өглөө эрт сургуульд өнгөрүүлэх цаг шиг уйтгартай болж, сэтгэлийнхээ гүнд би жинхэнэ адал явдлыг мөрөөдөх болов. Гэвч жинхэнэ адал явдал гэдэг гэртээ сууж байгаа хүмүүст ер тохиолддоггүй байх гэж би бодно.

Түүнийг эх орноосоо хол газар хайх учиртай аж. Нэгэн хэвийн сургуулийн амьдралыг ганцхан өдөр боловч зөрчих эсэхээ шийдэж ядан байтал зуны амралтын өдрүүд тун чиг ойртсон байлаа. Лео Диллон болон Мехони хэмээх нэгэн хөвгүүний хамтаар хичээл таслахаар бид хуйвалдав. Хүн бүр зургаан пенс цуглууллаа. Өглөөний арван цагт бид Вангийн сувгийн гүүрэн дээр уулзахаар тохиролцов. Мехонийн эгч сургууль руу зурвас илгээж, харин Жо Диллон дүүгээ өвчтэй гэж хэлэх учиртай байлаа. Бид усан зогсоол хүртэл яваад дараа нь

Пижэн-Хаус1 хүртэл бирваазаар явна гэж төлөвлөв. Лео Диллоны хувьд тийш явах замдаа бид Эцэг Батлер юм уу, коллежийн хэн нэгэнтэй тааралдчих вий гэхээс ихэд эмээж байв; Эцэг Батлер юу боллоо гэж Пижэн-Хаус руу явах юм бэ? гэж Мехони гайхшрангуй асуув. Чингээд бид тайвширцгааж,1 Дублины тохойн усан боомт Жойсийг амьдарч байх үед тэнд цахилгаан станц ажиллаж байв.

Боловсруулсан эхнийхээ төлөвлөгөөг хэрэгжүүлж дуусмагц, тэндээс зургаа зургаан пенс хурааж өөрт байгаа зоосыг ч бас үзүүлэв. Урьд орой нь эцэслэн тохиролцох үед бидний сэтгэл ихэд хөдөлсөн байлаа. Өөр хоорондоо гар барилцан инээх зуур,

- Найзууд аа! Маргааш хүртэл баяртай! гэж Мехони хэлэв. Тэр шөнө би тун муу нойртой хонов. Тэднээс би гүүрэнд хамгийн ойр амьдарч байсан тул өглөө эрт түрүүлж очсон байлаа. Ном дэвтрээ цэцэрлэгийн эцэс дэх хогийн нүхний ойролцоох өндөр өвсөн дунд нуугаад сувгийн эрэг дагуу гүйн одов. Зургаадугаар сарын эхний долоо хоногийн намуухан, нарлаг өглөө байлаа. Би гүүрний хашлага дээр сууж, элэгдэж хуучирсан тааран тогонцогруугаа харж, өчигдөр орой байдгаар нь шохойгоор цэвэрлэснээ санаж, дуулгавартай морьд сүйх тэрэг дүүрэн ажил хэрэгч хүмүүсийг толгод өөд чирч зүтгэхийг ажиглаж суулаа. Сувгийн эрэг дагуу ургасан өндөр моддын мөчрүүд хөгжилтэй, цайвар ногоон навчсаар гангарсан байх агаад нарны гэрэл тэдний завсраар ташуу нэвгэлж усан дээр туснам.

Гүүрний гантиг чулуу ал гуурхан халах үед би тол гойдоо орж ирсэн элдвийн зүйлийг бодож, халсан чулууг гараараа алгадаж зогсов. Надад тун сайхан байлаа. Мехонийн саарал хүрмийг олж хартал тэнд би тав, арван хором хүлээж суув. Тэрбээр инээмсэглэсээр толгой өөд гарч ирээд миний сууж байсан гүүр рүү авирч гарав. Биднийг хүлээх зуур тэр халааснаас нь цухуйж байсан чавхаа гаргаж ямаршуухан шинэчлэл хийсэн болохоо надад гайхуулав.



Түүнийг би яах гэж чавх авсныг асуухад, шувуу харвана!

гэж хариулав. Мехони тун олон хараалын үг мэддэг байсан бөгөөд Эцэг Батлерыг хүртэл “хөгшин сэрх” хэмээн хочилно. Бид дахин арван таван хором хүлээсэн ч Лео Диллон ирсэнгүй. Эцэст нь Мехони хашлага дээрээс үсрэн бууж:

- Явъя аа! Тэр Бүдүүнээг бултана гэдгийг би мэдэж байсан юм аа гэв.

- Түүний зургаан пенсийг... гэжби хэлэв.

- Энэ бол торгууль шүү дээ гэж Мехони өгүүлэв. - Бид яав л гэж? Сайн л биз. Нэг шиллинг, зургаан пенстэй боллоо. Бид Норт-Стрэндийн замаар химийн үйлдвэр хүрээд, усан зогсоол руу хөтлөх баруун гудамж руу эргэв. Хүний хөл татармагц Мехони индиан болон тоглож гарав. Тэрбээр сумлаагүй чавхаа эргүүлэн хааш яаш хувцасласан охидын араас хөөж, харин тэднийгхамгаалах сэтгэлдээ хөтлөгдсөн хоёр шалдан бандийг бидэн рүү чулуу шидэх үед хариуд нь “гал нээх” санал гаргав. Банди нар дэндүү жаахан байсан тул би эсэргүүцэж, бид цааш явлаа. Харин шалдан банди нар бидний араас “Та нар хэн юм бэ? Юу ч биш амьтад” хэмээн хашгирцгаана. Бид Үтюг хүрээд отолт хийхээр шийдсэн ч юу ч болсонгүй. Ингэхийн тулд дор хаяж гурвуулаа байх шаардлагатай байв.

Лео Диллоныг хэрхэн бултсан талаар бид өөр хоорондоо ярилцаж ноён Районы сүүлчийн хичээл дээр тэр ямар дүн авах вэ гэдгийг таахыг оролдов. Дараа нь бид гол руу очлоо. Өндөр чулуун хана бүхий шуугиант гудамжаар зөндөө тэнүүчилж, өргөгч цамхаг хэрхэн ажиллаж буйг ажиглан үе үехэн зогсоцгооно. Тэр үед бидний зүг хүндхэн тээш ачсан тээврийн тэрэгч нар хашгирч байлаа.

Голын эрэг дээр очмогц үд болж, ажилчид хоолоо идэхээр сууцгаахад, бид хоёр ч гэсэн нэрсний чанамалтай хоёр том нарийн боов худалдан авч, голын эрэг дээрх төмөр хоолой дээр тухлан идэхээр зэхэв. Худалдааны онгоцуудыг зогсоол руу ойртон тэртээ холоос хөвөн цагаан утаа мэт дохиог өгч, Рингсэндийн цаадах загасчдын хөлөг онгоцнуудын хүрэн усан флот, голын эсрэг талд ачаа буулгаж буй том цагаан далбаат онгоц зэрэг Дублины худалдааны усан боомтын амьдралыг бид сониучирхан харж байлаа.

- Энэ аварга хөлөг онгоцнуудын нэгээр далайд гарч зугтаавал тун сайхан аа! гэж Мехони хэлэв. Тэр ч бүүхэл, өндөр шургааг харахад сургуульд олж авсан газар зүйн хичээлийн маруухан мэдлэг минь нүдний өмнө хэрхэн жирэлзэн өнгөрч буйг төсөөлөн бодож зогсов. Орон гэр хийгээд сургууль минь надаас эцэс төгсгөлгүй холдож, өөрсдийгөө бид дэндүү эрх чөлөөтэй мэт мэдэрнэм. Гармаар гарсныхаа төлбөрийг төлчихөөд, бид боомтын хоёр ажилчин, шуудай үүрсэн жижигхэн жүүдийн хамт Лиффи голыг бяраваазаар гаталсан юм. Бид тун чухал царайлан явцгааж байсан ч нэгэнтээ харц тулгармагц тэсэхийн аргагүй хөхөрцгөөж билээ.

Эрэг дээр буусан хойноо бид нөгөө эрэг дээр байхдаа л олж харсан гурван шургааг бүхий хөлөг онгоцноос хэрхэн ачаа буулгахыг ажиглаж зогсов. Тэнд байсан үл таних хүн, энэ бол Норвегийн хөлөг онгоц гэв. Би хөлөг онгоцны хошуу руу очиж тэнд байгаа бичээсийн учрыг олохоор завдсан ч ер чадсангүй. Төдөлгүй буцаж ирээд гадаадын усан цэргүүдийг

сониучирхан харж эхлэв.

Тэд үнэхээр ногоон нүдтэй гэж үү? Надад ярьснаар бол... Усан цэргүүдийн нүд цэнхэр, саарал, бүр хар ч өнгөтэй байв.

Ногоон нүдтэй гэж нэрлэж болох ганцхан усан цэрэг байсан нь нэлээд өндөр биетэй эр ажээ. Тэрбээр банз шидлэх бүрийд тун хөгжилтэйхэн:

- Волж байна, болж байна! хэмээн хашгирч ойр хавийн хүмүүсийг зугаацуулна.

Төдөлгүй бид үүнийг харахаас залхаж, Рингсэнд рүү чимээгүйхэн зүглэв. Дэндүү бөгчим болж, хүнсний лангууны цонхон дээр наранд байсаар байгаад хөгзрөхөөс наагуур болчихсон хэвт боорцог өлгөөстэй байлаа. Бид хэвт боорцог болон шоколад худалдан авч загасчдын гэр бүл амьдарч байсан заваан гудамжаар явангаа гялс манас идэцгээв. Сүүний дэлгүүр олоогүй тул нэг нэг шил бөөрөлзгөний ундаа худалдаж авлаа. Жаал сэрүүцсэний дараа, Мехони нэгэн муурны араас булан тойрон хөөсөн ч өнөөх нь тэртээх тал руу чавхдан одов. Бид хоёр байдгаараа ядарч туйлдан тал руу гармагц налуу ташлуурыг чиглэв. Хярын цаана Додцэр гол мяралзана. Дэндүү орой болсон тул Пижэн-Хауст очих тухай ярихаас ч ядарнам.

Өдрийн дөрвөн цаг гэхэд бид гэртээ харих ёстой. Эс амжваас бидний орголтыг илрүүлж мэдэхээр байлаа. Мехони тун уйтгартай чавхаа ширтэнэ, харин төмөр замаар хот руу буцахыг санал болгоход бага зэрэг сэргэв. Наран авхай биднийг уйтгарт бодол, хоолны үлдэгдлийн хамт үлдээгээд үүлсийн цаагуур нуугдан оров. Тал дээр биднээс өөр хэн ч байсангүй. Хэдэн хормын турш юу ч дуугаралгүй ташлуур дээр хэвтсэний дараа, тэртээ холоос хэн нэгэн хүн айсууг би олж харав. Охидын мэргэ хийдэг өвсний ишийг зажлах зуур түүнийг би залхуутайхан ажиглав. Тэр хүн ташлуурын дэргэдүүр алгуурхан явна. Түүний нэг гар нь ташаан дээрээ байх агаад нөгөө гар дахь таягаараа газар түншин явж байлаа.

Тэрбээр үнгэгдсэн хар ногоон өнгийн хослол өмсөж, бүрх малгай нь бидний нэрлэж заншсан шөнийн хөтөвтэй тун адилхан харагдана. Сахал нь байдгаараа бууралтсан байх тул надад тэр хөгшин хүн мэт санагдав. Тэрбээр тун ойрхон өнгөрөхдөө бидэн рүү хяламхийн хараад цааш одов. Түүний араас би харсаар байсан бөгөөд тэрбээр тавь орчим алхам явснаа буцаад алхав.

Тэр хүн биднийг чиглэн тун удаан явах агаад чингэхдээ цаг үргэлж таягаараа газар түншиж байгааг нь харахул, ямар нэгэн зүйлийг зүлгэн дотроос хайж буй мэт санагдана. Бидний сууж байсан газарт хүрч ирээд тэр мэнд усаа мэдэв.

Үүний дараа тэр тун аажуухан, ихэд болгоомжтойгоор бидний сууж байсан ташлуур руу бууж ирэв. Тэрбээр цаг агаарын тухай яриа дэлгэж, энэ зун тун халуун болно гэв. Түүнийг хүүхэд байсан цагаас хойш цаг агаар нэлээдгүй өөрчлөгдсөн тухай ч нэмж хэлэв. Хүний амьдралын хамгийн жаргалтай жилүүд бол сурагч ахуй нас байдаг юм даа! гээд, дахин залуу болохын тулд бүхнээ зориулахад бэлэн байна гэв. Энэ тухай ярихдаа нэлээдгүй уйтгартай байсан бөгөөд бид ч дуугүй л чагнаж байлаа.

Дараа нь тэр сургууль, номын тухай ярьж гарав. Биднээс тэр Томас Мурын шүлгүүд, ноён Вальтэр Скоттын романууд, мөн гүн Бүлвэр-Литтоны зохиолуудыг уншсан эсэхийг асуув.

Түүний нэрлэсэн бүхий л номыг уншсан мэт царай гаргахад:

- Тийм ээ. Чамайг харахад яг л над шиг номын хорхойтон шиг байна.

Харин энэ хүү бол... гэж бидэн рүү нүдээ бүлтийлгэн харж байсан Мехони руу зааснаа,

- Энэ бол тийм биш ээ. Тэр тоглох тал дээрээ л чадалтай юм шиг байна хэмээн инээмсэглэн хэлэв. Манайд ноён Вальтер Скотт, гүн Литтон нарын бүхий л зохиол бий тэдгээрийг эргэн уншихад хэзээ ч сонирхол буурдаггүй юм гэж тэр өгүүлэв. “Мэдээж хэрэг гүн Литтонд хөвгүүдэд уншиж боломгүй хориотой ном бас бий” гэж тэр хэлэв. Хөвгүүд яагаад уншиж болохгүй талаар Мехони асуув;

Үл таних хүн намайг Мехонийн адил тэнэг амьтан гэж бодохоос айсан тул энэ асуулт миний уурыг барав. Гэвч тэр зүгээр л инээмсэглэв.

Тэр цөөн хэдхэн шар шүдтэй болохыг би олж харлаа. Дараа нь, бид хоёрын хэн нь олон найз охинтой болох талаар тэр асуув. Тэрбээр гурван найз охинтой гэдгийг Мехони өөрийн эрхгүй анзаарав. Үл таних эр надад хэдэн найз охин асуув. Нэг ч байхгүй гэж би хариуллаа. Тэр надад үл итгэн ямар нэгэн найз охин байгаа гэдэгт итгэлтэй байна гэв. Би юу ч хэлсэнгүй.

- Ингэхэд танд хэд байгаа вэ? гэж Мехони түүнд эрсхэн хэлэв. Үл таних эр дахин инээмсэглэснээ, бидний насан дээр өчнөөн олон найз охинтой байсан тухайгаа яриу.

- Ямар ч хөвгүүн бяцхан найз охинтой байдаг юм гэж тэрбээр нэмэв. Тиймэрхүү насны хүн ийм чөлөөтэй сэтгэж байгаа нь намайг алмайруулав. Хөвгүүд болон найз охидынх нь тухай ярьж байгаа түүний байдлыг би сэтгэлийнхээ гүнд, зөв гэж бодов. Гэвч түүний амнаас эдгээр үгсийг сонсох нь тун эвгүй байлаа.

Тэрнийг ямар нэгэн юмнаас айсан юм уу, гэнэтхэн жихүүдэст автах мэт хоёронтаа чичирхийлэхийг хараад би ихэд гайхшрав. Тэрбээр үргэлжлүүлэн ярих үед нь, хэл яриа нь тун сайн болохыг би анзаарав. Охидын үс ямар сайхан зөөлхөн байдаг тухай, тэдний гар ямар булбрай байдаг тухай, чингээд зогсохгүй бүх охид байгаа шигээ тийм сайн байдаггүй талаар тэр баахан юм яриу.

Энэ хорвоо дээр бүхнээс илүү тэр залуухан, сайхан бүсгүйг харах дуртайгаа өгүүлж, ялангуяа үзэсгэлэнт хасын цагаан гар хийгээд түүний торгомсог зөөлөн үсийг юунаас ч илүү харах дуртайгаа онцлон өгүүлэв. Тэрбээр цээжилсэн зүйлээ давтан өгүүлж байх мэт сэтгэгдэл төрж, аль эсвэл түүний оюун ухаан соронзон лугаа адил хэлэх үгсийх нь дагуу, ямар нэгэн үл хөдлөх тойрог замын дагуу алгуурхан эргэлдэж буй мэт санагдана. Заримдаа тэр бүхий л хүмүүсийн мэддэг зүйлийг сануулах мэт ярих авч үе үехэн хоолойгоо намсгаж, тун нууцлаг ярих агаад энэ нь бусад хүмүүст сонсогдуулахгүйн тулд аминчлан ямар нэгэн нууцын тухай өгүүлж байгаа мэт санагдана.

Өөрийн хэлэх үгийг тэр дахин дахин давтаж, тэр бүрдээ бага зэрэг өөрчилж, хоолойн өнгөө хувиргаж байлаа. Түүний ярихыг сонсохын сацуу ташлуур дагуу үргэлжлүүлэн харлаа. Нэлээдгүй хугацаа өнгөрсний дараа яриа нь гэнэт тасрав. Тэрбээр алгуурхан босч, түр

хугацаанд биднийг орхиж буйгаа харсан зүгээсээ харц салгалгүй хэлчихээд, хамгийн ойрхон талбайн зах руу алгуурхан дөхөж очихыг нь харав.

Түүнийг явсан хойгуур бид дуугүйхэн суусаар байлаа. Хоёр, гурван хором өнгөрсний дараа Мехони гэнэт ийнхүү хашгирав.

- Хүүш, чи түүнийг юу хийж байгааг хар даа! Хариуд нь би харц дээшлүүлэн юу ч дуугараагүй тул Мехони:

- Хүүш, ёстой нэг хөгшин төгцөг юм даа! гэж дахин хашгирав.

- Хэрэв тэр бидний нэрийг асуувал чи Мэрфи, харин би Смит болно шүү! гэж хэлэв. Бид бие биедээ дахин юу ч хэлсэнгүй.

Явах уу, болих уу? гэдгээ нэлээдгүй бодож байтал үл таних хүн эргэж ирээд бидний дэргэд дахин суув. Түүнийг суув уу, үгүй юу өмнө нь зугтсан муурыг олж харуугаа Мехони огло харайн босч араас нь хөөж гарав. Үл таних хүний хамт би түүнийг хэрхэн муурны араас хөөцөлдөхийг ажиглаж байлаа. Үнхэлцгээ хагартал айсан муур зугтаж одмогц, Мехони түүний нуугдсан хашааг давуулан чулуу шидэлж эхлэв. Төдөлгүй тэр залхсан уу яасан тэртээх талын хөвөөгөөр нааш цааш утга учиргүй холхиж гарав.

Хэсэг дуугүй суусны дараа үл таних хүн надтай яриа дэлгэв. Миний найзыг тун чиг бүдүүлэг хөвгүүн байна гэж тэр хэлээд, сургуульд түүнийг байнга зодуулдаг эсэх талаар асуув. Сахилга бат зөрчсөний төлөө цээрлэл хүлээдэг Үндэсний сургуулийнхан биш гэдгээ хэлэх гэснээ ч би дуугүйхэн өнгөрөв. Тэрбээр хөвгүүдэд зориулсан зодуур бүхий шийтгэлийн тухай ярьж гарав.

Түүний ухаан санаа, соронзон мэт үгсийн адил шинэ тойрог замаар алгуурхан эргэлдэх мэт санагдана. Иймэрхүүхөвгүүдэд больё гэтэл нь жавгий хүртээх хэрэгтэй гэж тэр хэлэв. Үгэнд ордоггүй бүдүүлэг хөвгүүдэд хамгийн тохиромжтой зүйл бол сайтар болгож тавих явдал ажээ. Гарыг нь цохих юм уу, чих мушгих нь багахан ач тус өгдөг гэнэ; харин түүнд зайлшгүй шаардлагатай зүйл бол больё гэтэл суран бүсээр ороолгох явдал. Иймэрхүү хандлага намайг гайхшруулсан тул би хүссэн хүсээгүй түүний нүүр рүү эгцлэн харлаа. Салгалсан духны дорх лонхон ногоон нүдний харцтай тулгарав. Түүнээс би нүүр буруулав. Үл таних хүн яриагаа үргэлжлүүлнэ.

Тэрбээр тун саяхны чөлөөт сэтгэлгээгээ мартсан бололтой. Ямар нэгэн хөвгүүн найз охинтой байж бусдыг харж сээтгэнэх аваас түүнийг байдгаар нь ороолгох хэрэгтэй чингэснээр тэр өөр охидтой дахин харьцах ч үгүй болно гэж хэлэв. Хэрэв хэн нэгэн хөвгүүн найз охинтой байгаад үүнийгээ тас нуух аваас ямар ч хөвгүүн урьд өмнө амсаагүй тийм эрүү шүүлтийг тэрхүү хөвгүүнд тулгах ажээ. Тун сайхан эрүү шүүлт болох нь ээ!

Тиймэрхүү хөвгүүнийг жанчих тухай тэр ямар нэгэн ээдрээт нууцыг тайлж байгаа мэтээр дүрслэн өгүүлэв. Энэ бол түүний хувьд хамгийн сайхан таашаал байна гэж хэлэв; чингээд түүний хоолойн олон өнгө аяс цаг ямагт надад тэрхүү нууцыг нээж байсан ч эдүгээ гагцхүү түүнийг ойлгоосой гэж хүсэх мэт энхрий болжээ. Түүний яриаг дуустал би хүлээв.

Тэр цагт би босч зогсов. Сэтгэл хөдөлсөн байдлаа үзүүлэхгүйн тулд би хэсэг зуур зориуд гутлаараа оролдож, үдээсийг нь зангидаж сууснаа, явах учиртайгаа хэлж хамгийн сайн сайхныг хүсэн ерөөв.

Ташлуураас би тайван боссон боловч зүрх минь айснаасаа болж амаар гарах шахаж байв. Тэр яг л хөлөөс минь бариад авах гэж байгаа мэт санагдав. Босоод түүн рүү харалгүйгээр эргэн харж, талын дээгүүр байдаг чадлаараа, Мэрфи! хэмээн хашгирав. Хоолойноос минь эр зориг сонсдож өөрийнхөө бяцхан зальнаас би үхтлээ ичиж билээ. Би дахин хэдэнтээ хашгирахад Мехони над руу хариу хашгирав.

Зүрх минь түг түг цохилох үед тэр намайг чиглэн тал дундуур гүйж байлаа. Тэрээр надад тусламж үзүүлэхээр яарч буй мэт санагдана.

Чингэхэд би түүнийг үргэлж бага зэрэг үзэн яддаг байсан тул сэтгэлийнхээ гүнд тун чиг ичмээр байж билээ.

## Араби

Христийн Ахан дүүсийн 1 сургуулийн хичээл дуусах цагийг эс тооцвол Норт Ричмондад нам гүмхэн байдаг байв. Мухар гудамжны эцэст хөршүүдээс хол дөрвөн талт ойн нуга дээр хоёр давхар эзгүй байшин байх аж.

Тэрхүү гудамжин дахь бусад байшингууд нэр бүхий бардам оршин суугчдаар дүүрэн агаад бие бие рүүгээ зэвхий даасан, хэзээ ч хувирашгүй нүүрэн талаараа харцгаана. Манай байрны хуучин эзэн болох ламтан умгархан зочны өрөөндөө насан эцэслэсэн гэдэг. Урт удаан хугацааны турш цоожтой байснаас болж бүх өрөөнд нь хөгзөрч ялзарсан үнэр ханхийж гал зуухны өрөөний дэргэдэх пинд хэнд ч хэрэггүй хуучны бичиг цаас овоолгоостой байв. Тэдний дундаас би хуудас нь шарлаж, чийг даасан цаасан хавтастай хэд хэдэн ном олсон нь: Вальтэр Скоттын “Хамба лам”, “Гэгээн ламтан” болон “Видокийн дурсамж”<sup>2</sup> зэрэг байв.

Сүүлийнх зохиол бусдаасаа илүү надад таалагдсаны учир нь бүх хуудас шарласанд оршино. Байшингийн цаадах цэцэрлэгт нэгэн алимны мод ургах агаад түүнийг тойрон хэд хэдэн сөөвийсөн бутнууд байх; Түүний дороос би талийгаач эзний унадаг дугуйны зэвэрсэн хийлэгчийг олов. Тэрбээр буяны ажил хийдгээрээ олонд зартай нэгэн байсан бөгөөд нас барахдаа бүх хөрөнгөө буяны үйлсэд зориулахыг гэрээсэлж, 1Гол төлөв ядуусын хууль бус хүүхдүүдийг хүмүүжүүлэхэд өөрсдийгөө зориулсан католик шашинтнуудын нөхөрлөл байв

2 “Гэгээн ламтан” (1813 онд хэвлэгдсэн) - П.Бэйкерийн зохиол; “Видокийн дурсамж” (1829 он) Франсуа-Жюль Видок нь хожим залилан мэхлэгч цагдаагийн дүрээр нэлээдгүй олон хэргийг зохион байгуулалттай үйлдэж, дараа нь түүнийг тун гайхалтай илрүүлж байсан гэмт хэрэгтэн юм. Харин орон гэрээ эгчдээ өвлүүлжээ.

Өдөр нь богино өвлийн цагт биднийг оройн зоог барихаас урьдаж харуй бүрий болно. Гудамжинд гарахуйд байшингууд тэр чигээрээ харанхуйд автсан байна. Бидний орой дээр байх тэнгэрийн өчүүхэн хэсэг улам бүр өтгөн, ягаан өнгөтэй болж, гудамжны дэнлүүнүүд түүн рүү ёлтойсон гэрлээ хандуулна.

Хүйтэн агаар арьс тэмтэрч, бид бүхий л биеэ халуу дүүгтэл тоглодог байлаа. Бидний хашгираан гудамжны нам гүмд дуу хадааж сонсдоно. Бид зэрлэг омгийнхны амьдарч байсан урцны дэргэд дайсны суманд оногдож, гудамны гаднах бохир орчинд тоглоом наадам үргэлжилж; харанхуй, чийг даасан арын хашааны ногоон талбай дахь хогийн савнаас бөөн өмхий үнэр ханхийнэ; тэр хавьд улаач эр морьдынхоо хомоолыг цэвэрлэж зогсдогсон, эс бөгөөс бүснийх нь ганган горхины аялгуут чимээ сонсдоно. Биднийг гудамж руу эргэн ирэх үед гал зуухны цонхны гэрэл харанхуйд нэвт тусна. Авга ах минь булангаас гарч ирвэл, бид сүүдэрт нуугдан хүлээж, гэр рүүгээ орсон хойно нь гарч ирцгээдэг байлаа.

Харин Мэнгана эгчийг довжоон дээр гарч ирээд цайгаа уу хэмээн ахыгаа дуудах үед бид сүүдэрт нуугдаж, түүнийг хэрхэн эргэн тойрноо ажиж буйг харцгаана. Эгчийг довжоон дээр зогссоор байх уу, эсвэл гэр рүүгээ орох уу гэдгийг мэдэх нь чухал. Хэрэв зогссоор байх ахул бид нуугдсан булангаасаа гарч ирэн Мэнганы зогсч буй довжоо руу дуулгавартайхан очицгооно. Тэрээр биднийг хүлээсээр зогсох үед хагас онгорхой хаалганы гэрэлтэй тэгш өнцөг дор түүний дүрсхарлан үзэгдэнэ. Ах минь үгэнд нь орохоосоо өмнө үргэлж түүнийг

шоглодог байсан бөгөөд харин би довжооны бариулны дэргэд зогсчихсон эгчмэд бүсгүй рүү ширтэн зогсдог байлаа. Түүнийг эргэх үед даашинз нь долгилсхийж урт, зөөлөн сүлжсэн үсний боолт ар нуруунд нь доргисхийнэ.

Өглөө бүхэн би зочны өрөөний шалан дээр хэвтэж, түүний хаалгыг ажиглана. Цонхны хаалттай хөшиг нь тавцан хүртэл нэг ямх дутаж байх тул гаднаас намайг харах боломжгүй байв. Довжоон дээр түүнийг гарч ирэх үед зүрх минь сэрдхийнэ. Үүдний өрөө рүү би байдгаараа гүйн очиж, номнуудаа тэвэрч аваад л түүний араас мөрддөг ажилтай болов. Урдаа яваа бор дүрсийг нэг хором ч гэсэн үл алдахаас гадна бидний зам уулзах эргэлт дээр алхаагаа хурдасган, гүйцэж очдог байлаа. Энэ явдал өдөр болгон давтагдана. Зарим нэгэн санаандгүй үгсийг эс тооцвол түүнтэй би нэг ч удаа ярьж байсангүй. Гэвч бүсгүйн нэр тун тэнэг байдлаар цусыг минь булиглуулдаг асан уриа мэт байлаа. Түүний гэгээн дүр сэтгэл үл хөдлөм тийм газарт ч гэсэн намайг хэзээ ч үл орхином. Бямба гарагийн орой бүр авга эгч минь намайг дагуулан хүнс цуглуулахаар дэлгүүр явах үед түүний араас би хоолны цүнхээ чирсээр гэлдэрдэг заншилтай.

Тодхон гэрэл тусах гудамжаар явахдаа бид худалдаачид хийгээд согтуучуудын чихцэлдээн, тариачдын хараал, лангууны дэргэд торхтой цувдай харгалзаж буй банди нарын цангинасан хоолой гудамжны дуучдын новшийн улилт, 0' Донован Росс1 -ын тухай сунжирсан дуу, эс бөгөөс манай төрөлх эх орны уй гунигийн тухай дуулийг хүссэн хүсээгүй сонссоор өнгөрдөг байна.

1 Буржгар хэмээх нэр дээр нэмсэн хоч. Ирландын үндэсний чөлөөлөх хөдөлгөөний зүтгэлтэн.

Энэ бүх чимээ шуугиан миний хувьд амьдралыг нэг цул юм шүү хэмээн мэдрэхэд хүргэж, тэнд цугларсан үй олон дайсны дундуур би өөрт ноогдсон царыг1 тун нандигнан авч явна хэмээн төсөөлнө. Заримдаа тун хачирхалтай түүний нэр сүлд дуу хийгээд залбирлын үеэр өөрийн эрхгүй аманд орж ирэхүйд учрыг нь би өөрөө ч сайн ойлгодоггүй байлаа. Миний нүдэнд нулимсхэдэнтээ мэлмэрч (яагаад гэдгийг би мэдэхгүй), заримдаа зүрхэнд минь бөөн давалгаа үүсч, бүхий л хэнхдэг цээжийг бүрхэж буй мэт санагдана. Цаашид юу болох тухай би шүүн тунгаахыг хичээнэм.

Хэзээ нэгэн цагт түүнтэй ярилцах болов уу гэдгийг би хэлж мэдэхгүй юм. Хэрэв тийм зүйл тохиолдвол, түүнийг би хүндлэн биширдэг тухайгаа яажшуухан хэлэхээ ч мэдэхгүй байлаа. Гэвч миний бие махбод яг л босоо ятга лугаа адил байх агаад харин түүний үгс утсан дээгүүр нь гүйх хуруу мэт бөлгөө. Нэгэн үдэш би ламтны нас барсан умгархан зочны өрөөнд оров. Тэр орой дэндүү харанхуй, бороотой байсан бөгөөд байшинд ямар ч чимээ үл сонсоно. Хагархай цонхны цаана борооны дуслууд газарт унаж, тоо томшгүй усан зүү ногооны норсон талбайг хайр найргүй цохилж байхыг би сонсов.

Тэртээ дор дэнлүү юм уу, аль эсвэл цонхны цаадах гэрэл тусна. Би багахан зүйл харж буйдаа туйлын их баяртай байв. Тэр цаг мөчид манан татаж байх шиг санагдаж, бүхий л мэдрэхүй минь яг одоо намайг орхих гэж байгаа мэт бодогдох тул гараа би өвдтөл нь базалж: “Хайрт минь! Хайрт минь!” хэмээн эцэс төгсгөлгүй давган өгүүлнэ. Сүүлд нь тэр надтай1 Гэгээн авьяастнуудад зориулсан цар буюу хул. Цар нь оюун санааны итгэл найдвар хийгээд

шүтээний билэгдэл гэсэн утгаар энд хэрэглэгдэж байна дуугарав. Түүний хэлсэн хэдхэн үгсийн дараа би юу ч хэлэхээ мэдэхгүй гайхшралд автлаа. Тэрээр намайг Араби<sup>1</sup> руу явах уу? хэмээн асуув. Түүнд би тийм эсвэл үгүй гэж хэлснээ ер санахгүй байна. Тун гайхамшигтай худалдаа гарна даа гэжтэр хэлэв; тэнд очихыг тэр тун их хүснэ.

- Та яагаад тийшээ очихгүй гэж? хэмээн түүнээс би асуув. Ярихдаа тэр гарынхаа мөнгөн бугуйвчийг цаг ямагт эргүүлнэ. Энэ долоо хоногт тэдний сүмийн сургуульд мацаг барих учир тэрээр явахгүй гэж хэлэв. Түүний ах нэгэн малгайнаас болж хоёр хөвгүүнтэй зодоон хийх үед би довжооны дэргэд зогсч байлаа. Тэрээр надруу тонгойж шатны бариулаас барьж зогсоно. Манай хаалган дээрх дэнлүүний гэрэл хүзүүнийх нь хасын цагаан туяаг харанхуйгаас шүүрэн авч хүзүүгээ даган унжих гэзгийг нь илбэж, доош тусахдаа бариулаас атгасан гарыг нь гэрэлтүүлнэ. Түүнийг хөдөлгөөнгүй зогсох үед өнөөх гэрэл даашинзан дээр нь тусч, дотуур банзлынх нь цагаан хөвөөг улам бүр тодруулна.

- Та ч азтай юм аа! гэж тэр хэлэв.

- Хэрэв би тийш явбал танд ямар нэгэн юм авчрах болно оо гэж би дуугарав. Ямар хязгааргүй их мөрөөдөл тэрхүү үдшийн дараа зүүд нойр хийгээд бодолд минь эргэлдэж байсан гээч! Хичээл номоо хийхийн аргагүйд хүрэв. Үдэш оройн цагаар миний өрөөнд, өдрийн цагаар хичээлийн танхимд түүний дүр төрх хаа сайгүй үзэгдэж, уншихыг оролдох номын хуудаснаа хүртэл тодрон харагдана.

“Араби” хэмээх үг Дорнын ид шидээр намайг илбэдэн,<sup>1</sup> Жил бүр Дублин хотын эмнэлгүүдэд туслах зорилгоор тавдугаар сарын 14-19 хооронд зохион байгуулагддаг буяны захын нэр сэтгэлийн минь эрхлэнхэн байсан тэрхүү нам гүмийн дундаас надад сонсдоно. Бямба гарагийн орой Буяны зах руу явах зөвшөөрөл би хүсэв. Авга эгч тун их гайхширсан ч, энэ бол ямар нэгэн франкмасын<sup>1</sup> санаа биш гэдэгт итгэж буйгаа хэлэв.

Хичээл дээр би муухан хариулж байв. Багшийн нүүрэн дээрх энхрий дотно байдал хатуу догшин байдлаар солигдов; надаас тэр залхуураад байна уу, аль эсвэл анхаарлаа төвлөрүүлж чадахгүй байна уу? гэж асуув. Ахуйн чухал ажил хэргийг би тэсэхийн аргагүй байсан бөгөөд тэр бүхэн миний болон хүслийн минь хооронд зогсч, надад туйлаас уйтгартай, нэгэн хэвийн хүүхдийн тоглоом мэт санагдана. Бямба гарагийн өглөө би оройхон тийш буяны зах руу явахыг хүсч буйгаа авга ахдаа сануулав. Тэрбээр бүрх малгайнаах сойзийг хайж өлгүүрийн дэргэд бөөн эрэл сурал болж байснаа:

- Тийм ээ, хүү минь би мэдэж байна гэж товчхон хариулав.

Түүнийг үүдний өрөөнд байсан тул би зочны өрөөнд орж цонхны өмнө хэвтэх боломжгүй байлаа. Тиймээс би гэрээс гарч тун сэтгэл дундуурхан сургууль руу зүглэв. Тэр өдөр ямар ч авралгүй бүрхэг байснаас гадна сэтгэл зүрхээрээ би зовлонг мэдэрнэ. Оройн хоолны үеэр гэртээ эргэн ирэхэд авга ах эзгүй байв. Цаг арай эрт байна. Хэсэг зуур цаг руу ширтэн суусан ч түг түг цохилох чимээ нь залхааж гүйцсэн тул өрөөнөөс гарав. Байшингийн дээд давхарт гарахаар шатаар өгсөв.

<sup>1</sup> Масончуудыг Ирландад католик шашинтнууд хэмээн хүлээн авч байсан бөгөөд



протестантуудын нэгэн адил “Жинхэнэ сүсэг бишрэлийн дайснууд” хэмээн үздэг байв.

Өндөр таазтай, ханхайсан, хүйтэн, баргар өрөөнүүдийг хараад дотор минь арай жаахан онгойсон тул дуу аялсаар нэг өрөөнөөс нөгөө рүү орж өөрийгөө саатуулав. Гудамжинд тоглож буй найз нөхдөө цонхоор олж харав. Тэдний хашгирах чимээ арай сул нэг их тод бус сонсдох тул би хүйтэн цонхонд духаа нааж, түүний амьдарч байсан эсрэг талын байрны харанхуйн зүг ширтэв. Ийнхүү бараг цаг зогсовч сэтгэлдээ бүтээсэн хүрэн даашинзтай дүрээс өөр юу ч олж харсангүй.

Намайг доош буухад задгай галын дэргэд хатагтай Мэрсэр сууж харагдав. Тэрээр чухам юуны учир гэдэг нь тодорхой бус зорилгоор шуудангийн хуучин марк цуглуулдаг байсан мөнгө хүүлэгчийн бэлэвсэн авгай болох яншаа, буурал чавганц байлаа. Оройн хоолны ширээний ард хэнд ч хэрэггүй хоосон яриа сонсоход хүрэв. Тэрхүү зоог нэг цагаар оройтсон ч авга ах ирсэнгүй. Хатагтай Мэрсэр ширээнээс босов. Тун харамсалтай. Тэглээ гээд есөн цаг болж байгаа тул дахин тэр хүлээж чадахгүй. Гудамжинд оройн цагаар гарахыг үл хүснэ. Шөнийн агаар түүнд хортой ажээ. Түүнийг явсан хойно би босч өрөөн дотуур гараа зангидаж нааш цааш холхив.

- Ням гараг хүртэл зах руу явах ажлаа чи хойшлуулахаас өөр аргагүй болсон байх аа! гэж авга эгч өгүүлэв. Оройн есөн цагт хаалганы цоожинд түлхүүр эргэх чимээ гарав. Авга ах минь өөртэйгөө ярьсаар орж ирэхэд, хүндхэн хүрмээс нь болж өлгүүр савлах чимээ дуулав. Энэ бүхэн юу гэсэн үг вэ? гэдгийг би тун сайн мэдэж байлаа. Оройн хоолоо хам хум идсэнийх нь дараа, зах руу явахаар түүнээс би мөнгө гуйв. Тэр бүхнийг мартжээ.

- Сайн санаат хүмүүс хоёр дахь зүүдээ үзэж байна гэж тэр бувтнав. Би огтхон ч инээсэнгүй.

- Түүнд чи мөнгө өгчих явж л байг. Хүүхэд зовоогоод яахав дээ! гэж авга эгч минь намайг эелдэгхэн өмөөрөв. Энэ бүхнийг мартсандаа тун их харамсч байна гэж авга ах хэлэв. Аливаа зугаа цэнгэл үгүй бол сургууль номондоо ч мөн амжилт гаргана гэж үгүй хэмээх хуучны зүйр цэцэн үгийг үргэлжид баримталдаг тухайгаа ч тэр өгүүлэв. Намайг хаашаа явах гэж байгаа талаар тэр дахин лавлаад, энэ тухай түүнд хоёр дахь удаагаа тайлбарлаж өгтөл, надаас тэр “Араб эр мориноосоо хагацсан нь”<sup>1</sup> хэмээх шүлгийг мэдэх үү? гэж асуув.

Гал зуухны өрөөнөөс намайг гарах үед тэрхүү шүлгийнхээ эхний мөрийг тэр авга эгчид хандан аялгуулан уншиж гарав. Гартаа би нэг флорин зоос чангахан атгасаар Бүкингэмын гудамжаар галт тэрэгний буудал тийш харайлгаж өгөв. Худал- дан авагчид пиг дүүрэн, хийн дэнлүүгээр тодхон гэрэлтүүлсэн гудамжийг харахуйд хаашаа, ямар зорилгоор явж буй минь тодорхой байлаа.

Гуравдугаар зэрэглэлийн хоосон вагонд би орж суув. Тэсэхийн аргагүй удаан хүлээсний эцэст галт тэрэг алгуурхан хөдлөв. Тэрбээр балгас мэт болсон байшингуудын дундуур, гэрэл цацрах голын дээгүүр мөлхөж байлаа. Вэстлэндын замын зогсоол дээр бөөн хүн вагонд суухыг оролдох үед, галт тэргийг гагцхүү зах хүртэл тусгай чиглэлээр явж байгааг үйлчлэгч нар сануулан орилж хашгирсаар хэнийг ч дотогш оруулсангүй. Хоосон вагонд би ганцаар үлдэв. Хэдэн хормын дараа галт тэрэг зогсоолд дөхөж ирэв. Намайг буух үед цагийн I Английн яруу найрагч эмэгтэй Р.Б.Шериданы охин Кэролайн Нортон бичсэн шүлгийн нэр.

/1808-1877 он/ зүү аравт гурван хором дутуу болохыг зааж байлаа. Миний өмнө томоос том байгууламж байх агаад түүний нүүрэн тал дээр шидэт нэр гялалзана. Би орох тасалбар авах гээд зургаан пэнс олсонгүй.

Захыг хаана гэхээс айж сандарсандаа би төмөр хайсны завсраар шурган орж, ядруухан царайтай хүнд нэг шиллингээ өгөв. Төдөлгүй би томоос том танхимд орчихсон явж байлаа. Бараг бүх лангуу хаалттай байх агаад танхимын тэн хагасаас илүү нь харанхуй ажээ. Яг л сүмийн үйл ажиллагаа дууссаны дараах шиг эргэн тойронд нам гүм ноёлно. Би биеэ барьсаар захын төв рүү очив. Хэд хэдэн хүн арай нэг хаагаагүй байсан лангууны өмнө бөөгнөрч байлаа.

Өнгө өнгийн гэрлээс бүтсэн “Cafe Chantant” хэмээх үгсийн доорх хөшигний өмнө зогсч буй хоёр хүн цартай мөнгө тоолно. Зоосон мөнгө шарчигнан унаж буй чимээ сондоно. Ямар учраас ийш ирснээ сая л нэгухаарч, ойролцоо байсан нэгэн лангуу руу дөхөж очоод шаазан ваар, цэцгэн хээтэй цайны иж бүрдлийг би үзэж сонирхов. Лангууны хаалган дээр зогсох худалдагч авхай хоёр залуутай сээтэгнэж харагдана. Англи аялгуугаар ярьж буйг анзаарсан тул өөрийн мэдэлгүй ярианд нь чих тавин сонсов.

- Хөөе, би ямар ч тийм юм яриагүй шүү!

- Үгүй ээ, та хэлсэн!

- Үгүй ээ, би яриагүй!

- Тэр үнэхээр хэлсэн гэж үү?

- Тийм ээ, би өөрийн чихээр сонссон.

- Та чинь ямар худалч юм бэ!

Намайг анзаарсан уу яасан, өнөөх авхай дөхөж ирснээ,

ямар нэгэн юм худалдаж авахыг хүсч байгаа эсэхийг асуув. Түүний ярианы өнгө нэг л таалагдсангүй. Ажлын шаардлагаас болж ярьсан бололтой.

Лангууны үүдний хоёр талд байх Дорнын хоёр харуул мэт томоос том ваар руу би гайхсан янзтай харснаа:

- Үгүй ээ, баярлалаа гэж дотроо бувтнав. Бүсгүй ямар нэгэн ваар байрыг нь сольж тавьснаа өнөөх залуус дээр эргэн очив.

Тэд дахин өнөөх л сэдвээрээ ярьж гарцгаана. Тэрээр нэг хоёр удаа над руу эргэж харав. Би лангууны дэргэд зогсч, түүний бараа миний сонирхлыг татаж байгаа мэт дүр эсгэхийг оролдовч, энэ бүхэн ямар ч утгагүй зүйл гэдгийг мэдэрч байлаа. Дараа нь би алгуурхан эргэж захын төвийг зорив. Хоёр пеннийгээ би зургаан пэнс байсан халаасныхаа ёроол руу унагачихав. Удахгүй гэрэл унтраана шүү! гэж хэн нэгэн хүний орилох дуун сонсдов.

Байгууламжийн дээд хэсэгт туйлын харанхуй байлаа. Тэрхүү харанхуйн зүг ширтэхдээ би, дэндүү их нэрэлхүү зандаа автан, доромжлогдсон амьтан мэт өөрийгөө олж харуут, уур, гомдол хоёр нэгэн зэрэг нүдийг минь өвч бүрхэж билээ.

## Эвэли

Үдшийн бүрий гудамж талбайг хэрхэн эзэгнэж буйг тэр харсаар цонхны дэргэд сууна. Түүнийг толгойгоо хөшигруу наамагц тоостой зузаан даавууны үнэр ханхийв. Саялядарснаа мэдрэв. Гудамжаар холхих хүмүүс тун цөөн ажээ. Сүүлчийн байрны оршин суугч гэррүүгээ оров.

Түүний шаахай цементэн замаар хэрхэн түчигнэж, дараа нь улаан байрнуудын дэргэдэх жимээр хүржигнэх чимээг тэр сонсоно. Урьд өмнө тэнд үдэш оройн цагаар хүүхдүүдийн тоглодог байсан хоосон газар байв. Дараа нь Бэлфастаас ирсэн хэн нэгэн хүн тэрхүүхоосон газрыг худалдан авч, тэдний нэгэн адил бяцхан бараан бус харин улаан тоосгоор барьсан, гялалзсан дээвэртэй байшингуудыг барьж босгов. Дивайныхан, Уотэрсынхон, Даннынхан, бяцхан зэрэмдэг жаал хүү Кьюу зэрэг тэндхийн хүүхдүүд ах, эгч нарын хамт урьд нь тэрхүү газар тоглож өсөцгөөсөн юм.

Харин Эрнстийн хувьд том болчихсон байсан тул тоглодоггүй байв. Аав минь үүргэнтийн саваагаа барьчихсан байнга л тэдний араас даган сул газраар хөөцөлдөж байдагсан гэвч бяцхан Кьюу аавыг минь харуутаа бүгдэд хашгирч хэл хүргэдэг байв. Тэр үе ч сайхан байж дээ! Аав минь яаж ийгээд л болгодог байсан; үүнээс гадна ээж минь ч эрүүл саруул байлаа. Энэ бүхэн эрт дээр үед байж дээ; эдүгээ тэр болон ах дүүс нь бүгд өсч том болцгоосон; ээж маань өнгөрчихсөн, Тиззи Данн ч мөн адил. Харин Уотэрсынхан Англи руу буцаад нүүчихсэн. Бүх юм өөрчлөгдөж байна. Харин одоо тэр удахгүй бусдын адил орон гэрээ орхин нүүх болно.

Орон гэр! Бүсгүй энэ олон жилийн туршид долоо хоног бүр шүүрдэж, цэвэрлэж байсан бүхий л танил зүйлсээ эргүүлж тойруулж харахдаа энэ их тоос шороо хаанаас гарч ирдэгт үргэлж гайхдаг байснаа эргэн дурсав. Хэзээ ч сална гэж бодож байгаагүй дэндүү дотнохон эд зүйлсээ тэр дахин хэзээ ч харахгүй байж мэднэ. Гэтэл энэ бүх он жилүүдийн туршид тэр Гэгээн Маргарита-Мария Алакок I-ийн чулуун барын зургийн дэргэд өлгөөтэй байх, шарлаж гандсан гэрэл зураг дээрх ламтны нэр усыг ердөө ч мэдэж чадсангүй. Тэрбээр аавын минь сургуулийн үеийн анд байсан юм. Зочдод түүний зургийг үзүүлэх үедээ аав минь:

- Одоо тэр Мэльбүрнд байгаа гэж хайхрамжгүй өнгөөр хэлнэ. Орон гэрээ орхин явахад тэр бэлэн байлаа. Энэ ухаалаг шийдвэр мөн үү? Орон гэрт ньтүүнд зүсэм талх, толгойхоргодох байр байгаа гэдэг нь тодорхой ч энэхүү шийдвэрийг тэр бүхий л талаас бодож үзэв. Мэдээж хэрэг ажил алба, ар гэртээ ихээхэн ажиллах шаардлагатай байсныг нуух юун. Түүнийг залуу хархүүгийн хамт оргон зугтсаныг мэдвэл дэлгүүрийнхэн юу гэх бол.

Аягүй бол түүнийг тэнэг амьтан гэнэ дээ; оронд нь хэн нэгнийг зарын дагуу ажилд авна. Хэйвэн авхай лав баярлана. Тэр үргэлж түүнээс өө хайдаг байсан юм.

- Хилл авхай, эдгээр хатагтай нар хүлээж байгааг та харахгүй байна уу?

- Хилл авхай хөгжилтэй байгаач! Ганцхан удаа надад туслачих.

Тэр лав дэлгүүрийн тухай санах нь юу л бол? Гэвч шинэ байрандаа, үл мэдэх алс оронд бүх

юм өөрөөр эргэх<sup>1</sup> (1647-1690) Гэгээн зүрхний тахил буюу католик сүмийн нэлээд түгээмэл тахилыг үндэслэгч гэлэнмаа болно. Тэр үед Эвелин хүний эхнэр болсон байна.

Түүнийг хүндлэх нь тодорхой. Мэдээж хэрэг ээжтэй нь харьцаж байсан шиг түүнд яаж хандах вэ дээ. Харин одоо, дөнгөж арван есөн нас шүргэж буй тэрээр аавынхаа хатуу ширүүн зангаас үргэлж айж эмээдэг юм. Үүнээс болж түүний зүрх нь үе үе савлах болсон гэдэгт тэр итгэлтэй байлаа. Тэднийг өсч торних үед Хэрри, Эрнст нарыг зоддог байсан шигээ аав нь түүнд гар хүрч байсангүй. Яагаад гэвэл тэр охин хүүхэд байлаа; Гэвч саяхнаас тэр, гагцхүү талийгаач эхийг чинь бодоод л гар хүрэхгүй байгаа шүү! гэж айлгаж сүрдүүлэх болжээ. Харин өдгөө түүнийг өмгөөлж хамгаалах хүн нэг ч үгүй.

Эрнст нас барж, Хэрри сүмийн чимэглэлийн ажлаар энд тэнд захиалгаар ажил гүйцэтгэнэ. Үүнээс гадна бямба гараг бүр мөнгөнөөс үүдсэн хэрүүл гарахыг тэсвэрлэхийн аргагүй болжээ. Зовж олсон долоон шиллингээ тэр бүгдийг нь өгч, Хэрри ч гэсэн байгаа бүхнээ илгээж байсан ч ааваасаа мөнгө авна гэдэг хүндхэн асуудал байлаа. Охиноо тэр өөрийн гэсэн ухаангүй, үрэлгэн амьтан хэмээн адалж, зовж олсон мөнгөө зориулах хүсэлгүй байгаагаа хэлэхээс гадна олон юм ярих агаад энэ бүхэн бямба гарагийн тааламжгүй байдлаас үүдэлтэй байв. Эцсийн эцэст тэр мөнгө өгдөг байсан ч ням гарагийн оройн хоолон дээр хачирлах юм авчрах эсэхийг түүнээс байнга асууж шалгаана. Тэгэхэд тэр ухаангүй юм шиг дэлгүүрээр гүйж, бөөн хүмүүсийн дундуур арайхийн чихцэлдэж, гартаа хар савхин хэтэвчээ чангахан атгасаар худалдаа наймаа хийж, үдэш оройн цагаар бөөн юм чирсээр гэртээ харина.

Ар гэрийн ажил эрхэлж, хоёр дүүгээ асарч, цагт нь хичээлд явуулж, цагт нь хоол унд өгнө гэдэг түүний хувьд тун хүндхэн ажил байлаа. Хүндхэн ажил, хүндхэн амьдрал. Гэвч одоо тэр явахаар шийдсэн тул энэхүү амьдрал нь түүнд тийм ч муугүй мэт санагдана. Фрэнкийн хамт тэр өөр амьдрал хайхаар алс замд гарахаар шийджээ. Фрэнк бол тун эелдэг, зоригтой, даруухан залуу байв. Тэд хамтдаа оройн хөлөг онгоцоор явж, түүний эхнэр болж, Бүэнос-Айрэст амьдралаа төвхнүүлэхээр шийджээ. Түүнтэй тааралдсан анхны учралаа тэр сайн санаж буй; Фрэнкийн үргэлж очдог байсан төв гудамжин дахь байранд тэр амьдардаг байж.

Энэ бүхэн хэдхэн долоон хоногийн өмнө болсон мэт санагдана. Түүнийг хашааны дэргэд зогсч байхад, саравчтай малгай нь хажуу дээрээ гарчихсан, туг үс хүрэл царай бүхий духыг нь дарсхийн тогтосон харагдсан. Дараа нь тэд танилцав. Орой бүхэн тэр дэлгүүрийн үүдэнд түүнийг угтаж, гэр рүү нь дөхүүлж өгнө. Нэгэн удаа тэд “Цыган бүсгүй”<sup>1</sup>-г үзэхэд урьд өмнө огт сууж байгаагүй тун тухтай суудал дээр тухалсан нь өөрийн эрхгүй бахархах сэтгэлийг төрүүлж байв.

Тэр хөгжимд дуртай, муугүй дуулна. Фрэнкийг араас нь гүйж байгааг бүгд мэддэг байсан агаад далайчин<sup>2</sup> эрд дурласан бүсгүйн тухай дуугаа дуулж өгөхөд нь, түүнд тун сайхан мэдрэмж төрдөг байжээ. Түүнийг тэр, Намуунаа гэж тоглоом шог лоомоор дуудна.

Эхэндээ бүсгүйд шүтэн бишрэгч гарч ирсэн мэт санагдсан ч, дараа нь тэр өөрт нь таалагдаж эхлэв. Залуу эр харь нутгийн тухай олонтаа ярьж өгдөг байв. Тэрбээр Канад руу зорчдог<sup>1</sup> М.Сэрвантэсийн өгуүллэгийн санаагаар Ирландын хөгжмийн зохиолч, дуурийн дуучин М.У.Болфын олонд түгсэн дуурь /1808-1870/

2 “Далайчны найз бүсгүй”, Английн хөгжмийн болон жүжгийн зохиолч Чарльз Дибдины дуу /1745-1814/ Аллэны1 шугамд идэр далайчнаар ажилд орж, сардаа нэг фунтын цалин авдаг байжээ. Бүсгүйд тэр ажиллаж байсан янз бүрийн (юнга) шугамныхаа олон төрлийн хөлөг онгоцны нэрсийг дэс дараагаар нь хэлж өгнө. Нэгэн удаа тэр Нагланы хоолойд аялж байхдаа аймшигт патагончуудтай тулгарснаа түүнд ярьж өгөв. Түүний хэлснээр бол, Бүэнос-Айрэст тэр бүрмөсөн төвхнөж, эх орондоо гагцхүү амралтаараа ирсэн аж. Аав нь мэдээж бүхнийг олж мэдээд тэр залуугийн тухай бодохыг ч хориглов.

- Би тэр далайчдыг чинь мэднэ ээ! гэж тэр хэлнэ.

Нэгэн удаа аав нь Фрэнктэй ам мурийснаас хойш хайртай залуутайгаа нууцхан уулзахаас өөр аргагүйд хүрэв. Үдшийн гудамж улам бүр өтгөрнө. Түүний өвдөг дээр хэвтэх хоёр захидал дээрх цагаан толбо байдгаараа нүүв. Нэг нь Херрид, нөгөөх нь эцэгтээ хандсан захидал. Түүний хайртай дүү Эрнст гэлээ ч Херрид ч бас хайртай байлаа.

Сүүлийн үед аав нь эрс хөгширсөн тул хаяахан түүнийг үгүйлэх нь мэдээж. Заримдаа тэр тун чиг эелдэг байдагсан. Саяхан түүнийг өвчтэй, оронд хэвтэж байхад нь тэр хий үзэгдлийн тухай өгүүллэг уншиж, хатаамал талх шарж өгчээ.

Басхүү ээжийг нь амьд байхад тэд Хаут-Хилл2 рүү амрахаар явцгааж байснаа санав. Ээжийнх нь малгайг толгой дээрээ тавьчихаад, аав нь хэрхэн хүүхдүүдээ хөгжөөж байсныг тэр эргэн санав. Цаг явсаар байтал тэрээр тоостой зузаан даавууны үнэрийг амьсгалсаар, толгойгоо хөшиг рүүгээ нааж, цонхны дэргэд суусаар байлаа.

1 Канад АНУ-тай Английг нэгтгэдэг усан зам

2 Дублины тохойн эрэг дээрх нэг их томгүй уул

Гудамжны тэртээх өнцгөөс эгшигт хайрцгийн дуун сонсдоно. Тэрхүү аялгуу тун дотно байж. Эгшигт хайрцаг чухам юуны учир энэхүү үдэш дуугарах болсон нь тун хачирхалтай. Аль эсвэл орон гэрээ удаан хугацаагаар орхихгүй гэж ээждээ өгч байсан тэрхүү амлалтыг нь сануулах гэсэн юм болов уу. Ээжийгээ нас барахын өмнөх шөнийг тэр эргэн санав: Түүнийг үүдний өрөөний эсрэг талын умгархан өрөөнд байхад нь гудамжинд гунигт итали аялгуу эгшиглэж байлаа. Эгшигт хайрцаг тоглуулагчид зургаан пэнс төлж тэндээс явахыг шаардаж билээ.

- Новшийн италичууд. Энд ч бас хүрээд ирчихэж! хэмээн тун хэгжүүн байдалтай өрөө рүү орж ирээд хэлж байснаа тэр санав.

Түүний өмнө бий болсон ээжийнх нь үл анзаарагдам хохирлоор дүүрэн амьдрал утга учиргүй байдлаар төгсч буй нь уйтгарт автуулна. Ээжийнхээ хоолойг дахин сонсуут, тэр зогтусан чичирхийлснээ: “Өвдөж шаналсан таашаалд дуусах цаг ирсэн. Өвдөж шаналсан таашаалд дуусах цаг ирсэн” хэмээх үгсийг сонсов. Тэрээр айж балмагдснаасаа болж огло харайн босно. Зугтах! Зугтах хэрэгтэй. Фрэнк түүнийг аварна. Тэр түүнд амьдрал, магадгүй хайраа ч бас зориулж мэдэх юм. Бүсгүй амьдрахыг хүснэ. Чухам яагаад тэр азгүй нэгэн байх учиртай гэж? Түүнд ч бас аз жаргалтай байх эрх бий. Фрэнк түүнийг энгэртээ нааж энхрийлэх болно.

Түүнийг тэр л аварна. Бүсгүй хүн хөл ихтэй Норт-Уоллын усан зогсоол дээр зогсоно. Тэд гар гараасаа атгалцан зогсох агаад эцэс төгсгөлгүй аяллын тухай түүний ямар нэгэн юм ярьж буйг нь сонсч байлаа.

Усан зогсоол дээр үүргэвч үүрсэн цэргүүд холхино.

Танхимын өргөн хаалгаар гэрэл тусган зогсох нүсэр том усан онгоц байхыг тэр олж харав. Юу ч дуугарсангүй. Гагцхүү хацар нь даарч, хөхөрч байгааг мэдэрч байсан агаад бурхан түүнд ухаан хайрлаж, ямар үүрэгтэй болохыг нь зааж өгөхийг хүсч, байж суух газраа олж ядан залбирч байлаа. Манан дунд зогсох хөлөг онгоц үргэлжилсэн, залхмаар дуут дохио өгөв. Хэрэв тэр явбал, маргааш гэхэд Фрэнкийн хамт Бүэнос-Айрэсийг чиглэн задгай далайд хөвж байх болно.

Тасалбар аль хэдийнэ авчихсан байв. Түүний төлөө тэр ийм их зүйл хийж байхад энэ бүхнээс ухарч болно гэж үү? Харууссан байдлаас болж дотор нь муухайрч тэрээр үг дуугүйхэн, халуухан залбирал үйлдэж, зогсоо зайгүй бувтнаж байлаа. Хонхны чимээ зүрхийг нь зүсэх шиг болов. Фрэнк түүний гараас атгасныг тэр мэдрэв.

- Явцгаая!

Далайн давалгаа зүрх сэтгэлийг нь тойрон давалгаалж байлаа. Түүнийг тэр хөлгүй их далай руу чангааж байна; түүнийг тэр живүүлэх болно. Бүсгүй төмөр бариулаас тас зуурав.

- Явцгаая!

- Үгүй ээ! Үгүй! Үгүй! Энэ байж боломгүй зүйл. Түүний гар байдаг чадлаараа бариулаас зуурч байлаа. Тэрээр өөрийг нь залгих гэж буй хөлгүй их далай руу харууслын чарлааныг чулуудав.

- Эвэлин! Эвэ!

Фрэнкхаалтнаас цааш гүйн одохдоо араасаа түүнийг дуудсаар байлаа. Хэн нэгэн хүн түүнрүү хашгирсан ч тэр дуудсаар байх авай. Хүссэн ч, эс хүссэн ч яг л хүчин мөхөс амьтан лугаа адил түүнрүү бүсгүй цонхийсон царайгаар эргэн харав.

Залууг тэр хайрын бус, салж хагацсан бусул таних харцаар ширтэж байлаа.

## Уралдааны дараа

Машиныуд Дублиныг чиглэн Наасын замаар мөхлөг мэт жигдхэн уруудаж байлаа. Инчикорын толгойн хяр дээр замын хоёр талаар эргэн ирж буй машинуудыг харан зугаацахыг хүссэн хүмүүс хэсэг бүлгээрээ зогсоцгооно. Энэхүү үгээгүй ядуу хийгээд зогсонги байдлын сувгаар өөрсдийн эд баялаг, оньсон хүрдийг эх газраас зөөж байлаа. Тиймээс ч дарлагдсан авч хүлээн зөвшөөрч буй ирландчуудын баярын уухай хаа сайгүй сонсдоно.

Угтаа тэд франц нөхдийнхөө хөх өнгийн уралдааны машинуудыг дэмжиж байлаа. Францчуудын хувьд бараг л баараггүй ялагчаар тодрох боломжтой байв. Тэдний цуваа барианд эв нэгдэлтэй орж ирэв; тэд хоёр, гуравдугаар байр эзэлсэн бол, ялалт байгуулсан герман машины жолооч сураг сонсохнээ бельги эр юмсанж. Толгойн хярд хүрсэн хөх өнгийн машин бүрийг хоёр дахин илүү уухайлан дэмжсээр угтах агаад машинд сууж байсан хүмүүс энэ бүхний хариуд инээмсэглэл хийгээд гараараа даллан хариу барих авай.

Нэгэн ганган хөх машинд сууж байсан бүлэг залуусын сэтгэлийн хөдөлгөөн франц соёлын хүндэтгэлээр дан ганц тайлбарлагдаж байсангүй; залуус бараг л сэтгэл дүүрэн байсан гэж хэлж болно. Тэд дөрвүүл байлаа. Машины эзэн канад гаралтай залуу Шарль Сэгүэн, цахилгаанчин Андрэ Ривьер; Виллона хэмээх үлэмж биетэй унгар эр, мөн Доил гэгч тол ийсон гялгар залуу нар байв.

Сэгүэны тун сайхан ааштай байсан нь гэнэтхэн хэд хэдэн машины захиалгын хөлс урьдчилж авсантай нь холбоотой аж.

(Тэрбээр Парист машин зардаг пүүс нээхээр зэхэж байв), харин Ривьерийн хувьд тус пүүсийн удирдах албанд томилогдоно гэдэгтээ итгэл төгс тун сайхан зантай байлаа; үүнээс гадна тэр хоёр (тэд үеэлүүд аж) франц машин түрүү авсан явдалд өндөр сэтгэгдэлтэй байлаа.

Подхийтэл хооллосон учраас Виллоны хувьд сэтгэл өег байсан бөгөөд ер нь байгаа байдлаасаа тэр өөдрөг нөхөр юм. Дөрөв дэх эрийн тухайд бол, чин сэтгэлээсээ баярлахаас илүү дэндүү их балмагдсан байжээ. Тэрбээр хорин зургаан настай, улаан шаргал сахалтай, бага зэрэг гэнэндүү саарал нүдтэй нэгэн аж. Түүний эцэг жинхэнэ үндсэрхэг үзэлтнээр амьдралаа эхэлсэн авч төдөлгүй үзэл бодлоо өөрчилсөн юм. Кингстаунд тэр махны худалдаа эрхэлж нэлээдгүй хөрөнгө цутуулж, Дублин хийгээд ойр орчмын сууринд хэд хэдэн лангуу нээжээ. Үүнээс гадна түүнд хэд хэдэн даатгалын шагнал авах аз тохиосон агаад эцэст нь тэр хагартлаа баяжсан тул Дублины сонинууд түүнийг худалдааны том газрын эзэн хэмээн өргөмжлөх болсон юм.

Өөрийн хүүг тэр Английн католик шашны томоохон сургуульд сургахаар явуулж, дараа нь эрх зүйч болгохоор Дублины Их сургуульд оруулжээ. Харин Жиммийн хувьд нэг их хичээнгүйлэн суралцсангүй. Чингээд зогсолгүй хэсэг зуур замаасаа хазайсан ч явдал бий. Тэр үргэлж мөнгөтэй байх тул л түүнийг бүгд хайрлана; бас хөгжим, машин сонирхоно. Дараа нь хүүгээ газар орон үзүүлэхээр хагас жилийн хугацаатай Кэмбриж рүү явуулжээ.

1 Их Британийн Эзэнт гүрний хүрээнд Ирландыг өөрөө өөрийгөө тодорхойлохыг шаардаж байсан гомрульчуудын намын гишүүн Эцэг нь түүнд юу ч хэлдэггүй байсан нь амьхандаа



хүүгийнхээ үрэлгэн зангаар бахархдаг байсных аж. Ямар сайндаа л Жиммийн тавьсан өрийг дарчихаад гэртээ авчирч байхав дээ. Кэмбрижэд байхдаа тэр Сэгүүнтэй танилцсан юм. Тэдний хооронд мундаг нөхөрлөл хэзээ ч байгаагүй ч, энэ яваа насандаа дэндүү их зүйл үзэж харсан хүнтэй хамт байх нь Жиммид таалагддаг байв. Сураг сонсохнээ, Францын томоохон зочид буудлын нэгийг тэр эзэмшдэг ажээ.

Хэдийгээр тэр нэг их сэтгэл татам, яриад байх хүн биш ч тийм хүнтэй (эцэг нь ч бас тиймэрхүү сэтгэгдэлтэй байв) анд нөхдийн харилцаа тогтоох нь зүйд нийцэж байлаа. Виллоны хамт байхад ч мөн уйдна гэж үгүй. Тэр дэндүү гялалзсан төгөлдөр хуурч байсан ч, харамсалтай нь маш ядуу нэгэн. Инээд цолгиулан давхих залуусын машин гудамжаар сүлжинэ. Үеэлүүд урд суудал дээр сууна. Жимми, унгар залуугийн хамт ар талын суудал дээр тухална. Виллона тун сайхан ааштай байсан нь сайн хэрэг байв; бүх л бүтэн бээрийн турш тэр баргил бүдүүн хоолойгоор ямар нэгэн ая хүнгэнүүлж явлаа.

Урд суудал дээрээс францчуудын хошин шогийн торгон мэдрэмж тодорч тэдний инээд наргиан сонсоно. Жимми наргианыг ойлгох гэж байнга урагш тонголзоно. Энэ нь нэг л эвтэйхэн бус байх тул цаг үргэлж утга санааг нь тааж, замын салхины өөдөөс хариу үгүй хашгирах шахна. Түүнээс гадна Виллоны хүнгэнэх чимээнээс болж мангуурч мэдэхээр байснаас гадна хөдөлгүүрийн дуу ч гэж жигтэйхэн байлаа. Энэ үеэр мөн алдар хүнд, үлэмж хэмжээний мөнгөтэй болсон ямар ч хүн нээлттэй орон зайгаар хөдөлсөндөө сэтгэлээ тэнийхийг мэдэрнэ. Эдгээр гурван нөлөө бүхий хүчин зүйл Жиммийн сэтгэлийн хөдөлгөөнийг илтгэнэм.

Энэ өдөр ихэнх танилууд нь түүнийг эх газраас ирсэн хүмүүсийн дунд байхыг харж байлаа. Гараанд гарахын өмнө Сэгүүн уралдаанд оролцогч нэгэн франц эртэй Жиммийг танилцуулсан агаад түүнийг эв хавгүйхэн найр тавьсны хариуд уралдаанч эрийн хөрслөг бор царайд цагаахан шүднүүд гялалзав. Иймэрхүү нэр хүндийг олоод тун таатай байхаас гадна үзэгчдийн ертөнц рүү эргэн ирэхдээ тохойлдон ёврох, олон харцтай тулгарахыг мэдрэх нь тааламжит сэтгэгдэл төрүүлнэ. Мөнгөний тухайд бол мөн чанартаа тэр ихээхэн хэмжээний хөрөнгөтэй нэгэн. Сэгүүнд энэ нь их биш санагдаж болох авч цаг зуурын төөрөгдөлд автсан Жиммийн хувьд л бүхнийг олж авахын тулд ямар их хөдөлмөр орсныг тэр тун сайн ойлгож байлаа.

Цагтаа түүний тавьсан энэ бүх өр шир үрэлгэн занг нь боломжийн хэмжээнд хазаарлаж байсан бол, тэрхүү мөнгөнд ямар их хөдөлмөр шингэснийг сайтар ухамсарлаж байсан бол, өндөр боловсролтой залуу хөвгүүний зугаа цэнгэлийн асуудлыг авч үзвэл, байгаа хөрөнгөнийхөө ихэнх хэсгийг тэр эрсдэлд оруулахаар шийдсэн байна. Түүний хувьд энэ тун чухал асуудал.

Мэдээж хэрэг андлал, нөхөрлөлийн төлөө Ирланд эрийн оруулж буй хандив концерны хуримтлалд орсон байх болно гэсэн итгэлийг Сэгүүн төрүүлж чадсан юм. Жиммийн хувьд худалдааны ажил төрөлд гярхай мэдрэмжтэй эцгээ хүндэлж байв. Гэтэл эцэг нь хувь эзэмших тухайд түрүүлж ам нээв; чийчааны үйлдвэрлэлд хөрөнгө оруулна гэдэг мэдээж хэрэг ашигтай ажил. Үүнээс гадна Сэгүүн дээр эд баялгийн тамга дараастай байв. Ажлын өдөр унаж буй тансаг машиныхаа төлбөрийг Жимми шилжүүлэхээр болов. Ямар хөнгөн явдалтай гээч! Тэд ямар гайхамшигтай хурдаар давхин одсон гээч! Тэрхүү машины явдал зүрхний цохилтод

шидэт мутраар хүрч, хүмүүний мэдрэлийн үйл ажиллагааны оньсон түлхүүр ч тэрхүү хөх араатныг дүүлэх агшинд тун уриалгахан хариу барина.

Тэд Дэймийн гудамжаар явж байлаа. Тэндхийн замын хөдөлгөөн нэлээд ширүүн байх агаад машины дуут дохионы чимээ хийгээд тэвчээргүй трамбайн хонхон дуун хаа сайгүй сонсдоно. Сэгүүныг банкны дэргэд тоормос гишгүүт, анд нөхрийн хамт Жимми машинаас буув. Хэрэгт дуртай хэсэг хүмүүс гудамжинд цугларч чамин ганган хийцийн тэрэгнүүдийг сониучирхан зогсоцгооно. Найзууд Сэгүүны буусан буудалд оройн зоог барихаар тохиролцов. Харин одоо Жимми гэрт нь амьдарч байсан найзынхаа хамт хувцсаа солихоор явах ёстой. Машин Грэфтоны гудамжийг чиглэн хөдлөх үед залуус амаа ангайсан бөөн хүний дундуур чихцэлдэн явцгаав.

Хойд зүгийг зорихдоо тэд хоёр зээрдээрээ явах нь нэг их тааламжтай явдал бус гэдгийг мэдрэхүйд зуны үдшийн утаан дундах Дублин хотын хувхай цайсан гэрлийн бөмбөлгүүд энд тэндгүй өлгөөстэй. Жиммийн гэрийнхний хувьд энэхүү оройн зоог тун их онцгой үйл явдал байлаа. Бахархах сэтгэл эцгийнх нь сэтгэлийн хөдөлгөөнтэй нийлэхүйд аливаа хүслийг дур мэдэн гүйцэлдүүлмээр санагдана.

Аугаа эх газарт орших нийслэл хотуудын нэр ус энэхүү хүслийг өдөөгч өөрийн гэсэн мөн чанарыгагуулдаг. Гоёлын хар хослолтой Жимми задгай танхимд зогсч, цагаан зангианыхаа үзүүрийг сүүлчийн удаа тэгшлэх үед, түүний эцэг ямар нэгэн

амжилттай наймаа хийсэн мэт сэтгэл хангалуун зогсоно. Хүүдээ өгсөн түүний зан чанарыг хэзээ ч мөнгөөр худалдаж авч болохгүй билээ. Тиймээс эцэг нь Виллонад тун найрсгаар хандаж, гаднаа гяланцаг байдлын өмнө чин сэтгэлээсээ хүндэтгэл илэрхийлж буйгаа байдлаараа илтгэнэ; гэвч гэрийн эзний ялдам зан хооллох хүсэлдээ дэндүү их автсан унгар эрийн хувьд үгүй болсон бололтой. Оройн зоог тун гайхалтай сайхан болж өнгөрөв.

Сэгүүн бол тасархай мэдрэмжтэй хүн юм гэж Жимми бодов. Найзуудын цугларалт дээр Раут хэмээх залуухан англи эр нэгдэв. Жимми түүнийг өмнө нь Сэгүүний Кэмбриж дэх гэрт харж байсан аж. Залуус цахилгаан дэнлүүгээр нэвг гэрэлтүүлсэн жижигхэн, тохилог танхимд оройн зоог барив. Бүгд л хэрэгтэй хэрэггүй юм чалчиж байлаа. Хоосон санаа өвөрлөсөн Жимми англи хийцийн хатуухан хэлхээтэй ясанд хоёр үеэлийн франц маягийн амьд байдал ямар сайхан сүлэлдэж буйг дотроо төсөөлнө.

Тун сайхан үнэн дүр зураг юм гэж тэр бодов. Гэрийн залуу эзэн ярианы сэдвийг хэрхэн чиглүүлж буйг хараад сэргэлэн занг нь биширч байлаа. Тэр тавын хувьд янз бүрийн хүсэл сонирхолтой тул яриа нийлэхгүй зовооно. Виллоны хувьд, хөнгөн бодолд автуулах английн хошин дууны гоо сайхныг тун хүндэтгэлтэйгээр мэдрүүлэхийг хичээж, хуучны зэмсгүүд байхгүй гэдгийг чадах чинээгээрээ ойлгуулахыг хүснэ. Ривьер ямар ч юм бодолгүй Францын оньсон хүрдийн амжилтын тухай Жиммитэй ярьж гарав. Унгар эрийн бүдүүн баргил дуун романтизмыг баримтлагч зураачдын болсон болоогүй зургийг гутаан доромжилж эхлэх үед, ярианы сэдвийг Сэгүүн улс төр рүү чиглүүлж, бүгд дахин амилцгаав.

Юу ч болсон хамаагүй хэмээн бодож байсан ч түүний дотор нойрсч байсан эцгийнх нь омголон зан хөдөлж ноомой Раутыг тэр хөдөлгөөнд оруулж чадав. Өрөөн доторх уур амьсгал

нэлээд ширүүсч Сэгүэний хувьд тун хүндхэн байдалд оров. Дэгдсэн маргаан хэрүүл болж мэдэхээр байлаа. Хамгийн эхний боломж гармагц л сүйхээтэй гэрийн эзэн хүмүүн төрөлхтний төлөө хундага өргөж, бүгд ерөөл талбин босохуйд цонхоо байдгаар нь нээв. Тэр шөнө Дүблин нийслэл хотын чимгээ зүүсэн байлаа.

Таван залуу Стивэнз Грины<sup>1</sup> хөвөн зөөлөн үүлс бүхий анхилуун үнэрт утаан дундуур аядуухан явцгаана. Тэд чанга ярилцан хөгжилдөн инээлдэцгээж, тэдний цув мөрнөөс нь чөлөөтэй унжиж байлаа. Гудамжинд өнгөрсөн хүмүүс тэдэнд зам тавьж өгнө. Грэфтоны гудамжны өнцөг дээр намхан нуруутай тарган эр, хээнцэр хувцасласан хоёр эмэгтэйг машинд суулгах үед жолооны ард бас өөр нэгэн тарган нөхөр сууж харагдана. Машин хөдлөхөд тарган эр залуусын зүг харав.

- Андрэ!

- Тийм ээ, энэ чинь Фарли байна шүү дээ!

Үүний араас ямар ч холбоосгүй бөөн үгс урсгаж гарав. Фарли бол америк хүн. Юун тухай ярьж буйг хэн ч сайн мэдсэнгүй. Виллона, Ривьер хоёр илүү их дуу шуутай байсан бол бусад нь нэлээдгүй сэтгэл хөдлөсөн байдалтай байлаа. Тэд чанга чанга хөхрөлдсөөр машинд сууцгаав. Өдгөө тэд хөгжилтэй хонхон дууны чимээн дор хөнгөхөн харуй бүрийд уусаж буй хэсэг бүлэг хүмүүсийн дэргэдүүр явж өнгөрөв.

<sup>1</sup> Дүблины төв дэх цэцэрлэгт хүрээлэн

Уэстлэндын замын зогсоолоос тэд галт тэргэнд суухад, хэдхэн мөчийн дараа Кингстауны галт тэрэгний зогсоол дээр бууж байгаа мэт Жиммид санагджээ.

Өвгөн хянагч Жиммид хандан мэхийн ёслоод:

- Эрхэм ээ, тун сайхан шөнө байна шүү! гэв. Зуны шөнө намуухан агаад усан зогсоол яг л бараантан харагдах толь мэт тэдний хөлийн өмнө хэвтэнэ. Тэд гар гараасаа барилцан доош буухдаа “Cadet RousseP-ийг бөөнөөр дуулж: “Ho! Ho! Hohe vraiment!”<sup>2</sup> гэх бүрийдээ нэгэн зэрэг дороо дэвсэлцгээнэ. Усан зогсоол дээр тэд завинд сууцгааж, америк эрийн хөлөг онгоц руу сэлүүрдэж. Тэднийг тэнд оройн зоог, дуу хөгжим, хөзөр сэлт хүлээж байлаа.

Виллона тун сэтгэл хөдөлсөн байдалтай:

- Энэ бол гайхамшиг! хэмээв. Хөлөг онгоцны өрөөнд төгөлдөр хуур байна. Фарли, Ривьер нарт зориулж Виллона вальсын ая тоглов; Фарли эр нь, Ривьер бүсгүй нь болж бүжиглэлээ. Дараа нь шуудхан “Кадрилийг” тоглох үед залуус шинэ дүрүүд санаанаасаа зохиоцгоов. Ямар их баяр баясал вэ? Жимми ч бүхий л тоглоомд уухайлан оролцоно; амьдрал гэж энэ л байх даа! Дараа нь Харли амьсгаагаа дарж ядан байж: “Зогс!” хэмээн хашгирав. Зөөгч эр оройн хөнгөн зоог авчрахад залуус ширээний ард сууцгаалаа. Чингээд тэд ёстой нэг зад авчээ.

Ирланд, Англи, Франц, Унгар, Америкийн Нэгдсэн Улсын телее тэд хундага харшуулж байлаа. Урт удаан, нуршсан үгнийхээ дундуур Жиммийг завсарлага авах үед нь Виллона<sup>1</sup>

XVIII зуунд бичигдсэн Францын цэргийн хорооны дуу.

Зохиогч нь тодорхойгүй.

2 Хүүе! Хүүе! үнэн хэрэгтээ. /франц/ түүнийг дэмжин: “Зөв, зөв” хэмээн тоть шиг давтана. Түүнийг яриагаа дуусгахад бүгд л удаан гэгч алга нижигнүүлэн нь ташицгаав.

Бодвол нэлээд дажгүй үг хэлсэн бололтой. Фарли түүний мөрөн дээр алгадаж чангаас чанга хөхрөв. Хөгжилтэй хамт олон, тэдэнтэй байхад ямар сайхан юм бэ? Хөзөр! Хөзөр! Ширээг цэвэрлэв. Виллона төгөлдөр хуур руу очиж намуухан аяз тоглоно. Бусад нь хөзөрдөж гарав. Тэд дөрвөлжин, цэцгийн хатны эрүүл мэндийн төлөө ууцгаалаа. Харамсалтай нь тэдний яриаг хэн ч сонсохгүй байгааг бодоод Жимми бага зэрэг харуусалд автав. Тоглоом оргилдоо хүрч, мөнгөн дэвсгэртүүд нааш цааш сүлжилдэнэ. Мөн чанартаа хэн хожоод байгааг Жимми сайн мэдэхгүй байвч ямар ч гэсэн тэр хожигдож байлаа.

Энэ бүхэнд тэр өөрөө л буруутай. Байнга хөзрөө андуурч, хамтрагчид нь түүний өмнөөс хэдийг төлөх ёстойг нь хүртэл бодоход хүрч байв. Тэнд байхад уйдаах зүйл ер гараагүй ч хурдхан л дуусгаасай билээ, орой болж байна. Хэн нэг нь “Ньюнортын үзэсгэлэн” хэмээх хөлөг онгоцны төлөө ерөөл айлдахад, дараа нь бас хэн нэгэн “сүүлчийн боолт” хийе! гэж санал гаргав. Төгөлдөр хуур дуугаа хураав; бодвол Виллона тавцан дээр гарсан бололтой. Сүүлчийн тоглолт нэлээд ширүүхэн өрнөв. Дуусахаас нь өмнө тэд түр азнаж, аз жаргалыг бэлгэдэн урд урдахаа хөнтөрцгөөв.

Раут, Сэгүүн хоёрыг хоорондоо үзэлцэж байна гэдгийг Жимми ойлгов. Ямар их сэтгэлийн хөдлөл вэ? Жиммийн сэтгэл ч мөн хөдөлж байлаа. Тэр хожигдох нь гарцаагүй. Ингэхэд хэдийг төлөх болж байна аа? Тоглоомчид сүүлчийн бооцоог

авахын тулд бүгд улайран зогсоогоор тоглож, гар хуруугаараа занган өөр хоорондоо маргалдана. Раут хожив. Хөлөг онгоц, “Хурай” хэмээх олны хашгираанаас болж доргиход хөзрийг цуглуулав. Дараа нь тэд тооцоогоо хийв. Фарли, Жимми хоёр бусдаас илүү алджээ. Өглөө тэр алдсан мөнгөндөө харамсана гэдгээ мэдэж байв. Гэвч одоо бол бусдын өмнөөс баярлана. Тэрбээр өөрийгөө хянах чадваргүй болсон байлаа. Ширээ тохойлдон толгойгоо базлан суухдаа тэр зүрхнийхээ цохилтыг тоолно. Өрөөний хаалга нээгдэж, довжоон дээр гэрэл тусахуйд унгар эрийг тэр олж харав.

- Эрхмүүд ээ, үүр цайчихлаа!

## Эрэлхэг хоёр

Наймдугаар сарын намуухан үдшийн бүрий хотыг нөмөрч, зөөлөн сэвшээ салхи өнгөрч буй зуны үдэлтийн мэндийг дэвшүүлэн гудамжаар эргэлдэнэ. Бүтэн сайн өдрийнх шиг бүгд хаалттай байх шилэн лангуу бүхий гудамжинд баярын өмсгөлтэй бөөн хүн буцалж байв. Гудамжны дэнлүүнүүд яг л эрдэнэс мэт өндөр багануудын орой дээрээс өнгө, хэлбэрээ тасралтгүй өөрчилж, урин дулаан үдшийн бүрийг хэзээ ч өөрчлөгдөхгүй, үл тасрах нүргээнээр илэрхийлж, дор дэрвэх даавуун дээр гэрэлтэнэ. Хоёр залуу Ратлэндын цэцэрлэгт гудамж бүхий уулын бэлээр явна. Тэдний нэг урт удаан яриагаа өндөрлөж байв. Харин нөгөөх нь явган хүний замын өнцгөөр явахдаа хамт яваа нөхрийн гайхшийг барж, гудамжны засмал зам руу үсрэн буугаад түүний яриаг таашаангуй, анхааралтайхан сонсоно.

Тэрбээр тоодгор хийгээд улаан хацартай нэгэн байлаа. Түүний өмссөн Саравчтай малгай дагзан дээр нь тогтох агаад тэр дэндүү хичээнгүйлэн сонсч байсан тул хэлсэн үг болгон нь түүний нүүрэн дээр илэрнэ. Энэ үеэр хөмсөг, хамрын угалз, амных нь амсар зэрэг чичирхийлж байлаа. Түүний хатингар биеэс шүгэлдэх мэт инээд огцом тасрах авай. Нүд нь баяр хөөртэй, зальжин маягтай ирмэх зуур, хором бүр л замын нөхрийн нүүр рүү тэр харж явав. Тэрбээр нэг мөрөн дээрээ тохсон бухтай тулалдагчийнх мэт хөнгөхөн цуваа хоёр, гурван ч удаа засаадхав. Түүний өмдний хийц, эрзээнэн ултай цагаан шаахай, эрэмгий маягаар тэрлэсэн цув нь залуу насны тухай нэгийг өгүүлнэ.

Гэвч бие нь эв хавгүй хэлбэрийг олж, цөөн тооны хэдэн буурал үснээс гадна мэдрэхүйн давалгаа түүнээс зугтан одохуйд царай нь нэлээд түгшсэн, ядрангуй байдалтай болж байлаа. Түүний яриа дууссан гэдэгт итгэмэгц, тэрбээр үл сонсогдох инээдээ барьж ядан бараг л хагас хором шахуу элгээ хөштөл инээжээ.

- Чи ойлгож байна уу? Энэ бол жинхэнэ тоглолт байна шүү! гэж дараа нь тэр хэлэв. Түүний хоолой бараг бүхий л чадлаа алдсан мэт санагдаж, өөрийн хэлсэн үгийг хүч оруулахын тулд тэр бага зэрэг баашлах зуураа,

- Энэ бол цорын ганц тусгай тансаг тоглолт байх болно гэж нэмж өгүүлэв. Чингэж хэлээд тэр дуугаа хурааж, албархуу царайлав. Түүний хэл ч цуцсан биз. Учир нь тэр Дорсэтийн гудамжин дахь нэгэн уушийн газар байх үеэс буюу аль үдийн хоолноос хойш ам хамхилгүй ярьж гарсан юм.

Ихэнх хүн Ленеханыг таваг долоогч хэмээн тооцсон ч өөрийн хэл яриа, сэргэлэн зангийн тусламжтайгаар тэр иймэрхүү золигийн нэр хүртсэн ч нөхдийнхөө муухай харцнаас зугтаж чадсангүй. Тэр юу ч болоогүй юм шиг уушийн газар дахь тэдний ширээ рүү дөхөж очин нүдээ унагах шахам тас ширтдэг байв, эцэс сүүлд нь аяга тагш юм хүртэх урилгыг хүлээж авна. Нэг ёсондоо тэр сайн дурын хошигногч, бөөн онигоо, оньсого зэргийн аугаа их нөөцтэй нэгэн ажээ.

Тэр нүд цавчилгүй ямар ч гомдлыг даван туулдаг байв. Ямар замаар тэр амьдралынхаа хэрэгцээг хангадаг болохыг хэн ч үл мэднэ. Гэвч түүний тухайд чих тавибаас морин уралдааны бооцоон дээр ямар нэгэн арга заль зохиодог нөхөр гэж ярих нь бий.

- Корли, чи түүнийг хаанаас олж авсан юм бэ? гэж тэр асууна. Корли дээд уруулаа хэлээрээ шилэмдэв.

- Нэгэн орой юм даа. Дэйнийн гудамжаар явж байгаад би нэг аятайхан өндөр охин Уотэрхаусын цагны дор зогсч байхыг олж харсан юм. Мэдээж хэрэг мэндлэлгүй яахав гэж тэр хэлэв.

- За тэгээд бид сувгийн дагуу явах үед, өөрийгөө тэр Бэгготын гудамжинд гэрийн үйлчлэгч хийдэгхэмээн хэлсэн юм. Би ч яахав түүнийг тэврэн авч, бага зэрэг ноолж, энд тэндээс нь базсан нь ойлгомжтой. Харин ням гарагт бид хоёр болзсон юм. Ойлгож байна уу? Бид Доннибрук явж, дараа нь би түүнийг тал руу дагуулж явсан. Надаас өмнө тэр сүүний худалдагчтай зугаалж байснаа ч ярьсан...

Найз минь, тун дажгүй шүү, чамд л гэж хэлье! Орой бүхэн тэр янжуур тамхи авчрахаас гадна трамбайд суух зардлыг минь хүртэл даана. Нэг удаа бүр "тасархай" хоёр навчин тамхи авчирсан гээд л бодчих...

Нэгдүгээр зэргийнх. Тиймэрхүү тамхийг манай өвөө л татдаг байсан... Түүнийг би жирэмсэн болчихоогүй байгаа гэж их айсан шүү! Гэвч тэр бол тэнэгхүүхэн биш байсан.

- Чамайг тэр өөртэйгөө гэрлэнэ гэж бодсон юм биш биз?

- Одоохондоо надад орох орон алга гэж түүнд би хэлсэн хэмээн Корли яриагаа үргэлжлүүлэв.

- Одоохондоо би Пимийнд1 ажиллаж байгаа гэж хэлсэн. Тэр миний нэрийг мэдэхгүй. Би ч жинхэнэ нэрээ хэлдэг тэнэг нь биш. Гэхдээ л намайг тэр цайлган сэтгэлтэй амьтан гэж бодож байгаа. Ленехан ямар ч чимээ үгүй дахин инээв.

- Би ч олон түүх сонсч байсан. Гэхдээ ийм юм болно гэж ер бодоогүй шүү! хэмээн тэр хэлэв.

1 Дүблин дэх томоохон хүнсний дэлгүүр. Ийнхүү магтсаны дараа Корлийн алхаа улам бүр далайцтай болов. Түүний үлэмж биеийн дайвалзах байдал явган хүний замаас засмал зам руу Ленеханыг хэд хэдэн хөнгөн үсрэлт хийж, эргэж буцахад хүргэв. Корли бол цагдаагийн мөрдөн байцаагчийн хүү агаад эцгийнхээ явдал, бие хааг тэр чигээр нь өвч дуурайжээ.

Тэрбээр гараа алдалж, толгойгоо нэгэн хэмээр савчин чигээрээ явна. Нэлээд махлаг, дугуй хэлбэртэй том толгой нь ямар ч цаг агаартай байсан үргэлжид хөлрөх агаад яг л салаалж ургасан сонгино шиг том дугариг бүрхээ хажуулдуулан тавьсан байлаа. Тэрбээр баярын жагсаалд оролцож байгаа мэт үргэлж чигээрээ харах бөгөөд зөрж өнгөрч буй хүмүүсийн хэн нэгнийг эргэн харахыг хүсвэл бүхий л биеэрээ эргэхээс нааш толгойгоо эргүүлж чаддаггүй байжээ.

Яг одоо бол тэр ямар ч ажилгүй нэгэн. Хаа нэг газар сул орон тоо гарч ирвэл, нөхөд нь хүртэл түүний өмнөөс ажиллахад бэлэн байдаг ажээ. Тэр үргэлж мөрдөгч нартай зугаалж, чингэхдээ хэл яриа сугалчих гээд дэмий л сэлгүүцнэ. Аливаа ажлын хөшигний цаадах явдлыг сайтар мэддэг байснаас гадна хэнийг ч үл өршөөх мэт байдлаар бусдад хандахыг хүснэ. Өөрийн хамтран ярилцагчийг ч ер хүн гэж тоолгүй ярьдаг нэгэн байлаа. Ярианы сэдвийн

дийлэнх нь тэр өөрөө байх агаад хэн нэгэнд тэгэж хэлсэн, хэн нэгэн түүнд ингэж хэлсэн, тиймээс би удахгүй энэ бүхэнд цэг тавих болно гэж ярих дуртай байв.

Энэ бүх харилцан яриаг тэр дахин дахин ярихдаа өөрийн нэрийг, ялангуяа эхний үсгэн дээр онцгой өргөлт өгч дууддаг байсныг яалтай ч билээ дээ. Ленехан найздаа янжуур тамхи санал болгов. Залуусыг олны дундуур явахад Корли хажуугаар өнгөрөх бүсгүйчүүдтэй сээтэгнэхийн тулд цаг үргэлж эргэн харж, инээмсэглэх авч Ленеханы харц том хоёр гэрлээр хүрээлсэн хувхай цайсан саран руу тэмүүлсэн байх авай. Аалзны саарал тор мэт харуй бүрий дугариг саран дээр хөвж буйг тэр бодлогошронгуй ажиглана.

- За тэгээд Корли, яах болж байна? Чамайг би энэ ажлыг зохицуулж чадна хэмээн бодож байна гэж эцэс сүүлд нь дуугарав. Үүний хариуд Корли нэг нүдээ байдгаар нь онийлгов.

- Энэ яадаг бол доо? гэж Ленехан тун эргэлзэнгүй асуув. - Хүүхнүүдтэй юу болохыг урьдчилж таахын аргагүй.

- Тэр тун сайн бүсгүй хэмээн Корли хэлэв. - Түүнтэй яаж учраа олохоо би сайн мэдэж байна. Мэдээж хэрэг надад тэр дурлачихсан байж таарна.

- Чи ч жинхэнэ Дон Жуан юм даа. Бүх Дон Жуануудын дундаас хамгийн айхтарыг нь нэрлэ гэвэл, би лав чамайгхэлнэ гэж Ленехан өгүүлэв.

Хөнгөн инээмсэглэл түүний ихэмсэг ярианы өнгийг номх- руулав. Өөрийн нэр төрийг аврахын тулд тэр үргэлж худал хэлдэг байв. Гэвч Корли тиймэрхүү нарийн ширийн зүйлийг ер ойлгодоггүй нэгэн аж.

- Гэрийн үйлчлэгч бол хамгийн новшийн ажил! гэж тэр өөртөө итгэлтэйхэн өгүүлэв.

- Надад чи итгэж болно шүү!

- Чамайг тэд нартай унтсан гэдэгт итгэхгүй гээд яах вэ? гэж Ленехан хэлэв.

- Эхэндээ би боломжийн бүсгүйчүүдтэй явдаг байсан юм гэж Корли итгэл төрүүлэм айлдав.

- Яагаав, нөгөө Өмнөд Тойргийнх1. Тэднийг би хаашаа ч юм трамбайгаар зөөхдөө1 Дублины баян дүүрэг төлбөрийг нь төлж, эсвэл хөгжим юм уу, театр руу дагуулж явахаас гадна шоколад, чихрээр дайлна, за ерөнхийдөө л нэг иймэрхүү байх шив дээ. Найз минь, тэд нарт би зориулж багагүй мөнгө зарцуулсан шүү! гэж хэлэхдээ тэр түүнийг сэжиглэн, үл итгэж байгаа мэт сүрлэг байдалтай байв.

Гэвч Ленехан түүнд итгэж байсан тул түүнийг дэмжин толгой дохив.

- Энэ новширсон явдлыг би сайн мэднэ. Зүгээр л хулхидаж байгаа юм гэж тэр хэлэв.

- Тэднээс ямар ашиг байна аа? гэж Корли өгүүлэв.

- Би захиалга өгье! гэж Ленехан дуугарав.

- Дөнгөж саяхан л нэгээс нь салсан биз дээ? хэмээн Корли цухалдлаа.

Тэрбээр хэлийнхээ үзүүрээр дээд уруулаа шилэмдэв. Түүний нүд дурсамжид автан сэргэв. Тэр ч мөн түүний адил угаан цаагуур нуугдах гэж буй бүдэгхэн, дугариг саран руу харц чулуудан бодолд автах шиг болно.

- Чи түүнийг мэдэх үү? Уг нь дажгүй бүсгүй шүү! гэж тэр харамсангуй өгүүлэв.

Тэр дахин дуугаа хураав. Дараа нь:

- Одоо ч тэр замаа алдсан даа. Саяхны нэгэн орой Эрлийн гудамжинд түүнийг хоёр залуугийн хамт машинтай явж байхыг олж харсан.

- Энэ ч бодвол чиний л хийсэн ажил биз? гэж Ленехан хэлэв.

- Надаас өмнө тэр явдалтай байсан! хэмээн Корли ухаалаг дүр эсгэв.

Энэ удаад Ленехан итгэхийг хүссэнгүй. Тэр толгой сэгсрэн инээмсэглэв.

- Корли, чи намайг хуурч чадахгүй шүү! гэж тэр хэлэв.

- Жинхэнэ үнэн үг! гэж Корли түүнийг дэмжив. -Надад тэр өөрөө хэлсэн юм.

Ленехан эмгэнэлт дохио үзүүлэв.

- Новшийн хууран мэхлэгч! гэж тэр хэлэв.

Тэднийг Тринити коллежийн хайсны дэргэдүүр явах үед, Ленехан засмал зам дээр гарч цаг руу дээш харав.

- Хорин хором! гэж тэр хэлэв.

- Амжина аа! гэж Корли тайвшруулав

. - Тэр хаашаа ч явахгүй. Түүнийг би үргэлж хүлээлгэдэг юм.

Ленехан намуухан инээмсэглэв.

- Корли, чи тэдэнтэй харьцаж чадна биз дээ? гэж тэр хэлэв.

- Би тэдний бүх арга залиг мэднэ хэмээн Корли нотлон өгүүлэв.

- Тэгвэл чи үүнийг яаж зохицуулах юм бэ? гэж Ленехан дахин хэлэв.

- Чи ойлгож байна уу? Энэ бол тун адармаатай хэрэг. Энэ тухай тэд нэг их ярих дургүй байдаг юм. Юу? Яагаад?

Тэрбээр хамт яваа нөхрийнхөө нүүр рүү хялам хийснээ, хоёр дахь нотлох баримтыг хайх мэт



гялалзсан нүдээрээ эрж хайлаа. Корли хэдэнтээ толгой сэгсэрснээ, хортон шавьжийг хөөх мэт хөмсгөө зангидав.

- Би бүхнийг зохицуулчихна. Энэ ажлыг надад даатга! гэж тэр хэлэв.

Хэрэв түүний нөхөр уурлавал ямар ч сайн юм болохгүй. Түүнийг чөтгөр рүү нь тонилгож, ямар ч зөвлөгөө авах шаардлагагүй гэж хэлэх болно. Тиймээс эвийг нь олох хэрэгтэй. Гэвч Корли удаан уурласангүй. Түүний бодол санаа өөр зүйлийг сэдсэн бололтой.

- Тэр тун дажгүй охин шүү! хэмээн хэлэв.

- Юу үнэн тэр үнэн! Тэд Нассын гудамжаар өнгөрч, дараа нь Килдерийн гудамж руу эргэв.

Клубын орцноос холгүйхэн хэд хэдэн хүмүүсээр өөрийгөө хүрээлүүлсэн босоо ятгачин гүүрэн дээр зогсоно. Тэрбээр арай ядан чавхдасыг татаж, хаяахан нэг хавь ойр зогсох хүмүүсийн нүүр рүү халыг харж, заримдаа тун ядарсан байдалтай тэнгэр өөд ширтэнэ. Түүний босоо ятганы гэр газар хэвтэх нь бусдын нүд, эзнийхээ гараас уйдаж ядарчихаа юу гэж санагдуулна. Нэг гар нь баргил өнгөөр “Мойль! минь чи намуухан байна” хэмээх аяыг тоглож байхад, нөгөөх нь хэлсэн үг болгоны дараа цангинасан дуу тоглон гүйнэ.

Гүн гүнзгий, бүрэн дүүрэн аялгуу сонсдоно. Түүний дэргэдүүр залуус чимээгүйхэн өнгөрөхдөө гашуудлын аяар үдүүлж дуугүйхэн одно. Стивэнс Грин дээр очоод тэд гудамж гатлав.

Тэндхийн трамбайн чимээ, гэрэл гэгээ хийгээд үй олон хүн дуугүй дүнбэгэр байдлаас нь тэднийг ангижруулав.

- Тэр тэнд байна! гэж Корли хэлэв.

Хьюмын гудамжны өнцөг дээр залуухан бүсгүй зогсоно. Тэрээр хөх даашинз, цагаан сүрлэн бүрхээр гоёжээ. Бүсгүй замын хашлага чулууны дэргэд зогсч шүхрээрээ даллана. Ленехан амь оров.

- Корли, би түүнийг харж болох уу? гэж тэр асуув.

Найз руугаа хяламхийн харахуйд, Корлийн нүүрэн дээр

1 Ирландын яруу найрагч Томас Мурын /1779-1852/ шүлгэнд хийсэн дууль

ёжтойхон инээмсэглэл тодров.

- Шавар хаах нь уу? гэж тэр асуув.

- Юу гэж тийм юм байх вэ? гэж Ленехан эргэлзсэн янзгүй хэлэв.

- Чамайг түүнтэй танилцуулаад өг! гэж гуйгаагүй шүү дээ. Би зүгээр л харах гэсэн юм. Түүнийг чинь би идчихгүй!

- Харахыг хүсэв үү? гэж Корли эелдэг өнгөөр хэлэв. - Тэгвэл... Би чамд нэг юм хэлье. Түүн дээр очоод би яриа өднө. Энэ үеэр чи хажуугаар өнгөрч болох юм.

- За яахав, тэгье гэж Ленехан хэлэв. Замын хажуугийн гинжин дээгүүр Корлийг хөлөө давуулах үед, Ленехан түүнд хандан:

- Дараа нь яах юм бэ? Бид хаана уулзах юм? хэмээн хашгирав.

- Арав гучийн үед! гэсээр Корли хөлөө давуулав.

- Хаана тэр вэ?

- Мэррионы гудамжны өнцөг дээр. Биднийг буцах үед.

- Битгий хэтрүүлчихээрэй! гэж Ленехан салах зуураа хэлэв. Корли юу ч хариулсангүй.

Тэрбээр яарсан шинжгүй толгойгоо нэгэн хэмээр савчуулсаар гудамж гатлан алхаж одов. Түүний том бие, далайцтай алхаа гишгээ, гутлынх нь өсгийний шийдэмгий товор товор хийх чимээнээс ямар нэгэн ялалтын дуу сонсоно. Тэрбээр бүсгүй дээр дөхөж очмогц ер мэндэлсэнгүй, шулуухан ярьж гарав. Бүсгүй ч гутлынхаа өсгий дээр гунхалзан байхдаа шүхрээ эргүүлэн даллав. Түүний зүг тонгойн юу ч юм ярихад, бүсгүй толгойгоо гудайлган инээд алдана. Хэдэн хормын туршид Ленехан тэднийг ажиглав. Дараа нь тэр гинжний дэргэдүүр яарангуй алхаж жаал яваад гудамжийг ташуу огтолж гарцгаав.

Хьюмын гудамжны өнцөг дээр ойртож очиход энгэсэгний хүчтэй үнэрийг тэр мэдэрч, тун хурдан, туршсан мэт харцаар бүсгүй харц чулуудав. Тэрээр байдгаараа гоёсон ажээ. Түүний биеийг барьсан хөх ноосон банзлын бүсэлхий дээр хар савхин бүс зүүсэн байлаа.

Томоос том мөнгөн гархи цагаан цамцных нь зөөлөн эдийг үрчийлгэх агаад түүний биеийн дунд хэсгийг дарах мэт санагдана. Тэрээр товчтой богино хар хантааз, хүзүүний үнгэгдсэн хар алчуур зүүсэн ажээ. Сүлжмэл захных нь хуниас сайтар индүүдсэн байх бөгөөд түүний цээжин дээр жижигхэн улаан цэцэгс хадаастай байлаа. Ленеханы харц намхан, булчинлаг бие дээр нь тусав.

Бүсгүйн нүүрэн дээр булцгар ягаан хацар, ичгүүр үгүй цэнхэр нүднийх нь харцанд эрүүл цовоо байдал зэрлэг маягаар цэцэглэжээ. Нүүрнийх нь төрхийг ажваас хангинуур сүх мэт гөлийсөн царайтай нэгэн байлаа. Балин хамартай, инээсээр байгаад хэлбэрээ алдсан амтай байхаас гадна дээд хоёр шүд нь урагш ёрдойж харагдана. Тэдэнтэй зэрэгцэж очмогц, Ленехан малгайгаа авч арав орчим мөчийн дараа Корли түүнд хандан орон зай тийш мэхийн ёслол.

Үүний тулд тэр бодолд автан тун шийдэмгий бусаар гараа өргөж, бүрхнийхээ байрлалыг хэдэнтээ өөрчлөв. Ленехан “Shelborn” зочид буудлын үүдэнд очуут тэнд зогсон хүлээж гарлаа. Хэсэг зуур хүлээсний эцэст, тэднийг өөдөөс нь ирж буйг тэр олж харав. Тэднийг баруун тийш эргэхэд араас нь дагаж Мэррионы цэцэрлэгт гудамжаар аажуухан алхав. Тэдний араас хөл нийлүүлэн алхахдаа тэр, бүсгүйн зүг хором бүр байн байн эргэн харах том голтой бөмбөрцөг мэт Корлийн толгой руу харна.

Тэднийг Дони-Брукийн трамбайн шатаар өгсөх хүртэл араас нь тэр дагав; чингэмэгц тэр даруйхан эргэж ирсэн замаараа буцав. Одоо тэр ганцаар үлдсэн даруйд түүний царай арай хөгшин мэт санагдана. Хөгжилтэй байдал нь түүнийг орхиж одсон бололтой. Тиймээс Дью-Лоуны дэргэдүүр явж өнгөрөхдөө тэр хайсны дээгүүр гараараа шүргэв. Босоо ятгачны тоглож байсан ая түүний хөдөлгөөнийг үл мэдэгхэнээр өөртөө татаж байлаа.

Зөөлөн шаахайтай хөл нь хөгжмийн хэмнэлийг товших үед гарынх нь хуруу хөгжмийн хувилбарыг төмөр хайсан дээр залхуутайхан тогшино. Тэрбээр Стивэнс Г ринээр хайнгадуухан эргэж, Грэфтоны гудамжаар бэдрэв. Түүний нүд зөрж өнгөрөх хүмүүсийн дундаас олон зүйлийг анзаарч, ихэд уйтгартайхан харна.

Түүний сэтгэлийг татах учиртай бүхэн утга учиргүй заваан мэт санагдаж, эрс шийдэмгий байхыг уриалан дуудсан бусдын харц руу тэр үл харах ажээ. Их зүйлийг ярьж, зохиож, зугаацуулах шаардлага тул гарлаа гэхэд, тэрхүү хоолой хийгээд толгойд энэ бүхнийг гүйцэлдүүлэхэд арай дэндүү хуурай байлаа.

Корлитой уулзатлаа цагийг хэрхэн нөхцөөх тухай асуудал түүнийг бага зэрэг эргэлзэхэд хүргэв. Тэрбээр гудамжаар зугаалахаас өөр ямар ч зүйл бодож олсонгүй. Ратлэндын цэцэрлэгт гудамжны өнцөг дээр очуут, тэр зүүн тийш эргэхэд, нам гүмхэн харанхуй гудамжны баргар төрх түүний зан ааштай тун адилхан байхуй өөрийгөө тэр эрх чөлөөтэй хүн шиг мэдрэв. Эцэст нь тэр “ундаа, зууш” хэмээн том цагаан үсгээр бичсэн хаяг бүхий уушийн газрын умгархан цонхны дэргэд очиж зогсов. Цонхны шилний цаана “цагаан гаатай шар айраг, цагаан гаатай дарс” хэмээх жижиг самбар бүхий хоёр хаяг өлгөсөн байх ажээ. Том хөх тавган дээр гахайн гуяны зүсмэл мах тавьсан байх агаад түүний дэргэдэх тавган дээр хямдхан цэлцэгнүүрийн дөрөвний нэг мэлтийнэ.

Хэсэг хором тэр энэ бүхнийг анхааралтай ажиглаж, хоёр тийш болгоомжтойхон харснаа, уушийн газар руу түргэхэн явж оров. Чалчаа хоёр зөөгчөөс гуйж байж арайхийн олж идсэн нарийн боовыг эс тооцвол, өглөөнөөс хойш тэр юу ч идээгүй тул аймшигтай өлсч байжээ. Тэрбээр бүтээлэггүй модон ширээний ард суухад түүний эсрэг талд хоёр ажилчин бүсгүй, нэг ажилчин залуу сууж байлаа.

Бохирдуухан зөөгч бүсгүй түүн рүү дөхөж ирэв.

- Вандуй ямар үнэтэй вэ? гэж тэр асуув.

- Эрхэм ээ, хагас пэнс гэж зөөгч хэлэв.

- Надад нэг тавгийг өгчих, бас дээр нь нэг лонх шар айраг. Тэднийг тэр өөрсдийнх нь нэг мэтээр хүлээн авахыг хүссэн тул албаар бүдүүлэгдүүхэн харьцжээ. Учир юун гэвэл, түүнийг орж ирснээс хойш бүгд дуугаа хураан болгоомжлохыг аяджээ.

Түүний хацар халуу шатаж байлаа. Олны нүдэнд өртөхгүйг хүссэн тул тэр өмсч байсан малгайгаа духдуулан тавьж, ширээ тохойлдон суулаа. Ажилчин эр, хоёр ажилчин бүсгүйн хамт түүнийг дээрээс доош нь анхааралтайхан сонжсоны эцэст, ярьж байсан яриагаа аядуухан үргэлжлүүлж эхлэв.

Зөөгч бүсгүй хар чинжүү, цагаан цуугаар амталсан халуун вандуй нэг тавгийг, сэрээ болон гаатай шар айрагны хамт авчирч өгөв. Тэрбээр амаа олохгүй хоолоо идэх зуур, ихэд амттай санагдсан тул энэхүү уушийн газрыг ой тойндоо тогтоохоор шийдэв. Вандуйгаа идэж дуусуут шар айрагнаасаа шимж, Корлитой явсан тухайгаа эргэцүүлэн бодов. Дурлалт хосууд аль нэгэн харанхуй замаар явж буйг тэр төсөөлнө.

Тэрбээр бүдүүлэгдүүхэн урмын үг хэлж буй Корлийн ярихыг сонсч, бүсгүйн ярзасхийх амыг дахин олж харав.

Энэ бүхэн түүний өөрийн оюун санааны хоосрол хийгээд халаас нимгэнийг ил тод болгов. Тэрбээр хийх юмгүй мөнхийн зовлон, элдэв дээдийн нууц явуулга, заль мэхнээс дэндүү их залхжээ. Арваннэгдүгээр сард тэр гучин нэг хүрнэ. Үнэхээр олигтойхон шиг орох оронтой болохгүй юм гэж үү? Гэрийнхээ задгай зуухны дэргэд сууж, ширээнийхээ ард тун сайхан зоог барина гэдэг ямар аятайхан бол? гэж тэр бодов. Найз нөхөд, охид эмстэй тэр хангалттай дэмий тэнэж гүйцлээ.

Тэрбээр найз нөхөд, охидын үнэ цэнийг нэвт шувт мэдэж байлаа. Амьдрал гэдэг түүний зүрх сэтгэлийг хатуу болгож, бүхний эсрэг чиглүүлэхэд хүрсэн юм. Гэвч итгэл найдвар нэг мөр орхисонгүй. Хоол идсэний дараа түүний дотор арай нэг уужрав. Тэрбээр ёс суртахууны хувьд дарамтад орж, амьдралаас залхаж орхисон мэт өөрийгөө үл мэдэрч байлаа. Тэр одоо ч гэсэн хаа нэгэн намуухан газар орон гэрээ төвхнүүлж, аз жаргалтай амьдарч чадна. Хамгийн гол нь сайн, ямар нэгэн хурган заль үгүй боломжийн хэмжээний хадгаламжтай бүсгүй л түүнд тааралдах нь чухал билээ.

Тэрбээр бохир зарц хүүхэнд хоёр хагас пэнс төлөөд уушийн газраас гарч гудамжаар хэсүүчилж гарав. Кэйплийн гудамжаар дайрч Сити Холлын барилга руу чиглэв. Дараа нь тэр Дэймийн гудамж руу эргэв. Жоржийн гудамжны өнцөг дээр

тэр хоёр андтайгаа тааралдаж, хэсэг зуур тэдэнтэй чалчиж зогсов. Явахаасаа залхсан тул бага ч атугай амрах боломж олдсонд ихэд баяртай байлаа. Нөхөд нь Корлийг харсан эсэх тухай, ер нь ямар сонин хачин сонсогдож байна гэж түүнээс асууна.

Тэр бүхий л өдрийг Корлийн хамт өнгөрөөснөө хэлэв. Нөхөд нь тун бага ярих аж. Тэд гудамжаар өнгөрөх хүмүүсийг хайнгадуухан харж, цаг үргэлж бусдыг шоолон инээцгээнэ. Тэдний нэг нь цагийн өмнө Уэстморлендын гудамжинд Мактай тааралдсан тухайгаа ярив. Ленехан ч үүний хариуд, өчигдөр орой Макийн хамт Иганы уушийн газарт сууснаа хэлэв. Уэстморлендын гудамжинд Мактай тааралдсан залуу, билльгардын тэмцээн дээр Макийг томоохон бооцоо авсан нь үнэн эсэх талаар түүнээс лавлав. Энэ тухай Ленехан юу ч сонсоогүй байсан тул тэнд байсан хүмүүсийг Хүлээн бүгдийг нь дарсаар дайлсан тухайгаа өгүүлэв. Тэрбээр андуудтайгаа салах ёс хийгээд арав болохоос арван таван хормын өмнө Жоржийн гудамжаар явж одов. Хотын захын тэнд Грэфтоны гудамж руу зүүн тийш эргэв.

Хэсэг бүлгээрээ явах охид, залуусын цуваа татарч, явах зуурт хосууд бие биендээ сайхан амрахыг хүсч буй нь сонстоно. Мэс заслын коллежийн дэргэдэх гудамжны цаг дээр очмогц арван цаг болох учиртай байлаа. Тиймээс тэр Стивэнс Гриний хойд талаар яаравчлан тойрч, Корлийг цагаасаа өмнө ирчих вий гэхээс ихэд айж байлаа. Тэр Нироны гудамжны өнцөгт

очуут гудамжны дэнлүүний сүүдэрт хянах байраа эзлэж, сожсон янжуураасаа нэгийг гаргаж асаав.

Тэрбээр дэнлүүний шон руу налж, Корли ба бүсгүйн ирэх зүг рүү харц салгалгүй ширтэв. Түүний толгойд бодол дахин эргэлдэж эхлэв. Корлийг санасандаа хүрсэн эсэх талаар тэр бодолд автав. Зугаалгын үеэр тэр нөгөөхөө амжуулав уу, эсвэл сүүлчийн хором хүртэл хойшлуулсан болов уу гэдэг нь сонин байлаа. Тэрбээр найзынхаа болон өөрийнхөө ийм доош орсон байдлаас болж байж суух газраа олж ядав.

Гэвч Корлийн тухай дурсамж гудамжны өнцгөөр түүнийг гарч ирүүт бага зэрэг замхрав. Корлийг бүхнийг зохицуулна гэдэгт тэр бүрэн итгэлтэй байлаа. Гэнэт түүний толгойд нэгэн бодол зурсхийв. Хэрэв Корли түүнийг өөр замаар гэр рүү нь хүргэж өгчихөөд бултсан бол яах вэ? Түүний нүд гудамжийг цоо ширтэв. Мэдэгдэх юм алга. Харин мэс заслын коллежийн дэргэдэх цаг руу харснаас хойш бараг хагас цаг өнгөрчээ.

Корли ингэж чадна гэж үү? Тэрбээр сүүлчийн янжуураа асааж байж суух газраа олж ядан угзарч гарав. Талбайн эсрэг талын буланд трамбай зогсох бүрийд хараагаа чиглүүлж байлаа. Янжуур нь ишиндээ тулахад тэр хараал тавин гүүрний зүг чулуудав. Гэнэт тэдний ирж буйг олж харав. Тэрбээр баярласнаасаа болж арай л дороо дэвхцсэнгүй. Шонгийн модонд наалдаж, тэдний явдлаар үр дүнг нь таахыг оролдов. Тэд тун хурдан явцгааж байсан агаад бүсгүй түргэн түргэн ойрхон алхалж, харин Корни том том гишгэлэн явах ажээ.

Харваас тэд дуугүйхэн яваа бололтой. Азгүй байдлын мэдрэмж яг л хурц иртэй зэмсгийн үзүүр мэт түүнийг хатгах шиг болов. Корли хэзээ ч чадахгүй гэдгийг тэр мэднэм; энэ бүхэн ямар ч амжилтгүй болсон гэдгийг тэр мэдэж байв. Бэгготын гудамж руу тэднийг эргэхэд, гудамжны нөгөө талаар тэр араас нь дагав. Зогсоход нь дагаж зогсоно. Тэд хэсэгхэн зуур ярилцаад, дараа нь бүсгүй нэгэн байшингийн хонгилын доод давхар руу шатаар бууж оров.

Корли явган хүний замын өнцөг дээр, орцноос холгүйхэн зогсоно. Хэдэн хором өнгөрөв. Дараа нь орцны хаалга болгоомжтойхон нээгдэв. Нэгэн эмэгтэй шатаар гүйж гарч ирснээ найтаалгав. Корли эргэн харж түүн рүү очив. Хэдэн мөчийн дараа түүний ханхгар цээж бүсгүйг далдалж, төдөлгүй тэр араас нь цухуйснаа эргээд гэр рүүгээ оров. Түүний араас хаалга хаагдмагц Корли Стивэнс Гриныг чиглэн тун яаравчлан алхав. Ленехан ч мөн тэр зүг рүү яаравчлав. Бороо ганц нэгээр дусалж байлаа. Үүнийг тэр анхааруулга хэмээн ойлгоод, залуу бүсгүйн байрны зүг эргэн харж, араас нь хэн ч хараагүй гэдгийг мэдмэгц зам хөндлөн гарч байдаг хурдаараа гүйв. Сэтгэлийн хөдөлгөөн, хөнгөн гүйдлээсээ болж баахан амьсгаадав.

- Хөөе, Корли! гэж тэр хашгирлаа. Түүнийг хэн дуудаж буйг харахаар Корли эргэн харав. Дараа нь тэр урьдын адил алхав. Ленехан мөрөн дээрх цуваа нэг гартаа тохсоор түүний араас гүйх зуур,

- Хөөе Корли! гэж дахин хашгирав. Найзыгаа гүйцэж очуут түүний нүүр рүү шуналтайхан харав.

Гэвч тэндээс юу ч олж харсангүй.

- Тэгээд юу болов оо? Чадсан уу, яасан? гэж тэр асуув.

Тэд Или-Плэйсийн гудамжны өнцөгт хүрэв. Корли юу ч

хэлэлгүй зүүн тийш эргэж цааш явсаар байлаа. Түүний төрх догшин агаад тайван байдлыг илтгэнэ. Ленехан найзынхаа дэргэд хөл нийлүүлэн алхаж хүндхэн амьсгаадна. Тэр хууртагджээ. Түүний хоолойд заналхийлсэн өнгө аяс тодров.

- Чи яагаад хариулахгүй байгаа юм бэ? гэж тэр хэлэв.

- Чи ядаж оролдож үзэв үү?

Корли замын дэргэдэх эхний дэнлүүний дэргэд зогсч, хоосон орон зай тийш баргар харц чулуудав. Дараа нь тэр ёслол төгөлдөр байдалтай гэрэл өөд гараа сунгаж, анд нөхрийнхөө нүдэн дээр алгуурхан тэнийлгэж үзүүлэв. Түүний алган дээр алтан зоос гялалзаж байлаа.

## Дотуур байр

Мүни авхай мах худалдагчийн охин ажээ. Тэрээр тун шийдэмгий, өөрийгөө өмгөөлж хамгаалах тал дээр сүрхий нэгэн байв. Тэрээр эцгийнхээ захирагчтай гэр бүл болж, Спринг-Гардэнсийн ойролцоо махны лангуу нээсэн юмсанж. Гэсэн хэдий ч хадам эцгийгээ нас баруут Мүнийн нөхөр яадгаа алдаж эхлэв. Тэрбээр байнга согтуурч, дэлгүүрийн мөнгө рүү гараа дүрж, баруун солгойгүй өр зээл тавьж гарчээ.

Засрах тухай нь түүнээс амлалт авна гэдэг сүүлдээ бүр утгаа алдав; хэдхэн хоноод л тэр болохоо байдаг байлаа. Худалдан авагчдын нүдэн дээр эхнэртэйгээ зодолдохын сацуу махных нь чанар муудаж худалдааг тасалдахад хүргэнэ. Тэр ч бүү хэл, нэгэн шөнө заазуур барьсаар эхнэрийнхээ араас элдэж нөгөөх нь хөршийндөө хонохоос аргагүйд хүрч байв. Үүнээс хойш тэд тусдаа амьдрах болжээ. Тэрээр ламтан дээр очиж хүүхдүүдээ өсгөн хүмүүжүүлэх эрхтэйгээр тусдаа амьдрах зөвшөөрөл авчээ. Эр нөхөртөө эд мөнгө, хоног төөрүүлэх өрөө гаргаж өгөхөөс татгалзсанаас гадна, хооллож ундлах тал дээр ч бүрмөсөн цэг тавьсан тул Мүнийн нөхөр цагдаагийн туслах ажилтан болохоос аргагүйд хүрэв.

Тэрбээр ялимгүй бөгтөр нуруутай, цайвар царай болон сахалтай, өрөвсөж улайсан бяцхан нүднийх нь дээгүүр харандаагаар зурсан мэт цайвар хөмсөгтэй тийм л нэгэн эр байж; өдөржингөө тэр шүүгчдийн өрөөнд сууж хэн нэгэн түүнийг зараалд явуулахыг хүлээнэ. Харин Мүни авхайн хувьд том лагас биетэй, дэндүү сүрлэг төрхтэй нэгэн махны худалдаанаас үлдсэн мөнгөөрөө тэр Хардуикийн гудамжинд дотуур байр худалдан авч хөлслүүлж эхэлсэн ажээ.

Дотуур байранд амьдрах хүмүүс байнга солигдохоос гадна гол төлөв Ливерпуль, Мэн арлаас ирсэн жуулчид, заримдаа мюзик-холлын жүжигчид буудаллана. Тэндхийн байнгын оршин суугчид нь Дублины бага тушаалын түшмэлүүд ажээ. Дотуур байраа тэр тун чадварлаг удирдахын сацуу хэзээ зээл олгох, хэдийд нь хурууныхаа салаагаар харах, хэдийд уурлахаа ч мэддэг байлаа. Тэндхийн байнгын оршин суугч залуучууд өөр хоорондоо түүнийг Хатагтай хэмээн авгайлна. Залуучууд долоо хоногтоо Мүни авхайд тус бүр 15 шиллинг ширээ болон өрөөний (шар айраг, үдийн зоог дээрх дарсыг оруулалгүйгээр) төлбөрт өгнө.

Тэдний сонирхол, хийж буй ажил гол төлөв нэг төрлийнх байх тул өөр хоорондоо тун чиг дажгүй нөхөрлөнө. Тэд горьдлоготой морьд, хар зүсмийн морьдынтүрүүлэх боломжийн тухайд байнга мэтгэлцэнэ. Хатагтайн хүү болох Жек Мүни Флитийн гудамжин дахь нэгэн худалдааны газар ажилладаг бөгөөд нэр хүнд гэж авах юмгүй нэгэн байлаа. Түүний хувьд жинхэнэ эр хүний үгийг мушгих дуртай байснаас гадна гэртээ гол төлөв үүр цүүрээр л орж ирнэ. Найз нөхөдтэйгээ уулзсан үедээ тасархай онигоо үй түмээр нь ярихаас гадна бусдаас илүү тэр л адармаатай мэдээ сонсчихсон явдаг байв. “Боломжийн” морь юм уу, “боломжийн” жүжигчин бүсгүйн тухай бусдаас урьдаж мэдээлэл авна.

Үүнээс гадна тэр муугүй бокс тоглож, хошин дууны дахилтыг аялах дуртай байв. Зарим нэгэн бүтэн сайн өдөр Мүни авхайн томоос том зочны өрөөнд үдэшлэг болно. Тэрхүү үдэшлэгт мюзик-холлын жүжигчид оролцсоноор улам

хөгжилтэй болгоно; Шэридан гэхэд вальс, полька бүжгийн ая тоглоно. Хатагтайн охин Полли

Мүни ч мөн дуу дуулж олныг хөгжөөнө.

Үнэндээ би хөнгөмсөг ч гэлээ шазруухан,

Үүнийгээ нуугаад яахав ээ,

Үйлдсэн нүгэл гэж үгүй дээ гэж тэрээр дуулам.

Полли бол арван есөн настай туранхай охин юм; тэрээр шингэхэн цайвар үстэй, бяцхан бамбагар уруултай нэгэн байв. Түүнийг хэн нэгэнтэй ярьж байх үед ногоон, саарал нүд нь харилцан ярилцагчаа дороос нь дээш харах агаад тухайн үедээ тэрээр бяцхан, шалигхан Дарь эхтэй тун чиг адилхан болно. Мүни авхайн хувьд, буудайн үр борлуулалтын албанд охиноо бичээчээр оруулсан ч цагдаагийн даргын бүтэл муутайхан туслах залуу охинтой нь ярилцах зөвшөөрөл олгохыг дөнгөж нэг өдрийн дараа Мүни авхайгаас хүссэн тул тэрээр яалт ч үгүй охиноо ажлаас нь гаргаж, гэрийн ажилд сургахаас өөр аргагүйд хүрэв.

Полли тун хөдөлгөөнтэй бүсгүй байсан тул залуу хүмүүсийн халамж түүнд илүү чухал байлаа. Залуусын хувьд ойр хавьд нь залуухан бүсгүй байна гэдэг үргэлжид тааламжтай байх нь мэдээжийн хэрэг. Полли ч гэсэн тэдэнтэй сээтэгнэх авч, Мүни авхай тун гярхай эмэгтэй тул залуучууд зүгээр нэг цаг нөхцөөж байгаа биз, тэдэнд ямар нэгэн далд санаа үгүй хэмээн ойлгоно.

Иймэрхүү байдлаар нэлээдгүй хугацаа өнгөрч, Мүни авхай ч Поллийг бичгийн машины ард дахин суулгах эсэх тухай бодож эхлэв. Гэтэл гэнэтхэн Полли болон өнөөх залуусын нэгнийх нь хооронд ямар нэгэн сэжигтэй зүйл болж буйг тэр

гадарлав. Тэрээр тэдний араас мөрдөж, мөшгиж эхэлсэн ч бүхнийг дотроо хадгалсаар байлаа. Полли ч гэсэн түүнийг мөрдөж мөшгиж байгааг мэдэж байвч эхийнх нь бүлх залгисан мэт дуугүй байдал үг хэлэхээс илүү бүхнийг тодхон илтгэнэ.

Эх, охин хоёрын дунд ямар ч нээлттэй тохироо, хамтын яриа хэлцэл байгаагүй ч шинэхэн хосуудын тухай дотуур байр даяар нэг жиг жуг хийж эхлэв.

Гэсэн хэдий ч Мүни авхай энэ бүхэнд хошуу дүрэхгүй л байлаа. Полли тун хачин байдалтай байх болох харин залуу эрийн хувьд тун гайхширсан байдалтай явах болов. Эцэс сүүлд нь хувьсгалын тохироо бүрдсэн гэж бодмогцоо Мүни авхай энэ бүхэнд хутгалдахаар шийдэв. Томхон заазуураар ямар амархан мах цавчдаг билээ дээ, түүн лугаа адил тэрээр амьдралын аливаа хүндрэлийг тун хялбархан даван туулдаг байлаа; харин тухайн тохиолдолд шийдвэр гарчихсан байв. Нэгэн сайхан бүтэн сайн өдрийн тунгалагхан өглөөгүүр халуун шатаж эхэлсэн ч сэвшээ салхин түүнийг зөөлрүүлнэм. Дотуур байрны бүх цонхнууд нээлттэй, онгорхой цонхны хүрэн дороос сүлжээсэн хөвөөтэй хөшигнүүд зөөлөн хөөсөрнөм. Гэгээн Георгийн сүмийн хонх олныг уриалахуйд сүсэгтнүүд ганц нэгээрээ, эсвэл бөөн бөөнөөрөө сүмийн өмнөх жижигхэн дугуй талбайг гэтлэн явцгаана; тэдний гарт барьсан залбирлын ном санаа зорилгыг нь илтгэх ажээ.

Дотуур байрны өглөөний цайны цаг дуусахад, өндөгний шар наалдсан тавагнууд, гахайн



утсан махны арьс, өөхний хэлтэрхий зэрэг зүйлс ширээн дээр эмх замбараагүй хэвтэнэ. Мүни авхай матмал сандал дээр суунгаа үйлчлэгч Мэриг ширээн дээрхийг хэрхэн цэвэрлэж буйг ажиглана. Мягмар гарагийн талхны цэл цэгнүүрт ашиглаж болохуйц талхны үйрмэг болон юу л байна тэр бүхнийг хамж авах даалгаврыг Мэрид өглөө. Ширээн дээрхийг хурааж, талхны хаягдлыг цуглуулж, элсэн чихэр, цөцгийн тос сэлтийг найдвартай газар нь хийж цоожилсны дараа, өчигдөрхөн Поллитой ярилцаж байсан зүйлээ Мүни авхай эргэцүүлэн тунгааж эхлэв.

Бүх зүйл түүний төсөөлж байснаар болсон аж: тэрээр шуудхан асуулт тавьж, харин Полли эрсхэн хариулж байлаа. Мэдээж хэрэгтэд хоёул эвгүй байдлыг мэдэрсэн нь ойлгомжтой. Мүни авхайн хувьд, шинэхэн мэдээг гэнэтхэн хүлээж авахыг хүсээгүй тул нэлээдгүй цочирдож, түүнийг тэр дэмжиж буй мэт харагдахыг хүссэнгүй.

Харин Поллийн хувьд, иймэрхүү төрлийн санаа сэдэл нь үргэлжид эвгүй мэдрэмж төрүүлж байснаар тайлбарлагдахаас гадна залуу насандаа тэр тодорхой зорилго тавьснаа түүнд ойлгуулахыг хүсээгүй аж. Энэ бүхний тухай Мүни авхай бодолхийлэн суухдаа, Гэгээн Георгийн сүмийн хонхны дуу нам гүм болмогц задгай зуухан дээр байх алтадмал жижигхэн цаг руу өөрийн эрхгүй харав. Арваннэгэн цаг арван долоон хором. Ноён Дорентой чин сэтгэлээсээ ярилцаад, Малборогийн гудамжин дахь арванхоёр цагийн ажилдаа амжчих цаг бас байна. Тэрээр өөрийн ялалтад тун итгэлтэй байлаа. Олон нийтийн санаа бодол түүний талд буюу доромжлогдсон эхийн талд байна гэдгээс бүхнийг эхлэх хэрэгтэй.

Тэрээр гэрийнхээ хаалгыг нээж өгөхдөө л түүнийг журамтай хүн хэмээн бодож байсан ч зочломтгой чанарыг нь тэр муугаар ашигласан билээ. Тэр гучин настай, тиймээс залуу насны алдаа хэмээн худал мэлзэх хэрэггүй. Юм мэдэхгүй байдал нь ч гэсэн үүнийг зөвтгөж чадахгүй. Амьдралыг тэр боломжийн хэмжээнд мэднэ. Тэр зүгээр л Поллийн залуу нас, туршлагагүй байдлыг ашигласан нь ойлгомжтой. Асуудлын гол нь өөрийн гэм бурууг тэр хэрхэн цайруулахад л оршино. Түүний хувьд гэм буруугаа цайруулах үүрэгтэй. Нэр хүнд сайхан л байдаг байх. Эр хүн гэдэг хүслээ хангачихаад, юу ч болоогүй юм шиг замаараа явж одно. Харин бүсгүй хүний хувьд, энэ бүхний лай ланчгийг өөр дээрээ хүлээн авахаас өөрцгүй болдог.

Ийм үед боломжийн мөнгө аваад дуугүйхэн өнгөрөхийг зөвшөөрөх эхчүүд бас бий. Иймэрхүү тохиолдол ч гарч л байсан. Гэвч тэр тийм хүмүүсийн нэг биш. Гагцхүү охиноо доромжлуулсан явдлыг хурим л цайруулж болох байлаа. Ноён Дорентой уулзахыг хүсч буй тухайгаа хэлүүлэхээр Мэриг явуулахаас өмнө Мүни авхай өөрт байгаа хөзрийг дахин тооцож үзэв.

Тэрээр ялна гэдэгтээ итгэлтэй байлаа. Мэдээж тэр нэлээдгүй бодолтой залуу хүн болохоос биш ямар нэгэн орилж чарласан шалдан банди биш. Түүний оронд Шэридан, Мид, эсвэл Бэнтам Лайонс нар байсан бол асуудал хүндрэх байлаа. Энэ явдлыг тэр олонд ил болгохыг хүсэхгүй нь лавгай. Оршин суугчид бүгдийг мэдэж байгаа; зарим нэг нь бүр янз бүрийн юм зохиочихсон байна билээ. Үүнээс гадна тэр томоохон дарсны компанид арван гурван жил ажиллаж байгаа бөгөөд энэ бүх яриа олны сонорт хүрвэл, түүний хувьд ажлын байраа алдах аюул ч нүүрлэж мэднэ.

Хэрэв зөвшөөрөх аваас бүх зүйл хэвэндээ байх болно. Түүний авдаг цалин нэлээд боломжийн байх ёстой, хадгаламж ч гэсэн байж л таарна хэмээн тэр таамаглаж байлаа. Арванхоёр цагт гучин хором дутуу! Тэрээр босч хавтастай толинд өөрийгөө сонжив. Мүни авхай эрүүл чийрэг байдлыг илтгэх гялалзсан царай, эрс шийдэмгий төрхөө харуут тун сэтгэл хангалуун болж, охидоо борлуулж чадахгүй байгаа зарим нэгэн танил авгай нарын тухай бодолхийлэв.

Энэхүү амралтын өдөр ноён Дорены сэтгэл тун ихээр хөдөлж байлаа. Тэрбээр хоёронтаа сахлаа хусах гэсэн авч гарынх нь салганан үл зогсох тул хусахаа болив. Гурван хоног аваагүй хууз сахал нь царай дарж, нүдний шил нь байнга цантах тул хоёр, гурван хором болоод л түүнийг арчихад хүрнэ.

Өчигдөрхөн нүглээ наминчилсан явдлыг эргэн дурсахуйд тун хүндхэн байлаа; ламтан түүнээс бүхий л ичгэвэртэй зүйлсийг нь нэгд нэгэнгүй яриулж аваад эцэс сүүлд нь нүглийг наминчилсан тул, эдүгээ ноён Дорен гэм буруугаа наминчлах ийм боломж олдсонд хөл нь газар хүрэхгүй баярлахаас наагуур байв.

Хорон муу зүйлийг аль хэдийнэ үйлдсэн. Харин одоо тэр гэрлэх үү, эсвэл зугтаж одох уу? Энэ бүхнийг үл тоон явах тэнхээ түүнд дутна. Энэхүү балай явдлын талаар мэдээж хэрэг цуурцгааж л таарна. Эцэс сүүлдээ тэр бүх хов жив даргынх нь чихэнд хүрэхээс зайлахгүй. Дүблин бол жижигхэн хот. Тэнд бүгд л бие биенийхээ тухай бүхнийг мэддэг юм. Ноён Дорены зүрх ёгхийв.

Түүний айж балмагдсан царай ноён Леонардын дүрийг сэтгэлдээ буулгаж: “Ноён Дореныг наашаа дууд” хэмээн хяхтнасан хоолойгоор хэлэх нь нүднээ үзэгдэх шиг болов. Энэ олон жилийн ажил алба иймхэн юмнаас болж талаар өнгөрөөх юм гэж үү! Түүний хичээнгүй зан, бүхий л мэрийлт үнсэн товрого болох юм гэж үү? Залуудаа тэр мэдээж хэрэг эрх чөлөөтэй байж, өөрийнхөө үзэл бодлыг магтаж, Бурхан байдгийг үгүйсгэж, анд нөхдийн хамт уушийн газраар хэсүүчилдэг байсан. Эргээд харахад энэ бүхэн өнгөрсөн цагт үлдэж дээ...

Одоо болтол тэр долоо хоног бүр "Рэйнолдз"1 сонинг худалдан авсаар байгаа авч тун даруухан амьдарч, байнга л сүмд очно. Өөрийн гэсэн орон гэртээ амьдрахад түүнд хангалттай мөнгө бий; гэвч хэргийн учир үүнд бус юм. Түүний гэрийнхэн Поллиг нэг нүдээрээ ч үзэхгүй. Замаа алдсан эцэг, дараа нь тэр ээжийнх нь дотуур байр гээд л бөөн хэл ам гарна. Гэхдээ тэр урхинд орсон гэдгээ мэдрэв. Найз нөхөд нь энэ явдлыг хэрхэн шүүн хэлэлцэж, доог тохуу хийх бол гэдгийг тэр сайтар төсөөлж байлаа. Мэдээж хэрэг Поллийн хувьд бүдүүлэг юм бий л дээ, заримдаа тэр “үүнд талрхан”, “хонгэл” гэх мэтээр ярих нь бий. Зөв бичих дүрэм ч дүүрчээ. Хамгийн гол нь түүнийг тэр чин сэтгэлээсээ хайрладаг бил үү?

Одоо болтол түүнд хайртай юу, эсвэл хийсэн зүйлийнх нь төлөө үзэн ядаж байна уу гэдгээ тэр шийдэж чадахгүй байлаа. Тийм ээ, гэвч тэр ч гэсэн энэ бүхэнд гар бие оролцсон. Хамгийн гол нь эрх чөлөөгөө хадгалж, гэрлэлтээс зайлсхийх хэрэгтэй хэмээн дотоод мэдрэхүй нь сануулна. Гэрлэсэн л бол дуусаа гэж ярьдаг бус уу? Орныхоо буланд яах учраа ололгүй пиджак үгүй суухдаа тэр Поллиг намуухан хаалга тогшин өрөөнд орж ирэхийг сонсов. Түүнд тэр бүгдийг нь ярив. Ээждээ үнэнээ хэлсэн тухай, эх нь түүнтэй өнөө өглөө уулзана гэдгийг ч мөн хэлсэн байна.

Тэрээр байдгаараа уйлсаар түүнийг хүзүүдэн авч:

- Боб минь дээ! Боб минь! Би одоо яах юм бэ? Би яах

1 Лондоны эрс тэс үзэлт сонин болж байна аа? хэмээн орь дуу тавив. Тэрээр амиа хорлоно гэв. Түүнийг тэр дурамжхан тайвшруулж, бүх юм болж бүтнэ, юунаас ч бүү ай, уйлаад хэрэггүй хэмээн аргадаж гарав. Түүний зүрх хэрхэн булгилж буйг цамцныхаа цаанаас тэр мэдрэв. Болсон явдалд тэр ганцаар буруугүй байлаа. Гоонь эрийн ой тоонд түүний даахинз, амьсгаа, савхан хуруунуудых нь бэлэглэж асан анхны тохиолдлын энхрийлэл дахин сэргэв. Дараа нь нэгэн үдэш түүнийг унтахаар зэхэн хувцсаа тайлах үед, Полли хаалгыг нь тогшиж билээ. Унтарсан лаагаа түүний лаанаас асаахыг хүсчээ. Бүсгүй дөнгөж саяхан усанд орсон байлаа. Тэрээр чөлөөт хийгээд задгай энгэртэй алаг тэрмэн унтлагын хувцас өмссөн байх ажээ. Түүний цагаахан өсгий шөнийн шаахайны цаанаас цухуйж, анхилам үнэртэй арьсан дороос нь халуухан цус булгилж байлаа.

Түүнийг лаа асаах зуур булбрайхан гараас нь зөөлөн, анхилуун үнэр ханхийнэ. Үдэш орой гэртээ ирэх үед, Полли түүнд хоолыг нь халааж өгнө. Түүний дэргэд сууж байхдаа тэр юу идэж байгаагаа ч бараг анзаардаггүй байснаас гадна нойрсч буй байшинд тэд хоёулхнаа байдагсан. Тэр ямар халамжтай гээч! Шөнө дөлөөр хүйтэн салхитай байх аваас үргэлжид түүнийг шилэн аягатай халуун дарс хүлээж байдаг байв. Тэд аз жаргалтай ч байж мэдэх л юм...

Дараа нь тэд тус бүртээ лаагаа барьсаар, өлмий дээрээ шатаар өгсч, гурав дахь давхрын талбай дээр бие биедээ хандан сайхан нойрсохыг хүснэ. Ингээд болоогүй үнсэлцэнэ. Түүний нүд, гар нь биед хүрэх нь, өөрийн ухаан мэдрэлгүй болгодгыг тэр сайн мэднэ. Гэвч ухаан мэдрэлгүй болох нь тэгсхийгээд л өнгөрдөг. Бүсгүйн хэлсэн “Одоо би яах вэ?” гэх үгсийг тэр өөртөө хандан санаандаа давтан өгүүлэв. Гоонь эрийн мэдрэмж болгоомжлоход хүргэв. Гэвч нүгэл хийсэн; тэгээд ч нэр төрийн тухай зовинол нүглээ наминчлахыг түүнээс шаардсан юм. Тэднийг орон дээр сууж байхад Мэри орж ирснээ, эзэгтэй түүнийг зочны өрөөнд хүлээж байна гэж хэлэв. Тэрбээр босч, хантааз болон пиджакаа өмсөх зуур өөрийгөө улам бүр балмагдсаныг мэдрэв.

Хувцсаа өмсч дуусмагц тэр Полли руу дөхөж очсоноо:

- Бүх юм болно. Айлтгүй! гэв. Тэрээр орон дээр суун уйлах зуур:

- Бурхан минь! Бурхан минь! хэмээн намуухан гэнгэнэж байлаа.

Түүнийг шатаар буух үед нүдний шил нь цантсан тул бас л арчих хэрэг гарав.

Тэр дээврээр нэвт гарч, энэ бүх золгүй явдлыг мартаж болох, хаа нэгтээ орших харийн орныг зорин нисэн дүүлэхийг хүснэм. Гэсэн хэдий ч ямар нэгэн татах хүчинд автаж, гишгүүр гишгүүрээр хөл тавин доош бууж байлаа. Хэзээ ч уучлахгүй дарга болон Хатагтайн царай түүний ялагдлыг ширтэнэ. Шатны дэргэд энгэртээ хоёр шил шар айраг тэврэн агуулахаас гарч ирэх Жек Мүнитэй таарав.

Тэд хоорондоо тун хүйтнээр мэнд усаа мэдэлцэв.

Нууц амрагийн харц энэхэн мөчид бух нохой лугаа адил хүндхэн царай хоёр бахим богино гар дээр тусав. Шатаар буусан хойноо тэр дээш эргэн харахад Жек түүний хойноос ширтсээр зогсч байв. Гэнэт тэр өнөөх мюзик-холлын жүжигчдийн нэг болох намхан нуруутай, цагаан царайтай Лондоны эр Поллийн тухай нэлээдгүй шударга шүүмжлэл хэлээд тавьчихсныг эргэн санах. Жекийн уурласан ч гэж

жигтэйхэн. Үдэшлэгийг тэр арай л тараачихаагүй юмдаг. Бүгд л түүнийг тайвшруулахыг оролдож байлаа. Мюзик-холлын жүжигчин царай нь бага зэрэг хувьс хийснээ, хэнийгч гомдоохыг хүсээгүй шүү! хэмээн инээмсэглэсээр хэлж байв; гэвч түүний дүү охинтой дураараа харьцахыг санаархсан хэнбугай ч байсан шүдийг нь цөм цохино! гэж нэлээдгүй бахирч билээ.

Хэдэн хормын дараа Полли орон дээр суучихсан уйлж байлаа. Дараа нь тэр толь руу дөхөж очин нүдээ арчив. Тэрээр алчуурын буланг савтай усанд норгоод хүйтэн усаар нүдээ чийглэв. Бүсгүй өөрийгөө хажуу талаас нь харснаа чихнийхээ дээрх үсний хатгуурыг засав. Дараа нь тэр ор руу дахин очиж хөлд нь суулаа. Дэр рүү харах үед тун нууцлаг, таатайхан дурсамж төрөв. Орны хүйтэн толгойд хүзүүгээ нааж бодолд автав. Түүний царай дээр ямар ч айж ичсэн ул мөр огт үлдээгүй байлаа.

Бүсгүй тун тэвчээртэй, бараг л баяр баясгалантай, ямар ч айдас хүйдэс үгүй хүлээхийн сацуу түүний дурсамжууд алгуур алгуурхан итгэл хийгээд ирээдүйн тухай гэгээн мөрөөдөлд байр сууриа тавьж өгөх ажээ. Тэрээр итгэл, мөрөөдөлдөө дэндүү их автсан байх тул ямар нэгэн зүйлийг хүлээж буйгаа ч умартаж, харц тэмүүлж асан цагаахан дэрээ ч үл харнам. Энэ бүхний эцэст Полли эхийнхээ дуудахыг сонсов. Тэрээр орноосоо огло харайн босч шатны бариул тийш гүйн очив.

- Полли! Полли!

- Яасан бэ? Ээж ээ?

- Хонгор минь буугаад ир! Ноён Дорен чамтай ярилцахыг хүсч байна. Энэ үед л Полли ямар зүйлийг ингэтлээ их хүлээж байснаа сая л нэг ухаарав.

## Үүл

Норт Уоллын усан зогсоол дээрээс тэр найзыгаа үдэж мордуулаад, аян замын ерөөл талбиж байснаас хойш өдгөө найман жил өнгөрчээ. Галлахер уул руу явав. Хэзээний л аялагчийн алхаа гишгээ, увайгүй өнгө бүхий сайн чанарын оёдолтой, зузаан ноосон хослол энэ бүхнийг илтгэнэ. Энэ хорвоо дээр ийм авьяаслаг хүн цөөн авч амжилтандаа ташуурсан нь бүр ч бага ажээ. Галлахер алт шиг хүн, олны талархлыг хүлээсэн нэгэн байв.

Түүн шиг найзтай болно гэдэг тоглоом биш. Өглөөний цайн дээр Галлахертай хийсэн уулзалт, Галлахерын амьдарч байсан нийслэл хотын амьдралын хэв маяг хийгээд түүний урилгын эргэн тойронд Бяцхан Чэндлэрийн бодол санаа эргэлдэнэ. Хэдийгээр тэр дунджаас ялимгүй намхан нуруутай ч яагаад ч юм Бяцхан Чэндлэр хэмээн нэрийдэх болсон юм. Тэрбээр жижигхэн цагаан гар, турьхан бие, намуухан хоолой, ааш аягтай нэгэн байв. Цайвар торгомсог үс сахлаа тэр ихэд анхаарч явдгаас гадна түүний нусны алчуураас үл ялиг сүрчигний үнэр сэнгэнэнэ. Хумсных нь хэлбэр ямар ч өө сэвгүй байснаас гадна инээхэд нь хүүхдийнх шиг цагаан шүд яралзана.

Кингз-Иннз1 дэх албан өрөөндөө тэр өнгөрсөн найман жилийн хугацаанд ямар өөрчлөлт гарсан тухай бодож суулаа. Сохор зоосгүй, үргэлжид ноорхой хувцастай явдаг найз нь Лондоны гялалзсан сэтгүүлч болжээ. Тэрбээр үе үехэн уйтгарт

1 Туршлагатай өмгөөлөгч нарыг бэлддэг корпораци буюу Лондоны шүүхийн шинэчилсэн байгууллагын нэгэн адил ирланд хувилбар цааснаасаа толгойгоо өндийлгөж, нээлттэй цонх руу харц чулуудан сууна. Намар цагийн жаргаж буй нарны улаан туяа цэцэрлэгт гудамж хийгээд зүлэг ногоон дээр тусна.

Тэрбээр гудамжны сандал дээр нойрсох турь муутайхан хөгшчүүд, бохирдуухан гэрийн үйлчлэгч нарын дээрээс тун өгөөмөр байдалтай алтан тоос сэгсэрч байлаа; цэцэрлэгт хүрээлэнгээр явах замын хүмүүс хайрган зам дээр хөөрөлдөн гүйх хүүхдүүд, хөдөлж байгаа бүхэн дээр тэр тоглоно. Бяцхан Чэндлэр энэ бүхнийг харуут амьдралын тухай эргэцүүлэн бодов; чингээд (амьдралын тухай үргэлжид бодох ахул) тэр уйтгарт автав. Хөнгөн гуниг түүнийг эзэмдэв. Хувь заяатайгаа тэмцэнэ гэдэг ямар ч үр дүнгүй болохыг тэр мэдрэв.

Зуу зуун жилийн түүнд гэрээсэлсэн цэцэн мэргэний дарамт ийм байх болой. Гэрийнхээ номын тавиур дээр байх шүлгийн түүврүүдийг эргэн санах. Тэрбээр ганц бие байхдаа л тэднийг худалдан авч байсан ба үдэш оройн цагаар үүдний өрөөний дэргэдэх умгархан өрөөнд сууж, тавиур дээрх номноосоо авч эхнэртээ үе үехэн уншиж өгөхсөн гэж туйлаас их хүсдэг байжээ. Гэвч тэр бүрийд хулчгар зан нь барьдаг байсан тул тэдгээр номууд ч гэсэн тавиур дээрээ хэвтсээр байдаг байлаа.

Заримдаа тэр өөртөө шүлэг уншиж өгөх нь бага ч атугай тайвшруулна. Ажлын өдөр дуусмагц тэр өрөөнөөсөө гарч ойр хавийн хүмүүстэй нэгд нэгэнгүй салах ёс хийнэ. Чингээд тэр Кинг-Иннзийн дундад зууны үеийнх шиг танхимын нуман хаалгаар гарч, Хэнриэттын гудамжаар тун хурдхан явж одов. Алтан шаргал нарны туяа тэртээд шингэж нэлээд сэрүүхэн болжээ. Гудамж талбай тэр чигээрээ бохир, заваан хүүхдүүдээр дүүрэн байлаа.

Тэд оготно мэт үүдний довжоон дээр чимээгүйхэн сууцгааж, онгорхой хаалганы өмнөх шатаар хаяхан мөлхөж, аль эсвэл гүүрэн дээгүүр гүйж харайх ажээ. Бяцхан Чэндпэр тэднийг огтхон ч тоосонгүй.

Бужигнаж буй энэхүү амьдралын дундуур тэр тун сурамгай гэгч нь зам гаргаж, эрт дээр цагт Дублины эрхэм дээдсүүд найр наадам хийдэг байсан эцэнхий хий үзэгдэл мэт орд харшийн нөмөр дор явж байлаа. Гэвч өнгөрсөн цагийн дүр зураг түүний санааг үл зовоохоос гадна тэр хэн нэгэнтэй уулзана хэмээн баяр хөөртэй явав.

Тэр хэзээ ч Корлессын<sup>1</sup> очиж байгаагүй ч энэ бол жинхэнэ цуцал гэдгийг сайн мэдэж байлаа. Театрт очсоны дараа хүмүүс ликёр дарс шимж, нядмар идэхээр очдог гэдгийг тэр мэдэх бөгөөд зөөгчид нь гэхэд л франц, германаар чөлөөтэй ярьдаг болохыг тэр сонсч байжээ.

Үдэш оройн цагаар тэрхүү орцны өмнө сүйх тэрэгнүүд ирж зогсуут хээнцэр хатагтай нар ноёдын хамт тэдгээрээс бууж хурдхан шиг хаалган цаагуур орон алга болохыг тэр тун яарангуй дэргэдүүр нь өнгөрөхдөө ажжээ. Тэд гол төлөв шар шурхийх даашинз, олон янзын нөмрөг тэрлэсэн байх аж. Нүүрэндээ тэд байдгаар нь оо энгэсэг түрхэж, сүйх тэрэгнээс буухдаа, балмагдсан Аталанта мэт банзлынхаа хормойг хамж буужаж. Дэргэдүүр нь өнгөрөхдөө тэр тэднийг харах гэж толгойгоо эргүүлдэг байв. Өдрийн цагаар ч хамаагүй гудамжаар үтэр түргэн явах зуршилтай байснаас гадна орой үдэш хотын төвд байх шаардлага гарсанд нэг дор айдас хийгээд сэрлийг мэдэрсээр тэр бараг л гүйхээрээ явна.

Ингэхэд тэр айж, эмээх шалтгаанаа өөрөө хайдаг байв.

## 1 Үнэтэй зоогийн газар

Тэрбээр хамгийн харанхуй, нарийн гудамжуудыг сонгож, тун зоримогхон урагшилдаг бөгөөд, түүний алхаа гишгээ тойрон орших нам гүм хүртэл түүнийг айлгадаг байлаа; тэр цаг үргэлж бөглүү агаад дэргэд цангинах инээдийг хүртэл сонсоод өнчин навч шиг байдгаараа чичирхийлнэ.

Кэйплийн гудамж руу баруун тийш эргэв. Игнатий Галлахер бол Лондоны сэтгүүлч. Найман жилийн өмнө хэн ийм болно хэмээн санах билээ. Гэвч өнгөрснийг эргэн харахад бяцхан Чэндлэр ирээдүйд нэр алдар хүртэх эрхэм шинжийг найзаасаа нээж байлаа.

Галлахерыг гол төлөв бүтэлгүй амьтан хэмээн нэрийднэ. Мэдээж тэр болж бүтэхгүй хүмүүстэй нийлж, нэлээдгүй ууж, баруун солгойгүй мөнгө зээлдэг байв. Эцсийн эцэст тэр балиар асуудалд холбогдов. Ямар нэгэн луйвар; ямар ч байсан түүний зугтсан асуудлын гол үндэслэлийн нэг энэ ажээ. Гэвч авьяасыг нь хэн ч үгүйсгэж чадсангүй. Игнатий Галлахерт ямар нэг содон зүйл байлаа...

Тэр ч бүү хэл, өөрсдийнх нь хүслийн эсрэг бусдын хүндлэлийг тэр хүлээнэ. Цаашилбал, тохой нь цоорчихсон, халаасандаа сохор зоос ч үгүй явахдаа хэзээ ч тэр сэргэлэн цовоо байдлаа гэж байсангүй. Игнатий Галлахер хүндхэн үеэ хэрхэн давж туулсан тухайгаа ярьж байсныг Бяцхан Чэндлэр эргэн санав.

- Хүүхдүүд ээ! Ганцхан хором завсарлая гэж тэр ажиг ч үгүй хэлэв.

- Би тархиа жаахан гэсгээмээр байна! Энэ бол Игнатий Галлахерын зан.

Чөтгөр аваг гэж! Түүгээр бахархахгүй байхын аргагүй! Бяцхан Чэндлэр алхаагаа түргэсгэнэ. Амьдралдаа тэр анх удаа дэргэдүүр өнгөрөх хүмүүсээс өөрийгөө илүү гэдгийг мэдрэв. Кэйплийн гудамжин дахь үгээгүй ядуу байдлын эсрэг амьдралдаа анх удаа тэр сэтгэлээсээ тэмцэж эхлэв.

Амжилтад хүрэхийн тулд эндээс зайлшгүй явах шаардлагатай гэдэгт эргэлзэх зүйл байсангүй. Дублинд юу ч хийхийн аргагүй байлаа. Грэфтоны гүүрээр гаруут, тэр тэртээх голын эрэг хавийн өгөршиж муудсан байшингуудын зүг өрөвдөнгүй харав. Тэд хир тоосондоо баригдаж, байдгаараа заваарсан хэсэг бүлэг гуйлгачин мэт санагдав. Нар шингэж буй алсыг ширтсээр тэд шөнийн хүйтнийг хүлээх агаад энэ бүхэн тэднийг хувцсаа гөвөөд явахыг хэлнэ.

Энэхүү бодлыг шүлгээр илэрхийлж чадах, эсэх тухай тэр бодов. Лондоны ямар нэгэн сонинд Галлахер түүнийг нь нийтлүүлж мэдэх юм. Тэр жинхэнэ яруу найраг туурвиж чадах болов уу? Ямар санаа илэрхийлэхийг хүсч буйгаа тэр бүрэн дүүрэн өөртөө төсөөлж чадаагүй ч яруу найрагчийн онгод байгаа гэх арвин их ухамсар нь бага зэрэг найдвар төрүүлэв. Тэрбээр тун бардамхан урагш алхана. Алхам бүрээр тэр Лондон руу ойртож үргэлжилсэн уйтгарт амьдралаас улам бүр холдож байлаа.

Түүний өмнө гэрэл үзэгдэв. Ингэхэд тэр нэг их хөгшин биш. Ердөө л гучин хоёр настай. Түүний найрагчийн авьяас одоо л эрийн цээнд хүрч буй ажээ. Ямар их мэдрэмж, бодол санааг тэр шүлгэндээ шингээсэн гэж санана. Энэ бүхнийг тэр өөртөө л тээж явна. Найрагчийн сэтгэл жинхэнэ эсэхийг мэдэхийн тулд, тэр сэтгэлдээ гүн гүнзгий нэвтрэхийг оролдож байлаа. Авьяасынхаа мөн чанарыг тэр гуниг, ааш хэмээн тодорхойлж байсан ч тэрхүү гуниг ааш нь хувь заяатайгаа эвлэрсэн итгэл үнэмшлийн тэсрэлтэд зөөлөрсөн агаад ямар ч гэм зэмгүй баяр баясал бүхий гуниг ааш л байх ёстой гэж тооцно.

Хэрэв тэр шүлгийн номондоо өөрийгөө илэрхийлж чадвал, түүний дуу хоолойг сонсох л байсан байх. Тэр хэзээ ч алдар цуутай нэгэн болохгүй гэдгээ ойлгож байлаа. Олны сэтгэлийг тэр эзэмдэж чадахгүй ч ойлгох сэтгэлтэй цөөн тооны хүмүүс түүнийг үнэлж мэдэх юм. Английн шүүмжлэгч нар түүний шүлгийн гуниг нь хүн байснаас болж түүнийг Кэльтийн сургуулийн яруу найрагчдад хамааруулах байв. Үүнээс гадна тэр өөрөө ч энэ талын хүн гэдгээ мэдрүүлэх болно.

Тэрбээр ирээдүйн номныхоо оршилд бичих янз бүрийн үг хэллэгийг бодож боловсруулах болно. Жишээ нь: “Ноён Чэндлэр бол тун хөнгөн, тансаг шүлэг туурвих авьяас дүүрэн нэгэн...”,

“Түүний шүлгүүд бодлогошронгуй, хөнгөн гуниг нэвт шингэсэн...”, “Кэльтийн өнгө аяс бол...” гэх мэтээр үргэлжлэх болно.

Харамсалтай нь тэр ирланд бус нэртэй, эсвэл нэрийнх нь ард эхийнх нь овгийг тавьдаг ч юм бил үү? Томас Мэлони Чэндлэр; эсвэл Т.Мэлони Чэндлэр гэсэн нь дээр болов уу. Энэ тухай

тэр Галлахертэй зөвлөх болно. Эдгээр мөрөөдөлдөө тэр хэт их автсанаас болж, өөрийнхөө гудамжийг аль хэдийнэ өнгөрсөн байх тул буцаж явахад хүрэв. “Корлэсс” руу дөхөж очмогц, сэтгэлийн хөдөлгөөн урьдын хүчээр түүнийг эзэмдэж, яахаа ч мэдэхгүй орцны үүдэн дээр зогсов. Эцэст нь тэр хаал гыг онгойлгож дотогш оров. Зоогийн газрын гэрэл гэгээ хийгээд дуу шуугиан хэсэгхэн зуур түүнийг хаалган дээр саатахад хүргэв. Тэрбээр эргэн тойрноо харсан ч түүний нүдэнд улаан, ногоон өнгийн жүнзнүүд нүдийг нь гялбуулж байлаа.

Зоогийн газар битүү хүнтэй байх агаад бүгд л түүнийг сониучирхан харж байгаа мэт санагдана. Тэрбээр хоёр тийш түргэхэн харц гүйлгээд (ямар нэгэн чухал ажлаар ирсэн мэт хөнгөхөн хөмсгөө зангидаад), бага зэрэг тайвширмагц хэн ч түүн рүү эргэж хараагүй болохыг олж харав. Харин тэртээх босоо лангууны сандал дээр Игнатий Галлахер сууж байгаа нь харагдав.

- Hello, Томми хуучны анд минь наашаа суу! Юу уух вэ? Сэтгэл зүрх чинь юу гэж байна? Би виски ууж байна. Ийм сархад Лондоноос лав олохгүй шүү! Рашаан, ус уух уу? Эсвэл Сэльтрийн ус уу? Рашаанд дургүй юм биз дээ? Хөөе, найз аа хоёр хундага виски аваад ирэхгүй юу? Уулзаагүй удлаа шүү! Энэ хугацаанд юу амжуулав даа? Бурхан минь! Бид ямар их хөгширч байна даа? Би аль хэдийнэ өвгөн болсон юм шиг харагдахгүй байна уу? Хамаг үс бууралтаж, оройгоороо бүр халзарсан байгаа биз?

Игнатий Галлахер бүрх малгайгаа авч, томоос том түнжин толгойгоо харуулав. Түүний царай нэлээд цонхигор бөгөөд сахлаа сайтар хуссан байх аж. Хар занар лугаа адил гүн цэнхэр нүд нь эрүүл бус цонхийсон байдлыг илэрхийлэх мэт улбар шар зангиан дээр нь тодоос тод гялалзана. Энэхүү зохицол бүхий хоёр толбоны завсар уруул нь чамгүй урт, ямар ч хэлбэр дүрсгүй, өнгөгүй мэт санагдана. Тэрбээр толгойгоо тонгойлгож халзарч буй үсээ хоёр хуруугаараа өрөвдөнгүй илэв. Бяцхан Чэндлэр эсэргүүцэх мэт толгой сэгсрэв. Игнатий Галлахер бүрх малгайгаа өмсөв.

- Бүр цөхөрч гүйцээ шив дээ? гэж тэр хэлэв.

- Сэтгүүлчийн амьдрал гэж юу байдаг юм бэ? Үргэлжийн мөнхөд яарч, байнга л мэдээ сэлтний араас хөөцөлдөж, заримдаа бүр юу ч олохгүй шүү дээ. Дахиад л бас ямар нэгэн шинэ юмны араас байнга хөөцөлдөнө. Тиймээс үсэг өрөгч нарыг би хэд хоног ч гэсэн чөтгөр рүү нь тонилгохоор шийдсэн юм. Төрсөн гал голомтдоо ирсэндээ би ямар их баярлаж байна гэж санана. Хэзээ нэгэн цагт амрах ёстой биз дээ? Гэнэтхэн би ухаан орж хонгорхон, хогонд дарагдсан Дублиндээ хүрээд ирчихсэн байна...

За ийм л байна даа. Томми, уугаач! Ус уу? Болохоороо хэлнэ биз.

Бяцхан Чэндлэр өөрт ноогдсон вискийг нэлээдгүй шингэлэв.

- Залуу минь, чи ач тус гэж ер мэдэхгүй юм даа! хэмээн Игнатий Галлахер хэлэв. - Би бол цэврээр нь уудаг.

- Ер нь би бага уудаг шүү! гэж Бяцхан Чэндлэр даруухан өгүүлэв.



- Хааяахан хуучны найз нөхөдтэйгөө таралдвал ганц нэг хундага тогтоох юм бол байна. Тэгээд л гүйцээ!

- За тэгвэл урьд өмнөх сайн сайхан цаг үе, олон жилийн нөхөрлөлийнхөө төлөө ууцгаая! гэж Игнатий Галлахер тун хөгжилтэй өгүүлэв. Тэд хундага харшуулан хөнтөрцгөөв.

- Өнөөдөр би хуучин нийлдэг байсан нөхдүүдийн нэгэнтэй таарсан гэж Игнатий Галлахер хэлэв. О'Хара надад яагаад ч юм таалагдсангүй. Тэр юу хийж байгаа вэ?

- Хийсэн юмгүй байна лээ. Бүр хэцүүдчихсэн явна лээ гэж Бяцхан Чэндлэр өгүүлэв.

- Хогэн дажгүй ажилд ороо шив дээ?

- Тийм ээ. Тэр газрын албанд ажиллаж байгаа.

- Түүнтэй би Лондонд таарсан шүү! Харваас томорч байгаа бололтой... Хөөрхий О'Хара! Бодвол архинд орчихсон биз?

- Тэгээд зогсохгүй гэж бяцхан Чэндлэр аядуухан хэлэв.

Игнатий Галлахер инээд алдав.

- Томми, харин чи ер өөрчлөгдөөгүй байна шүү гэж тэр хэлэв. - Чи яг л нөгөө ням гарагийн өглөө бүр намайг шартчихсан хэвгэж байхад сургаал айлддаг байсан тэр чухал царайт залуу хэвээрээ байна шүү! Уг нь бол чи ганц нэг газар үзэх хэрэгтэй байгаа юм даа. Арай чи хаашаа ч явж үзээгүй юм биш биз дээ?

- Би Мэн арал дээр очиж үзсэн шүү! гэж Бяцхан Чэндлэр хэлэв. Игнатий Галлахер инээд алдав.

- Мэн арал! гэнэ шүү! - Лондон юм уу, Парис руу яв. Гэхдээ Парис нь дээр байх. Энэ чамд хэрэгтэй шүү.

- Парист чи очиж байсан уу?

- Тэгэлгүй яах вэ? Тэнд би хэзээ ч мартахааргүйгээр зугаацсан шүү!

- Парис чинь тэгээд тийм гоё хот гэж үү? хэмээн Бяцхан Чэндлэр асуув.

Шилэн аягатайгаасаа тэр бага зэрэг бал гаж суутал Игнатий Галлахер нэг амьсгаагаар бүгдийг нь хөнтөрчихөв.

- Үнэхээр гоё гэж үү? хэмээн вискитэй аягаа алгуурхан эргүүлэх зуур нь Игнатий Галлахер - Гэхдээ тийм ч гоё бас биш ээ! Үгүй ээ, мэдээж хэрэг гоё л доо. Хамгийн гол нь тэндхийн амьдрал үгээр илэрхийлэхийн аргагүй. Зугаа цэнгэл, энэ тэр талаараа Паристай эн тэнцэх хот хаа ч үгүй...

Бяцхан Чэндлэр шилэн аягатайгаа ууж дуусгаад ямар ч зовлонгүй барны үйлчлэгчтэй харцтай тулгарав. Тэрбээр виски дахин захиалав.

- Би ч бас Мүлэн Рүжид очиж байсан хэмээн барны үйлчлэгчийг шилэн аяга хураах зуур хэлэхэд Игнатий Г аллахер яриагаа үргэлжлүүлэв. Тэр ч бүү хэл латин хорооллын бүхий л хоолны газруудад орж үзсэн. Чамд ч бараг илтгэл шиг юм тавьчихлаа. Гэхдээ чам шиг хүн тэнд очихын биш.

Бяцхан Чэндлэр дуугүйхэн суув; барны үйлчлэгч тун удалгүй хоёр шилэн аяга барьсаар эргэж ирэв; энэ үед тэр шилэн аягаа найзынхаа аяганд тулгаад түүний хэлсэн ерөөлийг давтан өгүүлэв. Тэрбээр хөнгөн гунигт авгав. Галлахерын ярианы өнгө, өөрийгөө илэрхийлж буй байдал түүнд ер таалагдсангүй.

Урьд өмнө хэзээ ч анзаарч байгаагүй ямар нэгэн бүдүүлэг занг тэр найзаасаа олж харав. Энэ бүхэн түүний сонин хэвлэлийн хов живээр дүүрсэн Лондонд амьдарч байгаагаас нь үүдэлтэй байж болно. Ямар ч байсан тэр шал өөр хүн болсон байлаа.

Харин Галлахерын хувьд, тэр юм үзэж, нүд тайлсан гэдэг нь тодорхой байв. Бяцхан Чэндлэр ихэд атаархсан байдалтай найзруугаа харав.

- Парист байгаа хүмүүс бүгд л хөгжилтэй байдаг гэж Игнатий Галлахер хэлэв.

- Тэндхийн хүмүүс амьдралаас таашаал авч чаддаг юм. Энэ муу юм биш биз дээ? Хэрэв үнэхээр сайхан амьдаръя гэж бодож байгаа бол Парис руу явах хэрэгтэй. Парисчууд ирланд хүмүүст тун сайхан ханддаг гэдгийг чи мэдэх үү? Намайг ирланд гэдгийг мэдмэгцээ тэд арай л дараад алчихаагүй.

Бяцхан Чэндлэр шилэн аяганаасаа дахин нэг балгав.

- Парис чинь ингэхэд гадуур цуурдаг шиг ямар ч ёс зүйгүй хот гэж үнэн үү, хэл дээ! хэмээн яриагаа эхлэв. Игнатий Галлахер ёслол төгөлдөр байдалтай баруун гараа өргөв.

- Бүх хотууд ёс зүйгүй шүү дээ гэж! тэр хэлэв.

- Мэдээж хэрэг Парист олон янзын гайхалтай зүйлийг олж харж болно. Жишээ нь оюутны бүжиг байна. Тахианууд тарж одсон хойно харах юм бий шүү! Хэний тухай ярьж байгааг чи ойлгож байгаа биз дээ?

- Тэдний тухай би сонсч байсан гэж Бяцхан Чэндлэр өгүүлэв.

Игнатий Галлахер вискигээ ууж дуусгаад толгой сэгсрэв.

- Тийм ээ. Франц бүсгүйг гүйцэх ямар ч эмэгтэй байхгүй шүү! гэж тэр хэлэв.

Ой ухаан, байгаа байдал гээд ярих юм үгүй!

- Тэгвэл тэр чинь ёс зүйгүй хот байна! гэж Бяцхан Чэндлэр байр сууриа уйгагүй хамгаалав.

- Би Лондон юм уу, Дүблинтэй харьцуулан хэлж байгаа юм шүү.

-Лондон! Гэж Игнатий Галлахер дуудав.

-Юугаа харьцуулах вэ дээ? Хонгор минь, Хогэнээс асуугаарай! Түүнийг ирэх үед нь би Лондоны талаар бага зэрэг гэгээрүүлсэн, тэр бас чиний нүдийг ч нээж магадгүй. Томми, чи сонс. Яагаад наад юмаа шимээд байгаа юм бэ? Наадах чинь ямар халуун дарс юм уу, шуудхан уугаач!

- Үгүй ээ, мөн чанартаа...

- За чи боль доо? Яав л гэж дээ? Өөр юу захиалах вэ? Дахиад нөгөөхөөсөө юу?

- За алив...

- Francois дахиад нэг нэгийг өгчих...

Томми, тамхилах уу? гэж хэлээд Игнатий Галлахер тамхины хайрцгаа гаргаж ирэв. Тэдэнд виски авчирч өгтөл тэд навчин тамхиа татсаар суув.

- Чи чамд өөрийнхөө сэтгэгдлээс хэлье гэж нуугдаж байсан Игнатий Галлахер утаат үүлний араас шумбан гарч ирснээ, бид тун хачин ертөндид амьдарч байна гэв. Энд ямар юмных нь ёс суртахуун байх вэ? Тиймэрхүү тохиолдлын тухай би сонсч байсан. Ингэхэд би юу ярьж байна аа? Сонссон л юм байна.

Тиймэрхүү тохиолдлыг би мэднэ. Игнатий Галлахер бодолд автан навчин тамхиа сэвшээд дараа нь нэгэн жигд туулийн өнгөөр хилийн чанад дахь завхайрлын дүр зургийг өөрийнхөө найзад дүрслэн үзүүлж гарав.

Тэрбээр хэд хэдэн улсын төв нийслэлийн дутагдлыг тоочсон бөгөөд ямар ч байсан Берлин хотод тэргүүн байрын дал мод олгохыг оролдсон бололтой. Амлаж чадахгүй зүйл ч бас түүнд байв. Гэвч олонхийг нь тэр өөрийн туршлагаас мэдэж байв. Тэрбээр ямар ч цол хэргэмийг үл хайхарч байлаа.

Европын сүм хийдийн нууцыг илчилж, дээдсийн хүрээлэнд оршиж буй ёс зүйг дүрслэн өгүүлээд Английн нэгэн гүнгийн ахайтны тухай шуугиант явдлыг бүхий л нарийн зүйлийн хамт ярьж энэ бүхнийг жинхэнэ үнэн хэмээн нотлон ярина. Бяцхан Чэндпэр тун их гайхав.

- Тийм ээ, манай хуучны, буйдхан Дүблинд иймэрхүү зүйлийг хэзээ ч сонсч байгаагүй юм гэж Игнатий Галлахер хэлэв.

- Тийм их юм үзэж харсны эцэст манайд чамд уйтгартай л байж таарна гэж Бяцхан Чэндлэр хэлэв.

- Энд ирнэ гэдэг миний хувьд жинхэнэ амралт гэдгийг чи мэдэх үү? хэмээн Игнатий Галлахер хэлэв. Тэгээд ч энэ бол жинхэнэ төрсөн нутаг ус минь шүү дээ. Тэнд юу ч байсан гэсэн үүнийг хайрлахгүй байхын аргагүй. Хүмүүний орчин гэдэг ийм л байна. За чи өөрийнхөө

тухай надад ярь л даа. Чамайг Гименейн баяр баяслыг мэдэрсэн гэж Хогэн надад хэлсэн. Бараг хоёр жил байх аа. Бяцхан Чэндпэр минчийтлээ улайж, үл ялиг инээмсэглэв.

- Тийм ээ, гэж тэр хэлэв.

- Өнгөрсөн тавдугаар сард хуримаа хийсний нэгжилийн ой тохиосон юм.

- Тэгвэл чамд чин сэтгэлээсээ баяр хүргэхийг зөвшөөрнө үү? хэмээн Игнатий Галлахер өгүүлэв.

- Оройтсон ч гэсэн баяр хүргэе! Би чиний хаягийг мэдэхгүй тул цаг тухайд нь баяр хүргэж чадсангүй.

Тэрбээр гараа сунгахад Бяцхан Чэндлэр түүнийг атгав.

- Чамд болон танай гэр бүлд хамгийн сайн сайхан, мөн хөрөнгө мөнгөтэй болохыг хүсэн ерөөе! Тэгээд өөрийн биеэр чамайг дуудах хүртэл тайван амьдарна биз дээ? гэж Галлахер хэлэв. Эрхэм Томми, чиний хамгийн хуучны анд нөхөр чинь энэ бүхнийг хүсч байна. Чи үүнийг ойлгож байна уу?

- Ойлгож байна аа? гэж Бяцхан Чэндлэр өгүүлэв.

- Хүүхэдтэй юу? хэмээн Игнатий Галлахер асуув.

Бяцхан Чэндлэр байдгаараа дахин улайв.

- Бид нэг хүүхэдтэй гэж тэр хэлэв.

- Хүү юу, охин уу?

-Хүү.

Игнатий Галлахер найзынхаа мөрөн дээр чангахан алгадсанаа:

- Сайн байна. Томми, би чамд ерөөсөө эргэлзэж байгаагүй! гэж хэлэв.

Бяцхан Чэндлэр инээмсэглээд хүүхдийнх шиг гурван цагаан шүдээр доод уруулаа хазлаад өөрийнхөө шилэн аяга руу зовсон янзтай харав.

- Явахаасаа өмнө чамайг манайхаар ирнэ гэдэгт би найдаж байна. Эхнэр маань баярлах болно шүү!

- Хонгор минь маш их баярлалаа гэж Игнатий Галлахер хэлэв.

- Бид эртхэн уулзаагүй нь жаахан харамсалтай юм.

Гэвч би маргааш орой явах ёстой.

- Тэгвэл өнөөдөр болох уу?

-Хонгор минь, надад тун харамсалтай байна. Би ганцаараа биш ээ. Найзтайгаа явж байгаа юм. Маш сонирхолтой залуу, бид хөзөр тоглохоор тохирчихсон юм. Тэгээгүй бол ч...

- Тэгэлгүй яахав би ойлгож байна...

- Хэн мэдлээ хэмээн Игнатий Галлахер бодлогошронгуй хэлэв. - За одоо ч нүүр хагарчихлаа. Тиймээс ирэх жил би танайд дахин ирж болох юм. Хугацаа хойшлох нь ямар ч таашаалыг үгүй хийхгүй биз дээ?

- Сайн байна. Чи дараа ирэхдээ манайд зочлоорой. Заавал шүү!

- Тэгэлгүй яахав. Ирэх жил чадвал заавал ч үгүй ирнэ гэж Parole d' honneur!1.

- Харин бидний гэрээг улам батжуулахын тулд дахин нэг нэг татчихъя. Игнатий Галлахер том алтан цагаа гаргаж ирээд цагийн зүүг харав.

- Сүүлчийнх бол яая гэхэв. Намайг цаана чинь хүмүүс хүлээж байна гэж тэр хэлэв.

- Яг сүүлчийнх! гэж Бяцхан Чэндлэр өгүүлэв.

- За яахав, тэгвэл бас ахин нэг нэг хундага deos an doruis2 татаж болох юм.

Бяцхан Чэндлэр виски захиалав. Хэдхэн хормын өмнө түүний хацар дээр туяарч байсан өнгө эдүгээ нүүрээр нь нэг тарж улаа бутарчээ. Тэр үргэлж хөнгөхөн улайдаг байв; харин одоо бол бага зэрэг сэтгэл нь хөөрч нэлээдгүй халсан ажээ.

1 Амлаж байна! /франц/

2 Аян замд гарахаас өмнө /ирланд/

Тэрбээр үргэлжид биеэ барьж, эрүүл мэндийн хувьд ч эмзэгхэн нэгэн байсан тул гурван шилэн аяга виски түүний толгойд гарч, Галлахерын дайлсан хатуухан навчин тамхи тархийг нь манантуулж орхив. Найман жилийн дараа Г аллахертай уулзаж, тодхон гэрэл гэгээ, дуу чимээтэй “Корлэсс”-т түүний хамт сууж, андынхаа яриаг сонсч, нүүдэлчний гялалзсан амьдралд бага боловч оролцох нь түүний хувьд адал явдал байлаа. Тэрбээр найзынхаа амьдралыг өөрийнхтэйгөө харьцуулж үзээд нэлээдгүй ялгаа байна гэдгийг мэдэрмэгц энэ бол шударга бус явдал гэж үзэв.

Угтаа бол Галлахер насаар ч, боловсролоор ч түүнээс дор нэгэн байлаа. Найзынхаа хэзээ ч хийж чадахгүй тийм зүйлийг тэр хавыгүй дээр хийж чадна гэдэгтээ итгэлтэй байсан агаад ямар нэгэн гудамжны сэтгүүл зүйгээс илүү зүйлийг боломж олдвол хийх л байсан гэдэгтээ тэр туйлаас итгэлтэй байлаа. Түүний замд юу саад болов? Азгүй бүрэг зан уу? Өөрийнхөө өмнөөс тэр өшөө авч, эр хүнийхээ мөн чанарыг өндөрт өргөхийг хүсэв.

Галлахер чухам ямар учраас түүний урилгаас татгалзсаныг тэр өөрөөр тайлбарлаж байв.

Гагцхүү чин үнэнч нөхөрлөлөөр түүнийг хүртэх учиртай байсан нь Ирландад ирснээрээ тэр өршөөгдөх байсантай адилхан байв. Барны үйлчлэгч виски авчирч өгөв. Бяцхан Чэндлэр нэг аягатайг найз руугаа түлхээд өөр нэгийг шалмагхан өргөв.

- Ирэх жил чамайг ирэхэд би ноён, хатагтай Галлахер нарт аз жаргал хүсч байх ч юм бил үү, хэн мэдлээ! гэж аягатайгаа тулгасны дараа тэр хэлэв.

Виски залгилахзуур Игнатий Галлахер нэг нүдээрээ шилэн аяганы амсар дээгүүр харав. Ууж дуусмагц ширээн дээр аягаа тавьснаа тун шийдэмгий гэгч нь тамшаалав.

- Эрхэм найз минь, санахын ч хэрэггүй! Эхлээд би жаал юм үзэж, нүд тайлах болно. Тэгж байж л нэг сая дөнгөнд орж мэдэх юм.

- Хэзээ нэгэн цагт тэгж л таарна даа! гэж Бяцхан Чэндлэр аядуухан хэлэв. Игнатий Галлахер бяцхан шар зангиа, хар занар мэт гүн цэнхэр нүдээрээ найз руугаа ширтэв.

- Чи тэгэж бодож байна уу? хэмээн тэр асуув.

- Өөрт тохирсон бүсгүйгээ олж чадвал бусдын адил дөнгөнд орох болно гэж Бяцхан Чэндлэр итгэлтэйхэн давган өгүүлэв. Үүнийг тэр нэлээд ихэмсэг өнгөөр хэлүүт өөрийгөө барьж өгснөө мэдрэв; хэдийгээр түүний хацрын улаан бага зэрэг арилсан ч найзыгаа тэр цоо ширтсээр байлаа. Игнатий Галлахер хэсэг зуур түүний царай руу харж байснаа:

- Хэрэв хэзээ нэгэн цагт ийм явдал болох аваас өөрт үлдсэн сүүлчийн шиллингээ бооцоо болгон тавих болно. Хэрэг явдал ямар ч асуудалгүйгээр болж л таарна. Би бол мөнгөтэй болсон хойноо л гэрлэнэ. Эсвэл нөгөөх маань банкинд хадгаламжтай, дуулгавартай зарцтай байвал энэтухай бодно. Бяцхан Чэндлэр толгой сэгсрэв.

- Хүн гуай, та юу бодож байна аа? гэж Игнатий Галлахер тун халуухан хэлэв.

- Би ганцхан үгхэлэхэд маргааш нь л гэхэд авгай авч мөнгөтэй болох болно. Итгэхгүй байна уу? Гэхдээ би үүнийг сайн мэдэж байна.

Мөнгөний үнэр авахуулаад, ганц ирмэхэд л дуусах мянга мянган жүүд юм уу, герман хүүхнүүд хаа сайгүй байна гэж би хэлнэ...

Найз минь хүлээж бай! Үүнийг би хэрхэн хэрэгжүүлэхийг чи хараарай!

Найз нь ямар нэгэн юм хийхээр шийдсэн бол алдаа гаргана гэж үгүй. Жаахан хүлээж бай! Тэрбээр амандаа аягаа ойртуулж, вискигээ ууж дуусмагц чанга чанга хөхрөв. Дараа нь тэр хоосон орон зай руу бодлогошронгуй харц чулуудаад арай тайван дуугаар,

- Гэхдээ би яарахгүй байна. Тэд хүлээж л байг. Өөрийгөө би ганцхан хүүхэнтэй холбохыг хүсэхгүй байна гэв. Тэрбээр ямар нэгэн зүйлийг амталж буй мэт уруулаа хөдөлгөх зуур царайгаа мушилзуулав.

- Залхсан цагт харин болох л юм гэж тэр хэлэв.

Бяцхан Чэндлэр үүдний өрөөнд хүүхэд тэврэн сууна. Хэмнэлт хийхийн тулд тэд гэрийн үйлчлэгч аваагүй ажээ. Моника болон түүний дүү Энни нар өглөө, оройдоо ээлжлэн гэрийн ажилд тусалдаг байв. Гэвч Моника аль хэдийнэ гэр рүүгээ явчихсан байлаа. Есөн цагт арван таван хором дутуу байв.

Бяцхан Чэндлэр цайны цагаас хоцорсноос гадна Бьюлийн1 кофег Эннид авчрахаа таг мартжээ. Мэдээж хэрэг тэр байдгаараа уурлаж, түүнтэй бараг юу ч ярьсангүй. Тэрбээр цайтай цайгүй болно гэж хэлсэн ч, булангийн дэлгүүр хааж байх үед, хоёр фунт элсэн чихэр, бага зэрэг цай авахаар явах болжээ. Нойрсч буй хүүхдээ түүний гарт тэврүүлснээ:

- Барьж бай! Битгий сэрээчихээрэй! Гэж тэр хэлэв. Ширээн дээр цагаан шаазан бүрхүүлтэй бяцхан чийдэн асч, эврэн хүрээтэй гэрэл зураг дээр тусч байв. Энэ бол Эннийн зураг аж.

Бяцхан Чэндлэр түүн рүү харснаа, жимийсэн нарийхан уруулыг нь зогтусан ажиглав. Хэзээний ч билээ, нэгэн бямба гарагийн орой бэлэг болгон түүнд авчирч өгсөн цайвар хөх1 Дублиний нэгэн дэлгүүр өнгийн цамцыг тэр өмссөн байлаа.

Үнэ нь арван шиллинг, арван нэгэн пенс; гэсэн хэдий ч ямар их сэтгэлийн зовлонг тэр амссан гээч! Дэлгүүрийн үйлчлүүлэгчид цөөрөхийг хүлээн лангууны дэргэдэх гадна хаалган дээр тэр тарчилж байхдаа хэнээс ч хамааралгүй чөлөөтэй байхыг оролдсон ч худалдагч бүсгүй түүний өмнө эмэгтэй хүний цамц эвхэж байх үед, кассанд мөнгөө тушааж хариултаа авахаа мартаж, чингээд кассчиныг түүний араас дуудахад дэлгүүрээс гарахдаа улаа бутарсан царайгаа нуухын тулд боодолтой цамцаа сайн зангидаж уу гэдгийг шалгаж байхдаа тэр ямар их тарчилж байсан гэж санана. Гэртээ эргэж ирээд тэр өнөөх цамцаа Эннид өгөхөд, түүнийг үнсээд маш сайхан чамин хийцтэй цамц юм гэж хэлсэн ч үнийг нь сонсуут өнөөх цамцаа ширээ рүү шидэлж, ийм юм арван шиллинг арван нэгэн пенсээр авна гэж юу байсан юм, ёстой л нэг хульхидуулсан байна! гэж билээ.

Эхэндээ ч буцаагаад аваачиж өгөхийг тэр хүсч байсан ч эхнэр нь түүнийг өмсч үзээд тун их таалагдсан тул, эр нөхрөө үнсч, өөрийнх нь төлөө санаа тавьсанд тун их баярласнаа илэрхийлж билээ.

- Хм!

Тэрбээр зураг дээрх нүд рүү хүйтнээр харахад тэд ч мөн түүний харцанд хүйтнээр хариу барив. Тэрхүү царай хийгээд нүд тэр чигээрээ үзэсгэлэн төгс байсан тухайд эргэлзэх зүйл үгүй. Гэвч ямар нэгэн олиггүй зүйл илэрхий байлаа. Яагаад тэрээр ийм цог зальгүй, маягтай байдаг юм бэ? Харцных нь тайван байдал түүнийг балмагдуулж байв. Нүд нь түүнийг түлхэж, ямар нэгэн урин дуудсан байдлыг илтгэнэ. Гэвч түүнд ямар ч тэчъяадал, ямар ч сэтгэлийн хөдөлгөөн үгүй байлаа. Баян жүүд авгай нарын тухай Галлахерын ярьж байсныг тэр эргэн санах.

Дорно зүгийн мойлон хар нүдэнд ямар их тэчъяадал, мэдрэхүйн шаналал байдаг тухай тэр бодолд автав. Хувь заяагаа тэр энэхүү зураг дээрх нүдтэй ямар учраас холбох болов оо? Энэхүү бодолдоо тэр өөрийгөө барьж аваад өрөөн доторхийг айсан байдалтай тойруулан ажиглав. Байраа тохижуулах гэж зээлээр авсан тансаг тавилга нь бас л олиггүй мэт санагдана. Энни түүнийг өөрөө сонгож авсан тул түүнд эхнэрийг нь санагдуулав. Тавилга үнэнхүү чамин

сонгодог хийцтэй байв. Амьдралдаа гутарсан хоосон тэнэглэл түүний дотор сэрэв.

Тэр үнэхээр энэ бачуухан байрнаасаа салж чадахгүй гэж үү? Галлахерын амьдарч буй шигзоримог, шинэхэн амьдралыг одоо эхлэхэд оройтсон гэж үү? Тэр үнэхээр Лондон руу явж чадахгүй юм гэж үү? Ядахнээ тавилгын төлбөр дуусаагүй байдаг. Хэрэв тэр ном бичиж, түүнийгээ хэвлүүлж чадваас маш их боломж өмнө нь нээгдэхээр байлаа. Байроны шүлгийн түүвэр ширээн дээр хэвтэнэ. Тэрбээр хүүхдээ сэрээхгүйн тулд тэрхүү номыг зүүн гараараа нээж, эхнийх нь дөрвөн мөрийг болгоомжтойхон уншиж эхлэв.

Салхи намдав... Шөнийн нам гүмийг үл эвдэнэ;

Сэвэлзэх сэвшээ салхи навчсыг үл оролдоно.

Надад дотнохон булш руу дахин би очно

Маргарита бүсгүйд би цэцгийн баглаатай очно,

Тэрбээр цааш уншихаа болив. Өрөөн доторх бүхий л агаар шүлгээр дүүрсэн мэт мэдрэхүй төрнөм. Энэ бүгдэд ямар их уй гуниг байна вэ? Тэрбээр үүн шиг бичиж, өөрийн шүлгэнд сэтгэлийнхээ уй гашууг илэрхийлж чадна гэж үү? Маш олон зүйлийг тэр дүрслэн бичихийг хүсч байв.

Ядаж л Грэттэний гүүрэн дээрх төрсөн өдрийн сэтгэгдлээс бичмээр байлаа. Хэрэв тэр сэтгэл оюунаа эргүүлж авчирч чаддагсан бол...

Хүүхэд нь сэргэж байдгаараа уйлав. Тэрбээр номноос хөндийрч түүнийг тайвшруулж гарав; гэвч хүүхэд нь дуугүй болохгүй байлаа. Бяцхан Чэндлэр түүнийг бүүвэйлсэн авч уйлах дуун улам бүр цангинав. Хүүхдээ улам хүчтэй бүүвэйлэх эуур түүний нүд хоёр дахь бадгийг уншиж байлаа.

Амьгүй цогцос нь хүйт даан бээрч байхад

Амьдрал гэдэг аль хэдийнэ! ...

Ямар ч хэрэг алга. Унших ч боломжалга. Юу ч хийх боломж алга. Хүүхдийн уйлах чимээнээс болж чих нь дөжирчээ. Ямар ч хэрэг алга. Тэрбээр бүхий л амьдралдаа олзлуулсан хүн. Түүний гар уурласнаасаа болж чичрэх агаад гэнэтхэн тэр бяцхан үрийнхээ нүүрэн дээр тонгойж, дуугүй бай! хэмээн чанга дуугаар хашгирав. Хүүхэд нь тэрхэн агшинд дуугүй болсноо айснаасаа болж дахин орилж гарав.

Бяцхан Чэндлэр хүүхдээ тэвэрсээр сандлаас босч, өрөөн дотуур урагш, хойш холхиж гарав. Хүүхэд нь зогсоо зайгүй уйлснаас болж хахаж цацан агшин зуур дуугүй болсноо, дараа нь улам хүчтэй орилж, чарлах ажээ. Хүүхдийн орилох чимээнээс болж нимгэн хана чичирхийлнэ. Түүнийг аргадах гэж тэр оролдсон ч хүүхдийн уйлах дуун мэгшилт болж хувирав.

Тэрбээр байдгаараа ээрэх бяцхан хүүгийн царай руу! Байроны залуудаа бичсэн шүлгийн



хэсгээс /1802/ хараад нэлээд сандрав. Хүү долоо дараалан зогссон тул Бяцхан Чэндлэр айснаасаа болж энгэртээ наав. Тэр үхчихвэл яана аа? Энэ үеэр хаалга дуу шуутайхан нээгдэж, залуухан эмэгтэй амьсгаадсаар орж ирэв.

- Юу болсон бэ? гэж тэрээр хашгирав. Бяцхан хүү эхийнхээ хоолойг сонсоод улам бүр чарлав.

- Энни юу ч болоогүй, юу ч болоогүй! Тэр зүгээр л уйлаад байна...

Тэрээр худалдаж авсан зүйлээ шалан дээр хаячихаад түүний гараас хүүхдээ суга татаж авав.

- Чи түүнийг яачихсан юм бэ? гэж өөдөөс нь харсаар хашгирав. Бяцхан Чэндлэр агшин зуур харц тулгармагц, зүрх нь байдгаараа базалж, ямар их үзэн ядаж байгааг түүний нүднээс нь уншив.

- Юу ч болоогүй... тэр... уйлсан... Би яаж ч чадаагүй. Би түүнийг яагаа ч үгүй...

- Юу гэнэ ээ? Түүнийг огт анхаарсан шинжгүй хүүхдээ тэвэрсээр нааш цааш өрөөгөөр алхах зуур:

- Бяцхан амьтан минь! Хонгорхон үр минь! Чамайг бүр айлгачихав уу? За яахав миний хүү битгий уйл! Ээжийн муухай амьтан хаана байна?

За яахав, за, за...

Бяцхан Чэндлэр ичсэнээсээ болж хацар нь улайж буйг мэдэрмэгц ширээний гэрлээс зайдуухан зогсов. Хүүхдийн уйлах чимээ улам бүр намсч буйг тэр сонссоор зогсоно; харин энэ мөчид харууслын гашуун нулимс түүний нүдэнд цийлэгнэж байлаа.

## Хуурамч дүр

Утасны хонх жингэнэн дуугарч, хатагтай Паркэтыг харилцуураа авахуйд хойд ирланд аялгатай цангинасан дуугаар:

- Фэррингтоныг наашаа дууд! гэж ууртайхан хашгирах нь сонсдов.

Хатагтай Паркэт бичгийн машин руугаа эргэн очиж, ширээн дээр тонгойн зогсох хүнд хандан:

- Ноён Олэйн таныг ороод ир гэж байна! хэмээн хэлэв.

- Чөтгөр алгад! гэж өнөөх эр хагас өнгөөр бувтнаад, босохоор сандлаа хойш болгов. Тэрбээр өндөр нуруутай, махлаг нэгэн байв. Улаан дарсан өнгө бүхий хөөнгө царай, цайвар сахал, хөмсөгтэй түүний, нүд ялимгүй бэлцийж, булингартай харагдана. Тэрбээр хаалтны түгжээг мулталж, үйлчлүүлэгчдийн хажуугаар хүндхэн гишгэлсээр албан өрөөнөөс гарав.

Хоёр давхрын шат өөд арайхийн гармагц үүдэн дээрээ хүрэл пайз бүхий “Ноён Олэйн” гэсэн хаягтай хаалганы босгон дээр түр саатаж, ядарч балмагдсандаа ч тэр үү амьсгаадсаар хаалга тогшив.

- Ороорой! гэх огцом дуу сонсдоно. Тэрбээр ноён Олэйны албан өрөөнд оров.

Шавилхан биетэй, сахлаа хуссан цэвэрхэн царайн дээр алтадмал хүрээтэй нүдний шил зүүсэн ноён Олэйн бөөн бичиг баримт дунд толгойгоо наачихсан сууж байлаа. Түүний толгой ямар ч үсгүй, ягаавгар өнгөтэй байх агаад яг л цаасан дээр хэвтэх томхон өндгийг санагдуулна.

Ноён Олэйн цаг алдахыг хүсээгүй бололтой:

- Фэррингтон уу? Энэ чинь юу болж байна аа? Хэдий болтол би танд анхааруулах вэ? Бодли, Кирван нарын гэрээний хуулбарыг та одоо болтол яагаад хийгээгүйг асууж болох уу? Дөрвөн цаг гэхэд надад хэрэгтэй гэж танд хэлсэн биз дээ? гэв.

- Эрхэм ээ, гэхдээ ноён Шэлли хэлэхдээ...

- Эрхэм ээ, ноён Шэлли гэнэ шүү...

- Ноён Шэллийн хэлэхийг бус, харин миний хэлснийг сонсохыг хичээж үз. Та үргэлж л ажлаас бултах арга саам хайх юм. Ажил тарахаас өмнө гэрээний хуулбар бэлэн болохгүй бол энэ талаар би ноён Кросбид хэлэх болно, ойлгож байна уу...

- Тийм ээ, эрхэм ээ.

- Ойлгов уу? Аан, бас нэг юм байна. Тантай ярих ч ханатай ярьсантай адилхан биз дээ. Өдрийн цай хагас цаг болохоос цаг хагас биш гэдгийг цаашид санаж яв. Таныг хичнээн төрлийн хоол захиалдгийг мэдэж болох уу?.. Одоо ойлгов уу?

- Тийм ээ, эрхэм ээ.

Ноён Олэйн толгой дохин бичиг цаас, овоолсон баримт руу дахин тонгойв. Харин мөнөөх эр “Кросби ба Олэйн” пүүсийн ажил хэргийг зохицуулж буй гялаан толгойт руу харж, түүний бөх баг чанарыг тодорхойлохыг оролдоно. Тэрхүү агшинд галзуу өвчин тусав уу гэлтэй хоолой боож, дараа нь арай гайгүй болмогц маш их ам цангахыг мэдэрчээ.

Оройн цагаар сайтар шингэн юм ууж байх ёстой гэдгийг тэр мэдэж байлаа. Удахгүй сарын эцэс болно. Хэрэв тэр хуулбарыг цагт нь хийж өгвөл ноён Олэйн түүнд санхүүгээс мөнгө авах бичиг хийж өгч магадгүй л юм. Тэрбээр овоолгоотой цаасан дунд дарагдаж суугаа дарга руугаа огт хөдөлгөөнгүй, харц салгалгүй ширтсээр зогсов. Гэнэт ноён Олэйн ямар нэгэн зүйл эрж хайх мэт цааснуудыг эргүүлж тойруулж гарав. Дараа нь хүн байгааг анзаарсан мэт дахин тэргүүнээ өндийлгөөд:

- За яав? Та арай өдөржин энд зогсохоор шийдсэн юм биш биз? Фэррингтон, үнэнийг хэлэхэд танд юу ч падлий алга! гэж тэр хэлэв.

- Ви хүлээхээр шийдсэн юм.

- Эрт орой хэзээ нэгэн цагт та хүлээх л болно. Явж тэр ажил төрлөө хий! Тэрбээр хаалга руу дөхөж өрөөнөөс гарахдаа, гэрээний хуулбар орой гэхэд бэлэн болохгүй бол энэ талаар би ноён Кросбид илтгэх болно шүү! гэж ноён Олэйнийг араас нь хашгирахыг тэр дахин сонсов. Тэрбээр доод давхрын өрөөндөө эргэж очуут дахин хэдэн хуудас хуулж бичих шаардлагатай вэ? гэдгийг тоолж үзэв.

Бэх авч янтайд дүрээд, хамгийн сүүлд бичсэн “Хэрэв Бэрнард Бодли байсан тохиолдолд...” гэх үгс рүү тэнэг хүн шиг нүд цавчилгүй харсаар байлаа. Харанхуй болж байв; хэдэн хормын дараа гэрэл өгмөгц бичих боломжтой болно. Тэрбээр амныхаа цангааг тайлах давж дийлэшгүй шаардлагыг мэдэрчээ.

Хаалтны түгжээг дахин мултлаад тэр өрөөнөөс гарав. Түүнийг гармагц албаны дарга нь гайхсан байдалтай харав.

- Ноён Шэлли, санаа бүү зов! гэж хэлээд хааш явж буйгаа хуруугаараа заав.

Албаны дарга өлгүүр рүү хяламхийн харснаа, бүрх малгай- нууд байрандаа байгааг олж хараад юу ч хэлсэнгүй. Шатны талбай дээр өнөөх эр дөрвөлжин шоотой малгай халааснаасаа гаргаж өмсөөд, даруйхан шатаар гүйж одов. Үүдний танхимаас тэр тун чимээгүйхэн хана бараадан явсаар, эцэст нь ямар нэгэн хаалга руу шурхийн оров. Бөглүү буланд орших тусгай өрөө бүхий 0’Нэйлийн зоогийн газарт хэн ч түүнийг үл харна.

Тиймээс тэр улаан дарс юм уу, бараан махны өнгө бүхий халуу шатсан толгойгоо зоогийн газрын руу онгорхой шагайвч РУУ цухуйлган:

-Хөөе Пат, найз л юм бол ганц аяга дарс өгчих! гэж хашгирав. Зоогийн газрын зөөгч шилэн аягатай дарс авчирч өгөв. Сайн эр түүнийг нэгэн амьсгаагаар дуустал нь хөнтөрчихөөд

гоньдны үрл байна уу? гэж асуув. Чингээд лангуун дээр нэг зоос гаргаж тавиад, харанхуйд түүнийг тэмтэрч олох боломжийг зөөгчид олгомгоцоо өнөөх л хулгайн, гэтсэн алхаагаар тэндээс сэмхэн гарч одов.

Харанхуй хийгээд өтгөн манан хоёрдугаар сарын үдшийн бүрийг эзэмдэх үед Юстэйсийн гудамжны дэнлүүнүүд ч асав. Тэрбээр албан өрөө рүүгээ хана даган явахдаа, гэрээний хуулбарыг цаг тухайд нь дуусгаж чадах болов уу? гэдгийг дотроо бодож байлаа. Шатаар өгсж явтал үнэртэй усны сэнгэнэсэн үнэр хамар нэвт цоргиулав.

Түүнийг 0'Нэйпийнд байх үед хатагтай Дэлакүр ирсэн бололтой. Тэрбээр малгайгаа авч халааслаад, юу ч болоогүй юм шиг өрөөндөө оров.

- Ноён Олэйн таныг асуусан шүү! гэж албаны дарга хатуухан хэлэв.

- Ингэхэд чи хаачихав аа?

Хаалтны дэргэд хоёр үйлчлүүлэгч байх тул, хариулахад эвгүй байна гэдгийг илтгэх мэт тэдний зүг хяламхийн харав. Үйлчлүүлэгчид эрчүүд байсан тул албаны дарга юун ч сүртэй! Согтууруулах архи дарсны үнэрийг дардаг юм гэж бодов.

- Энэ тоглоомыг чинь би мэднэ ээ! гэж тэр хэлэв.

- Өдөрт таван удаа, арай ихдэж байгаа юм биш үү... За яахав, цаг алдалгүй Дэлакүрын хавгаст хэрэгтэй холбоотой бичиг цаасыг ноён Олэйнд зориулж сонгоод аль! Гадны хүмүүсийн дэргэд ийм зэмлэл хүртсэндээ, халыт мулы дарс залгилаад шатаар яаравчлан өгссөнөөс болж сайн эрийн толгой булингартсан мэт манарч байлаа. Тэрбээр шаардлагатай бичиг баримтыг олж өгөхөөр өрөөндөө орж суумагц, оройн тав хагас гэхэд гэрээний хуулбарыг дуусгах ямар ч найдвар үгүй гэдгийг сая л нэг ойлгов.

Чийгтэй, харанхуй үдэш болж байх тул уушийн газар орж, тодхон гэрэлтэй газар аяга тагш юм харшилдуулан найз нөхөдтэйгээ суух хүсэл түүнийг чангаана. Тэрбээр Дэлакүрт холбогдох хэрэг бүхий хавтсыг олуут, өрөөнөөс гарав. Сүүлчийн хоёр захидал байхгүй гэдгийг ноён Олэйн анзаарахгүй байж мэднэ гэдэгт тэр найдвар тавьжээ.

Сэнгэнэсэн сүрчигний үнэр ноён Олэйны албан өрөө хүртэлх бүхий л замд ханхийж байлаа. Хатагтай Дэлакүр нэг их залуухан бус жүүд эмэгтэй ажээ. Ноён Олэйн түүнд, эсвэл мөнгөнд нь сэтгэл алдарсан тухайд тэр хавиар нэг шивэр авир ярьцгаана. Тэрээр үргэлжид түүний албан өрөөнд айлчилдаг агаад нэг ирсэн бол нэлээд удаан саатдаг байжээ. Эдүгээ тэр сүрчигнийхээ үнэрт автан бичгийн ширээний дэргэд, бүрх малгайнхаа том хар өдийг дохилзуулан шүхрийнхээ бариулыг ширтэж суулаа.

Ноён Олэйн түүнийг харахын тулд эргэдэг сандлаа эргүүлчихсэн хөлөө ачин сууна. Сайх эр хавгаст хэргийг ширээн дээр тавиад тун хүндэтгэлтэйгээр мэхийн ёсолсон ч, ноён Олэйн, хатагтай Дэлакүр нарын хэн нь ч түүний мэхийн ёсолсныг анзаарсангүй. Ноён Олэйн хавгаст хэргийг хуруугаараа товшиж байснаа, баярлалаа, одоо та явж болно гэсэн шиг хэргийг хажуу тийш түлхэв. Тэрбээр доош бууж өрөөндөө оров. Дараа нь тэр: “Хэрэв энэ тохиолдолд

Бэрнард Бодли байвал...” гэж бичиж дуусгаагүй өгүүлбэрээ нүд цавчилгүй, анхааралтайхан ширтэхдээ, сүүлчийн гурван үг нэг ижил үсгээр эхэлж буйг эргэцүүлэн бодов. Албаны дарга шуудан явуултал бүх захидлыг уншиж амжихгүй дээ гэж хатагтай Паркэрийг яаравчлуулж эхлэв. Хэсэг хормын турш сайх эр бичгийн машины түчигнэх чимээг сонсч байснаа, дараа нь гэрээнийхээ хуулбарыг хуулж гарав.

Гэвч түүний толгой даагдашгүй хүнд болсон агаад сэтгэл санаа нь тодхон гэрэл бүхий уушийн газарт аль хэдийнэ морилчихсон байлаа. Иймэрхүү өдөр ч халуун дарс шимэх сайхан шүү! Хуулбартай ноцолдож байх зуур оройн таван цаг болов. Дуусаагүй хуудас арван дөрөв үлджээ. Чөтгөр аваг гэж! Тэртэй тэргүй цагтаа дуусна гэж байхгүй! Тэрбээр чанга дуугаар хараал тавьж, байдгаараа ширээ шаахыг хүсэв. Тэр “Бэрнард Бодли” гэж бичихийн оронд “Бэрнард, Бэрнард” хэмээн давтаад биччихсэн байх тул бүхий л хуудсыг шинээр хуулахад хүрч ёстой л галзуурахад ганц хуруу дутуу байв.

Ганцаараа бүхий л албан газрыг ч байсан сүйд хийх хүч түүнд байгаа гэдгийг мэдрэв. Түүний бие ямар нэгэн юм хийх хүсэлдээ автаж, эргэн тойрон бүхнийг сүйд хийж, үнс нурам болгоход бэлэн байлаа. Амьдралын ядуу дорой байдал уур хилэнд автахад хүргэжээ... Цалингийн урьдчилгаа авах талаар санхүүгээс өөрөө ч гуйдаг юм бил үү? Үгүй ээ, санхүүд найдах хэрэггүй! Тэр юу боллоо гэж цалингийн урьдчилгаа өгөх билээ? Леонард О’Хэллорен, Урт хамарт Флинн зэрэг залуусыг хаанаас олж болохыг тэр сайтар мэдэж байлаа. Түүний дотоод хэмжүүр хүчтэй салхи шуурга дэгдэхийг мэдэрчээ. Бодолдоо гүн гүнзгий автсан тул, өөрийг нь дуудаж буйг гурав дахь удаа- гаа дуудуулж байж сая нэг юм мэдэв.

Ноён Олэйн, хатагтай Дэлакүрын хамт хаалтны дэргэд зогсчихсон, бүх ажилчид юу болохыг хүлээн тэдний зүг эргэн харцгаана. Тэр өрөөнөөс гарав. Ноён Олэйн хоёр захидал дутуу байгааг үзүүлж, хатуухан үгсийг урсгаж эхлэв. Харин түүний албат байгаа бүхнийг нь хуулан бичсэн, өөр юу ч мэдэхгүй хэмээн хариулж байлаа. Хилэнт үгс үргэлжлэн урссаар байх агаад тэр бүхэн ямар аймшигтай, хэрцгий байсан гэж санана. Энэ нь урдаа зогсч буй одой хүний толгой дээр нударга занги- дан хүчтэйхэн буулгах чин хүслээ арай ядан намжаахтай нэгэн адил хэрэг авай.

- Хоёр захидлын чинь талаар би юу ч мэдэхгүй! гэж тэнэг юм шиг тэр давтан өгүүлж байлаа.

- Та юу ч мэдэхгүй гэж үү? - Нээрээ ч хаанаас мэдэхэв дээ! гэж ноён Олэйн хэлэв. - Чи сонс, намайг хэн гэж бодоод байгаа юм бэ? Ямар нэгэн дүүрчихсэн амьтан гэж бодоод байгаа юм биш биз? хэмээн дэргэдээ зогсч буй хатагтайгаас дэмжлэг хүсэх мэт эргэн харсаар өгүүлэв.

Сайх эр хатагтайн царайнаас өндгөн хэлбэртэй бяцхан толгой руу харц шилжүүлснээ эргэн харав; түүнийг юу хийж байгааг ойлгохоос нь өмнө боломж гаруут ам хэлээ ашиглав.

- Эрхэм ээ, уучлаарай! Гэхдээ иймэрхүү асуудлаар надад хандах хэрэггүй ээ! гэж тэр хэлэв. Үүний дараа тэнд байсан түшмэлүүдийн амьсгал ч үл сонсдом завсарлага үргэлжлэв.

Бүгд л тун их балмагдсан байлаа. (Энэхүү арга сүвэгчилсэн этгээд хүртэл бусдаасаа дутуугүй айсан байв). Харин хатагтай Дэлакүр хэмээх мяраалаг биетэй, жавхалзсан авхай байдаг чангаараа инээд алдав.

Ноён Олэйн нохойн хошуу мэт ягаарсан ч одой хүний уур хилэн түүний амыг мурийлгав. Тэр сайх эрийн хамрын өмнө гараа зангидан сэгсрэхэд, тэрхүү зангидсан гар байдаг хурдаараа чичирхийлж буй мэт санагдав.

- Балмад этгээд! Бүдүүлэг амьтан! Одоо чи юу болохыг харна аа гайгүй! Та нар сонсов уу? Одоохон уучлалт гуйхгүй бол эндээс зайл!

Тэрбээр албан газрынхаа үүдний эсрэг талд санхүүгийн ажилтныг гарч ирэхийг хүлээн зогсоно. Бүх ажиллагсад тарсан бөгөөд хамгийн сүүлд санхүүч, албаны даргын хамт гарч ирэв. Даргын дэргэд түүнтэй ярих шаардлага үгүй байлаа. Санасан ажил нь бүтэлгүйтэж буйг ойлгов. Тэрбээр өөдөөс нь үг сөрснийхөө төлөө ноён Олэйнээс байж боломгүй уучлалт гуйлаа гэхэд, тэр өдрөөс эхлэн тайван ажиллахгүй гэдгээ сайтар мэдэж байлаа. Ноён Олэйн урьд нь ач хүүдээ ажлын байр гаргаж өгөхийн тулд бяцхан Пикийг байж суух газаргүй болтол нь дарамталж байсныг ч эргэн санах.

Үзэн ядалт, өшөө авах хүсэл, улангассан байдал зэрэг түүнийг тарчлаана; тэр өөртөө болон бүхий л орчлонд гомдож байлаа. Ноён Олэйн одоо тайван байлгахгүй.

Түүний амьдрал жинхэнэ там болж хувирна. Энэ удаа тэр боловсон тэнэг амьтныг хэн ч биш болгосон.

Ингэхэд түүний хэлнээс хэн чангаасан юм бэ? Юутай ч энэ бүхэн нэлээд дээр үеэс улбаатай аж. Ноён Олэйныг хойд ирланд аялгаар ярьж буйг Хиггинс, хатагтай Паркэр нар тоглоом шоглоом хийж тохуурсныг сонссоны дараа түүнтэй юу ч яриад нэмэргүй болов. Үүнээс л бүх юм эхэлсэн. Хиггинсээс мөнгө нэхвэл яах бол? Гэхдээ нэмэргүй дээ. Хиггинст ганц ч пэнни байхгүй дээ.

Хоёр гэр бүл тэжээж байгаа хүнд юу л байв гэж...

Түүний үлэмж том бие уушийн газрын тав тухыг мөрөөдөж, уйтгарт дахин автав. Тэрбээр манарч эхэлсэн тул 0'Нэйлийн зоогийн газарт очиж Патаас мөнгө зээлдэг юм бил үү гэж бодов. Тийм ээ, түүнээс сайндаа л нэг шиллинг олж долооно биз. Тэр шиллингээр тэгээд яах юм бэ?

Ямар ч байсан хаа нэгтэйгээс мөнгө олох хэрэгтэй. Өөрт байсан сүүлчийн пэннийгээр дарс авч уусан. Удахгүй харанхуй болж мөнгө олох аргагүйд хүрнэ. Тэрбээр цагныхаа гинжийг хуруугаараа имрэх зуур Флитын гудамж дахь Тэрри Кэллийн ломбардыг санах. Энэ ч сайхан санаа байна шүү!

Яагаад энэ тухай толгойд орж ирсэнгүй вэ! Тэрбээр Тэмпл- Барын нарийн гудамжаар хараал идсэн амьтдын тухай хамар дороо үгэлсээр явахдаа, энэ үдшийг ёстой нэг хүссэнээрээ өнгөрөөх болно гэж бодов. Тэрри Кэллийн ажилтан, нэг кроноор үнэлэв. Гэвч үнэлгээч үзээд, ердөө л зургаан шиллинг олгохыг зөвшөөрөв.

Эцсийн бүлэгт түүнд зургаан шиллинг тоолж өгөв. Ломбардаас тэр тун сэтгэл хангалуун гарч ирэхдээ долоовор болон, эрхий хурууныхаа завсар хэдэн зоосоо тас чимхэж барьсан байлаа.

Уэстморлендын гудамж дахь явган хүний зам ажлаасаа таран харьж буй залуусаар дүүрэн, хаа сайгүй үдшийн сонингийн нэрс хашгирах сонин түгээгч жаалууд үсрэн цовхчих авай. Тэрбээр хүмүүсийн дундуур явахдаа, бичээч нар, мөрдөн байцаах газрын ажилтан хүүхнүүдийн зүг ялалтын харц чулуудан тун чиг бардамхан харна.

Түүний толгойд трамбайн дуу чимээ, дугуйт тэшүүрийн исгэрэх чимээнээс болон шуугиж байхад хамрынх нь хоёр хар нүх уур савсуулан дэгдэх халуун дарсны үнэрийг сорж байлаа. Замдаа тэр, энэ бүхнээ хэрхэн найз нартаа ярих талаар хэлэх үгээ бодож явлаа.

- За тэгээд энэ үеэр би түүн рүү харна, та нар ойлгож байна уу? Нэлээд тайван харна, дараа нь нөгөөх эмэгтэй рүү харна. Дараа нь ахиад л түүн рүү харж, нэг их яарч сандарсан зүйлгүй “Уучлаарай, эрхэм ээ! Гэхдээ иймэрхүү асуудлаар надад хандах хэрэггүй байх” гэж хэлэх тухайгаа бодов. Урт хамарт Флинн Дэви Бэрний уушийн газрын өнөөх л суудалдаа тухалж, Фэррингтоныг яриагаа дуусахад түүний өмнө хагас пинт тавьж, энэ бол тун сайн хэрэг хэмээн дэмжив; Фэррингтон ч хариуд нь түүнийг дайлав. Хэсэг хугацааны дараа 0’Хэллорн, Падди Леонард нар орж ирсэн тул тэдэнд ч мөн бүх яриагаа эхнээс нь ярихад хүрэв.

0’Хэллорн бүгдийг нь халуун вискигээр дайлж Фаузын гудамж дахь Кэлленийд ажиллаж байхдаа тэр нэгэн удаа мөрдөн байцаах газрынхаа даргыг хэрхэн болгож тавьсан тухайгаа өгүүлэв; гэвч түүний ярианаас үзвэл хариулт нь тун эелдэг байсан агаад Фэррингтоны хариулт хавьгүй хатуу байсан гэдгийг тэр хүлээн зөвшөөрөхөөс аргагүйд хүрэв.

Энэ үеэр Фэррингтон, аяганыхаа ёроолыг харчихаад, дахиад нэмье! гэж нөхөддөө уриалав. Хамгийн гол нь хүн бүр өөрт тохирсон хорыг сонирхлоороо сонгож байх энэ үед Хиггинс хэмээх нөхөр орж ирэв. Мэдээж хэрэг түүнийг ширээндээ суулгахаас өөр аргагүй байлаа. Хэрэг явдал юу болсон талаар түүнээс асууж лавласан бөгөөд таван шилэн аяга халуухан виски хүртсэний дараа тэр хавьгүй сайхан зантай болж, бүх явдлыг нүдэнд харагдтал ярьж өгөв.

Ноён Олэйнийг Фэррингтоны хамрын өмнө гараа зангидчихсан зандарч байгааг тэр дүрслэн үзүүлмэгц, тэнд байсан бүх хүмүүс татаж унатлаа хөхөрцгөөв. Дараа нь тэр Фэррингтоныг танилцуулаад “Энэ үед манай баатар эр ийм тайван байна...” гэж хэлэхүйд, хүндхэн, булингартай харцаар Фэррингтон бүгдийг тойруулан харж, сахлаас нь бөнжигнөх вискины дуслыг үе үехэн доод уруулаараа сорон инээмсэглэж байлаа.

Энэ удаад ч мөн шилэн аяганууд хоосрох үед нам гүм болов. 0’Хэллорнд мөнгө байсан авч өнөөх хоёрт нь бодвол юу ч үлдээгүй бололтой; тиймээс тэр гурав харамсах юмгүй уушийн газрыг орхин одоцгоов. Дьюкийн гудамжны өнцөг дээр Хиггинс болон Урт хамарт Флинн нар зүүн гар тийш эргэж, харин үлдсэн хоёр нь хотын төв рүү буцав. Жавартай хүйтэн гудамжинд бороо шивэрч, тэд Балласт Офис1 дээр дөхөж очив.

Фэррингтон тэднийг Шотланд уушийн газар руу орохыг санал болгов. Тэнд бөөн хүн байхаас гадна шилэн аяга, хүмүүсийн дуу хоолой харшилдах чимээ сонсдоно. Тэр гурав үүдэн дээр гуйлга гуйж зогсох шүдэнз зарагч нарын хажуугаар чихцэлдэн орж, нэгэн босоо лангууны өнцөг дээр зайчлан зогсоцгоов.

# 1 Дублины усан боомтын ажлыг зохион байгуулагч байгууллага

Чингээд онигоо ярьж гарав. Леонард тэднийг “Тиволи”1-д нугарагч, дуучин зэрэг өвөрмөц ажил хийдэг Уэзерс хэмээх залуутай танилцуулж, Фэррингтон бүгдийг нь дайлахаар болов. Уэзерс аполлинаристай2 ирланд вискинээс нэг шилэн аягаа ууна гэж хэлэв. Биеэ хэрхэн авч явахыг нэгд нэгэнгүй мэддэг Фэррингтон рашаан уух өөр хүн байна уу? гэж тэднээс асуув. Гэвч Тимд хандан тэд халуухан юм аваад ир хэмээн хэлэв.

Ярианы сэдэв театр руу шилжив. Хэдийгээр Уэзерс татгалзах зуураа тэднийг дэндүү ирланд маягаар зочломтгой хандаж буйг нотлон хэлсэн ч эхлээд 0’Хаплорн, дараа нь Фэррингтон бас дахин нэг удаа бусдыгаа дайлав. Тэднийг тэр хөшигний араар оруулж. Аятайхан бүсгүйчүүдтэй танилцуулахаа амлав. Леонард бол явна, харин Фэррингтон явахгүй, тэр чинь гэр бүлтэй хүн гэж 0’Хэллорн хэлэв; тэдний наргианыг ойлгож буйгаа илтгэх мэт тэнд байсан нөхдөө хүндхэн, булингар бүхий хөлчүү нүдээр Фэррингтон хяламхийн харав.

Уэзерс бүгдийг нь нэг нэг аяга дарсаар дайлж байгаагаа хэлээд, арай хожуухан Пүлбэгийн гудамж дахь Маллиганыд уулзацгаая гэж амлав. Шотланд уушийн газрыг хаамагц, тэд Маллиганы руу нүүдэллэн шилжив. Тэд шуудхан арын өрөө рүү нь орцгоож, 0’Хэллорн бүгдэд нь халуун дарс өгөхийг зөөгчид сануулав. Тэд нэлээдгүй халамцжээ. Уэзерсийг ирэх үед Фэррингтон бусдыгаа дайлахаар зэхэж байв. Фэррингтоны аз болоход тэр ганцхан хундага хатуу юм захив.

Мөнгө ч урссаар л... Гэвч одоохондоо хоосрох болоогүй.

1 Италийн Аниэн гол дээрх усан хүрхрээг хүндэтгэн нэрлэсэн Дублины нэгэн театр

2 рашаан ус

Гэнэт том бүрх малгайтай хоёр залуухан хүүхэн, мөн шоон хээтэй хослол бүхий залуу эрийн хамт орж ирэн хажуугийн ширээнд сууцгаав. Уэзерс тэдэнд хандан мэхийн ёслоод, тэр гурвыг “Тиволи”-ийн ажилтнууд гэж хамт суугаа санаа нэгтнүүддээ хэлэв. Фэррингтоны харц залуу хүүхнүүдийн нэгэн дээр үе үехэн тусна. Түүний гаднах байдлыг харахуйд анхаарал татахуйц нэгэн байлаа.

Холимог өнгөтэй хөх шаа бүхий урт ороолт нь бүрх малгайг тойрон хүрээлж, эрүүнийхээ дор том эрвээхэй болгон зангидсан байлаа; тод шар өнгийн бээлий нь тохойндоо хүрэх ажээ. Олны анхаарлыг татахуйц хөдлөх түүний өргөн мөр рүү Фэррингтон биширсэн байдлаар харна; хэсэг хугацааны дараа тэр түүний харцанд хариу барьж, том алагхан нүд нь улам бүр бишрэхэд хүргэв.

Ялимгүй хяламхийн, цоо ширтэх нь түүний сэтгэлийг тун ихээр хөдөлгөх аж. Бүсгүйн зүг тэр дахин нэг хоёр удаа харж, хамт яваа хүмүүстэйгээ өрөөнөөс гарах үедээ сууж байсан сандлыг нь хөндөж, Лондон маягийн аялгаар “O’ pardon” гэж хэлэв. Тэр түүний араас харж, бүсгүйг эргэн харна хэмээн найдсан ч, тэрээр эргэж харсангүй. Өөрийнхөө ядуу байдлыг тэр үзэн ядаж, энэ үдэш хүн амьтан дайлж, Уэзерсыг рашаантай вискигээр дайлсандаа дэндүү их харамсав.



Хэрэв энэ мөчид тэр хэн нэгнийг үзэн ядаж байсан бол, бусдын мөнгөөр уухыг дурлагсдыг л үзэн ядаж байв. Түүний уур ихэд хүрч байсан тул найзууд нь юун тухай ярьж байсныг тэр сонсохыг хүссэнгүй. Падди Леонард түүнд хандав; хөнгөн атлетикийн тухай ярьж байсан аж. Уэзерс тэнд байсан хүмүүст гарынхаа булчинг үзүүлэн сагсуурч, үндэсний нэр төрийг дэмжихийн төлөө түүнийг дуудсан юм гэж онгироосон тул Фэррингтон ч мөн ханцуй шамлан гарынхаа булчинг үзүүлжээ.

Тэр хоёрын булчинг нэгд нэгэнгүй харьцуулан харж үзээд, эцсийн эцэст гар барилдаан хийхээр шийдвэрлэсэн байна. Ширээг цэвэрлэж, өрсөлдөгч нар гар гараасаа барилцан тохойлдон сууцгаав. Падди Леонардыг дохио өгөхөд тэд өрсөлдөгчийнхөө гарыг түрүүлж дарах учиртай байв. Фэррингтон тун шийдэмгий, албархуу төрх эсгэв. Тэмцээн эхлэв. Гучин мөчийн дараа Уэзерс өрсөлдөгчийнхөө гарыг алгуурхан дарж ялав. Фэррингтоны царай улам бүр барайж, ийм новшийн гөлөгт ялагдсандаа болж уурлах, ичих хоёр зэрэгцэж байлаа.

- Бүх биеэрээ дарж болохгүй! Дүрмээ сахина шүү! гэж тэр хэлэв.

- Хэн дүрэм зөрчсөн юм! гэж Уэзерс хэдэрлэнэ.

- Дахиад эхэлье! Гурваас хэн нь хоёр удаа ялахыг үзье! Тэмцээн дахин эхлэв.

Фэррингтоны духны судас гүрийж, харин Уэзерсийн цонхигор царай цээнийн өнгө шиг болов. Тэр хоёрын гар хуруу байдгаараа чичирхийлнэ. Нэлээдгүй тэмцэлдсэний эцэст, Уэзерс өрсөлдөгчийнхөө гарыг дахин алгуурхан ширээн дээр буулгаж авав. Үзэгчдийн дунд сайшаан дэмжих дуу чимээ сонсдоно. Ширээний буланд зогсч байсан зөөгч залуу ялагчид хандан шар толгойгоо дохиж:

- Ёстой алах нь байна шүү! гэв.

- Чамд ямар хамаатай юм бэ? гэж Фэррингтон түүн рүү харж уурсангүй хэлэв.

- Энэ чиний хийх ёстой ажил биш байх шүү нөхөр минь!

- Чимээгүй, юу болов оо? хэмээн Фэррингтоны уурласан байдлыг олж хараад О'Хэллорн хэлэв.

-Залуусаа,өндөрлөх цаг боллоо. Дахиад нэг, нэгийг тогтоогоод гэр рүүгээ харьцгаая.

Баргар царайт нөхөр О' Коннелийн гүүрэн дээр Сэндимаунт руу явах трамбай хүлээн зогсоно. Түүний дотор уур хилэн, өшөө авах хүсэл буцалж байлаа. Тэр асар их доромжлол, харууолыг мэдэрч байсан агаад бараг архи нь гарчихсан байвч, халаасанд нь гагцхүү хоёр пэнс л үлджээ.

Энэ ертөнцийн бүх зүйлийг тэр хараав. Ажил дээрээ эвгүй байдалд орж, цагаа барьцаанд тавьж, бүх мөнгөө үрсэн ч олигтойхон ууж чадсангүй. Тэр дахин ам цангахыг мэдэрч, бүгчимхэн тамхины утаа болсон уушийн газар руу эргэн очих хүсэлдээ автав. Хэн нэгэн шалдан банди хоёр ч удаа түүнийг ялсны дараа, жинхэнэ хүчтэн хэмээх нэр хүнд нь шалдаа

буув.

Зүрх сэтгэл нь уур хилэнд авгаж, том бүрх малгайтай эмэгтэйг санахуйд уур хилэн нь түүнийг арай л боогоод алчихсангүй. Трамбай түүнийг Шэлборны зам хүртэл хүргэж өгсөн агаад хүндхэн, лагс зовлогоо тэр хуарангийн ханын дэргэдүүр арайхийн чирч явлаа. Гэр рүүгээ харихаас дургүй хүрнэ. Арын хаалгаар орохдоо тэр галын өрөөнд хэн ч үгүй, зуухан дахь гал бараг унтарсныг олж харав.

Гэнэт тэрбээр:

- Ада! Хөөе, Ада! хэмээн хашгирав.

Түүний эхнэр гэж намхан нуруутай, олби оготно шигхүүхэн нөхрийгөө эрүүл үед эрүүний шөл уулгаж, харин согтсон үедээ нөхөр нь түүнийг болгож тавьдаг тийм л нэгэн эмэгтэй байлаа. Тэд таван хүүхэдтэй ажээ.

Бяцхан жаалхүү шатаар уруудан бууж ирэв.

- Тэнд хэн байна аа? гэж харанхуй тийш харан эцэг нь асуув.

- Би байна аав аа.

- Би гэж хэн бэ? Чарли юу?

- Үгүй ээ, аав аа, Том байна.

- Ээж чинь хаана байна?

- Сүм рүү явсан.

- Оройн хоол яасан бэ? Надад хоол тавьсан уу?

- Тийм ээ, аав аа. Би...

- Наад гэрлээ асаа! Та нар чинь яагаад харанхуйд байж байдаг юм? Бусад нь хааччихсан юм? Унтчихсан юм уу?

Түүнийг сандал дээр лагхийн суух үед жаалхүү ширээний чийдэнг асаав. Тэрбээр хүүгийнхээ хэлснийг шоолон: “Сүмд... Сүмд гэж хэл дээ” хэмээн хагас өнгөөр бувтнав. Гэрэл асмагц, тэр зангидсан гараараа ширээ шааж, байдаг чангаар:

- Тэр хоол чинь хаана байна аа? гэж хашгирав.

- Аав аа, би одоохон бэлдээд өгье! гэж жаалхүү хэлэв. Эцэг нь уурандаа огло харайн босч зуух руу хуруугаа чичлэн,

- Ийм гал дээр гэж үү? Наадхи бүх юм чинь түлэгдээд дуусчихлаа! Алив байз, галыг нь яаж

тохируулахыг би чамд харуулаад өгье. Тэрбээр хаалга руу очиж буланд байх таягыг шүүрч авав.

- Гал алдвал яадгийг чи одоо мэдэх болно гэж хэлээд тэр ханцуйгаа шамлав.

- Аав аа! хэмээн жаалхүү хашгирснаа, ширээ тойрон уйлсаар зугтаж гарав. Гэвч түүний эцэг араас нь элдэжхөөсөөр хүрэмнийх нь захаас барьж авав. Жаалхүү байдгаараа ийш тийш харсан ч аврал олох газар нэгэнт үгүйд өвдөг сөхрөн унав.

- Дараагийн удаа чи гал алдахгүй байх болно! гэж эцэг нь хашгираад түүнийг таягаар тун хүчтэйхэн далайн цохив.

- Гөлөг минь, энэ чамд хангалттай!

Жаалхүү өвдсөнөөсөө болж орь дуу тавихад, түүний гуяыг таягаар шилбүүрдэж гарав. Тэрбээр гараа зангидаж, айснаасаа болж хоолой нь чичирхийлж байлаа.

- Аав аа! гэж тэр хашгирна.

- Аав аа, намайг битгий зод л доо! Таны өмнөөс би залбирах болно...

Аав аа, би Гэгээн Дарь-Эхээс гуйх болно... Аав аа, би Гэгээн Дарь-Эхээс гуйх болно...

## Шороо

Хүүхнүүдийг цайгаа ууж дууссан даруйд, ахлагч эмэгтэй түүнд явах зөвшөөрөл олгосон агаад эрх чөлөөт үдшийг өнгөрүүлнэ гэхээс Мария хөл нь газар хүрэхгүй баярлаж байлаа.

Гал тогоонд бүх юм байдгаараа гялалзана; том хүрэл тогоонуудыг толины оронд хэрэглэж болохуйц хэмжээнд гялалзаж байна гэж тогооч авгай хэлэв. Зууханд гэрэл сацруулан гал асч, хажуугийн нэгэн ширээн дээр дөрвөн том бялуу тавьжээ. Холоос харахад хэрчээгүй мэт санагдана; гэвч ойроос ажвал, зузаан зузаан зүсэм болгож нямбайлан хэрчсэн байх агаад одоо түүнийг цайтай хамт өгч болохоор байлаа. Мария бялууг өөрөө зүссэн ажээ.

Тэрээр тун намхан нуруутай урт хамар, эрүүтэй нэгэн байв. Мария үргэлж л хамраа гуншигнуулан “тийм ээ, хонгор минь” “үгүй ээ, хонгор минь” гэх зэргээр эелдэгхэн ярих нь хэн нэгнийг тайвшруулж байгаа мэт санагдана. Авгай, хүүхнүүд тэвшнийхээ төлөө хэрүүл маргаан дэгдээхэд үргэлж түүнийг зохицуулагчаар явуулах бөгөөд энхийг сахиулах үүрэг нь үргэлжид амжилтаар өндөрлөнө.

Нэгэн удаа ахлагч түүнд хандан:

- Мария, та бол жинхэнэ энхийг сахиулагч шүү! гэж хэлжээ. Энэхүү магтаалыг угаагч эмэгтэй, хоёр ивээгч авгай сонсчээ. Харин Жинжэр Мүни, дүлий индүүчин Мариаг байгаагүйсэн бол балрах байсан тухай үргэлж ярьдаг байв. Мариаг бүгд л хайрлаж хүндэтгэнэ. Цай зургаан цагт бэлэн болно. Тиймээс долоо болохоос өмнө тэр явж болно. Боллсын гүүрнээс Нильсоны Багана хүртэл хорин хором, Баганаас Драмкондра 1 хүртэл хорин хормын зайтай. Мөн худалдаа хийхэд хорин хором зарцуулна. Тиймээс тэр найман цаг гэхэд өлхөн оччихсон байна.

Тэрээр мөнгөн түгжээтэй хэтэвчээ гаргаж ирээд "Белфастаас мэнд хүргэж байна" хэмээх бичгийг дахин нэг удаа уншив. Мария таван жилийн тэртээ Олф Жо нарын Сүнснүүдийн өдөрт оролцохоор Белфаст руу явахдаа авчирч өгсөн энэхүү хэтэвчинд тун их хайртай ажээ. Хэтэвчинд хоёр хагас крон, мөн хэдэн задгай мөнгө байв. Трамбайд суусны дараа цэвэр таван шиллинг үлдэнэ.

Хүүхдүүд бүгд дуу дуулцгааж, ямар сайхан үдшийг тэд өнгөрөөнө гэж санана. Хамгийн гол нь Жо гэртээ битгий л согтуу ирээсэй билээ. Уучихаараа тэр хүнээ байчихдаг юм. Тэр нэг бус удаа хамтдаа амьдрахыг түүнээс гуйж байжээ;

Гэвч (хэдийгээр Жогийн эхнэр түүнд үргэлж сайн ханддаг байсан ч) тэднийг багтаж ядаж байхад саад болно гэхээс тэр эмээнэ. Үүнээс гадна тэр угаалгын газар дахь амьдралдаа аль хэдийнэ дасчихсан байлаа. Жо бол дажгүй залуу.

Мариа түүнийг, мөн Олфийг ч өсгөж, хүмүүжүүлсэн хүн; тиймээс Жо түүнд хандан:

- Ээж бол ээжээрээ. Харин миний жинхэнэ эх бол Мариа юм шүү! гэж хэлнэ.

Гэр бүл салсны дараа, хөвгүүд түүнд “Үдшийн Дүблин” хэмээх угаалгын газарт ажил олж

өгсөн нь ихэд таалагдсан байна. Юун түрүүн тэрээр протестантуудын2 талаар тун буруу

1 Дублины ойролцоох хот

2Үдшийн Дүблин” хэмээх угаалгын газарнь протестант шашны байгууллагын ивээн тэтгэлгээр оршин тогтнодог байжээ.

Ойлголттой явж байсан ч одоо тэднийг ямар сайхан хүмүүс болохыг нь бага ч атугай ойлгосон ажээ. Хэтэрхий аядуу тайван, албархуу зантай авч хамт амьдрахад тун давгүй хүмүүс гэдгийг тэр өдөр ирэх бүр сайтар мэдэрнэм.

Үүнээс гадна өөрийн гэсэн ургамал ногоо хүлэмжинд тарьж, арчлах тун дуртай байв.

Гайхамшигт ойм хийгээд лаван модод тэнд байхаас гадна хэрэв хэн нэгэн айлчилж ирвэл зочиндоо өөрийн хүлэмжнээс хоёр гурван үрсэлгээний мөчир бэлэглэдэг заншилтай байжээ. Түүний цорын ганц дургүй зүйл нь амь аврагч товхимлууд байсны сацуу үргэлжид нүднээ тусах нь ядаргаатай хэдий ч ахлагчтай ажил ярихад тун аятайхан, жинхэнэ хатагтай байлаа.

Тогооч авгай бүх юм бэлэн гэж түүнд хэлэхэд, тэрээр цайны газарт орж том хонх жингэнүүлж гарав. Хэсэг хугацааны дараа хоёр, гурваараа авгай, хүүхнүүд цуварч халуу дүүгсэн чийгтэй алгаа банзлынхаа хормойд арчингаа ханцуйгаа буулгана. Тогооч болон дүлий бүсгүй хоёр томоос том зэс данхтай чихэртэй сүүтэй цайг тэдний өмнөх аварга том сэнжтэй аяганд хийж өгнө. Мариягийн хувьд амтат бялуу хуваах ажлыг хариуцаж хүн бүр өөрт оногдох дөрвөн зүсмийг авч буй эсэхийг хянана.

Цайны цагаар инээд наргиан, хошигнол ч гэж жигтэйхэн. Жил бүрийн Бүхий л Гэгээнтнүүдийн өдөр, Марияд л мэдээж бөгж таарна даа гэж Флэминг хэлдэг байсан ч тэрээр ичингүйрэн инээмсэглэж, түүнд ямарч бөгж хэрэггүй, эр нөхөр ч бас хэрэггүй Бүх Гэгээнтнүүдийн өдрийн өмнө буюу аравдугаар сарын 31-нд амтат бялуу жигнэдэ гуламжлалтай байжээ. Мөн мэргэ төлгө хийхийн өмнө ч гэсэн үүнийг ашиглана. Энэ тохиолдолд бялуунд бөпк болон самар хийж жигнэдэг уламжлалтай байжээ. Хэрчсэн бялуунд нь бөпк гарч ирвэл тухайн хүн төдөлгүй гэрлэх ёстой болдог байна; харин самар гарч ирсэн тохиолдолд тэр хүн өөрийн хувь заяаг бэлэвсэн хүнтэй холбохын тэмдэг хэмээн үздэг байжээ. Харин самрын яс нь хоосон байх аваас бүсгүй насаараа хөгширсөн хүүхэн болон үлдэж, залуу хүн байваас насаараа гоонь явдаг байна гэж Лиззи Флэмингийг хэлэхэд хариуг нь барина. Түүнийг инээх үед хөх саарал нүдэнд нь мартагдсан итгэл сэргэж хамрынх нь үзүүр, эрүүнийх нь үзүүрт бараг шүргэдэг байв.

Дараа нь Жинжэр Мүни аягатай цайгаа өргөж, Мариягийн эрүүл мэндийн төлөө уухыг санал болгохдоо, иймэрхүү тохиолдолд угтаа дарс балгах нь зүйд нийцэх тухай хэлэхэд, бусад нь бүгд сэнжтэй аягаа барин ширээгээ нүдэж гарав. Мариаг байдгаараа инээд алдахуйд, хамрын үзүүр эрүүнийх нь үзүүрт бараг тулах агаад жижигхэн бие нь инээдээ барьж чадалгүй салгалж, Мүнийг ямар ч боловсролгүй, эгэл эмэгтэй гэдгийг мэдэж байсан ч түүнийг аль болох сайн сайхныг хүсч буйг тэрээр мэдэж байлаа.

Хүүхнүүд цайгаа ууж дуусмагц тогооч болон дүлий охин хоёр аяга саваа хураах зуур Мариа

тун их сэтгэл өндөр байсан аж. Тэрээр өөрийнхөө өрөөнд очмогц, маргааш өглөө эрт сүмийн цуглаанд очих ёстой гэдгээ санаад цагийнхаа зүүг долоо дээр байсныг зургаа дээр шилжүүлж тавив. Дараа нь тэр ажилдаа өмсдөг банзал, гэрийн шаахайгаа тайлж хамгийн дажгүй гэсэн банзлаа орон дээрээ гаргаж тавиад хаяхан нэг амралтын өдрөөр л өмсдөг бяцхан шаахайгаа гаргав.

Тэрээр бас өөр цамц өмсөв; толины өмнө зогсохдоо залуу насаа дурсаж, бүтэн сайн өдөр сүмийн цуглаанд явахдаа байдаг бүхнээрээ гоёхыг хүсч байсан жижигхэн биеэ тун хачин энхрийлсэн байдлаар ажив. Насыг нь эс тооцвол, тэр тун хонгорхон, аятайхан биетэй байлаа. Түүнийг гудамж руу гарахад зам талбай борооны дараа өнгө орон гялалзах агаад хуучин бор цуваа өмссөндөө тэр тун их баярлав. Трамбайд олон хүнтэй байсан тул ард талын жижигхэн сандал дээр суухад түүний хөл шаланд арайхийн хүрч байлаа.

Одоо тэр хэрхэхээ бодож, өөрийн гэсэн мөнгөтэй хэнээс ч үл хамаардаг бол ямар сайхан бэ гэж бодож явлаа. Мэдээж хэрэг тэд гайхамшигтай үдшийг өнгөрөөх болно. Хамгийн гол нь Олфи, Жо хоёр бие биетэйгээ юу ч ярихгүй байгаа нь л харамсалтай. Одоо тэд байнга хэрүүл хийнэ. Хүүхэд байхдаа ямар сайхан тайван амьдарч байлаа даа.

Гэвч амьдрал гэдэг ийм хойно яалтай ч билээ дээ. Баганын дэргэд тэр трамбайгаас бууж, олны дундуур сурамгай гэгч нь сүлжин явлаа. Чингээд Даунзын нарийн боовны дэлгүүрийг зүглэж, бөөн хүн байсан тул дарааллаа болтол чамгүй удаан хүлээхэд хүрэв. Арав орчим амтат боов ширхэгийг нь нэг пеннигээр авч, эцэст нь том цаасан уут барьсаар дэлгүүрээс гарав. Дараа нь тэр өөр юу худалдаж авахаа бодов; ямар нэгэн амттай зүйл авахыг тэр хүсчээ.

Алим, самар бол тэднийд хангалттай байгаа. Юу авах талаар бодно гэдэг амаргүй бодлого байлаа. Шанзтай жигнэмэгнээс өөр ямар ч юм толгойд нь орж ирсэнгүй. Тэрээр шанзтай жигнэмэг худалдан авахаар шийдсэн ч Даунзын жигнэмэгийн чихэртэй бүйлсний түрхлэг тун бага байсан тул Хенрийн гудамж дахь өөр нэгэн нарийн боовны дэлгүүрийг зүглэв.

Тэнд очуут тэр юу авахаа шийдэж ядан удаан зогссон тул, лангууны ард байсан хээнцэр хувцастай залуухан авхай тэсвэр алдсан бололтой, та арай хуримын бялуу сонгох гэж байгаа юм биш биз? хэмээн асуужээ. Энэ үед Мария байдгаараа улайж, бүсгүйд хандан инээмсэглэхүйд бүсгүй түүнд шанзтай жигнэмэгээс том зүсмийг хэрчиж цаасанд ороож өгөөд:

Хоёр шиллинг, дөрвөн пэнс гэж хэлэв.

Трамбайд оруут тэр Драмкондра хүртэл бүхий л замын турш зогсохоос аргагүй боллоо хэмээн бодсоор байлаа. Учир нь тэнд байсан залуусын хэн нь ч түүнийг үл анзаарч байгаа мэт санагдсан ч нэгэн хижээл насны эр хажуу тийш болж суудлаа тавьж өгчээ. Тэр эр нэлээдгүй тарган, хар хүрэм, цомбон малгай өмссөн байв; тэрбээр буурал суусан сахал, дөрвөлжин улаан нүүртэй ажээ.

Түүнийг хараад Мария, энэ лав хурандаа хүн байх аа хэмээн бодов. Толгойгоо ч өндийлгөхгүй, юу ч болоогүй юм шиг суух залуу хүмүүсийн хажууд тэр хавьгүй эелдэг нэгэн байлаа. Сайх эр түүнтэй Бүх Гэгээнтнүүдийн өдрийн тухай, бороотой цаг агаарын тухай яриа

өрнүүлэв. Түүний торонд хүүхдэд зориулсан амттан буй гэж таамаглаж байснаа ч хэлэв. Ингэх ч ёстой юм. Залуу цагтаа баярлаж цэнгэхгүй бол, хэдийд ингэж наргих вэ гэж тэр нэмж өгүүлэв.

Мария түүнийг хүлээн зөвшөөрсөн байдалтай толгой дохин суулаа. Түүнд тэр ихэд өгөөмөр хандсан тул сувгийн дээгүүрх гүүрэн дээр буух үедээ талархал илэрхийлэн мэхийн ёслоход, тэр ч бас хариуд нь хүндэтгэн ёслоод, бүрх малгайгаа авч дээш өргөв. Жижигхэн толгойгоо гудайлган бороон дор эрэг дагуу явахдаа хэдийгээр бага зэрэг үнэртүүлсэн ч жинхэнэ эр хүн гэдэг эхний харцаар л тодорхой байх юм даа гэж тэр бодов.

Гэрт оруут Жо болон тэнд байсан хүмүүс Мария эгч ирлээ! хэмээн орилцгоов. Жогийн хувьд дөнгөж сая ажлаасаа тарж ирсэн аж. Хүүхдүүд нь бүгд баяр ёслолын байдалтай гоёлын хувцсаа өмссөн байв. Зэргэлдээх байрнаас мөн хоёр бүсгүй ирсэн байсан тул найр наадам ид дундаа хавтгайрчээ. Мария бэлэгтэй уугаа Олфид өгч, бүх хүмүүст тараахыг хүсэхэд, ийм их амттан өгч хүүхдүүдийг эрхлүүлж болохгүй шүү! Гэж хатагтай Доннели түүнд хандан хэлэв.

- Мария эгнээ, танд их баярлалаа! хэмээн баяр хөөртэйхэн талархал илэрхийлэв. Эцэг, эхэд нь ч бас бэлэгтэй ирсэн гэдгээ Мария дуулгав. Чингээд тэр шанзтай жигнэмэгээ хайж гарав. Тэрээр нарийн боовны уут, цувныхаа халаас, өлгүүр зэрэг газарт хичнээн хайсан ч жигнэмэг хаана ч байсангүй. Хүүхдүүдийн хэн нэг нь андуураад идчихээгүй биз? хэмээн тэр асууж үзэв.

Гэвч хүүхдүүд, үгүй! гэж хариулсан агаад хэрэв тэднийг хулгайд сэрдэж байгаа бол ямар ч нарийн боов хэрэггүй гэж хэлэхийг завдах мэт байдгаараа улайцгаав. Энэхүү оньсогыг хүн бүр өөрийнхөөрөө тайлбарлав. Харин хатагтай Доннели, тэрхүү жигнэмэгээ Мариаг трамбайд орхисон байх гэж хэлэв. Буурал суусан сахалтай эр түүний толгойг хэрхэн эргүүлж байсныг санаад, ичсэндээ Мария байдгаараа улайв. Бүтэлгүйхэн гэнэтийн бэлгээ санаж шал дэмий хаясан хоёр шиллинг дөрвөн пэнсийнхээ төлөө тэр золтой л нулимс унагачихсангүй.

- Энэ бол юу ч биш ээ! гэж Жо хэлээд, задгай галын дэргэд түүнийг суулгав. Түүнд тэр тун эелдэгхэн хандаж байлаа. Ажил дээр нь юу болж байгаа талаар тэр бүгдийг ярьж саяхны нэгэн өдөр захирагчаа болгож тавьсан тухай ч мөн яриа дэлгэв. Юунаас болж Жог ингэж их эмээгээд байгааг Мария ер ойлгосонгүй. Гэвч захирагч хүн гэдэг мэдээж хэрэг дэндүү их эрх мэдэлтэй тул ажил төрөл ярихад хүндрэлтэй байж таарна гэж хэлэв. Тэр тийм муу хүн биш. Хамгийн гол нь хэрхэн эв зүйгээ олохоо мэдэх нь чухал. Дургүйг нь хүргэхгүй бол бүх юм дажгүй гэж Жо хэлэв.

Хатагтай Доннели төгөлдөр хуурын ард сууж, хүүхдүүд дуугаа дуулж, бүжгээ бүжиж гарна. Хөрш айлын бүсгүйчүүд бүгдэд нь самар тараав. Гэтэл хэн нь ч бахь хайгаад олсонгүй. Мариад бахь өгөөгүй юм чинь самрыг тэр яах болж байна аа? гэж Жо хэлээд арай л уурласангүй. Ингээд бөөн эрэл сурал болов. Гэвч Мария самарт дургүй гэдгээ хэлээд санаа зовохгүй байхыг хүсэв. Түүнээс шар айраг уух уу гэж Жог асуухад, дарс увал портвэйн дарс байгаа шүү дээ гэж эхнэр нь хэлэв.

Мариаг юу ч уухгүй гэж хэлсэн ч Жо түүнийг ятгасаар байлаа.

Мария зөвшөөрөхөөс өөр аргагүйд хүрч дараа нь тэд галын дэргэд сууж, өнгөрсөн сайхан цаг үеэ дурсах зуур одоо л нэг Олфийн төлөө үг хэлдэг цаг хэмээн тэр бодов. Гэвч Жо орилж хашгирч эхэлсэн бөгөөд хэрэв тэр дахин нэг удаа ч болов ахыгаа харвал, Бурхан түүнийг гэсгээх болно хэмээн хашгирч гарсан тул, энэ талаар дэмий яриа дэлгэснээ Мария хүлээн зөвшөөрөв. Төрсөн ахынхаа тухай ийм зүйл ярих нь утга учиргүй юм гэдгийг хатагтай Доннели нөхөртөө анхааруулав. Гэвч Жо, Олфи бол миний ах биш гэж хэлүүт, энэ бүхэн арай л хэрүүлээр дууссангүй. Гэвч энэ үдэш бол уурлаж байх өдөр биш гэдгийг тэр хэлээд, лонхтой шар айрагнаас нэмж онгойлгохыг эхнэрээсээ хүсэв.

Бүсгүйчүүд Бүхий л Гэгээнтнүүдийн өдөрт зориулсан жирийн тоглоомуудыг сэдэж, төдөлгүй бүгд хөгжилдөв. Жо болон түүний эхнэр, хүүхдүүд ийм их баяр баясгалантай байгаад Мария маш их баярлаж байлаа. Ширээн дээр Мариаг таваг тавихад, хөрш айлын бүсгүйчүүд хүүхдүүдийн нүдийг боож ээлж дараалан тэднийг ширээ рүү хөтлөн аваачив. Нэгэнд нь залбирлын ном, гуравт нь ус таарчээ. Харин хөрш айлын бүсгүйчүүдийн нэгэнд бөгж тааруут хатагтай Доннели улаа бутарсан бүсгүй рүү хуруугаараа зааснаа: “За тэр харж байна уу, би бас сонссон шүү”<sup>1</sup> гэж хэлэх мэт зангав.

Энэ үед бүгд л, Мариагийн нүдийг ч гэсэн боох хэрэгтэй, тэр бас ширээ рүү очих ёстой гэж хашгиралдав. Түүнд юу таарах нь сонин байна. Нүдийг нь боох зуур Мариа байдгаараа инээж, хамрын үзүүр, эрүүнийх нь үзүүртэй бараг нийлж байлаа. Бүгд инээд хөөр болсоор ширээ рүү дагуулж очиход, гараа урагш алдлан зогсов. Мариа гараараа занган явсаар эцэст нь нэгэн тавган дээр тавив. Түүний хуруунд ямар нэгэн чийгтэй, зөөлөн зүйл мэдрэгдэхэд тэр тун их гайхав.

Бүгд дуугаа хурааж, хэн нь ч түүний нүднээс боолтыг үл авна. Хэсэг зуур нам гүм байлаа; дараа нь бөөн шивнэлдээн, үймээн дэгдэв. Хэн нэгэн цэцэрлэгийн тухай сануулахад, эцэст нь хатагтай Доннели тэнд байсан бүсгүйчүүдийн нэгэнд хандан, үүнийг нэн даруй гаргаж хая! гэж ууртайхан хэлжээ; иймэрхүү зүйлээр тоглодоггүй юм. Энд ямар нэгэн зүйл биш болсон бололтой гэдгийг Мариа сая нэг ойлгов; тиймээс үүнийг дахин давгахаар болж, эдүгээ түүнд залбирлын ном таарчээ. Хатагтай Доннели тэр даруйд рила2-гийн ая тоглож, харин Жо Мариад хандан, нэг жүнз дарс уугаач! хэмээн шахав. Төдөлгүй бүгд дахин баяр хөөрөөр бялхах үед, энэ жил Мариагийн хувьд<sup>1</sup> Бүх Гэгээнтнүүдийн баярын урьд өдөр мэргэ төлгө хийдэг заншилтай бөгөөд мэргэлүүлж байгаа хүмүүс нүдээ боолгож, ширээн дээр байгаа эд зүйлс дээр очиж гараараа хүрдэг байна. Залбирлын ном нь лам болохыг бэлгэднэ. Бөгж-хурим, ус-урт удаан амьдрал, газар-үхлийг бэлгэднэ

2 Шотландын уулынхны хийдэг тойрон бүжиг залбирлын ном хүртсэн тул сүмд очиж суух ёстой болжээ хэмээн хатагтай Доннели хэлэв.

Энэ үдэш шиг Жо хэзээ ч түүнтэй ийм энхрий дотно хандаж байсан нь Мариагийн санаанд ер буусангүй. Өнгөрсөн бүхний тухайд ямар их зүйлийг эргэн дурсаж түүнтэй ярилцав даа. Тэд түүнд үнэхээр чин сэтгэлээсээ хандаж байсан талаар тэр хэлэв. Эцэст нь хүүхдүүд ядарч унтахаар зэхэх үед Жо Мариад хандан, явахаасаа өмнө ямар нэгэн хуучны дуу дуулж өгөөч хэмээн хүсчээ. Хатагтай Доннели ч гэсэн “тийм ээ, тийм Мариа эгч ээ, та дуу дуулж өгөөч” гэв. Мариа босч төгөлдөр хуур руу дөхөв. Хүүхдүүддээ шуугихгүй байхыг анхааруулаад Мариагийн дуулахыг сонс! хэмээн хатагтай Доннели үүрэгдэв.



Дараа нь тэр өмнөтгөл хэсгийг тоглож дуусмагцаа, за Мариягийн ээлж үү? гэв. Энэ үед Мария тун нарийхан чичирхийлсэн хоолойгоор байдгаараа дуулж гарав. “Нэгэнтээ би харшид амьдарч байна гэж зүүдэллээ”<sup>1</sup> хэмээн тэр дуулж гарснаа, хоёр дахь дахилт дээр очуут:

Нүсэр олон боолын дунд хүрээлүүлсээр Нэгэнтээ би харшид амьдарч байна гэж зүүдэллээ.

Төрсөн нутгийнхаа итгэлээр алдар нэрийг хүртэж Түмэн олон албат, хязгаар үгүй баялагтай билээ би.

Аугаа овог нэрээрээ бахархаж явах дуртай Аяа чи минь намайг урьдын адил хайрлаж байна гэж Аргамжаатай зүүдэнд хайрт минь дахин дахин үзэгдсэн шүү! гэж дахин дуулж гарав.

Гэсэн хэдий ч түүний алдааг хэн ч засаж өгсөнгүй; харин дуулж дуусахад нь Жо-гийн сэтгэл тун их хөдөлсөн байлаа.

1 М.У.Болфын “Цыган бүсгүй” хэмээх дуурийн арийн хэсэг

Тэнд юу ч гэж ярьж байсан, эрт дээр үед хавьгүй сайхан амьдарч байсан юм, дотны хөгшин Болфаас илүү хөгжим гэж байсангүй хэмээн тэр хэлэв; хоёр нүдийг нь нулимс бүрхмэгц, тэр хайж байсан зүйлээ олж ядан, ингэхэд дарс онгойлгогч хаана байна аа? гэж эхнэрээсээ асуужээ.

## Золгүй явдал

Ноён Жэймс Даффи Дублин хотын иргэн авч бүдүүлэг хэв маяг болон дэндүү орчин үеийн мэт санагдах бусад дайвар хотуудаас аль болохоор холхон, буйдхан газар амьдрахыг хүссэн тул Чэпэлизодод<sup>1</sup> амьдарч байв. Тэрбээр хуучны дүнсгэр нэгэн байшинд амьдарч цонхоор нь хаягдсан дарс нэрдэг үйлдвэр хийгээд Дублин хоттой хаяа залган урсах багшаархан устай голын эрэг ч харагддаг байв.

Өндөр тааз бүхий өрөөнийх нь шалан дээр хивс ч үгүй агаад хананд нь ганц ч зураг үгүй ажээ. Орон байраа тохижуулах гэж хар төмөр ор, төмөр угаалтуур, матмал дөрвөн сандал, өлгүүр, нүүрсний хайрцаг, задгай зуухны галын хайч болон давхар тавиуртай дөрвөлжин ширээ зэргийг олж авсан байна. Номын шүүгээг цагаан модон тавиур бүхий хөндий орлоно. Ор нь цагаан бүтээлэгтэй түүний хөлд улаан, хар өнгийн том ноосон алчуур хэвтэнэ. Бяцхан толь угаалтуур дээр өлгөөтэй өдрийн цагаар задгай зуухан дээр цагаан бүрхүүлтэй ширээний чийдэн байх нь өрөөний цорын ганц гоёл болж байлаа.

Цагаан модон тавиур дээр номнууд өндөр, намаараа өрөөстэй байв. Хамгийн доод тавиурын нэг талын өнцөг дээр Вордсвортын зохиолын бүрэн эмхэтгэлүүд харин эсрэг талын дээд тавиур дээр “Манутын товч сургаал”<sup>2</sup> тэмдэглэлийн дэвтрийн коленкор хавтастай байх аж.

Тавиур дээр үргэлжид бичгийн хэрэгслүүд хэвтэж байдаг байлаа. Хайрцган дотор улаан өнгийн бэхээр тэмдэглэл

1 Домогт өгуулснээр Триетан, Изольда Чэпэлизодод учирч байсан гэдэг

2 Манут хотод Ирландын католик шашны төв байрлаж байжээ хийсэн, хүрэл үдээсээр цоолж тогтоосон тийм ч их биш цаас Гауптманы "Михаэл Крамер"<sup>1</sup> хэмээх жүжгийн зохиолын гар бичмэл бүхий орчуулага хадгалагдаж байлаа. Тэдгээр цаасан дээр цаг үргэлж ямар нэгэн үг өгүүлбэр буй болно; хөгжилтэй байх үедээ нүүрэн талын цаасан дээр нь элэгний эмний сурталчилгааны хуудас нааж байсан ч үе бий.

Тавиурын тагийг авч үзвэл, хуш модоор хийсэн шинэ харандаа юм уу, эсвэл тийш нь хийгээд мартаж орхисон муудсан алимны үл ялиг үнэр дарна. Ноён Даффи биеийн хийгээд сэтгэл санааны тавгүй байдлын аливаа илрэлд үзэн ядах байдлаар ханддаг байв. Дундад зууны эрдэмтэн түүнийг харвал Санчир<sup>2</sup> гарагийн одон дор төрсөн хэмээн лав л хэлэх байсан биз ээ. Ноён Даффийн царайг харахул, хөрслөг бор өнгөөрөө Дублины гудамжийг санагдуулж, өнгөрсөн он жилүүд нь тодхон бичээстэй байлаа.

Нэлээдгүй том, гонзгой толгойд нь хуурай хар үс ургаж, хүрэн шаргал сахал нь амных нь эвгүй хэлбэрийг арайхийн далдална. Товгор шанаа нь түүний царайг улам хатуу дүр төрхтэй болгоно; гэвч улаан шаргал хөмсгөн дороосоо орчлон руу харж байсан түүний нүдэнд ямар ч хэрцгий байдал үл илэрнэ. Тэрхүү нүдний эзэн бусад хүмүүсээс өөрсдийнх нь дутагдлыг нууж буй ямар нэгэн зүйлийг олж харахыг хүсэх авч ихэнхдээ сэтгэлээр унадаг болох нь тодорхой байлаа. Тэрбээр өөрийгөө хөндлөнгөөс харж, хийж буй зан үйлээ хүнийх мэт үл итгэх харцаар ажиглана.

1 Германы жүжгийн зохиолч, яруу найрагч Г.Гауптманы жүжиг /1862-1946/

2 Санчир гарагийн одон дор баргар, эелдэг бус хүмүүс төрдөг хэмээн одон орон судлаачид үздэг аж

Тэр бас тун сонин зуршилтай, цаг үргэлж бодол санаандаа гуравдугаар биед хамаарч, өнгөрсөн цагт үгүйлэгдэх өөрийн тухай үг, өгүүлбэр зохиох нь түүнд ихээхэн таашаал авчирдаг байлаа. Тэрбээр хэзээ ч өглөг өгч байгаагүй бөгөөд самрын модон таягаа тулж хөлөө ширүүхэн тавьж явна. Олон жилийн турш тэр Бегготын гудамжин дахь хувийн банкинд мөнгө тоологч хийжээ. Өглөө бүр тэр Чэпэлизодоос трамбайгаар ирнэ. Үд дундын үед Дэн Бэркийнд очиж лонх шар айраг, нэг таваг амтат жигнэмэг авч иддэг байв. Өдрийн дөрвөн цагийн үед ажлаасаа тарна.

Үдийн хоолоо тэр Жоржийн гудамжин дахь цайны газар идэх агаад тэндхийн хоол унд тун дажгүйн сацуу Дублины “Хүнлэг залуустай” учрах аюул үгүй байв. Үдэш оройг тэр байрны эзэгтэйн төгөлдөр хуурын ард юм уу, хотын захаар тэнүүчилж өнгөрөөнө. Моцартыг бишрэн шүтдэг нь заримдаа дуурь юм уу, ямар нэгэн концерт руу очиход хүргэнэ. Энэ бол амьдралынх нь цорын ганц зугаа цэнгэл байлаа. Танил тал, найз нөхөд, гүн ухааны тогтолцоо, итгэл зэрэг нь түүний хувьд хамааралгүй зүйл ажээ. Тэрбээр хэнтэй ч үл харилцах агаад хамаатан саднаа Зул сарын баяраар л нэг эргэж тойрч, үхэх цагт нь харин чимээгүй хот руу үдэж мордуулах мэтээр гагцхүү өөрийнхөө амьдралаар л хоног өдрийг төөрүүлнэ. Гагцхүү энэ хоёр үйл явдлыг хуучны ёс заншлыг хүндэтгэн гүйцэлдүүлдэг байсан болохоос биш нийгмийн амьдралыг удирдаж буй нөхцөл байдлын ямар ч зүйлд бууж өгдөггүй байв. Тодорхой нөхцөлд банк дээрэмдэж болох юм гэж боддог байсан ч иймэрхүү байдал ер үүсэхгүй байснаас гадна түүний амьдрал үйл явдал үгүй тууж шиг нэгэн хэмээр урсана.

Нэгэн үдэш Ротондад1 очихдоо тэр хоёр бүсгүйн дэргэд суудал таарчээ. Танхим дахь нам гүм хийгээд хүн цөөтэй нь цөм шаталтыг илтгэнэ. Түүний дэргэд сууж асан бүсгүй хоосон танхим руу хоёронтаа эргэн харснаа:

- Өнөөдөр ийм цөөхөн хүнтэй байгаа юм уу, ямар харамсалтай юм бэ? Хоосон танхимын өмнө дуу дуулна гэдэг эвгүй шүү дээ гэв.

Эдгээр үгсийг сонсуут энэ бол яриа өдсөн урилга хэмээн тэр ойлгов. Хатагтайн биеэ чөлөөтэй авч яваа байдал түүнийг гайхшруулав. Түүнтэй ярилцах зуур тэр ой ухаандаа царайг нь төсөөлөхийг оролдов. Түүний дэргэд суугаа бүсгүй охин нь гэдгийг мэдмэгц энэ хатагтай надаас хоёр юм уу, нэг насаар дүү байж таарна гэж бодов.

Бодвол залуудаа сайхан бүсгүй байсан болов уу гэлтэй түүний царай эдүгээ хүртэл цовоо сэргэлэн төрхийгхадгалжээ. Энэ бол огцом төрх бүхий сувгаан царай байлаа. Гүн цэнхэр нүд нь тас ширтэнэ. Түүний харц эхэндээ урин дуудаж буй мэт санагдавч, гэнэт хүүхэн хараа нь томорч тун эмзэгхэн хэврэгхэн сэтгэл тодхон харагдав. Харин хүүхэн хараа нь багасах үед тэрхүү халы үзэгдсэн сэтгэл хэрсүү ухааны хальсанд нуугдаж, сэргэр том хөхийг нь товойлгох каракулин хантааз нь мөнөөх урин дуудалтыг улам бүр дэвэргэж байлаа.

Хэдэн долоо хоногийн дараа тэр Эрлсфорт Тэртээс дахь концерт дээр түүнтэй дахин учирчээ;

охин нь хэн нэгэн рүү цоо ширтэх мөчид тэрээр боломж гарган ойр дотно танилцахыг оролджээ. Нэг хоёр удаа нөхрийнхөө тухай халт дурссан

1 Дублин хотын Ратлэндын цэцэрлэгт гудамжин дахь театр концертын танхим байрлах дугуй хэлбэртэй байгууламж авч түүний ярианы өнгөнд ямар нэгэн болгоомжлол ер анзаарагдсангүй. Түүнийг Хатагтай Синико гэнэ. Нөхрийнх нь өвөг эцэг Ливорногоос гаралтай аж. Түүний нөхөр Дүблин, Холландын хооронд зорчдог худалдааны усан онгоцны ахмад аж; тэд ганц хүүхэдтэй. Гурав дахь удаагаа санаандгүй тааралдах үедээ болзох хүсэлтэй байгаагаа түүнд эр зориг гарган хэлжээ. Тэр ирэв. Энэ бол анхны бөгөөд ар араасаа олон учрал дагуулсан уулзалт байлаа. Тэд үдэш оройн цагаар болзож, хамтдаа зугаалах хамгийн намуухан гудамжуудыг сонгоно. Гэвч энэхүү нууцлаг байдал нь ноён Даффид дэндүү утгагүй байсан агаад тэд гагцхүү нууцхан уулзах боломжтой гэдгийг ойлгосон цагт өөрийгөө заавал ч үгүй гэртээ урихыг түүнээс хүсчээ.

Ахмад Синико түүний айлчлалыг гүнээ хүндэтгэж, охинтой нь суух санал тавих нь хэмээн гэж бодсон аж. Эхнэрээ тэр сонирхол татахуйц эмэгтэйчүүдийн эгнээнээс аль хэдийнэ хасчихсан тул хэн нэгэн түүнийг сонирхоно гэж огт тооцоогүй байна. Эр нөхөр нь байнга л томилолтоор, охин нь байнга хөгжмийн хичээлдээ явах тул хатагтай Синикотой хамт байх боломж ноён Даффид тун олон гарчээ.

Эдүгээ болтол тэр хоёрын хэн хэнийх нь хувьд ямар ч адал явдал тохиолдож байгаагүйгээс гадна үүнээс тэд ямар ч муу зүйлийг олж харахгүй байлаа. Яваа яваандаа тэр бодол санаагаа түүнтэй хуваалцах болов. Түүнд элдэв дээдийн ном өгч, үзэл санаагаа илэрхийлж, өөрийнхөө ертөнц рүүгээ илбэдэн оруулав. Тэрээр хязгааргүй их баяртай байлаа. Заримдаа түүний эргэцүүллийн хариуд тэрээр амьдралдаа тохиолдсон ямар нэгэн явдлыг ярьж өгнө. Бараг л эхийн хайр халамжаар түүний сэтгэлийг нээж тэр нэг ёсондоо номлогч нь болжээ.

Хэсэг хугацаанд тэр Ирландын Социалист намын хурал цуглаанд оролцсоноо түүнд ярихдаа, бүдэгхэн дэнлүүний гэрэлд цугласан ажилчдын дунд өөрийгөө гадны хүн мэт мэдэрч байснаа хэлэв. Нам нь гурван жигүүр болон салан бутрахад, тус бүр нь өөр өөрийн гэсэн удирдагчтай болсонд тэрбээр хуралд нь оролцохоо больжээ. Ажилчдын өрнүүлж байсан маргаан түүний бодлоор дэндүү энгийн, хэнд ч ойлгомжтой байсны дээр цалин хөлсний асуудалд хандах тэдний сонирхол арай хэтэрхий мэт санагджээ.

Тэд бол жинхэнэ бүдүүлэг ашиг харагчид бөгөөд бодол санаагаа ч тов тодорхой илэрхийлж чаддаггүйг нь тэр мэдэрч байлаа. Энэхүү чадвар нь түүний зав чөлөөний үр дүн байсан юм. Нийгмийн хувьсгал Дүблинд боллоо гэхэд хоёр, гурван зуун жилийн дараа л гарна гэж тэр ярьдаг байв. Түүнээс яагаад өөрийнхөө бодлыг бичиж авахгүй байгаа талаар асуухад. Яах юм бэ? гэж тэр их л хайнгадуухан хариулна. Бодох чадваргүй, хоосон ярьдаг хүмүүстэй жаран мөчийн турш өрсөлдөхийн тулд гэж үү?

Эсвэл ёс суртахуунаа цагдаа нарт тулгаж, урлагийг театрын эздэд итгүүлэхийг хүсч буй муйхар бэртэгчингүүдийн цохилтод өртөхийн тулд гэж үү? Тэрбээр өөрийн амьдарч асан Дүблины ойрол цоох жижигхэн хувийн сууцанд үргэлж очдог байв; үдшийг тэд хоёулаа олонтаа өнгөрөөж байв. Тэдний хооронд оюун санааны хавьталд өсөх тусам ярианых нь сэдэв ч улам бүр эмзэг сэдэв рүү шилжинэ. Түүнийг хүрээлэн байгаа орчин халуун орны ургамалд

зориулсан хүлэмжийн хөрс мэт байв.

Олон удаа түүнтэй хамт шөнө дөл болтол суухдаа дэнлүүгээ асаахыгтөдий л яардаггүй байлаа. Харанхуй, нам гүмхэн өрөө, ганцаардал, чихэнд дуулдсаар байх аялгуу тэднийг улам бүр ойртуулнам.

Энэхүү дотносол түүний сэтгэлийг сэргээж, зан байдлынх нь хурц өнцгийг билүүдэж, хувийн амьдралыг нь сэтгэлийн хөдөлгөөнөөр улам бүр баяжуулж байлаа. Заримдаа тэр өөрийн дуу хоолойг сонсч байгаа мэт бодно. Түүний нүдэнд тэр сахиусан тэнгэрийн хэргэм цол хүртэлээ мандаж, оргилсон сэтгэлтэй найз бүсгүйгээ улам бүр өөртөө татах бүрийд тун хачин, эзэн биегүй хоолойноос өөрийнхөө дууг таньж, хэзээ ч эдгэрэшгүй ганцаардсан сэтгэлийн тухай улам бүр өөртөө итгүүлдэг байлаа.

Бид өөрсдийгөө хэнд ч өгч болохгүй, бид гагцхүү өөрөө өөртөө хамаарна гэж тэрхүү хоолой өгүүлнэ. Нэгэн үдэш хатагтай Синико тун сэтгэл хөдөлсөн байдалтай түүний гараас тачаангуйхан барьсаар хацартаа наах үед эдгээр ярианд төгсгөл тавив. Ноён Даффи тун их гайхширсан байлаа. Түүний үгийг ийнхүү тайлбарласан нь бүхий л хуурмаг үзэгдлийг үгүй хийв. Тэрбээр долоо хоног орчим түүнтэй уулзалгүй байсны эцэст уулзах зөвшөөрөл хүссэн захидал бичжээ. Тэдний сүүлчийн болзоо сүйрсэн нүглээ наминчлах газрын тухай бодлыг эргэн сануулахыг тэр үл хүсч байсан тул Фениксийн цэцэрлэгт хүрээлэнгийн дэргэдэх жижигхэн чихэр боовны дэлгүүрийн үүдэн дээр тэд уулзав. Жиндүүхэн намар цаг хаяанд ирсэн авч гадаах хүйтнийг умартан тэд гурван цаг орчим замаар алхацгаав.

Тэд дахин хэзээ ч уулзахгүй байхаар шийджээ. Аливаа холбоо сүлбээ зовлон авчирдаг юм гэж тэр хэлэв. Цэцэрлэгт хүрээлэнгээс гараад тэд трамбайн зогсоол руу дуугүйхэн явцгаав; гэвч гэнэт тэрээр хүчтэйхэн чичирч эхэлсэн тул түүний зүгээс дахин ямар нэг нялцгар, салж ядсан байдал илрэх вий гэхээс эмээж, түүнийг орхин бушуухан явж оджээ. Хэд хоногийн дараа өөрийн номнууд болон ноот бүхий илгээмжийг хүлээн авав.

Дөрвөн жил өнгөрөв. Ноён Даффи өмнөх амьдралынхаа хэв маягт эргэж оров. Түүний өрөө олон жилийн тэртээх эмх цэгцтэй байдлаа илтгэнэ. Шинэхэн ноотнууд нэг давхрын өрөөний тавиур дээр бий болж, номын тавиур дээр “Заратустра ингэж хэлэв”, “Хөгжилтэй шинжлэх ухаан” гэх Ницшегийн хоёр боть тавиастай байв.

Одоо тэр хайрцганд хэвтэх цааснууд дээр хааяахан нэг бичнэ. Харин хатагтай Синикотой сүүлчийн удаа уулзсанаасаа хоёр сарын дараа: “Хоёр эрэгтэй хүн бие биедээ хайр сэтгэлтэй болох ямар ч боломжгүй. Яагаад гэвэл тэдний хооронд бие махбодийн дотносол байж болохгүй юм. Эр, эм хүмүүсийн хооронд үерхэл нөхөрлөл байж болохгүй. Учир нь бие махбодийн сонирхол зайлшгүй бий болно” гэж бичив. Түүнтэй тааралдахаас айсандаа тэр концерт ч үзэхээ болив. Түүний эцэг нас барав. Банкны ажилтан тэрбээр ажилгүй болов. Гэвч ноён Даффи урьдын адил өглөө бүр хот руу трамбайгаар орж ирээд, үдэш бүр Жоржийн гудамжинд даруухан зоог барьж, үдшийн сонин гарчиглачихаад гэр рүүгээ явган буццаг заншилтай болов.

Нэгэн үдэш тэр бага зэрэг байцаатай давсалсан махнаас ам руугаа дөхүүлснээ гэнэтхэн зогтусав. Түүний харц уншиж буй үдшийн сониных нь нэгэн нийтлэл дээр тогтжээ. Тэрбээр

барьж байсан зүйлээ тавган дээр тавиад тэрхүү нийтлэлийг анхааралтайхан уншиж гарав. Дараа нь аягатай уснаас нэг балгаснаа хажуу тийш нь түлхээд, тэрхүү нийтлэлийг эхнээс нь дуустал хэдэнтээ уншиж үзэв. Тавган дээрх байцаа тос даасан харагдана. Зөөгч бүсгүй түүн рүү дөхөж оройн зоог амттай байсан эсэхийг лавлав. Хоол тун сайхан байсан гэж тэр хэлээд хоёр, гурван хэрчмийг арайхийн үмхэв. Дараа нь тооцоогоо хийгээд гадагш гарав. Арваннэгдүгээр сарын жиндүүхэн үдэш түүний түргэхэн алхаанд, гартаа барьсан таяг нь нэгэн хэмнэлээр зам түншин явах зуур “Mail”-ийн шар өнгөтэй булан хоёр энгэртэй бариу хүрэмнийх нь халааснаас цухуйж байлаа. Фениксийн цэцэрлэгт хүрээлэн Чэпэлизод хаалганы хоорондох хүнгүй замаар явахдаа тэр алхаагаа сааруулав.

Түүний таяг явган хүний замыг түншивч, санаа алдалт лугаа адил нэгэн хэмийн бус амьсгаа нь хүйтэн агаарт царцах шиг болов. Гэртээ очоод шуудхан унтлагын өрөөндөө орж, халааснаасаа сонинг гаргаж цонхны бүдэгхэн гэрэлд өнөөх нийтлэлээ дахин уншив. Тэр өөрт сонсогдохоор бус уншиж байвч, тусгай залбирал айлдаж буй ламтан лугаа адил уруулаа өмөлзүүлж байлаа.

Тэрхүү нийтлэлд ийн өгүүлсэн байв:

Сидни Пэрэйд дахь эмэгтэйн үхэл золгүй явдал

Сидни-Пэрэйдийн галт тэрэгний зогсоол дээр өчигдөр орой нас барсан 43 настай хатагтай Эмили Синикогийн үхлийн шалтгааныг тогтоох мөрдөн шалгах ажиллагааг Дублин хотын эмнэлгийн дэргэдэх цагдаагийн тасгийн ажилтан өнөөдөр явуулав. Эмнэлгийн дүгнэлтээс үзэхэд, талийгаач нь төмөр замаар гарахыг завдах үедээ Кингстаунаас ирж байсан иргэний зорчигч тээврийн 10 цагийн галт тэрэгний толгойд мөргүүлж, тархи болон баруун мөрөндөө хүнд гэмтэл авсаны улмаас нас баржээ. Машинч Жэймс Леннен төмөр замын компанид 15 наснаасаа ажиллаж байгаа аж. Шалгагчийг шүгэлдсэний дагуу тэр галт тэргийг хөдөл гөж, хэн нэгний хашгирах чимээг сонсоод шуудхан түүнийг зогсоосон байна. Галт тэрэг тун удаан явж байв. Тэрэг түрэгч П.Дэннийн мэдүүлснээр бол, галт тэргийг зогсоолоос хөдлөх үед Төмөр замаар гарахыг завдаж байсан эмэгтэйг тэр харжээ.

Түүнийг араас нь дуудан гүйх үед уурын галт тэрэг урд хэсгээрээ хохирогчийг мөргөж тэрээр үхэтхийн унасан байна.

Иргэдийн төлөөлөгч: Тэр эмэгтэйг унаж байхыг та харсан уу?

Гэрч: Тийм ээ.

Цагдаагийн дэслэгч Кроули хэргийн газраас талийгаачийг ухаангүй байхад нь олсон тухайгаа мэдэгдэв. Түүний цогцсыг эмнэлгийн сүйх тэрэг иртэл хүлээлгийн танхим руу зөөж оруулсан байна. 57 дугаарын цагдаа түүний ярьсныг нотлов. Дублин хотын эмнэлгийн мэс засалч Холпин эмчийн мэдүүлснээс үзвэл, талийгаачийн доод талын хоёр хавирга хугарсан, баруун мөр бяцарсан нь тогтоогджээ.

Толгойн баруун тал унах үедээ гэмтсэн аж. Гэвч эдгээр гэмтэл нь эрүүл саруул хүнийг үхэлд хүргэх үндэс болохгүй юм. Түүний хэлснээр бол, үхэл гэнэтийн дайрлага болон зүрхний үйл

ажиллагаа огцом унаснаас үүдэлтэй гэнэ. Ноён Х.Б.Пэттерсон Финлей төмөр замын компанийн өмнөөс ийм золгүй явдал болгонд гүн эмгэнэл илэрхийлэв. Тус компани нь зорчигчдыг гагцхүү гүүрээр гарч байхад онцгой анхаарч, ийм зорилгоор зогсоол бүр дээр чиг заагчийг өлгөж, гарц бүрийн дэргэд автомат хөндлөвчийг тавьсаар иржээ. Талийгаачийн хувьд, тухайн нөхцөл байдлыг анхааралгүй үдэш оройн цагаар төмөр замын хориотой хэсгээр байнга гардаг байсан бөгөөд төмөр замын ажилтнууд үүнд буруугүй гэж үзэж байгаа ажээ.

Сидни Пэрэйдийн Лэовиллд оршин суудаг талийгаачийн нөхөр, ахмад Синико ч мөн мэдүүлэг өгчээ. Бүрлээчийг өөрийн эхнэр мөн болохыг тэр бас гэрчлэн хэлсэн байна. Энэхүү золгүй явдлыг гарах үед тэрбээр Дублинд байгаагүй бөгөөд өнөө өглөө Роттердамаас ирсэн аж. Гэр бүл болоод тэд хорин хоёр жил амьдарсан ч хоёр жилийн өмнөөс эхнэр нь согтууруулах ундаанд донтох хүртэл аз жаргалаар дүүрэн айл байжээ. Хатагтай Мэри Синикогийн мэдүүлснээр, сүүлийн үед эх нь үдэш оройн цагаар дарс худалдаж авахаар байнга гэрээсээ гардаг байсан гэнэ.

Гэрчийн мэдүүлснээр, эхийгээ тэрээр бор дарснаас гаргах гэж Архидан согтуурахын эсрэг нийгэмлэгт хүртэл элсэхийг ятгаж байжээ. Хэрэг гарснаас цагийн дараа тэрээр гэртээ ирсэн аж. Эмчийн дүгнэлт дээр үндэслэн иргэдийн төлөөлөгчдийн гаргасан шийдвэрээр бол, Леннон ямар ч буруугүй болох нь тогтоогдов. Хэргийг шалгасан цагдаагийн ажилтан, “Энэ бол түүний ажил үүрэгт тохиолдсон хамгийн эмгэнэлтэй, золгүй учралын нэг гэж хэлээд, ахмад Синико болон түүний охинд гүн эмгэнэл илэрхийлжээ. Төмөр замын компанийг цаашид иймэрхүү осол гаргахгүй байх талаар шийдвэртэй арга хэмжээ авахыг ч мөн үүрэг болгов. Тухайн тохиолдолд буруутай хүн үгүй байна.

Ноён Даффи сонины хуудаснаас нүдээ салгаж, баяр баясал үгүй үдшийн зураглал бүхий цонх руу ширтэв. Хаягдсан дарсны үйлдвэрийн дэргэдүүр гол ус намуухан урсаж Дьюкийн зам дээрх аль нэг байшинд гэрэл асав. Ямар аймаар төгсгөл вэ? Түүний үхлийн талаарх энэ нийтлэлд тэр эргэлзэж байлаа. Түүний хувьд хамгийн ариун нандин зүйл юу вэ? гэж тэртээх он жилүүдэд ярьж байсан бодолдоо ч эргэлзэхэд хүрэв. Эмгэнэлийн хоосон үгс, зарим нэг болсон үйл явдлыг тодорхой хэмжээнд нуун далдлахыг хүссэний дагуу сэтгүүлчийн бичсэн болгоомжтойхон үгсийг харуут дотор нь муухайрав.

Үүнээс гадна тэр өөрийгөө доош хийж, түүнийг ч бас давхар гутаан доромжилжээ. Түүний гутамшигт, өөрөөсөө түлхэгч, үзэн ядмаар амьдралыг тэр төсөөлж үзэв. Ингэхэд тэр хайртай бүсгүй нь байсан гэж үү? Ингэхэд тэр сэтгэлийн уяа нь байсан гэж үү? Хоосон лонх, сав суулга барьсаар уушийн газрын гадуур эргэлдэх золгүй амьд санаанд бууна. Бурхан минь, ямар аймаар төгсгөл вэ? Тэрээр амьдралд учраа олоогүй, тэсвэр хагуужилгүй байсны улмаас тун амархан гэгч нь муу зуршлын золиос болжээ.

Соёл иргэншил бусдын яс махан дээр бий болдог агаад тэрхүү амиа золиослогчдын нэг нь тэр байлаа. Ингэхэд, яаж яваад ийм доош орчихов оо? Юуны учир түүнд хууртагдчихав аа? Тэрхүү дурсгалт үдэш бүсгүйн гаргасан сэтгэлийн хөдөлгөөнийг эргэн санаж, энэ удаад түүнийг улам эрс шийдэмгий буруушаасан билээ. Одоо тэр зөв зүйтэй алхам хийсэндээ үнэхээр итгэлтэй байлаа. Харуй бүрий болж, бодол санаа нь төөрөлдөж, гэнэтхэн бүсгүй гараас нь бариад авах шиг санагдав. Эхэндээ дотор муухайрч байсан бол одоо хамаг бие нь дагжин чичирхийлж байлаа. Тэрбээр бүрх малгай, хүрмээ хурдхан шиг өмсөн гарч одов.

Хүйтэн салхи босгон дээр угтаж, хүрэмнийх нь ханцуй руу хүссэн хүсээгүй шургалав.

Чэпэлизодын гүүрний дэргэдэх уушийн газар руу оруут, халуун дарс захиалав. Уушийн газрын эзэн тун эелдэгхэн үйлчилсэн ч ямар нэгэн яриа дэлгэхийг хүссэнгүй. Тэнд байсан тав, зургаан ажилчин Килдэрийн гүнлэгт орших ямар нэгэн эдлэн газрын үнэ хөлсний талаар маргалдана. Тэд том том сэнжгэй аяганаас байдгаар нь балгаж, тамхи баагиулж, шал руу шүлсээ хаяж, том хар гутлаараа талын нэг тарааж байлаа. Ноён Даффи тэдний зүг юу ч харалгүй, юу ч сонсолгүй ажна. Төдөлгүй тэд явж, тэрээр дахин захиалга өгөв.

Түүнийхээ ард нэлээд удаан суув. Уушийн газарт нам гүм ноёлно. Эзэн лангуу руу тонгойн өвшөөх зуур “Herald Tribune” сонин уншина. Үе үехэн хүнгүй замаар трамбайн чимээ сонсоно. Ийнхүү тэр түүнтэй өнгөрүүлсэн өдөр, хоногоо эргэн дурсахуйд одоо тэр бүсгүй байхгүй, энэ бүхэн ердөө л дурсамж болон хувирсан гэдгийг хатуухан ойлгож байлаа. Түүний дотор харанхуйлав.

Өөр би яах ёстой байсан юм бэ? гэж өөрөөсөө асууна. Цаашид тэр жүжиглэж чадахгүй байсан; нээлттэй амьдарч чадахгүй байх байсан. Тэр аль болохоор зөв зүйтэй гэж бодсоноо л хийсэн. Түүний буруу гэж байна уу? Одоо ганцхан нас барсан хойно нь, урт удаан үдэш бүрийд өрөөндөө тэр хэрхэн ганцаардан байсныг гүнээ ойлгож байлаа. Түүний амьдрал ч гэсэн насны эцэст энэ хорвоо дээр үгүй болж, хэн нэгэн хүн эргэн дурсах дурсамж болон үлдэх хүртэл тэр ганцаардсаар байх болно.

Уушийн газраас гарах үед оройн арван цаг болж байв. Нэлээд хүйтэн харанхуй шөнө угтав. Тэрбээр хамгийн ойрын хаалгаар Фениксийн цэцэрлэгт хүрээлэн рүү орж, мөчрөө гөвсөн моддын доогуур алхана. Дөрвөн жилийн тэртээд хамтдаа зугаалж асан уйтгар дүүрэн модот гудамжаар тэр ганцаар бэдэрч байлаа. Бүсгүй түүний дэргэд, харанхуйд явж буй мэт санагдана. Заримдаа хоолой нь сонсдож, гар хүрэх мэт сонин мэдрэхүй төрнө. Тэрбээр зогтусан чих тавив. Түүний амьдралыг тэр яах гэж булаав даа? Юуны учир түүнийг нас барахад хүргэв ээ?

Түүний цэгцтэй, зөв зүйтэй ертөнц нуран унаж байлаа. Мэгэзин-Хиллийн оройд очмогц, тэр түр саатаж, тасгим хүйтэн шөнөөр тун дулаахан, зочломтгой гэгч нь анивчин гэрэлтэх Дублин хотоор гороолон урсах голын зүгширтэн зогсов. Тэрбээр толгойн бэлд зогсон доош харахуйд, цэцэрлэгт хүрээлэнгийн хайсны сүүдэрт нойрсч буй хар дүрснүүдийг олж харав. Энэхүү нүгэлт, нууцлаг хайр түүний сэтгэлийг харууслаар дүүргэнэ. Ёс зүйн тогтвортой байдлыг үзэн ядаж, өөрийгөө тэр амьдралын баяр баяслаас бүрмөсөн холдсон мэт мэдэрч байлаа.

Ганцхан хүн түүнийг хайрласан билээ; харин тэр амьдрал хийгээд аз жаргалыг бэлэглэхээс татгалзсан; түүнийг тэр гутамшиг хийгээд ичгүүртэй үхлээр ялласан. Тэртээ дор нойрсох амьтай бүхэн түүний араас ажиглаж, хурдхан явахыг нь хүсч буйг тэр мэдэж байлаа.

Одоо тэр хэнд ч хэрэггүй болсон. Амьдралын баяр баяслыг тэр хүртэхээсээ нэгэнт өнгөрсөн. Тэрбээр Дублин хотыг чиглэн тахиралдсан саарал өнгөөр гэрэлтэн урсах гол руу харц шилжүүлэв. Голын цаадах Кингсийн гүүрний галт тэрэгний зогсоол дээрээс галт толгойтой жаран хөлт лугаа адил ачааны галт тэрэг харанхуйг ихэд мэрийн гэтэлж, удаахан мөлхөж



буйг тэр олж харав. Галт тэрэг нүднээс алгуурхан далд орсон авч дугуйн чимээ нь түүний нэрийг тун удаан давтан өгүүлж байлаа.

Тэрбээр ирсэн замаараа эргэж буцав; Галт тэрэгний нэгэн жигд чимээ чихэнд нь дуулдсаар байлаа. Тэрхүү дурсамж чухам юун тухай өгүүлсний бодит байдалд эргэлзэж эхлэв. Тэрбээр оддын дор зогсч, нэгэн жигд чимээ сонсогдохгүй болтол зогссоор байлаа. Харанхуйд тэр бүсгүйг үл мэдрэх агаад түүний хоолой дахин зовоосонгүй. Тэрбээр хэдэн хором чих тавин хүлээжэв. Юу ч олж сонссонгүй. Гүн харанхуй шөнө хэлгүй, дүлий мэт. Тэр дахин чих тавин сонсов. Юу ч үгүй нам гүм. Тэр ганцаар байлаа.

## Ороонго өвсний өдөр

Хөгшин Жэк жижигхэн хатуу цаасаар үнс хутгаж аваад цайрсан нүүрсэн дээр хичээнгүйлэн асгав. Овоолсон нүүрсийг үнсний нимгэн давхарга бүрхсэн дарууд өвгөний царай харанхуйд авгаж, гал асаахаар түүнийг үлээж эхэлмэгц бөгтөр сүүдэр ард талын ханан дээр ургаж, өвгөжөөр царай нь дахин тодрох ажээ.

Тэр нь нэлээд эцэнхий, сахал үсэндээ баригдсан хөгшин царай байлаа. Галын дөлөөс болж нулимс бүрхсэн гүн цэнхэр нүд өөрийн эрхгүй анивчиж, тэрбээр ямар ч шүдгүй шүлсэрхэг амаараа эцэс төгсгөлгүй хэвсээр байлаа. Нүүрс улайсмагц, тэр хатуу цаасыг хана руу налуулж тавин санаа алдсанаа:

- Ноён 0'Коннор энэ нь ч дээр дээ гэж хэлэв.

Ноён 0'Коннор бол авах юмгүй болтол батга шавсан нүүртэй, буурал үстэй энэ эрхэм дөнгөж саяхан тамхи ороосон ч хэн нэгэн түүнд хандсаныг сонсоод, бодолд авган нөгөөхөө буцааж задлав. Дараа нь тэр тамхиа дахин ороож, хэсэг хором бодолхийлснээ цаасыг нь норгов.

- Ноён Тирни хэзээ ирнэ гэдгээ хэлээгүй юу? хэмээн тэр сөөнгөдүүхэн, нарийхан дуугаар асуув.

- Үгүй ээ, хэлээгүй.

Ноён 0'Коннор амандаа тамхиа зуугаад халаасаа тэмтэрч гарав. Тэрбээр тун нимгэн цаастай нэрийн хуудаснууд гаргаж ирэв.

1 Аравдугаар сарын зургааны өдөр бол Чарльз Стюарт Парнеллын нас барсан өдөр юм. Парнеллын талыг баримтлагчид түүний дурсгалыг хүндэтгэн жил бүрийн энэхүү өдөр энгэртээ ороонго өвсний навчийг зүүх болсон ажээ. Ногоон өнгө нь Ирландын үндэсний өнгө

- Би танд шүдэнз өгье гэж өвгөн хэлэв.

- Бүх юм хэвийн. Өөрийгөө зовоогоод яахав гэж ноён 0'Коннор өгүүлэв.

Тэрбээр нэгэн нэрийн хуудсыг гаргаж ирснээ: “Орон нутгийн сонгууль Вангийн биржийн дүүрэг. Ноён Ричард Ж.Тирни. П.С.Б1. Эрхэм танд мэхийн ёслохын сацуу таны дуу хоолойг түүнд сонсгож, Вангийн биржийн дүүрэг дэх ирэх сонгуульд таныг нөлөө үзүүлэхийг хүсье”<sup>2</sup> хэмээн уншив.

Ноён 0'Коннорын хувьд ноён Т ирнийн сонгуулийн тойргийн нэгэн хорооны сонгогчидтой уулзах хөлсний төлөөлөгч байлаа. Цаг агаар таагүй байснаас болж гутал нь байдгаараа норчихсон тул өдрийн ихэнхийг тэр Уиклоугийн гудамжин дахь хорооны штабт Жэк өвгөний хамт задгай зуухны дэргэд сууж өнгөрүүлэхэд хүрэв.

Тэрхүү байрыг харж хандах үүргийг Жэк хүлээж байв. Харуй бүрий болтол тэд суусаар байлаа. Аравдугаар сарын зургааны зэврүүн, бүүдгэр өдөр. Ноён 0'Коннор нэрийн хуудасны

булангаас урж аван ноцоож тамхиа асаав. Тэрхүү галын дөл түүний энгэрт зүүлттэй байх ороонго өвсний бараавтар гялгар навчийг гэрэлтүүлэв.

Өвгөн тун хянамгай харснаа, хатуу цаасыг авч галыг аажуухан өрдөх зуур хамт суугаа нөхөр нь тамхиа татсаар байлаа.

- Тийм ээ, тийм. Хүүхдийг яаж хүмүүжүүлэхийг хаанаас мэдэх билээ дээ? гэж яриагаа үргэлжлүүлэх зуур тэр хэлэв.

- Түүнийг энэ замаар явна гэдгийг хэн мэдэх билээ? Уг нь би

1 Ядуусын зөвлөлийг ивээн тэтгэгч

2 Вангийн бирж нь Лиффи голын баруун эрэг дээр Дублины төвд орших Ирландын засаг захиргааны төв байр)

Христийн ахан дүүсийн сургуульд түүнийг өгч чадах бүхнээ л хийсэн. Гэтэл тэр архинд орчихсон. Хүмүүстэй танилцуулах гэж ч оролдож үзсэн. Хатуу цаасыг тэр байранд нь алгуурхан тавив.

- Одоо би ч хөгширчээ. Түүнээс биш түүнд үг хэлэх л байлаа. Болохгүй бол цохиур мод аваад л болгож тавих байсан. Урьдынх шигээ хамаг хүчээрээ л цохих байсан даа. Ээж нь түүнийг дэндүү их эрхлүүлчихсэн юм. Түүнд их учир бий...

- Энэ л харин хүүхдийг алж байгаа юм гэж ноён 0'Коннор хэлэв.

- Яг тэр шүү! Гэж өвгөн хэлэв.

-Ядаж танд баярладаг байгаа даа? Гэтэл үргэлж л шазруун зан гаргаж байх юм. Намайг ганц хундага уусныг харвал лүндэн буулгаж гарна даа. Хөвгүүд нь эцэгтээ ингэж хандаж байхад өөр яалтай ч билээ дээ.

- Тэр чинь хэдэн настай юм бэ? гэж ноён 0'Коннор асуув.

- Арван ес гэж өвгөн хариулав.

- Түүнийг та яагаад ажилд оруулдаггүй юм?

- Яажтэр вэ? Энэ новшийн амьтныг сургууль төгссөн цагаас нь хойш янз бүрийн л юм сэдэж үзлээ. “Чамайг би тэжээхгүй шүү!” гэж хүртэл хэлсэн.

- Явдаг газраа яваарай! гэж хүртэл хэлсэн. Харин очих газраа олсон нь бүр долоон дор. Байдгаа тавиад туучихна. Уухаас өөр юм мэдэхээ больсон доо.

Ноён 0'Коннор тун харамсангуй толгой сэгсэрч, өвгөн гал руу харсаар дуугаа хураав. Өрөөний хаалгыг хэн нэгэн онгойлгосноо:

- Хөөе! Наана чинь масоны хурал болоод байгаа юм уу, хаашаа юм гэв.

- Тэнд хэн байна аа? гэж өвгөн асуув.

- Энэ харанхуйд та юу хийж байгаа юм бэ? гэж хэн нэгэн хэлэв.

- Хайнс, та юу? гэж ноён 0'Коннор асуув.

- Тийм ээ. Та энэ харанхуйд юу хийж байгаа юм бэ? гэж гэрэлд гарах зуур ноён Хайнс хэлэв.

Тэрбээр өндөр цэх нуруутай, цайвар шаргал сахалтай залуу байлаа. Борооны дусал бүрхнийх нь хүрээн дээр бөнжигнөж, хүрэмнийхээ захыг босгосон байх аж.

- За Мэт, сонин сайхан юу байна? гэж ноён 0'Коннорт хандан тэр хэлэв.

Ноён 0'Коннор толгой дохив. Өвгөн задгай зуухнаас холдон харанхуйд бүдчин явсаар лааны хоёр суурь хайж олоод, нэг нэгээр нь тэднийг задгай зуухнаас асааж, ширээн дээр тавив. Өрөөний нүцгэн хана гэрэлтэж ирмэгц, тэрхүү гал хөгжилтэйхэн бадамлахаа болив. Ханан дээрх сонгогчдод хандсан уриалга тодров.

Өрөөний голд бөөн цаас овоолсон жижигхэн ширээ байв. Ноён Хайнс задгай зуух руу тонгойсноо,

- Та нарт тэр төлбөрөө төлөөгүй юу? гэж асуув.

- Арай өгөөгүй байна. Гэхдээ биднийг эвгүй байдалд оруулахгүй гэдэгт итгэж байна хэмээн ноён 0'Коннор хэлэв. Ноён Хайнс инээд алдлаа.

- Тийм ээ, тэр ч төлчихнө, айхын хэрэггүй! гэж тэр хэлэв. Хэрэв тэр үнэхээр ажил хэрэгч хүн юм бол яаравчлах байлгүй дээ! гэж ноён 0'Коннор өчив.

- Жэк, та юу гэж бодож байна? хэмээн ноён Хайнс өвгөнд хандан инээвхийлэн асуув. Өвгөн ч задгай зуухны өмнөх сууж

байсан байрандаа эргэж очуут:

- Түүнд ч мөнгө бий нь бий. Тэр ямар ажилгүй амьтан байгаа биш гэв.

- Ямар ажилгүй амьтан гэж? хэмээн ноён Хайнс асуув.

- Колгэн! гэж өвгөн үзэн ядсан байдалтай хариулав.

- Колгэнийг ажилчин болохоор нь та ингэж хэлж байгаа юм уу? Тэр уушийн газрын нөхөр чинь шударга чулуучнаас юугаараа дээр юм бэ? Ажилчин хүн гэхээр орон нутгийн зөвлөлд сонгогдох ёсгүй юм уу? Харин ч тэр ямар нэгэн дарга даамлын өмнө хөлөө хугалчих гээд гүйх алиа салбадай нарын дэргэд хавыгүй илүү эрх дархтай байх шүү! Мэт, тийм биш гэж үү? хэмээн ноён Хайнс 0'Коннорт хандан өгүүлэв.

- Миний бодлоор түүний зөв! гэж ноён О'Коннор хэлэв.

- Эгэл ажилчин хүн ямар ч заль мэх хэрэглэнэ гэж байхгүй. Орон нутгийн захиргаанд тэр ажилчин ангийг төлөөлөх болно. Харин таны дэвшүүлэхээр зүтгэж байгаа хүн бол зөөлөн суудалд санаархсан л амыан байгаа даа.

- Мэдээж хэрэг ажилчин анги өөрийн гэсэн төлөөлөгчтэй байх ёстой гэж өвгөн өгүүлэв.

- Ажилчин хүнд сохор зоос ч гэсэн хайран байдаг юм гэж ноён Хайнс хэлэв. Тэдэнд өчүүхэн төдий зүйл оногдсон ч дээдийн заяа. Гэтэл хөдөлмөр гэдэг хамгийн гол нь юм шүү дээ. Ажилчин хүн харин өөрийн үр хүүхэд, ах дүү, амраг садныг зөөлөн суудалд суулгахыг ер бодохгүй. Ажилчин хүн Дублины аугаа нэрийг ямар нэгэн Германы ванд1 долигонож, шавар шавхайтай хутгахгүй шүү дээ.

1 VIII Эдуард /1841-1910/ Английн вангаар 1901 оноос тохоон томилогдож Германтай харилцаа холбоог ихээхэн хөгжүүлж байв

- Юу гэнэ ээ? гэж өвгөн асуув.

- Та нар тэднийг Эдуард ванг ирэх жил ирвэл хүндэтгэл үзүүлэх болно гэдгийг мэдээгүй байгаа юм уу? Яахлаараа бид харийн вангийн өмнө үсчин цовхчих ёстой гэж?

- Манайх лав түүнийг дэмжиж саналаа өгөхгүй гэж ноён О'Коннор хэлэв.

- Үндэсний жагсаалтаар1 тэр явж байгаа юм.

- Дэмжихгүй гэв үү? хэмээн ноён Хайнс хэлэв.

- Цаг нь болохоор хэрхэхийг харж л байя. Түүнийг би мэднэ. Ямартаа л түүнийг Залы Тирни гэж байхав дээ.

- Чөтгөр аваг гэж! Жо, таны зөв ч байж болно хэмээн ноён О'Коннор хэлэв.

- Ямар ч байсан би өөрийнхөө мөнгийг авмаар байна. Тэр гурав бүгд дуугаа хураав. Өвгөн дахиад л үнсээ хутгаж эхлэв. Ноён Хайнс бүрх малгайгаа авч сэгсрээд, хүрэмнийхээ захыг буулгав; түүний энгэрийн зүүлт дэх ороонго өвсний навчийг бүгд олж харав.

- Хэрэв тэр амьд байсан бол2 хэмээн тэрхүү навч руу заах зуур, энэ талархал дэвшүүлэх тухай хэн ярих юм бэ? гэв.

- Яг тийм шүү! гэж ноён О'Коннор хэлэв.

- Тэнд юу болж байна аа? Цаг байсан бол Бурхан түүнийг өршөөх болтугай! гэж өвгөн бувгнав.

Өрөөнд дахин нам гүм болов. Хаалган дээр нэгэн олби оготно шиг нөхөр цухалзахад хамраас нь нус гоожиж, чих нь хөлдсөн байлаа. Тэрбээр задгай зуух руу түргэхэн дөхөж очин, яг л оч

гаргахыг хүсэх мэт алгаа үрж гарав.

- Хүүхдүүд ээ, мөнгө байхгүй! гэж тэр хэлэв.

- Ноён Хэнчи, наашаа суу! гэж өвгөн түүнд сандлаа тавьж

1 Тирни бол Ирландын парламентын намын гишүүн 1890 онд Парнеллыг огцорсны дараа тус намд хагарал гарчээ

2 Парнеллыг хэлж байна

өгөх зуур хэлээд,

- Жэк, санаа зоволтгүй! гэв. Тэрбээр ноён Хайнстай толгой дохин мэндлээд өвгөний тавьж өгсөн сандал дээр суув.

- Та Ожиэрийн гудамжийг бүтэн тойров уу? гэж ноён О'Коннороос тэр асуув.

- Тийм ээ гэж ноён О'Коннор хэлэх зуур тэмдэглэлийн дэвтрээ хайж, халаасаа тэмтчиж гарав.

- Граймсынхаар оров уу?

- Орсон.

- Тэр юу гэж байна?

- Юу ч амлахгүй байна. “Хэний төлөө санал өгөхөө би хэнд ч хэлэхгүй” гэж байна лээ. Гэхдээ л бүх юм болно байх гэж би бодож байна.

- Яагаад тэр билээ?

- Надаас тэр нэр дэвшигчийг хэн дэмжиж байгааг асууж байна лээ. Ви Эцэг Бэркийн нэрийг барьчихсан. Бүх юм болно байх аа.

Ноён Хэнчи зуухны өмнө гарынхаа алгыг үрсээр хамраа шуухитнуулан суулаа. Дараа нь тэр:

- Жэк, нүүрс аваад ирээч! Тэнд байгаа шүү дээ! гэж хэлэв. Өвгөн өрөөнөөс гарав.

- Ажил муу л байна даа! гэж ноён Хэнчи толгой сэгсрэн өгүүлэв.

- Би энэ новшийн амьтнаас асуусан чинь: “Ноён Хэнчи минь, ажил дажгүй өрнөж байгааг харсан цагт таныг би мартахгүй, итгэлтэй байж болно шүү” гэж хэлсэн. Ёстой л нэг новшийн амьтан юм даа. Ингэхэд түүнээс юу горьдох юм бэ?

- Мэт, би танд юу гэж хэлж байлаа? Муу зальт Тирни гэж ноён Хайнс хэлэв.

- Бүр ямар зальтай гээч! хэмээн ноён Хэнчи өгүүлэв.

- Ямар сайндаа л тэр гахай шиг нүдтэй байхав дээ.

- Чөтгөр түүнийг аваасай! Хүн шиг байж болдоггүй л юм байх даа? Ямар нэгэн үг хэл бололгүй хэдэн зоос өгчихдөггүй л юм байх даа. Тэгсэн чинь харин “Ноён Хэнчи, та ойлгож байна уу? Эхлээд би ноён Фэннингтэй ярих хэрэгтэй байна...”

Би нэлээдгүй мөнгө зарцууллаа шүү дээ ч гэх шиг балай юм яриад. Эцгийгээ Мэри-Лэйн дээр хуучин хувцас зарж байсныг мартчихсан юм байх даа.

Муу нохойн гөлөг!

- Тэр чинь үнэн юм уу? хэмээн О’Коннор асуув.

- Бурхан минь, юу ярих нь тэр вэ? гэж ноён Хэнчи хэлэв.

- Та хэзээ ч сонсч байгаагүй гэж үү? Ням гарагийн өглөөгүүр хантааз юм уу, өмд авах гэж байгаа юм шиг тэр язгууртныд очицгоодог байсан юм. Харин нусгай Тирнийн нусанхай эцэг нь үргэлж л хаа нэг буландаа хар лонхтой юм хадгалдаг байсан юм. Хэрэг явдал юунд байсныг ойлгож байна уу? Яг түүнд. Тэнд л нөгөө хонгор чинь хорвоод мэндэлсэн юм. Өвгөн бага зэрэг нүүрс авчирч гал руу чулуудав. Сайхан боломж гарчээ. Хэлэх үг алга хэмээн ноён О’Коннор онцлон хэлэв.

- Хэрэв тэр хоосорчихгүй бол түүний төлөө биднийг ажиллана гэж мөрөөдөөд ч хэрэггүй.

- За яая гэхэв. Би ч бас хийж болох юм гэж ноён Хэнчи хэлэв.

- Миний бүх эд хогшлыг тодорхой хэлэх болно. Харж л байгаарай!

Ноён Хайнс инээд алдсаар задгай зуухнаас холдож, явахаар зэхэв.

- Эдди ванг ирэхээр бүх юм байрандаа орох болно гэж тэр хэлэв.

-Залуус аа, би явлаа. Эргээд уулзана аа, баяртай!

Өрөөнөөс тэр алгуурхан гарав. Ноён Хэнчи, өвгөн хоёрын хэн нь ч юу ч хэлсэнгүй. Харин түүний араас хаалга хаагдмагц ноён О’Коннор гал руу уйтгартайхан ширтэж байснаа:

- Жо! баяртай, хэмээн амандаа гэнэт бувтнав.

Ноён Хэнчи хэдэн хором хүлээсний эцэст хаалга руу зүглэв.

- Манай нөхрийг ямар юм нь өнөөдөр наашаа дуудчихав аа? гэдгийг надад хэлээд аль! Түүнд юу хэрэгтэй байсан юм бол? гэж задгай зуухны эсрэг талд суух зуураа тэр асуув.

- Хөөрхий муу, Жо! ядарсан амьтан гэж хэлээд ноён О’Коннор тамхиныхаа ишийг гал руу шидэв. - Бидний нэгэн адил сохор ч зоосгүй л сууж байгаа биз. Ноён Хэнчи хамраа шархиртал дуугарснаа задгай зуух руу нэлээд хүчтэй нулимтал, асч байсан галыг бараг тэр

чигээр нь унтраачихаа шахав.

- Хэрэв та миний чин сэтгэлийн үгийг мэдэхийг хүсч байвал тэр бол өөр бүлгийн хүн шүү! гэж тэр хэлэв. Түүнийг Колгэний тагнуул гэдгийг та нарт хэлье. Тэд яаж байгааг яваад шиншлээд ир! гэж үүрэгдсэн биз. Таныг бол сэжиглэхгүй шүү дээ. Одоо ойлгоцгоов уу?

- Хөөрхий муу Жо, дажгүй залуу шүү!

- Эцэг нь тун тохитой хүн байсан юм гэж ноён Хэнчи түүнтэй санал нэгдэв.

- Хөөрхий Лэри Хайнс! Цагтаа тэр олон хүнд тусалсан даа. Гэсэн хэдий ч бидний сайн нөхөр тийм ч шударга нэгэн биш бол яах вэ гэдгээс би бага зэрэг болгоомжилж байна. Сохор зоосгүй байна гэдэг амаргүй гэдгийг ойлгоно. Харин тагнуул хийнэ гэдгийг би тэнгэр ниргэсэн ч ер ойлгохгүй. Түүнд өөрөө өөрийгөө хайрлах өчүүхэн төдий сэтгэл үлдээгүй гэж үү?

- Надад тэр нэг их таалагдахгүй байна шүү! гэж өвгөн хэлэв.

- Нэр дэвшигчийнхээ төлөө л ажиллана биз, энүүгээр шиншлээд гүйгээд байх хэрэггүй шүү дээ!

- Мэдэхгүй юм даа гэж тун эргэлзсэн байдалтай ноён О'Коннор хэлээд тамхи ороох цаас, ороомгийн хамт гаргаж ирэв.

- Миний бодлоор Жо Хайнс бол шударга хүн. Тэр бичихдээ ч гаргуун. Та нар түүний бичсэн зүйлийг санаж байна уу?

- Уулын хүмүүс хийгээд энэ бүх фэний<sup>1</sup> нар бол дэндүү сэргэлэн хүмүүс гэдгийг та нарт би хэлье! гэж ноён Хэнчи онцлон өгүүлэв.

- Та нар энэ алиа салбадай нарын тухай миний чин сэтгэлийн үгсийг сонсохыг хүсч байна уу? Тэдний талаас илүү хувь нь Цамхагаас<sup>2</sup> тэтгэлэг авдаг байх гэж би бодож байна.

- За тэрийг хэн мэдлээ гэж өвгөн хэлэв.

- Би ч мэдэж байна аа гэж ноён Хэнчи өгүүлэв.

- Тэд чинь эрх баригчдын хурууны үзүүрт л зарагддаг юм. Хайнсын тухай би хэлээгүй юм шүү... Үгүй ээ, чөтгөр аваг, гэж түүнийг би тийм хүн гэж бодохгүй байна... Гэтэл нэг өрөөсөн нүдтэй эр мундаг эх орончийн дүрийг эсгээд явсныг санаж байна уу?

Тэр нэг л биш ээ. Ноён О'Коннор толгой дохив.

- Хошууч Сэрын ойрын хамаатан! Зуун хувь эх оронч хүн!

<sup>1</sup> Ирландын хувьсгалч бүгд найрамдахчууд бол XIX-XX зууны эхэн үеийн “Ирландын хувьсгалч ахан дүүс” хэмээх нууц байгууллагын гишүүд юм.



Тэд Ирландын тусгаар тогтнолын төлөө тэмцэж, тэр ч бүү хэл алан хядах үйл ажиллагаа явуулж байжээ. Энэхүү нэр нь Fene гэх Эртний гэль хэл, Эртний Ирландад амьдарч байсан Fianna гэх домогт баатруудын холилдсон нэрнээс үүсчээ. Эх орныхоо тусгаар тогтнолын төлөө тэмцэж байсан эдгээр домогт дайчид Гуравдугаар зуунд Финн Мак Кул Вангийн үед амьдарч байжээ. Заримдаа фэнийчүүдийг “уулын хүмүүс” гэж нуугдаж байгаа газар нутгаар нь нэрийддэг байжээ

2 Английн эрх ашгийн төлөө ажиллаж байгааг хэлж буй аж

Тэр нөхөр бол дөрвөн пэнсээр ч хамаагүй эх орноо худалдаж, тэр ч бүү хэл зарах юм байна хэмээн Бурханд талархаад зогсохгүй өвдөг сөхрөх болно.

Хаалга тогшив.

- Ороорой гэж ноён Хэнчи хэлэв.

Хаалган дээр ядуу ламтан юм уу, ядруухан жүжигчин лугаа адил нэгэн хүн зогсоно. Өвч товчилсон хар дээл намхан биеийг нь байдгаар нь барих агаад шашны юм уу, дээдсийн хэв загварын алин болохыг ялгаж салгахад хүндрэлтэй байлаа. Учир юун гэвээс үнгэгдэж хуучирсан дээлийнх нь захны халцарсан товчин дээр лааны гэрэл тусна. Зах нь дэндүү дээш өргөгдсөн ажээ.

Тэрбээр хагуу эсгийгээр хийсэн дугуй бүрх малгай өмссөн байв. Түүний царай бороонд норсноос гялалзах нь тос даасан шаргал бяслагийг санагдуулах агаад шанаан дээр нь хоёр ягаан толбо үл мэдэгхэн тодорно. Тэрбээр харууслаа илэрхийлэхийг хүсэх мэт гэнэт том амаа нээсэн авч дэндүү хөдөлгөөнтэй гүн цэнхэр нүдэнд нь нэгэн зэрэг гайхшрал хийгээд таашаал тодрон харагдана.

- Өө, Эцэг Кион! Та байсан юм уу, ор ор! гэж хэлээд ноён Хэнчи суудлаасаа босов.

- Үгүй ээ, үгүй! гэж яг л хүүхдэд хандаж буй мэт уруулаа жимийлгэн Эцэг Кион маш түргэн хэлэв.

- Та наашаа ороод суу л даа!

- Үгүй ээ, үгүй, үгүй! гэж Эцэг Кион тун аядуухан, зөөлөн дуугаар хэлэв.

- Та нарт саад болохыг хүсэхгүй байна. Энд би ноён Фэннинг байна уу, үгүй юу гэдгийг мэдэх гэж шагайсан юм.

- Хажуугийн “Хар бүргэдэд” байгаа гэж ноён Хэнчи хэлэв.

- Та орж ирээд суухгүй юм уу?

- Үгүй ээ, үгүй, танд баярлалаа. Би түүнтэй нэг ажил ярих ёстой юм гэж Эцэг Кион хэлэв.

- Хэрэггүй ээ, танд баярлалаа. Түүнийг доош уруудан одоход, ноён Хэнчи суурьтай лаа

барьсаар шатыг нь гэрэлтүүлж өгөхөөр хаалга руу дөхөв.

- Санаа зовсны хэрэггүй!

- Зүгээр ээ, наад шатан дээр чинь харанхуй байна.

- Яах нь вэ? Би харж байна, баярлалаа.

- Зүгээр биз?

- Тийм ээ, зүгээр. Танд баярлалаа...

Ноён Хэнчи суурьтай лаа барьсаар ширээн дээр очиж суув. Хэсэг хугацаанд нам гүм болов.

- Жон, та сонс доо! гэж тамхиа татах зуур ноён О'Коннор хэлэв.

- Тийм үү? Ингэхэд тэр чинь юу болж байна?

- Арай хөнгөхөн юм асуу л даа гэж ноён Хэнчи хэлэв.

- Фэннинг тэр хоёрыг сүхээр цохиод ч салахгүй. Тэд үргэлж л Каваныд хамтдаа байдаг юм. Тэр үнэхээр ламтан мөн үү?

- Мөн байх аа... Ерөнхийдөө л “новшийн амьтан” гэжхэлж болно. Бурханы авралаар манайд иймэрхүү юмнууд нэг их олон биш ч ганц нэг байна аа... Хөөрхий амьтан гэхдээ л хүн биз дээ?

- Тэр юугаараа амьдардаг юм бэ? гэж ноён О'Коннор асуув.

- Энэ ч бас оньсого.

- Ямар сүмд суудаг юм? Тэр юу хийдэг юм бэ?

- Тэр мөрөөрөө л байдаг юм гэж ноён Хэнчи хэлэв.

- Бурхан минь намайг өршөөж хайрла! Түүнийг би ер таньсангүй.

Уушийн газраас баахан дарс авчирч байгаа хүн л гэж бодсон хэмээн дараа нь тэр нэмж хэлэв.

- Ингэхэд дарс юу болсон бэ? гэж ноён О'Коннор асуув.

- Миний хоолой ч бүр хатаж дууслаа.

- Тэр ухаантнаас дарс явуулах, эсэх талаар гурван ч удаа асуусан гэж ноён Хэнчи өгүүлэв. Саяхан би дахиад л асуусан. Харин тэр хантааз өмсөн лангуу тохойлдон зогсчихсон Каулийн засаг захиргааны гишүүнтэй шивэр авир хийж байна лээ.

- Тэгвэл та яагаад түүнд сануулаагүй юм бэ? гэж ноён О'Коннор хэлэв.

- Түүнийг Каулийн засаг захиргааны гишүүнтэй ярьж байгаа учраас ойртож очихыг хүссэнгүй. Намайг анзаарахыг нь хүлээж жаал зогссон юм. Тэгээд харсан даруйд нь л “нөгөө миний ярьж байсан юм юу болж байна вэ?” гэхэд тэр “Ноён Хэнчи бүх юм болно оо” гэж хэлсэн. Тэр хуруун чинээ хүү чинь биднийг мартчихсан юм болов уу?

- Тэнд ямар нэгэн юм болох гэж байгаа бололтой гэж 0'Коннор бодолд авган өгүүлэв.

- Өчигдөр Саффолкын гудамжны өнцөгдээр гурван нөхөр шивэр авирхийлцэн байхыг би харсан шүү.

- Тэднийг ямар юм сэдсэнийг би мэдэж байж ч магадгүй гэж ноён Хэнчи өгүүлэв.

- Харин одоо би амбан захирагч болохыг хүсвэл эцгүүдээс хотуудыг зээлэх хэрэгтэй. Тэгсэн цагт тэд чамайг амбан захирагч болгох болно. Бурханы нэрийг барин тангаргалъя! Энэ хотын эцэг болчихвол яасан юм бэ? гэж би өөрөө ч бас бодож байна. Таныхаар бол ямар санагдаж байна?

Би тохирох уу? Ноён 0'Коннор байдгаараа хөхрөв.

- Өрөөнд орохын тулд энэ бүхнийг сэдсэн гэвэл ч...

-Тэгвэл Цамхагаас тэр чигээрээ үенгийн арьсаар гоёчихсон

гарч... Харин манай Жэк гоёлын хиймэл үстэй байх болно гэж ноён Хэнчи хэлэв. Ямар байна даа?

- Жон, намайг хувийн туслахаараа томилчихоорой.

- Бололгүй яахав. Харин Эцэг Кионыг шашны зөвлөхөөрөө авчих. Тэгээд л үзэж тарна даа.

- Ноён Хэнчи, тун зөв шүү! Та ч бусдын адил ингэж их нарийлж болохгүй байсан даа гэж өвгөн хэлэв.

- Саяхан би хөгшин лам Кигэнтэй нэлээд ярьж хуучилсан юм. “Фэт, манай шинэ эзэн чамд ямар санагдаж байна?” гэж түүнээс би асуулаа. Та нар ч нэг их баярлахгүй л байгаа бололтой дог гэж хатгаж үзлээ. “Тун хөгжилтэй байгаа шүү, байхгүй үеэр нь сэмхэн хоол идэж байна даа” гэж тэр хэлж байна лээ. Надад өөр бас юу гэж хэлснийг мэдэх үү? Түүнд би итгээгүй.

- Юу гэсэн юм бэ? гэж ноён Хэнчи, 0'Коннор нар шалгааж гарав.

- Нэг фунт мах авахаар дэлгүүр рүү илгээдэг Дублин хотын амбан захирагч чамд ямар санагдаж байна даа? гэж надаас тэр асуув. Жинхэнэ тансаг амьдрал чинь энэ дээ! гэж тэр хэлсэн. За, чи боль доо гэж түүнд би хэлэв. Амбан захирагчид зориулсан нэг фунт мах гэв. За, чи боль доо гэж түүнд би хэлсэн. - Одоогийн хүмүүс чинь ямар сонин болчихсон юм бэ? гэж байна лээ.

Энэ үеэр хэн нэгэн хүн хаалга тогшиж, нэгэн хөвгүүний толгой цухуйв.

- Тэнд юу болж байна? гэж өвгөн асуув.

- “Хар бүргэд”-ээс ирлээ! гэсээр өнөөх хөвгүүн орж ирээд дүүрэн лонхтой матмал сагс шалан дээр тавив. Лонхтой зүйлийг ширээн дээр гаргаж, тоолоход нь илгээмж зөөгнид өвгөн туслав. Дараа нь хөвгүүн матмал сагсаа шүүрч авснаа,

- Эрхэм ээ, шилнүүдээ яах юм бэ? гэж асуув.

- Ямар шил вэ? гэж өвгөн хэлэв.

- Эхлээд тэднийг чинь уух хэрэгтэй шүү дээ гэж ноён Хэнчи хэлэв.

- Шил байна уу, үгүй юу гэж намайг асуугаарай! гэсэн юм.

- Маргааш ир дээ! гэж өвгөн хэлэв.

- Хөөе, банди аа, чи 0’Фэррелийнд гүйж очоод, ноён Хэнчи явууллаа. Сугалуураа түр өгч байгаач гэж хэлээд аваад ир! Удахгүй биднийг буцаагаад өгнө гээд хэлчих. Наад сагсаа энд орхичих.

Хөвгүүнийг явсан хойгуур ноён Хэнчи тун баяр хөөртэй алгаа үрэх зуур:

- За энэ ч нэг их муу биш шүү! За за, тэр ч тийм ч их муу хүн биш юм аа! Ямар ч байсан хэлсэн үгэндээ хүрлээ гэв.

- Шилэн аяга алга даа гэж өвгөн хэлэв.

- Жэк, санаа зоволтгүй. Тэр ч бүү хэл, боловсон хүмүүс шилнээс нь уудаг юм.

- Юу ч үгүй байснаас дээр шүү дээ гэж ноён 0’Коннор өгүүлэв.

- Тэр бол муу хүн биш ээ. Хамгийн гол нь Фэннинг тэднийг дэндүү их хавчдаг юм гэж ноён Хэнчи хэлэв.

Хөвгүүн сугалуур барьсаар эргэж ирэв. Өвгөн гурван лонх онгойлгоод сугалуурыг түүнд өгмөгц ноён Хэнчи хөвгүүнд хандан,

- Залуу, чи уумаар байна уу? гэв.

- Тийм ээ, эрхэм ээ. Болвол тэгэлгүй яахав.

Өвгөн дуртай дургүй бас дахин нэгэн лонх онгойлгоод хөвгүүнд өгөв.

- Ингэхэд чи хэдтэй билээ?

- Арван долоотой гэж өнөөх хөвгүүн хэлэв.

Өвгөн юу ч дуугарсангүй. Харин хөвгүүн өнөөх лонхыг авснаа:

- Ноён Хэнчи, танд их баярлалаа гэснээ, шилтэй дарсыг пүлхийтэл сорчихоод хоосон лонхыг ширээн дээр нь тавьж ханцуйгаараа уруулаа арчив. Дараа нь сугалуурыг авч юу ч юм бувгнасаар гарч одов.

- Үүнээс л эхэлдэг юм гэж өвгөн айлдав.

- Эхлэх ч бага хэрэг байна аа гэж ноён Хэнчи хэлэв.

Өвгөн онгойлгосон гурван лонхоо тарааж, тэр гурав ууж

эхлэв. Ганц нэгхэн балгамагцаа тэд задгай зуух руу лонхтойгоо ойртуулж тавиад тун сэтгэл хангалуун санаа алдацгаав.

- Өнөөдөр ч би сайн ажиллалаа шүү гэж хэсэг зуур чимээгүй сууснаа ноён Хэнчи өгүүлэв.

- Тийм үү, Жон?

- Тийм ээ. Би Крофтоны хамт Даусоны гудамжинд хэдэн хүний санал авахаар ярьчихсан байгаа. Энүүхэндээ гэж хэлэхэд. Крофтон мэдээжсайн хүн. Гэвч сонгуулийн кампанит ажилд тохирох хүн биш. Загас шиг юу ч дуугардаггүй юм. Мангар юм шиг зогсчихоод харахаас цаашгүй хүн дээ.

Энэ үеэр өрөөнд гурван хүн орж ирэв. Тэдний нэг дэндүү тарган тул хөх шевиотон хослол нь оёдлоороо ханзарчээ. Тэрбээр бух шиг том царайтай, гүн цэнхэр нүд нь духан дээрээ гарчихсан, буурал сахалтай нэгэн байлаа. Харин арай залуу туранхай хоёр эрийн нэг нь нэлээд горзгор, сахал үсээ авсан нэгэн ажээ. Тэрбээр эргэдэг захтай дээл өргөн хүрээтэй малгай өмссөн байв.

- Hello, за Крофтон ч хүрээд ирлээ гэж ноён Хэнчи тарган эрд хандан өгүүлэв.

- Тун хөнгөн шингэн харагдаж байна шүү...

- Уух юм хаанаас олов оо? гэж залуу эр асуув. Манай энэ чинь арай өгөөмөр загнаж байгаа юм биш биз?

- Мэдээж хэрэг. Хамгийн түрүүн уух юмыг Лайонс мэдэрчээ гэж тун баяр хөөртэйгээр ноён О'Коннор өгүүлэв.

- Ингэхэд та чинь сонгогчидтойгоо тулж уулзаж байна уу? гэж ноён Лайонс хэлэв.

- Гэтэл Крофтон бид хоёр хүйтэн бороон дунд санал цуглуулан гүйж байдаг.

- За та нарыг дээ! гэж ноён Хэнчи хэлэв.

- Би ч таван хормын дотор та хоёрын долоон хоног цуглуулснаас илүү олон санал цуглуулж чадна.

- Жэк, хоёр шил дарс онгойлгочих гэж ноён О'Коннор хэлэв.

- Сугалуур байхгүй байхад би яаж онгойлгох юм бэ? гэж өвгөн халаглав.

- Байж бай! Та нар ийм илбэ үзсэн үү? гэж байрнаасаа огло харайн босох зуур ноён Хэнчи хашгирав.

Ширээн дээрээс тэр хоёр лонх дарс аваад задгай зуухны өмнөх хайсан дээр тавив. Дараа нь тэр зуухны өмнө эргэн суугаад лонхтойгоосоо бага зэрэг балгав. Ноён Лайонс ширээний өнцөг дээр сууж, малгайгаа духдуулан тавиад хөлөө савчиж гарав.

- Наад хоёрын чинь аль нь минийх юм бэ? гэж тэр хашгирав.

- Хөгшин минь энэ нь чинийх гэж тэр хэлэв.

Хайрцган дээр сууж байсан ноён Крофтон хайсан дээрх хоёр лонхноос нүд ер салгасангүй. Тэрбээр хоёр шалтгааны улмаас дуугүй байлаа. Нэг дэх нь мэдээж хэрэг нэлээд даацтай байсан тул түүнд хэлэх юм байсангүй; хоёр дахь шалтгаан бол, хамтрагчдаа тэр доогуур үнэлдэг байв. Урьд нь тэр Уилкинсын төлөө санал цуглуулж байсан ч консерваторчууд нэр дэвшигчээ татаж авсаны дараа, цуглуулсан саналаа үндэстний намаас нэр дэвшигчийн төлөө өгсөн тул ноён Тирнийн сонгуулийн сурталчилгаанд тэр ажиллахад хүрсэн ажээ. Хэдэн хормын дараа “пог” хэмээн даруухан дуугарч ноён Лайонсын лонхны бөглөө мулт үсрэх чимээ сонсдов. Ноён Лайонс ширээн дээрээс үсрэн бууж задгай зуух руу очоод, лонхтой дарсыг авч ширээ рүү эргэв.

- Крофтон, та бид өнөөдөр боломжийн хэмжээний санал цутуулсан тухайд би сая ярьж байлаа гэж ноён Хэнчи хэлэв.

- Ингэхэд та хэнийг илрүүлчихсэн юм бэ? гэж ноён Лайонс асуув.

- Нэгдүгээрт, би Парксыг илрүүлсэн, хоёрдугаарт, би Аткинсоныг илрүүлсэн. Мөн түүнээс гадна Даусоны гудамжны Уордыг илрүүлсэн. Жинхэнэ эр хүн дээ. Хуучны консерватив үзэлтэн. Гайхалтай өвгөн шүү! “Тэр чинь танай үндэстний үзэлт нэр дэвшигч шүү дээ” гэж тэр өгүүлэв. “Тэр чинь олонд хүндлэгдсэн алдартай хүн” гэж би хэлэв.

- Манай эх оронд ач тустай байж болох бүх юмны төлөө Строт тэмцдэг, их хэмжээний татвар төлдөг юм гэж би хэлэв. - Тэр хотын төвд байртай, гурван ч хонтоортой, тиймээс түүний ашиг сонирхол бол аль болох татварыг багасгах асуудал юм. Тэрбээр олны танил, хүндэт иргэн бөгөөд ядуусын зөвлөлийг ивээн тэтгэгч нам бус хүн гэж би хэлэв. Тэдэнтэй ингэж л ярих учиртай.

- Тэгвэл танд илгээх хаягийн тухай яах болж байна? гэж дарсаа шимэн уруулаа жимийлгэх зуур ноён Лайонс асуув.

- Танд би нэг юм хэлье. Манай эх оронд хөрөнгө хэрэгтэй. Энэ бол тун чухал зүйл гэж хөгшин Уордод би хэлж байсан юм гэж ноён Хэнчи яриагаа эхлэв. Вангийн айлчлал манай

улсад мөнгө цутгахын дохио юм. Дублины иргэдэд ч бас ач тусаа өгнө. Үйлдвэрийн барилгуудыг хар даа, ажиллаж байгаа юм нэг ч алга. Хуучны аж үйлдвэрлэл болох үйлдвэрийн барилгуудыг ажилд оруулвал улс оронд маань хичнээн их мөнгө орж ирэх вэ? Бодоод үз дээ. Бидэнд хамгийн чухал байгаа зүйл бол хөрөнгө юм.

- Жон, гэхдээ та сонсдоо гэж ноён О'Коннор хэлэв.

- Бид яахлээрээ Английн Вангхүлээн зөвшөөрөх ёстой гэж? Парнелл чинь өөрөө...1

- Парнелл үхсэн шүү дээ! гэж ноён Хэнчи хэлэв.

- Энэ бол миний үзэл бодол. Харин одоо хөгшин эх2 нь түүнийг санчиганд нь буурал суутал юунд ч хүргэдэггүй байсны эцэст энэ нөхөр Вангийн сэнтийд заларлаа. Тэр бол дээд язгуурын хүн, тиймээс ч бидэнд муу юм хүсэхгүй байгаа. Тэр маш тохитой, томоотой сайн залуу. Хэрэв та нар миний сэтгэгдлийг сонсохыг хүсч байгаа бол одоо би хэлье. Тэр өөртөө хандан: “Эмгэн хэзээ ч энэ зэрлэг ирландчууд руу хяламхийж ч байгаагүй. Тиймээс1 1885 онд Парнелл “Ирландын бүхий л хараат бус эх оронч иргэдийг” VII Эдуардыг айлчлах явдлыг эсэргүүцэхэд уриалж байв

2 Вангийн ахайтан Виктория /1815-1901/ тэднийг ямар амьтад болохыг нь өөрийн биеэр явж үзье” гэж өөртөө хэлж байсан гэдэг. Тиймээс биднийг нөхөрсгөөр эргэн ирэх гэж байхад нь юунд түүнийг доромжлох шаардлага байна вэ? Аль вэ, хэл дээ? Крофтон, миний зөв биш гэж үү?

Ноён Крофтон толгой дохив.

- Эдуард Вангийн амьдралыг та нар мэдэж байна уу? Нэг их...1 Тэдний яриаг хүлээн зөвшөөрч байна уу? гэж ноён Лайонс хэлэхдээ тэдний ярьсантай санал нийлсэнгүй.

- Өнгөрсөн борооны хойноос цув нөмрөх хэрэггүй гэж ноён Хэнчи хэлэв.

- Би лав хувьдаа энэ хүнээр бахархаж байна. Тэр бол бидний нэгэн адил жирийн нэгэн танхай архичин. Уух идэх, хүүхэн эргүүлэхээс гадна тэр маш сайн тамирчин хүн. Үнэн хэрэгтээ ирландчууд бид яагаад түүнд хүн шиг хандаж болохгүй гэж?

- За тийм байж. Гэвч Парнеллын хэргийг эргэн санаач гэж ноён Лайонс хэлэв.

- Бурхан өршөө! Үүнд төстэй зүйл байгаа гэж үү? Хэмээн ноён Хэнчи өгүүлэв.

- Бидэнд ч гэсэн өөрийн гэсэн шүтээн байгаа гэдгийг би хэлэх гэсэн юм хэмээн ноён Лайонс яриагаа үргэлжлүүлэв. Тиймээс бид тэр нөхрийг юу боллоо гэж баяр хөөр болон угтах ёстой юм бэ? Тэр хийсэн үйлдлийнхээ дараа Парнелл тэгээд манай удирдагч байж чадах байсан юм уу? Долоодугаар Эдуардыг бид яагаад баяр ёслолын байдалтай угтан авах ёстой гэж?

- Өнөөдөр Парнеллын Бурхан болсон өдөр гэж ноён

1 Вангийн олон тооны нууц амрагуудыг энд хэлж байна. Тэрбээр завхай байдлаасаа болж

шүүхэд хүртэл дуудагдаж байжээ

0'Коннор хэлэв. - Өнгөрснийг хэн эргэн санах вэ дээ...

Түүнийг нас барж оршуулагдсан хойно, бид байтугай консервативчууд хүртэл түүнийг хүндлэн мэхийж байна гэж харж ноён Крофтонд хандан эргэн тэр хэлэв.

Пог! Оройтсон үйсэн бөглөө ноён Крофтоны лонхноос үсрэн гарав. Ноён Крофтон хайрцган дээрээс босч, задгай зуух руу дөхөж очив. Өөрийн олзтой эргэн ирэх зуур тэр тун сэтгэл шингэсэн дуугаар:

- Манай нам түүнийг жинхэнэ эр хүн байсных нь төлөө хүндэлдэг юм хэмээн өгүүлэв.

- Крофтон, чиний зөв! гэж ноён Хэнчи түүний хэлснийг халуунаар дэмжив.

- Тэр бол энэ бүх шуудайнд хийсэн эвэр шиг амьтдыг тогтоож чадаж байсан цорын ганц хүн. “Нохой минь дуугүй бай!”, “Нохойн гөлөгнүүд минь дуугүй бай!” Тэдэнтэй тэр ингэж л харьцаж байсан.

- Жо, ор, ор! гэж тэрбээр хаалган дээр зогсох ноён Хайнст хандан хэлэв. Ноён Хайнс алгуурхан оров.

- Жэк, дахиад нэг лонх онгойлгочих гэж ноён Хэнчи хэлэв.

- Тийм ээ, сугалуур байхгүй гэдгийг би бүр мартчихаж! Наашаа нэгийг өгчих. Галд ойрхон тавьчихъя.

Өвгөн түүнд бас дахин нэг лонх дарс авч өгөхөд ноён Хэнчи түүнийг хайсан дээр тавив.

- Жо, наашаа суу! Энд бид их удирдагчийн тухай ярилцаж байна гэж ноён 0'Коннор өгүүлэв.

- Яг тийм шүү гэж ноён Хэнчи хэлэв.

Ноён Хайнс Лайонсын дэргэдэх ширээний өнцөг дээр дуугүйхэн суув.

- Түүнээс холдож чадаагүй ядаж ганц хүн байгаа юм шүү гэж ноён Хэнчи хэлэв. - Жо, та сайн хүн шүү! Та бол түүний төлөө эцсийг нь хүртэл зогсч байсан хүн.

- Жо, намайг сонс! гэж ноён 0'Коннор гэнэтхэн хэлэв.

\- Та өөрийнхөө бичсэн тэр шүлгийг бидэнд уншиж өгөхгүй юу?

Санаж байна уу? Та түүнийг цээжээрээ мэдэх үү? Жо, эхэл дээ гэж ноён 0'Коннор хэлэв.

- Алив унш л даа! гэж ноён Хэнчи хэлэв.

- Бидэнд уншиж өгөөч! Крофтон түүнийг та сонсч байсан уу? Тэгвэл сонс л доо. Тун



гайхамшигтай!

- За алив Жо, эхэл дээ! гэж ноён О'Коннор хэлэв.

Ярианы сэдэв болж байсан шүлгийг ноён Хайнс шуудхан санаагүй ч хэсэг азнасны эцэст,

- Аан, тэр шүлэг үү... Нэлээд эрт бичсэн дээ хэмээв.

- Уншаач! гэж ноён О'Коннор өгүүлэв.

- Чиш-ш! Чимээгүй! гэж ноён Хэнчи хэлэв.

-Жо эхлээрэй! Ноён Хайнс бага зэрэг тээнэгэлзэв. Дараа нь бүгд дуугүй болмогц, малгайгаа авч ширээн дээр тавиад босов. Тэрбээр шүлгийн мөрийг өөрөө өөртөө давгах мэт зогсоно. Нэлээдгүй үргэлжилсэн завсарлагааны эцэст тэр хоёр ч удаа ханиалгаснаа ийнхүү уншиж эхлэв.

ПАРНЕЛЛЫН ҮХЭЛ /1891 оны 10 дугаар сарын 6-ны өдөр/

Тэр үхсэн. Сэнтийд суугаагүй ван Төрсөн нутгийнхаа шороонд шингэсэн.

Төрөлх Эрин1 минь түүнийг өрөвдөн эгшээч Таны хүү худал гүтгүүлж бурхан болсон.

1 Ирланд орны эртний нэр

Новшийн ноход өгөөмөр занг нь хөсөр хаяж Нэгэнтээ түүнийг хорлосон юм.

Хоёр нүүртэн хийгээд хулчгар нэгэн

Хорон үйлдэлдээ баясч өчүүхэн төдий баярлана.

Эрин минь чи орд харш, ядуусын урцанд ч Эгэлгүй сэтгэлийн нулимсаа мэлмэрүүлж байна. Аугаа хүмүүний цогцсыг булшилснаараа чи Амьдралд хандах итгэлээ оршууллаа даа, чи.

Баатар эрс, дуучдыг мандуулснаараа тэр Бүрэгхэн чиний нэрийг олонд өргөх байсан.

Эцэг дээдсийнхээ үеэс үед дамжсан Энгүй ногоон хиуарыг хийсгэх байсан тэр.

Энэ л хүслийн агшин хаяанд нь байх үед Эрх чөлөө рүү тэр сэтгэлээрээ тэмүүлсэн.

Удирдан зохион байгуулагч аугаа тэр хүмүүн Урвагч нэгний хорон цохилтод өртсөн.

Андгай тангараг өргөсөн хүмүүний Амийг хороосон хэн боловч хараал идэг!

Өөдгүй лам нарт шүүхээс эрх олгосон Өмхий луйварчидтай хуйвалдагсдыг чөтгөр аваг!

Алдар нэрийг нь шавхайтай хутгасан ч

Аяа, сүүлчийн шүлгийн гүвгнэх дуун сонсдоно.

Ичгүүрт байдал тэдний нэрийг ч

Энэ л насных нь дурсамж бүрийг хэмлэн идэх болно.

Эрин минь чи, домогт баатруудын зүрхийг Ихэд нямбайлан, нандигнан хадгалнам.

Эцсээ хүртэл тэр эрэлхэг зоригтой байж Эрэмгий дайчны адил амиа өгсөн юм.

Алдар нэрийн дуудлага, тэмцлийн шуугиан ч бай Аяа, гүн нойрноос хэзээ ч сэрээж чадахгүй.

Агаат дайсны хөлөөс зайдуухан Амьдралаас хол, нууцхан нойрсч байна.

Ялалт тэднийх, ялагдал түүнийх Ямар ч гэсэн Фэникс лугаа адил аугаа сүнс Энэ л галаас дахин өндийж, гэнэт үүр цайхыг Эрин минь та ойлгох учиртай.

Төрөлх Эрин эрх чөлөө гуйнам Тэрхүү баярын гялалзсан хундаганд Тэмцэгч Парнелл мөнхөд нойрсч буй гэх Тодоос тод уй гашууг илтгэх нэгэн дусал байх ажээ.

Ноён Хайнс ширээндээ суув. Түүнийгуншиж дуусмагц нам гүм ноёлж, дараа нь нижигнэсэн алга ташилт сонсдов. Тэр ч бүү хэл, ноён Лайонс хүртэл алга ташиж байлаа. Тэрхүү нижигнэсэн алга ташилт хэсэг хугацаанд үргэлжлэв. Нам гүм болмогц, сонсогчид бүгд л дуугүйхэн ганц нэг дарс балгацгаав.

- Пог!

Ноён Хайнсын лонхны үйсэн бөглөө погхийн үсрэх үед тэрбээр ширээн дээр малгайгүй чигээрээ улаа бутарчихсан

суусаар байлаа. Тэрээр ч сонсоогүй мэт харагдана.

- Жо, сайн байна гэж ноён О'Коннор хэлээд сэтгэлийн хөдөлгөөнөө дарахын тулд тамхины цаас, хайрцагтай ороомог зэргийг халааснаасаа гаргаж ирэв.

- За Крофтон минь, таны сэтгэгдэл ямар байна даа? гэж ноён Хэнчи хашгирав. - Маш гайхамшигтай байгаа биз? Тийм үү?

- Энэ шүлэг үнэхээр гайхамшигтай юм! гэж ноён Крофтон санаашрангуй өгүүлэв.

Ноён Хүлоэн “Eire Abu” нийгэмлэгийн нарийн бичгийн даргын туслах бөгөөд бараг сарын турш бүхий л Дүблинээр нэг гүйжээ. Түүний гарт бөөн бохир цаасны цуглуулга байх агаад тиймэрхүү цааснууд мөн л халааснаас нь цухуйна. Тэрбээр хэд хэдэн концерт зохион байгуулж байв. Нэг хөл нь богино тул нехед нь түүнийг “хазгар Хүлоэн” гэж хочилно.

Тэрбээр зогсоо зайгүй урагш, хойш алхалж, хэдэн цагаар ч хамаагүй замын уулзвар дээр зогсч, бүхий л хүмүүстэй ажил үүргээ шүүн ярилцаж, ямар нэгэн зүйл бичиж тэмдэглэн авах хэдий ч эцэст нь энэ бүхнийг хатагтай Карни зохион байгуулсан болж таарав. Дэвлин бүсгүй Карни авхай болж олны дургүйг хүргэв. Тэрээр франц хэл, дуу хөгжмийн хичээл заадаг сургалт сайтай сүмд сурч боловсорчээ.

Харахад бүрэг мэт авч, хэт ёсорхуу тэрээр сургуульд байхдаа бараг хэнтэй ч үерхдэггүй байжээ. Эр нехерт гаргаж, олны нүдийг хужирлах үед ихэнх хүмүүс түүний наргианч зан хийгээд биеэ авч явах байдлыг шагшин ярилцах болов. Өөрийгөө тэр төгс төгөлдөр байдлын мөсөн ханаар хүрээлүүлж суухдаа, эцэс сүүлд нь хэн нэгэн түүнийг хүчээр эзэмдэж, гялалзсан сайхан амьдралыг санал болгоно хэмээн хүлээсээр байлаа. Гэвч түүнтэй учирч байсан залуус бусдаас юугаар ч үл ялгарах тул тэднийг тэр үл тооно; харин гэнэн цайлган сэтгэлийн хөдөлгөөнөө Дорно зүгийн амттан хүртэн байж дарна.

Тэр ч бүүхэл, найз хүүхнүүд нь хэл амаа билүүдэж эхэлмэгц, тэдний амыг хаахын тулд Ормондын эрэгт багашаархан гутал засварын газартай Карни гэгчтэй гэр бүл болжээ. Түүнээс тэр хавгүй хөгшин нэгэн байв. Үргэлжийн чухал хэл яриа урт хүрэн сахалд нь тээглэнэ. Нөхөрт гарснаас хойш нэг жилийн дараа иймэрхүү хүн ямар нэгэн ойворгон залуугаас хавьгүй дээр юм гэдгийг хатагтай Карни ойлгосон ч гэгээхэн үзэл бодлоо ер орхисонгүй. Тэрбээр сүсэг бишрэлтэй, туйлын гамтай, тэсвэр тэвчээртэй нэгэн тул сар бүрийн эхний баасан гарагт заримдаа эхнэрийн хамт, гол төлөв ганцаар ариусдаг байсан бол, бүсгүй хатуухан итгэл үнэмшилтэйн сацуу түүний сайн эхнэр байлаа.

Нэг их дотно бус айлд зочилвол түүнийг хөмсгөө бага зэрэг зангидахад л эр нөхөр нь босч гэрийн эзэдтэй салах ёс хийнэ. Харин түүнийг ханиад хүрвэл хөлийг нь өдөн хөнжлөөр хучиж, халуун дарс бэлдэж өгнө. Нөгөөтэйгүүр, тэр үлгэр жишээ гэрийн эзэн байв. Долоо хоног бүр бага зэрэг мөнгө хийснээр, хоёр охиноо хорин дөрвөн нас хүрэхэд зуу зуун фунтын инж өгөх боломжтой болжээ.

Том охин Кэтлинийг франц хэл, дуу хөгжим зааж сургадаг сайн сургалттай сүмд өгсөн бол, дараа нь түүнийг Академид<sup>1</sup> сурах төлбөрийг хийжээ. Жил бүрийн долоодугаар сард хатагтай Карни завшаан л гарвал хэн нэгэн найз бүсгүйдээ хандан: “Манай нөхөр биднийг Скэрриз руу гурван долоон хоногийн хугацаатай явуулах гэж байгаа” хэмээн хэлэхийг үл мартана. Хэрэв энэ нь Скэрриз биш байлаа гэж бодоход Хоут юм уу, Грэйстонз<sup>2</sup> байлаа.

Ирландын Сэргэн мандалт хүчээ авсан цагт, хатагтай Карни охиныхоо нэрээр ашиг олохоор шийдэж, ирланд

2 Ирландын дээд зэргийн сувиллын газрууд хэлний багшийг гэртээ урьсан байна. Кэтлин эгчийнхээ хамт Ирландын нутаг усны өнгөлөг зураг бүхий ил захидлууд найз нөхөддөө илгээж, хариуд нь тэднээс мөн л тиймэрхүү өнгөлөг ил захидлууд хүлээн авч байлаа. Ноён Карнийг гэр бүлийн хамт сүмийн цуглаанд явдаг ням гараг бүр гудамжны өнцөг дээр бөөн хүн ажлаа таран цугладаг байжээ.

Тэд бүгд Карнийн гэр бүлийн анд нөхөд агаад дуу хөгжим юм уу, Гэлийн Сэргэн мандалт зэрэг сонирхлын эрх ашиг тэднийг холбож байлаа; хов живээ солилцож дуусахуйд тэд гар гараасаа барилцан, нэг дор ийм олон гар барилцаж буйг шоолон инээцгээж, бие биедээ гэлиэр “баяртай!” хэмээн салах ёс хийнэ.

Төдөлгүй Кэтлин Карни бүсгүйн нэрийг улам бүр давтан ярьцгаах болов. Гайхамшигтай хөгжимчин, тун хонгорхон бүсгүй гэхээс гадна Гэлийн Сэргэн мандлын талыг баримтлагч хэмээн түүнийг сайшаан ярина. Хатагтай Карни энэ бүхэнд тун их сэтгэл хангалуун байлаа. Тиймээс нэгэн сайхан өдөр ноён Хүлоэн тэднийд ирж, Энтъентийн концертын танхимд Нийгэмлэгээс зохион байгуулахаар болсон дөрвөн том концерт дээр охиныг нь хөгжим тоглохыг санал тавихад нь тэр ер гайхсангүй.

Түүнийг тэр зочны өрөөнд урьж, суухыг санал болгоод шилэн савтай дарс, мөнгөлөг савтай жигнэмэгээр дайлав. Тэрхүү байгууллагын бүхий л үйл ажиллагааг тун сониучирхан асууж, янз бүрийн санал зөвлөгөө өгч гарав; эцэс сүүлд нь дөрвөн том концерт дээр хөгжим тоглосны төлөө Кэтлин найман гинейн хөлс авах ёстой гэх гэрээ хийжээ.

Ноён Хүлоэны хувьд, зарлалын үг бичих, хөтөлбөрийн дэс дугаарыг зохицуулах зэрэг иймэрхүү нарийн ширийн ажилд маруухан нэгэн байсан тул хатагтай Карни түүнд тусалж байлаа. Тэрээр тун торгон мэдрэмжтэй нэгэн ажээ. Ямар жүжигчдийн нэрсийг том үсгээр, хэнийг нь жижигрүүлж бичихийг тэр сайн мэднэ.

Тэргүүн цээл хоолойт дуучин ноён Мид хошин дууны дараа дуулахыг хүсэхгүй гэдгийг тэр мэдэж байлаа. Үзэгчдийг уйдаахгүйн тулд зарим нэгэн эргэлзээ бүхий хөтөлбөрийн завсар олны танил болсон жүжигчдийн тоглолтыг хавчуулжээ. Ноён Хүлоэн өдөр бүр түүн дээр очиж ямар нэгэн асуудлаар зөвлөлдөнө. Түүнийг тэр ойрын хамаатан шигээ тун найрсгаар ивээлдээ авч бүхий л талаар туслахыг хичээнэ.

Тэрээр лонхтой дарс ойртуулж тавьснаа:

- Ноён Хүлоэн, та өөртөө хийгээрэй! гэж хэлэв. Шилэн лонхноос барьж авах үед тэр:

- Алив дүүрэн хий л дээ! гэж хатгана. Бүх зүйл тун сайхан бүтэж байлаа.

Хатагтай Карни Кэтлин даашинзанд оруулга хийхээр Браун Томасаас 1 тун сайхан шүрэн торго худалдаж авав. Энэ тийм ч хямд байсангүй авч зарим нэгэн онцгой тохиолдолд илүү мөнгө төлөх явдал гарах энүүхэнд. Сүүлчийн концертын арван тасалбарыг тус бүрийг нь хоёр шиллингээр худалдан авч урихаас өөр аргагүй найз нөхөддөө тэр илгээжээ. Бүгдийг санаж байх тул үүний хүчинд бүх зүйл яг таг бүтэмжтэй болов. Концертыг лхагва, пүрэв, баасан, бямба гарагт тус бүр тоглох учиртай байв.

Лхагва гарагийн үдэш хатагтай Карнийг охины хамт 1 Үнэтэй эд бараа худалддаг Дублины баячуудад зориулсан дэлгүүр Энтъентийн концертын танхимд хүрэлцэн ирэхэд ямар нэгэн зүйл түүнд ер таалагдсангүй. Тод цэнхэр (гогцоо бүхий) тэмдэгтэй хэд хэдэн залуу үүдний танхимд баяр ёслолын байдалтай зогсоно; тэдний хэн нь ч гоёлын хослолгүй байлаа. Тэрээр охины хамт тэдний дэргэдүүр өнгөрч, танхимын нээлттэй хаалга руу түргэхэн харц чулуудаад, зохион байгуулагчид чухам яагаад ажилгүй зогсч буйг ойлгожээ. Эхэндээ тэр цагаа андуураагүй байгаа хэмээн бодсон аж. Үгүй ээ, наймд хорин хором дутуу байлаа.

Тайзны ар дахь жүжигчдийн өрөөнд Нийгэмлэгийн нарийн бичгийн дарга ноён Фицпатрикт түүнийг танилцуулав. Тэрээр инээмсэглэсээр гараа сунгав. Эрхэм ноёнтон намхан нуруутай, огт хэнэггүй, цонхигор царайтай нэгэн байв. Зөөлөн хүрэн бүрхээ хэлтгйдүүхэн тавьж, англи аялгаар ярьж байхыг нь тэр анзаарав.

Гартаа тэр хөтөлбөр барьсаар хатагтай Карнтай ярилцах з зуур> түүний булангаас урж зажилж байлаа. Хувь заяаны цохилтыг тэр тун хөнгөхөн давж гардаг болох нь харагдана. Таван хором тутам ноён Хүлөөн өрөөнд орж ирэн тасалбарын худалдаа ямархуу байгаа талаар мэдээлнэ. Жүжигчид тун сэтгэл хөдөлсөн байдалтай өөр хоорондоо ярилцаж, цаг үргэлж толинд харцгааж, ноотнуудаа эргүүлж тойруулан хуйлцгааж байлаа.

Бараг найм хагас болохын алдад танхимд сууж байсан цөөн тооны үзэгчид тэвчээр алдран шуугиж гарав. Ноён Фицпатрик орж ирүүт хэвнэг инээмсэглэснээ,

- Ноёд, хатагтай нар аа! Миний бодлоор үдшийн цэнгүүнийг нээх цаг болжээ гэж тэр айлдав. Хатагтай Карни түүнийг үзэн ядсан харцаар мялааж, дараа нь охиндоо хандан, сэтгэлийг нь өргөсөн өнгөөр:

- Хонгор минь, чи бэлэн үү? гэж асуув. Хэсэг хормын дараа тэр ноён Хүлөөнийг дуудаж зайдуухан очоод, энэ бүхэн юунаас болов оо? гэж түүнээс шалгаав. Энэ бүхэн ямар учиртайг ноён Хүлөөн мэдэхгүй байлаа.

Хорооны зүгээс нэгэн зэрэг дөрвөн концерт тавихаар шийдвэрлэсэн нь буруу болжээ. Дөрөв арай ихдэж байна гэж тэр хэлэв.

- Тэгвэл энэ жүжигчид чинь яах болж байна аа? гэж хатагтай Карни өгүүлэв.

- Мэдээж хэрэг тэдэнд хэцүү л байгаа. Гэвч тэд нар чинь ер шаардлага хангахгүй байна.

Ноён Хүлөөн жүжигчдийг шаардлага хангахгүй гэдгийг хүлээн зөвшөөрөв. Түүний хэлснээр бол, хорооны зүгээс эхний гурван концертыг урсгалаар нь орхиж, бүхий л авьяастнуудыг ням гарагийн тоглолтод гаргахаар шийджээ. Хатагтай Карни дуугүй болсон хэдий ч тайзан дээр гарах ёстой сайн дурын уран сайханчид солигдон гарах зуур танхимд суусан үзэгчид улам бүр цөөрч, ийм концертын төлөө хамаг байдгаа зарцуулсандаа тэр харамсч эхлэв.

Энэ бүхэн түүнд ер таалагдахгүй байсны сацуу ноён Фицпатрикийн хэнэггүй инээмсэглэл түүнийг галзууруулах шахав. Гэвч тэр энэ бүхэн юугаар дуусахыг дуугүйхэн хүлээж байлаа. Оройн арван цагт хөтөлбөр дуусах шатандаа орж, тэнд цугласан хүмүүс гэр гэр рүүгээ

тарцгаав. Пүрэв гарагийн концерт дээр арай олон хүн байсан ч танхимд дан ганц тасалбар түгээгч нар сууж буйг Карни авхай хараад л мэдрэв.

Үзэгчид концерт биш харин сургуулилалт дээр ирсэн мэт үл хүндэтгэсэн байдлаар хандаж байлаа. Харин ноён Фицпатрикийн хувьд хатагтай Карни түүний зан байдлыг ажиглахуйд, уурлаж буйг нь ер анзаараагүйгээс гадна тун чиг сэтгэл хангалуун байхыг мэдрэв. Тэрбээр хажуугийн гэрэлтүүлгийн дэргэд зогсч, үе үе толгойгоо цухуйлгах агаад дээд давхрын буланд сууж буй хоёр найзтайгаа биесээ даажигнаж байлаа.

Үдэшлэг дуусахын алдад баасан гарагт концерт тоглохгүй гэдгийг хатагтай Карни мэдсэн агаад хорооны шийдвэрээр бямба гарагийн орой танхим дүүрэн хүн цуглуулахын төлөө бүхнийг хийхээр төлөвлөжээ. Хатагтай Карни үүнийг сонсуут ноён Хүлөөнийг эрж олов. Тэрбээр шилэн аягатай нимбэгний ундаа барьсаар, хэн нэгэн залуу авхайд аваачиж өгөхөөр яаравчлан хазагнаж явах замд нь түүнийг барьж аваад, энэ бүхэн үнэн эсэхийг асуужээ. Тийм ээ. Энэ үнэн байлаа.

- Тэглээ гээд гэрээнд өөрчлөлт орохгүй биз дээ? Гэрээг дөрвөн концертод тоглуулахаар хийсэн шүү дээ! гэв.

Ноён Хүлөөн тун ихяарч байв; тэр түүнд ноён Фицпатриктэй ярилцахыг зөвлөв. Хатагтай Карни санаа зовж эхлэв. Ноён Фицпатрикийг тэр гэрэлтүүлгийн араас дуудаж, түүний охин дөрвөн концертод тоглох гэрээ хийснийг хэлэв. Нийгэмлэгийн зүгээс дөрөв ба түүнээс бага концерттогтноос үл шалтгаалж, гэрээнд заасны дагуу охин нь тохирсон хөлсөө авах учиртай гэж тэр асав. Ноён Фицпатрик хэрэг явдал юунд оршиж буйг шуудхан ойлгоогүй тул энэхүү асуудлыг шуудхан шийдэхэд хүндрэлтэй байна гэж хэлээд энэ талаар хороонд уламжлая гэв. Уур хилэнд автсанаас болж түүний царай байдгаараа улайж: “Тэр хороо гэдэг чинь юу юм бэ? Алив хэлээд аль” гэж арай л хэлэхийн наагуур амаа барив. Энэ нь боловсролтой эмэгтэйн хувьд байж боломгүй зүйл гэдгийг мэдрээд юу ч хэлсэнгүй. Баасан гарагийн өглөөгүүр бөөн зарын хуудас барьсан банди нарыг Дүблины гудамжаар хаа сайгүй илгээв. Бүхий л үдшийн сонингуудад маргааш орой тэднийг хүлээж буй баярыг сануулсан тусгай зар гарсан байлаа. Хатагтай Карни бага зэрэг тайвширсан ч санаа зовж буйгаа нөхөртэйгөө хуваалцах нь зүйтэй юм гэж үзэв. Нөхөр нь түүний яриаг анхааралтайхан сонсоод, ирэх бямба гарагт тэд хамтдаа явбал дээр юм байна гэж хэлэв. Тэрээр зөвшөөрөв. Хатагтай Карни Төв шууданг үндэс суурьтай, найдвартай байгууллага гэж үздэг шигээ эр нөхрөө мөн хүндэлдэг нэгэн байв; түүний авьяас чадвар нэг их биш ч эр хүний хийсвэр зан чанарыг нь тэр үнэлдэг байлаа.

Түүнийг хамтдаа явах санал гаргасанд нь тэр ихэд баярлав Тэрээр өөрийнхөө төлөвлөгөөг дахин бодож үзэв. Томоохон концерт тоглох үдэш болов. Хатагтай Карни, нөхөр, охины хамт тоглолт эхлэхээс арван таван хормын өмнө Энтъентийн концертын танхимд очжээ. Харамсалтай нь бороо орж байлаа. Хатагтай Карни нөмрөг хийгээд охиныхоо ноотыг нөхөртөө өгчихөөд, ноён Хүлөөн юм уу, ноён Фицпатрик нарыг хайхаар бүхий л байгууламжаар нэг явав.

Тэдний хэнийгч тэр олжчадсангүй. Хорооны төлөөлөгчдөөс хэн нэгэн байгаа эсэх талаар зохион байгуулагчдаас лавлахад, нэлээд юм болсны эцэст Бэйрн хэмээх жижигхэн биетэй

хүүхнийг олж өгөв. Нарийн бичгийн дарга нарын хэн нэг нь хэрэгтэй байгаа талаар хатагтай Карни түүнд тайлбарлав. Бэйрн авхай тэднийг удахгүй ирэх тухай хэлээд ямар нэгэн зүйлээр тусалж чадах эсэхээ асуув.

Баяр бахдал хийгээд итгэмтгий байдал шингэсэн хуучны шавар бурхан шиг дүр төрх бүхий царайг харууг:

- Үгүй ээ, танд баярлалаа! гэж Хатагтай Карни хариулав.

Өнөөдөр лав танхим дүүрэн байна гэдэгт итгэж буйгаа Бэйрн хэлэв. Бороонд норсон гудамжны баргархан дүр зураг түүний үрчлээстэй нүүрнээс баяр хөөр хийгээд итгэл найдварыг бүрэн арилгаж дуустал шиврэн орох бороог тэр ширтэн зогссоор байлаа. Тэрээр зөөлөн санаа алдаад:

- За яахав. Бурхан харж л байгаа. Бид чадах бүхнээ л хийсэн гэж хэлэв. Хатагтай Карни жүжигчдийн өрөө рүү эргэж очиход. Жүжигчид цуглаж байлаа.

Баргил хоолойт, хоёр дахь цээл хоолойт ч бас ирчихсэн байв. Баргил хоолойт ноён Даггэн бол өрвийсөн хар сахалтай, цэх нуруутай залуу хүн ажээ. Тэрбээр хотын нэгэн албанд хаалгачийн хүү байсан агаад аль багын л албан байгууллагын аугаа том үүдний танхимд баргил хоолойгоороо хангинуулж байсан гэдэг. Эгэл бор амьдралаасаа тэр өөрийн хүчээр гарч ирээд, эцэст нь тэргүүн зэргийн жүжигчин болж чадсан юм. Тэр дуурьт дуулдаг байв. Нэгэн удаа дуурийн жүжигчдийн нэг өвдсөн үед тэр “Вангийн ахайтан”<sup>1</sup> театрт товлогдсон “Маритана” дуурийн Вангийн хэсгийг дуулж байжээ.

Тэрбээр өөрийн хэсгийг тун их мэдрэмжтэй хийгээд чадалтай дуулсныг үзэгчид халуухнаар хүлээж авсан билээ; харамсалтай нь тэр мартамхай зандаа авган хоёр ч удаа илгэн бээлий рүүгээ найтаасан нь хүмүүсийн сайхан сэтгэгдлийг үгүй хийсэн юм. Гэвч тэр хүний анхаарал татах амьтан биш агаад тун бага ярина.

<sup>1</sup> XX зууны эхэн үеийн Дублины гурван том театрын нэг

Тэгж хэмээн ярихын оронд “тигж” хэмээн тун зөөлөн дуугаар хэлэхийг нь бараг хэн ч анзаардаггүй байсны сацуу хоолойгоо гамнаж сүүнээс өөр хатуу юм огт уудаггүй байв. Хоёр дахь цээл хоолойт болох ноён Бэллын хувьд жил бүр “Feis SeoI”<sup>1</sup>-д оролцдог хасын цагаан царайт царайлаг залуу ажээ.

Дөрөв дэх уралдаант шалгаруулалт дээр түүнд хүрэл медаль хүртээжээ. Тэрбээр тун хийрхүү нэгэн байсны сацуу бусад цээл хоолойтууддаа атаархаж, өөрийн хий атаархлыг найз нөхөр мэт хуурмаг зан гаргаж нуудаг байлаа. Концертод оролцоно гэдэг түүний хувьд ямар их ял болохыг тэр бүх хүнд ойлгуулахыг хичээнэ. Тиймээс ноён Даггэныг харуут түүн рүү дөхөж очоод:

- Та бас оролцож байна уу? гэж асуув.

- Тийм ээ хэмээн ноён Даггэн хариулав.

Ноён Бэлл зовлон нэгт нөхөртөө хандан инээмсэглэж, гараа түүнд сунгаад:

- Тун их харамсч байна гэж хэлэв.

Хатагтай Карни энэ хоёр залуугийн хажуугаар өнгөрч танхим руу харсаар гэрэлтүүлэг руу дөхөж очив. Суудал нэлээдгүй дүүрч, танхимд аятайхан уур амьсгал бий болсон байлаа. Тэрээр жүжигчдийн өрөө рүү эргэж очоод нөхөртэйгөө нууцхан шивнэлдэв. Бодвол тэд Кэтлины тухай ярилцаж байсан биз ээ.

Учир нь тэд үе үеэ түүн рүү харцгаана, харин тэрээр эрдүү хоолойт Хилли бүсгүйтэй ярилцаж зогсоно. Хэний ч үлгэр Баяр /ирланд үлгэр Жич: 1897 оноос эхлэн жил бүр зохиогддог Дублины хөгжмийн уралдаант шалгаруулалтын нэр

таних нэгэн цонхигор царайтай хатагтай өрөөнд орж ирэв. Ясархуу биеийг нь барьсан, гандсан цэнхэр даашир руу нь тэнд байсан хүүхнүүд тун гярхай харцгаана. Хэн нэгэн түүнийг нарийн хоолойт хатагтай Глинн гэж хэлэв.

- Түүнийг хаанаас ухаж олсон юм бол доо? гэж Кэтлин бүсгүй Хиллид хандан өгүүлэв.

- Түүний тухай би хэзээ ч сонсч байгаагүй юм байна. Хилли бүсгүй инээхээс өөр аргагүйд хүрэв. Энэ үеэр өрөө рүү ноён Хүлөөн хазганасаар орж ирмэгц, хоёр бүсгүй түүнээс үл таних хатагтайн талаар асуужээ. Энэ бол Лондонгоос ирсэн хатагтай Глинн гэж ноён Хүлөөн хэлэв. Өрөөний булан дахь ажиглагчийн байран дээрээс хатагтайн Гл инн тэнд байсан хүмүүс рүү тун гайхсан байдалтай харахдаа, хуйлсан ноотоо алдахаас айсан мэт чангахан барьж зогсоно.

Түүний гандсан дааширзыг сүүдэр халхалсан ч яг л чадах гэсэн мэт эгэмнийх нь ирмэг бяцхан хонхорхойг тодхон илтгэнэм. Танхим дахь дуу чимээ улам бүр нэмэгдэнэ. Нэг дэх цээл хоолойт, баргил хоолойт хоёр хамтдаа ирэв. Тэд тун аятайхан хувцасласны сацуу мяраалаг нь зохисон зөөлөн сэтгэлтэй залуус байсан учир ямар нэгэн таашаал бүхий уур амьсгалыг авчрав. Хатагтай Карни охиноо дагуулан тэр хоёр дээр очиж тун эелдэгхэн яриа дэлгэв.

Тэрээр тэдэнд нөхөрсөг байдлаар хандахыг хүсч байсан ч сав л хийвэл нүднээс далд орохыг санаархаж буй хазгар ноён Хүлөөнийг нүдээрээ хариулж байлаа. Боломж гаруут тэр уучлал хүсч түүний араас дагав.

- Ноён Хүлөөн, тантай уулзаж болох уу? гэж тэрээр хэлэв. Тэд хонгилын хамгийн цаад үзүүрт очив. Хатагтай Карни охиных нь шагналыг хэзээ өгөх талаар асуув. Энэ бол ноён Фицпатрикийн мэдэх асуудал гэж ноён Хүлөөн хэлэв. Ноён Фицпатрикийг тэр сайн мэдэхгүй гэж хатагтай Карни өгүүлэв. Түүний охин найман гинейн үнэ бүхий гэрээнд гарын үсэг зурсан тул түүнд төлбөр төлөх ёстой.

Энэ бол миний мэдэх асуудал биш! гэж ноён Хүлөөн хэлэв.

- Яагаад таны мэдэх асуудал биш? гэж хатагтай Карни асуулаа.

- Ингэхэд та чинь өөрөө гэрээг авчирсан юм биш үү? Ямар ч тохиолдолд, хэрэв энэ таны хийх



ёстой ажил биш бол миний хийх ёстой ажил гэдэг нь тодорхой. Тиймээс би энэ тал дээр анхаарах учиртай.

- Та ноён Фицпатриктэй уулзсан нь дээр байх гэж ноён Хүлөөн хайнгадуухан хэлэв.

- Би тэр ноён Фицпатрикийг чинь ер мэдэхгүй! гэжхатагтай Карни давтан өгүүлэв.

- Надад гэрээ бий; тиймээс би түүнийг хэрэгжих тал дээр анхаарах ёстой. Түүнийг жүжигчний өрөө рүү эргэн ирэхэд хацар нь ялимгүй улайсан байв. Өрөөнд бөөн хүн. Хүрэм өмссөн хоёр эр задгай зуухны дэргэдэх буланг эзэгнэчихсэн, Хилли бүсгүй, баргил хоолойт залуу нартай юу ч юм чалчина.

Тэд бол “Freeman” сэтгүүлийн сурвалжлагч, мөн ноён 0’Мэддэн Бэрк нар юм. Концерт эхлэхийг хүлээж чадахгүй гэдгээ хэлэхээр сурвалжлагч орж ирсэн байв. Тэрбээр америк номлогчийн шилтгээнд уншиж буй номлолын талаар нийтлэл бичих шаардлагатай байгаа аж. Тиймээс концертын тухай мэдээллийг сэтгүүлийн газарт аваачиж өг гэж хэлсэн бөгөөд хэвлэх асуудлыг нь анхааралдаа авах болно гэжээ. Тэрбээр буурал толгойтой, хүнгэнэсэн хоолойтой, тун няхуур эр байлаа.

Гартаа тэр унтарсан навчин тамхи барих агаад утааных нь анхилуун үнэр эргэн тойрон хөвнө. Эдгээр концерт, түүнд оролцогчдоос аль эрт залхсан учир энд тэр удаан байхыг хүссэнгүй. Гэсэн хэдий ч задгай зуухны самбар дээр тохойлдон зогссоор байлаа.

Түүний өмнө Хилли бүсгүй зогсон яриа дэлгэх зуураа зөөлөн инээмсэглэнэ. Түүний найрсаг зангийн цорын ганц учир шалтгааныг таахын тулд тэр дэндүү хөгшидсэн авч боломж алдахгүйн хэмжээнд сэтгэлээрээ залуу нэгэн байлаа.

Түүний арьсны өнгө, анхилуун үнэр, халуун дулаан байдал тун таатай сэтгэгдэл төрүүлнэ. Нүдний өмнө дээш доош болох сэргэр хөх нь энэ мөчид гагцхүү түүний төлөө ийнхүү нааш цааш болж буйг тэр тун тааламжтайхан мэдэрч байсан бөгөөд цангинасан инээд, ариун тансаг үнэр, сээтэгнэсэн харц бүгд түүнд өгч буй Бурханы хишиг гэлтэй. Цаашид удаан байх боломжгүй болсон тул тэр тун харууссан байдалтай салах ёс гүйцэтгэлээ.

- 0’Мэддэн Бэрк тэмдэглэл бичнэ. Түүнийг нь би хэвлэж өгнө гэж ноён Хүлөөнд тэр тайлбарлаж өгөв.

- Ноён Хэндрик, танд тун их талархаж байна! гэж Хүлөөн хэлэв.

- Таныг хэвлэнэ гэдгийг би мэдэж байна. Явахаасаа өмнө ямар нэгэн юм уухгүй биз?

- Татгалзах зүйл алга даа! гэж ноён Хэндрик өгүүлэв. Тэд хоёул хонгилоор явж, харанхуй шатаар өгсөн даруухан өрөөнд орцгоов.

Тэнд байсан зохион байгуулагчдын нэг бүлэг эрчүүдэд зориулан лонхны бөглөө мултална. Тэдний нэг нь торгон мэдрэмждээ хөтлөгдөн ийш ирсэн ноён 0’Мэддэн Бэрк байв. Нэлээд сэргэлэн, хижээл насны эр тэрбээр торгомсог том шүхрээ ардаа тулж намуухан ганхсаар

зогсоно. Түүний сонсголонтой ирланд нэр бас л нэгэн төрлийн шүхрийн нэр байсан хийгээд тэрхүү сүүдэрт санхүүгийн үйл ажиллагаа нь нэн хурдацтай цэцэглэнэ.

Тэрбээр олны хүндэтгэлийг хүлээсэн нэгэн байв. Ноён Хүлоэнийг сурвалжлагчтай ярилцаж байх зуур, хатагтай Карни эр нөхөртэйгөө юу ч юм ярьж түүнийг бага зэрэг дуугаа намсгахыг хүсчээ. Жүжигчдийн өрөөнд байсан бусад хүмүүсийн ярианы өнгө нэлээд түгшингүй аястай болов. Хөтөлбөрийн эхэнд гарах учиртай ноён Бэлл гартаа ноот барин бэлэн байдалтай зогсовч, түүний хөгжимчин байрнаасаа ер хөдөлсөнгүй. Бодвол ямар нэгэн зүйл болохгүй байсан бололтой.

Ноён Карни сахлаа имрэх зуур цэх урагш харж харин хатагтай Карни тун биеэ барьсан байдалтай Кэтлины чихэнд юу ч юм шивнэв. Танхимаас тэсвэр алдсан дуу чимээ, алга ташилт хийгээд хөлийн чимээ сонсдоно. Нэг дэх цээл хоолойт тенор, баргил хоолойт болон Хилли бүсгүй нар тун тайвуухан хамтдаа зогсч байхад, ноён Бэлл өөрөөс нь болж оройтож байна хэмээн үзэгчид бодох вий гэхээс дотроо түгшин сандарч байлаа. Ноён Хүлоэн, 0'Мэддэн Бэрк нар өрөөнд орж ирэв. Ноён Хүлоэн дуугүй байгаагийн шалтгааныг шуудхан ойлгов.

Тэрбээр хатагтай Карни руу дөхөж очин тун албархуу өнгөөр ярьж эхлэв. Тэднийг ярилцах зуур танхим дахь дуу чимээ улам хүчтэй болж байлаа. Ноён Хүлоэн гэнэтхэн улайж, сандарч гарав. Тэрбээр тун хурдан ярих агаад харин хатагтай Карни цаг үргэлжид:

- Тэр тоглохгүй! Эхлээд найман гиней төл! хэмээн мөчөөгөө өгсөнгүй. Ноён Хүлоэн хаалганы цаана шуугилдан бужигнаж буй үзэгчдийн зүг хэлэх үгээ олж ядан заав. Тэрбээр ноён Карни, Кэтлин нарт хандаж буй нь энэ аж. Гэвч ноён Карни сахлаа имэрсээр зогсов, харин Кэтлин шинэхэн шаахайныхаа хоншоорыг хөдөлгөн шал руу ширтэнэ.

- Түүнд буруу байхгүй! Мөнгө өгөхгүй бол түүнийг тоглуулахгүй! гэж хатагтай Карни давтан өгүүлнэ. Жаал үг хаясны эцэст, ноён Хүлоэн хаалга чиглэн хазганасаар явж одов. Үг дуугүй байдал, тэсэхийн аргагүй болмогц Хилли бүсгүй баргил хоолойтод хандан:

- Та хатагтай Кэт Кэмпбэлийг<sup>1</sup> энэ долоон хоногт харсан уу? хэмээн асуув. Баргил хоолойт түүнийг хараагүй боловч, та тун их үзэсгэлэнтэй харагдаж байна гэж уламжлав.

Яриа тасалдав. Нэг дэх цээл хоолойт тэргүүнээ гудайлгаж, хэвлийн тус газар нь хөндлөн унжих алтан гинжний хэлхээсийг тоолж гарав. Чингэхдээ янз бүрийн ноот сонгон хоолойгоо шалгаж зогсоно. Бүгд байсхийгээд л хатагтай Карни руу харцгаана. Танхим дахь чимээ хашгираан болон хувирах үед ноён Фицпатрик ширүүхэн орж ирэв; түүний араас амьсгаагаа дарж ядсаар ноён Хүлоэн гүйхээрээ нэг орж ирэв. Танхимд алга таших, хөлөөрөө дэвслэх чимээн дээр шүгэлдэх чимээ ч бас нэмэгдэв.

Ноён Фицпатрик гартаа хэд хэдэн зээлийн тасалбар барьсан байлаа. Тэрбээр хатагтай Карнид дөрвийг тоолж өгөөд, үлдсэн хэсгийг нь завсарлагааны үеэр өгөх болно гэв.

1 Б.Шоугийн танил, Английн алдарт жүжигчийн Патрик Кэмпбэлийг хэлж байна

- Дөрвөн шиллинг дугуу байна гэж хатагтай Карни хэлэв. Энэ үеэр Кэтлин банзлаа сонгочихсон байсан агаад яг л нарс модны навч лугаа адил чичрэн хөтөлбөрийн эхний үзүүлбэр болох “Ноён Бэлл”-д хандан таны гарах цаг боллоо гэж өгүүлэв. Дуучин, хөгжимчин хоёр хамтдаа гарав. Танхимд нам гүм болов. Хэсэг зуур завсарлага авсны дараа төгөлдөр хуурын тоглох чимээ сонсдов.

Хатагтай Глинны тоглолтыг эс тооцвол эхний хэсэг тун дажгүй болж өнгөрөв. Хөөрхий амьтан “Килларни” 1-г ямар ч аялгуу үгүй, тасалдсан өнгөөр дуулахдаа, хуучинсаг хэв маяг хийгээд нугалаа хийснээ тун аятайхан болсон гэж бодсон бололтой. Тэрээр хуучин хувцасны газраас түрээсээр авсан даашинз өмссөн мэт харагдах агаад хямд суудал дээр сууж байсан үзэгчид, нохой мэт гаслах дууг нь байдгаараа шоолж байлаа.

Гэсэн хэдий ч нэгдэх цээл хоолойт, эрдүүхоолойт нар үзэгчдийг байлдан дагуулж чадав. Кэтлины хувьд ирланд дуунуудыг эмхэтгэж тоглосон нь олны талархлыг хүлээв. Тоглолтын эхний хэсэг сонирхогчийн жүжгийг зохион байгуулагч залуу авхайн уран уншсан, сэтгэл хөдөлгөм эх оронч шүлгээр өндөрлөв.

Түүний уран уншлагыг нижигнэсэн алга ташилтаар угтаж шүлэг уншиж дуусмагц завсарлага зарлаж, эрчүүд тамхилахаар гарцгаав. Энэ хугацаанд жүжигчдийн хувцасны өрөөнд зөгийн үүр шиг дүнгэнэлдэж байлаа. Нэгэн буланд ноён Хүлоэн, ноён Фицпатрик, Бэйрн бүсгүй, хоёр зохион байгуулагч, баргил хоолойт, аргил хоолойт, ноён О’Мэддэн Бэрк нар цуглажээ.

1 М.Болфын дуурийн дууль. Килларни- олон алдарт нуур бүхий Баруун урд зүгт орших үзэсгэлэнт байгаль бүхий газар Ноён О’Мэддэн Бэрк ийм эгдүү хүрэм зан байдлыг урьд өмнө өр хараагүй гэж хэлэв. Үүний дараа тэр Кэтлин Карни бүсгүйн хөгжмийн ирээдүй Дүбл инд лав дууссан тухай айлдав. Хатагтай Карнийн зан байдлын тухай юу гэж бодож буй талаар баргил хоолойтоос асуув. Тэрбээр хариулахаас татгалзав.

Түүний хувьд авах юмаа авчихсан тул хэнтэй ч муудалцахыг хүссэнгүй. Үүнээс гадна тэр хатагтай Карни болон тоглолтод оролцож буй хүмүүст арай илүү шан харамж өгч болох юм гэж хэлэв. Завсарлага эхэлмэгц, одоо яах ёстой талаар зохион байгуулагчид халуухан маргаан өрнүүлэв. Би Бэйрн бүсгүйтэй санал нэг байна гэж ноён О’Мэддэн Бэрк хэлэв.

- Түүнд юу ч төлөх хэрэггүй. Өрөөний нөгөө буланд хатагтай Карни нөхрийн хамт, ноён Бэлл, Хилли бүсгүй, эх оронч шүлэг уран уншигч залуу авхай нар зогсоно. Хорооны зүгээс түүнтэй эвгүй хандсан талаар хатагтай Карни гомдоллож байлаа.

Тэрээр ямар их зардал, нөр их хөдөлмөр гаргасан ч энэ бүхний хариуд багашаархан хөлс төлсөнд гомдолтой байлаа. Тэд толгойг нь эргүүлчихэж болох туршлагагүй хүүхэнтэй тулна гэж бодсон бололтой. Яадгийг нь үзүүлээд өгөх болно. Түүнийг эр хүн байсан бол, ингэж харьцахгүй байсан гэнэ. Гэсэн хэдий ч охин эрхийнхээ дагуу авах ёстой хөлсөө заавал ч үгүй авахын төлөө уйгагүй хөөцөлдөнө гэж тэр хэлэв. Сүүлчийн хүрэл зоосыг хүртэл үлдсэн хөлсийг нь төлөхгүй бол, тэр бүхий л Дүблин даяар шуугиан дэгдээх болно гэдгээ мэдэгдэв. Мэдээж хэрэг жүжигчдийн өмнө түүнд эвгүй л байж таарна. Гэлээ гээд яах билээ. Түүнд шударга бус хандсан гэж хэлсэн хоёр дахь цээл хоолойт дуучинд, дараа нь Хилли бүсгүйд хандав.

Нөгөөх нь өөр хэсэг рүү нэгдэхийг хүсэвч Кэтлины дотны найз байсан тул яаж ч чадсангүй. Тоглолтын нэгдүгээр хэсэг дуусах үед ноён Фицпатрик, ноён Хүлоэн нар хатагтай Карни дээр очиж ирэх мягмар гарагт хорооны хурал болсны дараа үлдсэн дөрвөн гинейг өгөх болно гэжээ. Хэрэв охин нь хоёр дахь хэсэг дээр тоглохгүй бол, хорооны зүгээс гэрээг цуцалсанд тооцож юу ч нэмж төлөхгүй гэж мэдэгдэв.

- Би ямар ч хороо гэдгийг чинь мэдэхгүй! Миний охинд гэрээ байгаа! гэж хатагтай Карни ууртайхан өчив. Гар дээрээ тэр дөрвөн фунт найман шиллинг авах учиртай. Эс бөгөөс энэ тайзан дээр тэр хөл тавих учиргүй.

- Хатагтай Карни, таныг хараад тун их гайхаж байна. Таныг ийм зан гаргана гэж хэзээ ч бодож байсангүй хэмээн ноён Хүлоэн хэлэв.

- Харин та надад яаж хандаж байгаа юм бэ? гэж хатагтай Карни асуув. Түүний царай уур хилэнд авгаж, одоохон тэр хэн нэгэн рүү гар зангидан дайрах гэж буй мэт дүр эсгэв.

- Би авах ёстой зүйлээ л шаардаж байна гэж тэр хэлэв.

- Ёс зүйн тухай та бодож болоогүй юу? гэж ноён Хүлоэн өгүүлэв.

- Юу гэнэ ээ? Миний охинд төлбөр төлөх үү? гэж би асуухад ямар ч эелдэг хариу олж сонсоогүй шүү дээ! гэв.

Тэрээр толгойгоо дээш өргөн тун ихэмсэг дуугаар:

- Та нарийн бичгийн даргатай ярих хэрэгтэй. Энэ миний хэрэг биш. Би бол чухал асуудал шийддэг хүн гэх зэргээр баахан юм хэлсэн биз дээ гэв.

- Таныг би боловсролтой эмэгтэй гэж бодож байсан хэмээн хэлээд ноён Хүлоэн тэндээс явж одов. Үүний дараа хатагтай Карнийн зан байдлыг эргэж буцалтгүйгээр ойлгосон тул хорооны шийдвэрийг бүгд л дэмжих болов.

Тэрээр уур хилэндээ багтаж ядан хаалган дээр зогсч, нөхөр, охин хоёртойгоо хэрүүл хийж, яах учраа олж ядна. Зохион байгуулагчийг түүн дээр хүрч ирнэ хэмээн найдаж, тоглолтын хоёр дахь хэсгийг хүлээв. Гэвч Хилли бүсгүй ганц нэг тоглолт дээр хөгжимдөж өгөхийг сайн дураараа зөвшөөрөв. Хатагтай Карни баргил хоолойт болон хөгжимчнийг тайзан дээр гарах үед зай тавьж өгөхөөс өөр яаж ч чадсангүй. Тэр хэсэг зуур бухимдалд автсан чулуун хүн шиг хөдөлгөөнгүй зогсч байснаа, хайрын дууны эхний аялгуу чихэнд нь сонсдог охиныхоо нөмрөгийг булаан авснаа:

- Сүйх тэрэг олоод ир! гэж нөхөртөө лүндэн буул гав. Нөгөөх нь ч тэр даруй явж одов.

Хатагтай Карни охиндоо нөмрөг өмсгөөд араас нь гарав. Хаалган дээр түр саатаж, ноён Хүлоэн рүү ууртайхан харц чулуудав.

- Та нартай би тооцоо дуусаагүй шүү! гэж тэр эрсхэн хэлэв.

- Харин миний хувьд тантай ярих юм ер байхгүй! гэж ноён Хүлөөн хэдэрлэв. Кэтлин эхийнхээ араас дуулгавартайхан дагалдав.

Ноён Хүлөөн уурандаа багтаж ядан өрөөн дотуур нааш цааш холхино.

- Ёстой л нэг хүмүүжилтэй авгай юм даа, хэлэх ч үг алга! гэв.

- Хүлөөн, та шаардлагатай бүхнийг хийсэн шүү! гэж ноён О'Мэддэн Бэркхэлээд, түүнийг дэмжиж буйгаа илэрхийлэх мэт бүхий л биеэрээ шүхрээ тулан зогсов.

## Бурханы хишиг

Ариун цэврийн өрөөнд байсан хоёр эр ямар ч чадваргүй болсон нэгэн нөхөрт туслахыг оролдоно. Тэрбээр шатны дор түрүүлгээ харан хэвтэж байлаа. Түүний нүүрийг тэд дээш нь харуулав. Бүрх малгай нь хэдэн алхмын цаана өнхрөөд уначихсан харин тэр нойтон бохир шалан дээр хэвтэж байсан тул өмссөн хослол нь байдгаараа норчээ. Түүний нүд аниастай ч тэрбээр тун чанга хийгээд сөөнгөдүүхэн амьсгална. Амнаас нь цус гарч байв. Хоёр эр, зөөгчийн хамт түүнийг шатаар дээш өргөн гарч уушийн газрын шалан дээр хэвтүүлэв.

Хэсэг хугацааны дараа хэрэгт дуртай хүмүүс шавсан байлаа. Түүнийг хэн болох, дэргэд нь хэн байсан талаар уушийн газрын зөөгч хүмүүсээс асууж шалгаана. Хэн болохыг нь мэдэх хүн тэнд лав байсангүй. Харин зөөгч нарын нэг тэр эрд жүнзтэй шарз өгч байснаа өгүүлэв.

- Тэр ганцаараа байсан уу? гэж уушийн газрын зөөгч асуув.

- Үгүй ээ, эрхэм ээ хамт хоёр хүн байсан.

- Тэд нар тэгээд хаана байна?

Мэдэх хүн байсангүй.

- Алив, холдоцгоо! Наад хүнд чинь амьсгалах агаар алга. Тэр ухаан алдсан байна гэж хэн нэгэн хэлэв.

Хэрэгт дурлагсад зай тавьж өгсөн авч төдөлгүй түүнийг эргээд л хүрээлцгээв. Үл таних хүний толгойн орчимд цусны толбо харлан үзэгдэнэ. Түүний ухаангүй царайг харуут уушийн газрын зөөгч балмагдсандаа ч тэр үү цагдаа дуудав. Үл таних эрийн цамцны захыг суллаж, зангиаг нь тайлав. Тэрбээр

хэсэгхэн зуур нүдээ нээж санаа алдсанаа эргээд анив.

Түүнийг өргөж авчирсан хоёр эрийн нэг үрчийсэн цомбон малгай гартаа барьжээ. Түүнийг хэн болох, найз нөхөд нь хаашаа явсныг мэдэх хүн байгаа эсэх талаар зөөгч уйгагүй лавлаж байлаа. Хаалга нээгдмэгц үлэмж биетэй цагдаа орж ирэв. Гудамжаар түүний араас дагаж байсан хэсэг хүмүүс хаалганы дэргэд бөөгнөрцгөөв; бүгд л урагш тэмүүлж тэр дотор юу болсныг харахыг санаархана.

Уушийн газрын зөөгч мэдэж байгаа бүхнээ ярьж гарав. Ямар ч нүүрний хувиралгүй залуухан цагдаа яриаг нэгд нэгэнгүй сонсов. Тэр толгойгоо хоёр тийш алгуурхан эргүүлж зөөгчийн харцнаас шалан дээр хэвтэж буй хүн рүү харах нь ямар нэгэн худал хуурмагийн золиос болохоос эмээсэн мэт санагдана. Дараа нь тэр бээлийгээ тайлж, халааснаасаа тэмдэглэлийн дэвтэр гаргаж ирэв. Харандааны үзүүрийг шүлсдэж протокол бичихээр зэхэв.

- Энэ юун хүн бэ? Түүний нэр, гэрийн хаяг? гэж тун сэжиглэнгүй хөдөөний хүн шиг асуув. Спорт хослолтой нэгэн залуу хэрэгт дурлагсдын дундуур зүсэн орж ирэв. Тэрбээр хохирогчийн дэргэд яаравчлан өвдөглөн суугаад ус авчрахыг шаардав. Цагдаа ч гэсэн түүнд

туслахаар өвдөглөн суулаа. Залуу эр хохирогчийн уруул дээрх цусыг арилгаад бага зэрэг шарз авчрахыг хүсэв. Зөөгчийг шилэн аягатай шарз авчиртал түүний тавьсан шаардлагыг цагдаагийн ажилтан ч бас захирангуй өнгөөр давтан өгүүлж байлаа. Хохирогчийн ам руу бага зэрэг шарз дусаав.

Хэсэг хугацааны дараа тэр нүдээ нээж, эргэн тойрноо ажиглав. Хүрээлэн зогсох хэрэгт дурлагсад руу тэр харснаа, хаана байгаагаа ухаарсан уу, яасан босох гэж оролдов.

- За яав? Одоо арай дээрдэв үү? гэж спорт хослолтой залуу асуув.

- Зүгээр ээ гэж босохыг оролдох зуур хохирогч өгүүлнэ. Түүнд туслав. Уушийн газрын зөөгч эмнэлгийн тухай ямар нэгэн юм хэлсэн даруйд тэнд байсан хүмүүс янз бүрийн зөвлөгөө өгч гарлаа.

Хохирогчийн толгой дээр үрчийсэн цомбон малгайг нь тавив.

- Та хаана амьдардаг вэ? гэж цагдаа асуув. Харин өнөөх эр юу ч хариулсангүй, гагцхүү сахлынхаа үзүүрийг имрэв. Энэхүү болсон явдалд тэр огтхон ч ач холбогдол өгсөнгүй.

- Зүгээр ээ, энэ бол өчүүхэн төдий таагүй явдал гэж тэр хэлэв. Тэрбээр тун ойлгомжгүй ярих аж.

- Та хаана амьдардаг вэ? гэж цагдаа дахин асуув.

Гэтэл өнөөх эр түүнээс сүйх тэрэг дуудаж өгөхийг хүсэв. Сүйх тэрэг дуудахаар хэн явахыг шийдэж ядан байтал уушийн газрын тэртээх булангаас өндөр нуруутай, эрсхэн хөдөлгөөнтэй, цайвар үстэй, урт шаргал өнгийн хүрэм өмссөн хүн дөхөж ирэв. Юу болсныг хараад тэр:

- Том, чи гайгүй юу? Чи чинь яагаа вэ? гэж дуу алдан өгүүлэв.

- Зүгээр ээ, гэж хохирогч хэлэв.

Дөнгөж сая ирсэн хүн өрөвдмөөр царайлан өмнө нь зогсох эрийг харснаа,

- Цагдаа гуай, та санаа зовох хэрэггүй, түүнийг би гэрт нь хүргээд өгчихье гэв.

Цагдаагийн ажилтан малгайдаа гар хүрснээ,

- Ноён Пауэр! Таны хэлснийг ойлголоо гэж хариулав.

- За Том минь, яс чинь бүтэн биз дээ? Өөрөө явж чадах нь уу? гэж нөхрийнхөө гараас барих зуур ноён Пауэр өгүүлэв.

Спорт хослолтой залуу нөгөө гараас нь барих үед тэнд шавсан хүмүүс зай тавьж өгөв.

- Чи чинь юу болох нь энэ вэ? гэж ноён Пауэр асуув.

- Энэ эрхэм шатнаас уначихсан юм гэж залуу өмнөөс нь өчив.

- Эрхэм ээ, би тун их талархаж байна гэж хохирогч өгүүлэв.

- Зүгээр ээ, зүгээр.

- Тэгвэл ганц нэг зуу татахгүй юм уу?

- Дараа больё.

Тэр гурвыг уушийн газраас гарах үед тэнд шавсан хүмүүс аажимдаа тарцгаав. Уушийн газрын зөөгч хэргийн газарт үзлэг хийлгэхээр цагдаагийн ажилтныг дагуулж одов. Түүнийг хий гишгэсэн байх гэдэг дээрхоёул тэд санал нэгдэв. Үйлчл үүлэгчид босоо лангуу руу эргэн ирцгээж, зөөгч нарын нэг шалан дээрх цусны толбыг угааж эхлэв. Грэфтоны гудамж руу гаруут ноён Пауэр сүйх тэрэг дуудав.

- Эрхэм ээ, би танд тун их талархаж байна. Дараа нь эргэн уулзана гэж найдаж байна. Миний нэр Кернан гэж хэлж буй үгсээ аль болох цэвэр хэлэхийг оролдон хохирогч өгүүлэв. Шатнаас унасан таагүй явдал, улам бүр нэмэгдэж буй өвдөлт нь түүнийг бага боловч эрүүл болгожээ.

- Бүх юм хэвийн гэж залуу хэлэв.

Тэд гар барьцгаав. Ноён Кернаныг сүйх тэргэнд суухад нь тусалж байхад ноён Пауэр улаачид хандан очих газраа хэлж, залууд ч бас талархсанаа илэрхийлээд хамтдаа ганц нэг хундага тогтоож чадаагүйдээ харамсч буйгаа илэрхийлэв.

- Дараа болно биз дээ гэж залуу эр хэлэв.

Сүйх тэр Уэстморлендын гудамжийг чиглэн одов. Түүнийг Балласт-офисын дэргэдүүр өнгөрөх үед цагийн зүү оройн ес хагасыг заана. Голын хөндийгөөс үлээх Дорнын сэвэлзүүр салхи нүүр нүдгүй ороолгоно. Ноён Кернан даарснаасаа болж байдгаараа атирч сууна. Энэ бүхэн чухам юунаас болсныг ярьж өгөхийг өөрийн нөхрөөс ноён Пауэр хүсэв.

- Чадахгүй нь ээ, би хэлээ хазчихаж гэж нөгөөх нь хариулав.

- Алив үзүүл дээ. Ноён Пауэр доош тонгойж, Кернаны ам руу өнгийсөн ч юу ч харж чадсангүй.

Тэрбээр шүдэнз асааж, алгаараа салхийг нь хааж ноён Кернаны ангайсан ам руу дахин харах гэж оролдов. Сүйх тэрэгний савлах хөдөлгөөнөөс болж шүдэнзийг нэг бол ойртуулж, нэг бол холдуулж байлаа. Доод талын шүднийх нь буйланд нөжирсөн цус тогтсон байв; харваас хэлнийхээ үзүүрийг тас хазсан бололтой. Шүдэнз унтрав.

- Аймаар юм гэж ноён Пауэр хэлэв.

- Зүгээр ээ, гэж ноён Кернан амаа хамхих зуур хэлээд, бохирдсон хүрэмнийхээ захыг босгов.



Ноён Кернан өмнө нь сургуулийн худалдаа эрхэлсэн ажилтан байсан агаад өөрийнхөө мэргэжлийг бүхий л төрлийн хүндлэл хүлээх учиртай хэмээн тооцдог байжээ. Хотод түүнийг аятайхан цомбон малгай болон шаахайвчгүйгээр хэзээ ч харж байсангүй. Энэ хоёр зүйл хүмүүний өмнө бүхий л хаалгыг нээж байдаг юм гэж тэр ярих дуртай.

Түүнд өөрийн гэсэн Наполеон, аугаа Бэлчерн гээд шүтэн бишрэхүйн үлгэр дууриал болсон хүмүүс байдаг тухай тэр цөөнгүй удаа эргэн дурсч байв. Орчин үеийн ажил хэргээ явуулахад хөшгөн дээрээ өөрийн пүүс болон Лондон, Ист-Энд гэх нэр нь бичээстэй багшаархан албан тасалгаа Краугийн гудамжинд байхад л хангалттай байв. Тэрхүү авсаархан албан тасалгааны задгай зуухан дээр баахан тугалган цэргүүд өрөөстэй байх агаад харин цонхны өмнөх ширээн дээр гол төлөв дундаа хүртэл хар шингэнтэй тав, зургаан аяга байна. Тэрхүү аяганаас ноён Кернан цай амталдаг юмсанж.

Тэрбээр нэг балгаж, цайг амсч мэдрүүтээ задгай зуух руу нулимна. Дараа нь хэсэг бодолхийлж байснаа өөрийн бодол санааг айлтгадаг байв. Харин ноён Пауэрийн хувьд түүнээс нэлээд залуу бөгөөд Дүблины цагдаагийн газар алба хашдаг байжээ. Нийгмийн шатаар дээш гарсан тахир замнал нь нөхрийнх нь тахир уналттай огтлолцож байсан авч ноён Кернаны уналт түүний амжилтын оргилд байсныг мэдэх олон нөхдийнх нь нүдэн дээр урьдын адил аугаа хэвээрээ байсны хүчинд нэг их анзаарагдахгүй байлаа. Тиймэрхүү хүмүүсийн тоонд ноён Пауэр орно. Өөрийн тавьсан өр зээлээ тэр чандлан нууцалдаг тул, танилууд нь түүний данс тооцооны талаар хов жив ярих дуртай ч ерөнхийдөө тун дажгүй залуу байлаа.

Гласневины зам дээрх жижигхэн байшингийн өмнө сүйх тэрэг зогсуут, ноён Кернаныг гэрт нь оруулав. Эхнэр нь түүнийг унтуулахаар зэхэж, харин ноён Пауэр гал зуухны өрөөнд, түүний хүүхдүүдийг ямар сургуульд сурч байгаа тухай, мөн ямар хичээл үзэж байгаа талаар асууж шалгааж гарав. Кернаны хүүхдүүд болох хоёр охин, нэг хүү ямар ч загнах хүнгүй боломжийг ашиглан хэнд ч хэрэггүй шуугиан дэгдээж гарав. Тэдний үйлдэл, ярианых нь дуудлага түүнийг ихэд гайхшруулжээ. Тиймээс тэр нэлээдгүй бодолд автав. Төдөлгүй гал зуухны өрөөнд хатагтай Кернан орж ирснээ,

- Сайн байна, хэлэх ч үг алга. Хэзээ нэгэн цагт тэр балрах хүн дээ. Хэрхэхийг Бурхан мэднэ. Аль өнгөрсөн баасан гарагаас л ууж байна гэв.

Энэ асуудалд тэр ямар ч хамаагүй гэдгээ тайлбарлах ёстой гэж ноён Пауэр бодов. Тэр зүгээр л хэргийн газар санамсаргүй очсон гэдгээ хэлэх учиртай байв. Гэр бүлийн таагүй байдлын үед ноён Пауэрыг хэдэнтээ тусламж үзүүлж байсныг хатагтай Кернан санах учиртай ч, тэрээр байж суух газраа олж ядсандаа:

- Ноён Пауэр, та чинь юу ярина вэ? Энэ талаар надад хэлэхгүй байж болно шүү дээ. Хэрэгтэй хэрэггүй амьтдыг бодвол, та түүний жинхэнэ нөхөр гэдгийг би мэднэ. Түүнийг мөнгөтэй үед нь тэд эхнэр хүүхэд, гэр орон руу нь явуулахыг огт хүсэхгүй. Ёстой л нэг найзууд юм даа. Өнөө орой тэр хэнтэй байсныг би мэдэж болохсон болов уу? гэж тэр асуув.

Ноён Пауэр толгой сэгсэрснээ юу ч хэлсэнгүй.

- Надад тун их харамсалтай байна. Таныг дайлах юм алга даа гэж тэрээр хэлэв. Гэхдээ түр хүлээзнэвэл, энэ булангийн Фогартийн дэлгүүр рүү ямар нэгэн юманд хүн явуулж болох юм гэв. Ноён Пауэр явахаар босов.

- Түүнийг бид мөнгөтэй ирэхийг нь хүлээж байсан. Гэр бүлтэй гэдгээ тэр мартсан бололтой.

- Хатагтай Кернан, зүгээр дээ. Одоо тэр амьдралаа шинээр эхлэх болно гэж ноён Пауэр хэлэв.  
-Мартинтай би ярина аа.

Тэр бол яг тохирох хүн. Ойрын үед бид хоёр ирж энэ бүхний талаар ярилцах болно.

Түүнийг хаалган дээр гаргаж өгөв. Улаач эр дулаацахын тулд гараа савчин, хөлөө дэвслэх зуур нааш цааш алхана.

- Хүргэж өгсөнд их баярлалаа гэж гэрийн эзэгтэй хэлэв.

- Зүгээр ээ, зүгээр гэж ноён Пауэр өчив. Тэрбээр сүйх тэргэнд суулаа. Тэрэг хөдөлсний дараа тэр малгайгаа авч тун хөгжилтэйхэн даллав.

- Түүнийг бид хүн болгох болно. Хатагтай Кернан сайхан амраарай! гэж тэр хэлэв.

Хатагтай Кернан барааг нь тасартал сүйх тэрэгний араас гайхширсан харцаар харж зогсов. Чингээд тэр гэртээ орж эр нөхрийнхөө халааснуудыг эргүүлж, тойруулж гарав. Хатагтай Кернан тун хөдөлгөөнтэй, дунд орчим насны байдаг л нэг эмэгтэй ажээ.

Саяхантэрээр мөнгөн хуримаа хийж, ноён Пауэрын тоглосон хөгжмийн аялгуун дор эр нөхөртэйгөө хэдэнтээ вальс эргээд, түүнд туйлаас их дотно болсон тухайгаа ярьж байж билээ.

Ноён Кернан араас нь гүйжбайхад, түүнд нэлээд боловсон, соёлтой залуу мэт санагдаж байв; өдгөө хүртэл ямар нэгэн хуримын тухай сонсмогц тэрээр сүмийн хаалга руу яаран очиж, шинэхэн гэрлэсэн хосуудыг харах бүрийд Сэндимаунтад байхдаа, “Далайн од” хэмээх сүмээс тэр аз жаргал дүүрэн залуугийн хамт хэрхэн гарч ирж байснаа эргэн дурсдаг байлаа. Гэр бүлийн хамтын амьдрал эхэлснээс хойш гурван долоо хоногийн дараа энэ бүхэн түүнд ядаргаатай мэт санагдаж, хожим нь тэрхүү амьдрал тэсэхийн аргагүй мэт болох үед тэр нэгэнт эх хүн болсон байлаа.

Эхийн үүрэг түүний хувьд давшгүй хүнд зүйл байгаагүй ч хорин таван жилийн турш эр нөхрийнхөө арын албыг тун чадварлаг хашсан нь энэ бүхнийг илтгэнэ. Хоёр том хүү нь хөл дээрээ зогсч, нэг нь Глазго дахь гар үйлдвэрлэлийн дэлгүүрт нөгөө нь Белфастын цайны пүүст алба хашиж байлаа. Тэд сайн хөвгүүд агаад байнга захидал зангаа бичиж, заримдаа ар гэртээ мөнгө хүртэл илгээнэ.

Бусад хүүхдүүд нь сургуульд сурч байв. Маргааш өдөр нь ноён Кернан албан газар руугаа захидал илгээж, орондоо хэвтсээр өнжив. Эхнэр нь түүнд шөл хийж өгөөд, тун чиг сайн эрүүний шөл уулгажээ. Нөхрийнхөө байнгын тэвчээргүй занг яалтай ч билээ дээ хэмээн

уучилж, өвчтэй үед нь түүнийг халамжлан эмчилж, ажил албандаа явахаас нь өмнө өглөөний цай ч болов уулгахыг мэрийдэг байлаа.

Үүнээс дор эр нөхөр ч бас бий. Хөвгүүдээ томорсноос хойш түүнд тэр хэзээ ч дахин гар хүрсэнгүй. Нөгөөтэйгүүр тэр хэрэгтэй, хэрэггүй ямар ч даалгавар өгсөн гүйцэлдүүлэхийн тулд Томасын гудамжныг эцэс ороод эргэж ирэх шаардлагатай байсан ч биелүүлэхэд бэлэн байх болно гэдгээ тэр сайтар мэднэ.

Үүнээс нэг өдрийн дараа найзууд нь түүнийг эргэж ирэв. Тэднийг унтлагын өрөө рүү оруулж, задгай зуухны өмнө сандал тавьж өгөхөд, тэндхийн агаар гэж авах юмгүй ажээ. Ноён Кернаны хэл өвдсөн хэвээр үүнээсээ болж нэлээдгүй бачимдаж тун багахан ярьж байв.

1 Кернаны амьдарч байсан гудамжнаас Томасын гудамж хүртэл нэг бээрийн зайтай ажээ. Тэнд Ирландын алдарт Гиннес шар айрагны үйлдвэр байсан юм. Энд Жойсийн хошигнол явж байна. Тэнд зочилсон хүмүүст нэг аяга шар айраг үнэгүй өгдөг байжээ

Бөөн сөдөн дэр бүхий оронд ноён Кернан хагас суух бөгөөд түүний булцгар хацарт ялимгүй улаа бутарна. Тэрбээр өрөөгөө эмх замбараагүй байгаад уучлал хүсээд, эрэлхэг ахмад зүтгэлтний байдлаар зочид руугаа харав. Тэрбээр өөрийн найз болох ноён Каннингем, Маккой, Пауэр нарын хатагтай Кернанд хэдийнээ мэдээлсэн хуйвалдааны золиос болсон гэдгээ огтхон ч сэжиглэсэнгүй. Тэрхүү санааг ноён Пауэр сэдэж хэрэгжүүлэх үүргийг Каннингемд өгсөн байв. Ноён Кернан протестант гэр бүлээс гаралтай бөгөөд хэдийгээр гэрлэхээсээ өмнөхөн католик шашинтан болсон ч сүүлийн хорин жил лав сүмийн босгоор нэг ч алхаагүй юмдаг.

Үүнээс гадна ойр дотны найз нөхдийнхөө хүрээнд тэр католик шашныг доог тохуу хийж, шүүмжлэх нь энүүхэнд байв. Ноён Каннингемийн хувьд иймэрхүү төрлийн ажилд бусдаас илүү тохирох хүн. Тэрбээр ноён Пауэрын эртний хамтран зүтгэгч байсан юм. Гэр бүлийн амьдралдаа тэр нэг их ад шоо болоогүй биз. Бүгд л түүнийг маш их өрөвдөж байсан агаад архичин хүүхэнтэй гэр бүл болсныг нь мэдэхгүй амьтан үгүй байлаа. Түүний төлөө тэр зургаан ч удаа гэр орныхоо тавилгыг шинээр өөрчилсөн авч тухай бүрт нь түүний нэрийг барьдаг байв. Хөөрхий муу Мартин Каннингемийг бүгд л хүндэтгэнэ.

Тэрбээр тун тохитой, томоотой, нөлөө бүхий ухаалаг нэгэн байв. Сахлын хутга лугаа адил байгалиас төрсөн торгон мэдрэмж нь хүмүүсийг ойлгох шүүхийн хэрэгтэй байнга холбогдог нь оюун санаагаа хордуулах гашуун ус руу үе үе орж гарах байдлаар хязгаарлагдана. Тэр тун чиг боловсролтой хүн. Анд нөхөд нь хэлж ярьсан зүйлийг нь хүндлэн биширч, түүнийг Шекспиртэй адилтгаж үзнэ.

Тэрхүү хуйвалдааны тухай түүнд мэдэгдэх үед,

- Ноён Каннингем танд энэ бүхнийг санал болгож байна гэж хатагтай Кернан хэлэв. Хорин таван жил болсон гэр бүлийн амьдралын дараа түүний хувьд тун бага хуурмаг үзэгдэл үлдсэн гэдэг хэнд ч ойлгомжтой. Шашин гэдэг жирийн нэг зуршил болж, түүний насан дээр хүн огцом өөрчлөгдөж, үхэн үхтлээ тийм байх боломжгүй гэдэгт тэр гүнээ итгэдэг.

Мэдээж хэрэг түүнд тохиолдсон золгүй явдлыг Бурхны заасан зураг төөрөг хэмээн үзэж хэдийгээр тэр цус сорогч мэт санагдаж болох авч, ноён Кернаны хэл бага зэрэг богиносно л биз. Үүнээс болжтүүнд муу юм болохгүй тухай ч тэр найз нөхдөд нь хэлэхээс зовохгүй байлаа. Гэвч ноён Каннингем бол ажил хэрэгч хүн. Харин шашин бол шашин. Хэрэв энэ төлөвлөгөө ач тусаа өгөхгүй юм гэхэд ямар ч байсан хор хохирол үл авчирна. Тэрээр нэг их сүсэг бишрэлгүй хүн. Тэр католик шашны бүхий л гэгээнтнээс хамгийн найдвартай нь хэмээн Христийн зүрхэнд хатуухан итгэж, аливаа нууцлаг зүйлд тун хүндэтгэлтэйгээр хандана.

Түүний ертөнц гал зуухны өрөөхнөөр хязгаарлагдаж байсан ч ямар нэгэн зүйл тохиолдвол, чөтгөр ч байсан ч тэр гэгээн сүнс мэт итгэх нэгэн байлаа. Болсон явдлын талаар зочид ярьж эхлэв. Үүнтэй төстэй явдлыг санаж байна гэж ноён Каннингем өгүүлэв. Далан настай нэгэн өвгөн ухаан алдаж унахдаа хэлнийхээ үзүүрийг тас хазсан ч, санасныг бодоход хамаагүй хурдан эдгэсэн байна лээ.

- Би ямар далан настай юм уу? гэж өвчтөн бувтнав.

- Бурхан өршөөг! гэж ноён Каннингем залбирав.

- Одоо таны хэл өвдөхгүй байна уу? гэж ноён Маккой асуув.

Цагтаа ноён Маккой нэлээд алдартай цээл хоолойт дуучин байсан юм. Түүний эхнэр тун нарийн хоолойт дуучин байсан агаад өдгөө тэр айлын хүүхдүүдэд дуу хөгжмийн хичээл заах болжээ. Түүний амьдралын шугам хоёр цэгийн хоорондох богинохон зайд байсангүй.

Тэр ч бүү хэл, аливаа зүйлийг шийдэхийн тулд янз бүрийн арга саам хэрэглэх үе ч зөндөө тохиож байв. Тэрбээр Мидлэндийн төмөр замын удирдах газар алба хашиж байгаад фарааНб“Irish Times” сонин, “Freeman”1 сэтгүүлд зар цуглуулагч, хувийн мөрдөгч, нүүрсний нэгэн компанийн зуучлагч, дүүргийн цагдаагийн албаны даргын туслах зэрэг ажил эрхэлж байсан бөгөөд саяхан Дүблин хотын Шүүх эмнэлгийн даргын туслахын ажилд оржээ.

Шинэ албанд очсондоо ч тэр үү, ноён Кернанд тохиолдсон явдалд тэр мэргэжлийн үүднээс сониучирхан хандаж байв.

- Өвдөж байна гэв үү?

- Нэг их өвдсөн юм алга. Гэвч тун эвгүй мэдрэмж төрж байна. Яг л бөөлжих гэж байгаа мэт болох юм гэж ноён Кернан хариулав.

- Тэр чинь архи их ууснаас л болж байгаа хэрэг гэж ноён Каннингем хатуухан хэлэв.

- Үгүй ээ. Сүйх тэргэнд явж байхдаа л даарчих шиг боллоо. Хоолой дээр үргэлж л нэг юм тээглээд байна гэж ноён Кернан бувтнав.

1 “Айриш Таймс бол консерватив үзлийг номлогч сонин юм. Харин “Фримэн” сэтгүүл бол үүний эсрэг гомрулийг дэмжигч аядуу либерал бодлого баримтлагч юм. Жойсийн зохиолын

дүр нэгэн зэрэг тэс өөр хоёр хэвлэлд ажиллаж байгаа явдал нь түүнд тодорхой улс төрийн байр суурь байхгүй гэдгийг харуулж байна

- Гялтан хальс л биз гэж ноён Маккой даажигнав.

- Хоолойн дороос ямар нэгэн юм дээш болоод л дотор муухайрч байна.

- Тийм ээ, тийм. Наадах чинь мөгөөрсөн хоолой гэж ноён Маккой цаашлуулав.

Ноён Каннингем, Пауэр нар руутэр нэгэн зэрэгтун гайхсан байдалтай харав. Ноён Каннингем яаравчлан толгой дохимогц, ноён Пауэр түүнд хандаж,

- Бүх юм сайнаар дуусдаг нь л сайхан юм даа! гэв.

- Хөгшөөн, чамд би өртэй үлдлээ шүү! гэж өвчтөн бувгнав. Ноён Пауэр гараараа зангав.

- Надтай хамт байсан тэр хоёр...

- Таны хамт хэн байсан юм бэ? гэж ноён Каннингем асуув.

- Нэг этгээд. Хэн гэдэг билээ дээ мартчихаж. Чөтгөр аваг! гэж хэн билээ дээ? Тийм намхан нуруутай, шаргал үстэй...

- Өөр хэн байсан юм бэ?

- Харфорд.

- За тийм байж! гэж ноён Каннингем өгүүлэв.

Бүгд дуугаа хураав. Тэрбээр нууц эх сурвалжаас мэдээлэл авч байгаа нь тодорхой байв. Тухайн тохиолдолд аялга үг нь сурган хүмүүжүүлэх ач холбогдолтой юм. Ноён Харфордын хувьд ням гарагийн сүмийн цуглааны дараа хотоос зайдуухан орших ямар нэгэн уушийн газар очиж архидалт зохион байгуулдаг хэсэг бүлэг нөхдийг толгойлогч нэгэн байв. Чингээд болоогүй өөрсдийгөө тэд аялагчид<sup>1</sup> хэмээн худал залдаг байжээ.

<sup>1</sup> Ирландад согтууруулах ундааг тодорхой цагт худалдаалдаг байжээ. Харин аялагчдын хувьд энэ хууль огт хамаардаггүй байж

Гэвч ноён Харфордын аян замын нөхөд түүний гарал үүслийг хэзээ ч хүлээн зөвшөөрч чаддаггүй байв. Угтаа тэр хар ажлаас ажлын гараагаа эхэлсэн гэнэ. Бага зэргийн мөнгө ажилчдад хүүтэй зээлдэг байснаа ч бас ярьжээ.

Дараа нь тэр Лиффи дэх банкны ажилтан ноён Голдберг хэмээх намхан нуруутай, тарган эртэй хамтран зүтгэх болжээ. Жүүд эртэй түүнийг хуучны мэргэжил нь холбож байсан ч хүндхэн байдалд орсон католик шашинт нөхөд нь түүний төрсөн хүү төрөлхийн гажигтай талаар нууцхан шивнэлдэж, энэ бүхэн нь новшийн мөнгө хүүлэгчид Бурхнаас оноосон шударга шийтгэл хэмээн үздэг байлаа. Мэдээж хэрэгтэй үед нь тэд түүний сайн чанарыг

эргэн дурсах авай.

- Ингэхэд тэр хаачсан бэ? гэж ноён Кернан асуув. Тэрхүү явдлын нарийн ширийн зүйл хэнд ч мэдэгдэхгүй үлдээсэй гэж тэр хүсчээ. Үүний оронд найз нөхөд нь ямар нэгэн эндүүрэл болж, ноён Харфорд тэр хоёр санамсаргүй гар зөрүүлсэн биз гэж бодсон нь дээр байлаа.

Уусан үедээ ноён Харфордыг хэрхэн тавьтиргүй зан гаргадгийг мэддэг тул нөхөд нь дуугүйхэн сууцгаана.

- Бүх юм сайнаар дуусдаг нь л сайхан юм даа! гэж ноён Пауэр дахин өгүүлэв.

Ноён Кернан ярианыхаа сэдвийг өөрчлөв.

- Тэр анагаахын оюутан тун дажгүй залуу шүү! гэж тэр хэлэв.

- Түүнийг байгаагүйсэн бол...

- Тийм ээ, түүнийг байгаагүй бол долоо хоног торны цаана сууж, шийтгэлийг торгуулиар төлөхийн аргагүй болох байсан гэж ноён Пауэр өчив.

- Тийм ээ, тийм гэж өнгөрснөө эргэн санахыг оролдох зуур

ноён Кернан өгүүлэв.

- Одоо санаж байна. Тэнд нэг цагдаа байсан. Тун дажгүй залуу шиг санагдсан. Энэ бүхэн яаж болж өнгөрснийг ч нэг л сайн ойлгохгүй байна.

- Том, та дэндүү их хор долоосноос л хамаг юм болсон шүү дээ! гэж ноён Каннингем голд нь ортол хэлэв.

- Юу үнэн, тэр үнэн! гэж түүний хариуд ноён Кернан өчив.

- Жэк, ингэхэд та тэр цагдааг аргалсан юм биш үү? гэж ноён Маккой өгүүлэв.

Ноён Пауэр нэрээр нь дуудсанд нэг их дуртай биш байлаа. Албархуу байдлаар тэр бусдаас ялгарч байсангүй ч саяхан ноён Маккойн гаргасан муухай аашийг мартаж чадсангүй. Түүний эхнэр улс даяар аялан тоглолт хийх гэж байгаа гэж ноён Маккой мэдэгдэв.

Мөн чанартаа ямар ч аялан тоглолт болоогүй хэдий ч танил талаасаа тэр баахан цүнх сав сэгсэрчихсэн ажээ. Ноён Пауэрын хувьд ч бас энэхүү бага зэргийн залиланд өртөж золиос болсондоо багагүй ууртай байлаа. Тэрбээр асуултад хариулсан ч энэ бүхнийг ноён Кернан хэлсэн мэт дүр эсгэв. Энэ бүх яриа ноён Кернаныг эвгүй байдалд оруулав. Тэрбээр Дублины иргэн гэдгээ хэзээ ч мартаж байсангүй, хотод хандах түүний хандлага харилцан хүндлэл дээр бий болсон гэж үзэх агаад хөдөөний малчин гэгдэх тэр хүмүүс түүнийг ямар нэгэн байдлаар доромжлох аваас ихэд эгдүүцдэг байв.

- Үүний тулд бид татвар төлдөг юм гэж үү? хэмээн тэр асуув.

- Энэ тэнэг амьтдыг хооллож ундлахын төлөө юу... Гэтэл тэд бол зүгээр л тэнэг новшнууд, өөр юу ч биш.

Ноён Каннингем инээд алдав. Тэрбээр гагцхүү ажлын цагт л цагдаагийн байгууллагын ажилтан байдаг байв.

- Том, тэднээс өөр юу горьдох юм бэ? Гэж тэр хэлэв. Чингээд тэр хөдөө маягийн бүдүүлэг шийтгэлийг хөхүүлэн дэмжих мэт:

- Дөчин тав аа, наад байцаагаа бариад ав! гэж тушаал буулгав. Бүгд инээд алдав.

Тэрхүү ярианд ямар нэгэн байдлаар оролцохыг хүссэн ноён Маккой энэхүү түүхийг хэзээ ч сонсч байгаагүй мэт дүр эсгэнэ.

- Тосгоны бахим амьтдыг цэргийн хуаранд хэрхэн болгож тавьж байсныг та нар мэдэх үү? гэж ноён Каннингем хэлэв.

- Түрүүч бүгдэд нь таваг бариулж, хана дагуулан нэг эгнээ жагсаана. Өөрийн яриаг тэр хошин шогийн дохио зангаагаар тодорхой үзүүлнэ.

- Оройн хоол, мэдэж байна уу? гэтэл тэдний өмнөх ширээн дээр дүүрэн байцаатай хоолны сав байна. Харин түрүүчийн гарт хүрз шиг урт хоолны шанага бариастай байна. Тэгээд л тэр хоолны шанага дүүрэн байцааг өрөөн дотуур шидэлж гарна даа. Харин өнөөх өрөвдмөөр амыад нь наадах дөчин тавыгаа, байцаагаа бариад ав гэж хэлэх тоолонд тавгаараа түүнийгээ тосох учиртай аж.

Бүгд дахин инээд алдсан ч ноён Кернан эргэлзсэн хэвээр байв. Энэ тухай сонинд бичих ёстой юм байна гэж хэлэв.

- Тэр мөрдөстэй сармагчингууд чинь өөрсдийгөө бүхнийг захирах эрхтэй гэж бодсон бололтой гэж тэр хэлэв. Тэд чинь юун хүмүүс болохыг Мартин, та надад хэлэх ёсгүй биз дээ? Ноён Каннингем хүлээн зөвшөөрсөн ч сэтгэл дундуур байлаа.

- Хаана ч гэсэн адилхан. Манайд ч гэсэн тийм байгаа гэж тэр хэлэв.

- Новшийн амыад ч тааралдана, сайн хүмүүс ч бас тааралдана.

- Тийм ээ, сайн хүмүүс ч тааралдана гэдэгтэй би санаа нийлж байна гэж ноён Кернан тун сэтгэл ханамжтай өгүүлэв.

- Ер нь бол тэдэнтэй орооцолдоод хэрэггүй байгаа юм, би лав тэгж бодож байна гэж ноён Маккой нүхээ малтав.

Хатагтай Кернан өрөөнд орж ирээд ширээн дээр цартай зоог тавьснаа:

- Үүнээс зооглоцгоо! гэж хэлэв.

Ноён Пауэр гэрийн эзний үүргийг гүйцэтгэх мэт суудлаасаа босч, сууж байсан сандлаа түүнд өгөв. Тэрээр хувцас индүүдэх ажилтай гэж хэлээд суухаас татгалзаж ноён Пауэрын хойгуур гарахдаа ноён Каннингемыг харж нэг ирмэснээ хаалга руу зүглэв. Нөхөр нь түүнийг дуудав.

- Хонгор минь, надад чи юу ч авчраагүй юм уу?

- Чамд уу? Чамд бол салаавч л өгнө! гэж хатагтай Кернан тун ширүүхэн өгүүлэв.

- Эр нөхөртөө юу ч үгүй гэнэ шүү! эр араас нь хашгирав.

Түүний өрөвдмөөр хоолой хийгээд хөгийн дүр төрх тэнд цугласан олны инээдийг барж, зочид ч өөр өөрийн шилэн аягатай дарсыг барьцгаав. Эрчүүд аягатайгаа хөнтөрч ширээн дээр тавьснаа хэсэг зуур дуугүйхэн сууцгаав. Дараа нь Каннингем ноён Пауэр руу эргэн харснаа:

- Жэк, та пүрэв гарагийн орой гэв үү? хэмээн асуув.

- Тийм ээ, пүрэв гарагт! гэж ноён Пауэр өгүүлэв.

- Тун сайн хэрэг гэж ноён Каннингем хурдхан өлгөж авав.

- Мак-Аулийн уушийн газар уулзаж болох юм гэж ноён Маккой өгүүлэв.

- Тэр нь бидэнд арай тухтай байх болов уу.

- Хамгийн гол нь хоцрохгүй шүү. Оройтвол бөөн хүнтэй болчихдог юм гэж ноён Пауэр албархуу дуугаар хэлэв.

- Оройн долоо хагаст тохирвол ямар вэ гэж ноён Маккой өгүүлэв.

- Болж байна гэж ноён Каннингем хэлэв.

- За тэгвэл орой долоо хагаст Мак-Аулийнд, тохирлоо шүү!

Хэсэг хугацаанд нам гүм ноёлов. Түүний нөхөд тэрхүү төлөвлөгөөндөө өөрийг нь багтаах болов уу? гэдгийг ноён Кернан хүлээж байлаа.

- Ингэхэд та нар чинь яах гэж байна аа? хэмээн тэр асуув. Өө, онц юм биш дээ! гэж ноён Каннингем хэлэв.

- Пүрэв гарагт нэгэн ажил зохицуулах тухай ярьж байна.

- Дуурь үзэх гэж байгаа юм уу? хэмээн ноён Кернан хэдэрлэв.

- Үгүй ээ, үгүй. Зүгээр л нэг ажил байгаа юм гэж ноён Каннингем булзааруулсан өнгөөр хэлэв.

- Аан! гээд ноён Кернан тайвшрав.



Дахин нам гүм ноёлов.

- Том, үнэнийг хэлбэл, бид мөргөл хийхээр цугларах гэж байгаа юм гэж ноён Пауэр шуудхан хэлэв.

- Тийм ээ, Жэк болон Маккой бид нар бага зэрэг цэвэрлэгээ хийх гэсэн юм гэж ноён Каннингем өгүүлэв.

Энэхүү үгсийг тэр тун энгийн боловч нэлээд мэдрэмжтэйхэн өгүүлснээ:

- Чин сэтгэлээсээ хэлбэл, бид бол соёлтой новшнууд шүү дээ. Тийм ээ, бүгд адилхан гэж доош орсон байдалтай ноён Пауэрт хандан нэмж хэлэв.

- Та нар хүлээн зөвшөөрнө биз дээ? гэж тэр яриагаа үргэлжлүүлэв.

- Хүлээн зөвшөөрч байна аа! гэж ноён Пауэр хэлэв.

- Би ч бас хүлээн зөвшөөрч байна гэж ноён Маккой дэмжив.

- Тиймээс бид хамтдаа бүх зүйлийг цэвэрлэхээр шийдсэн юм гэж ноён Каннингем хэлэв.

Ямар нэгэн бодол түүний толгойд оров. Гэнэт тэр өвчтөнд хандан:

- Том, та миний толгойд юу орж ирснийг мэдэх үү? гэж хэлэв. Бидэнтэй нэгдвэл зүгээр байх. Ямар ч байшин дөрвөн булангүй босдоггүй биз дээ?

- Сайхан санаа байна. Тэгвэл дөрвүүлээ явахгүй юу гэж ноён Пауэр хэлэв.

Ноён Кернан юу ч хэлсэнгүй. Ноён Каннингемын санал түүнд юу ч өгүүлсэнгүй. Гэвч шашны байгууллагууд түүний талаар бөөн маргаан дэгдээж байгааг тэр мэдэрч байсан тул нэр төрөө хадгалахын тулд зарим нэг тууштай байдлыг илэрхийлэх нь зөв гэж үзэв. Нөхдийнхөө иезуитуудыг шүүмжлэх байгаа ярианд тэр оролцолгүй нэлээд удсан ч гагцхүү тайван, өширхсөн байдлаар бүхнийг сонсч байлаа.

- Иезуитуудын тухай би тийм ч их муугаар боддоггүй гэж сүүлд нь тэр ярианд оролцов.

- Тэд бол соёлт бүлгийнхэн. Миний бодоход тэдний хүсэл зорилго ч гэсэн сайн сайхны төлөө байдаг байх.

- Том, энэ бол бүх бүлгийнхнээс хамгийн аугаа нь юм гэж ноён Каннингем яриаг нь өлгөж авав.

- Сүмийн шатлан захирах ёсонд иезуитуудын одонт генерал бол пап ламыг л зайлшгүй дагадаг юм.

- Энэ талаар ямар яриа байх вэ? Хэрэв хэрэг явдлыг цэвэрхэн хийхийг хүсвэл иезуитуудад хандах хэрэгтэй гэж ноён Маккой хэлэв. Тэдний гар хөл хаана ч байна. Та нарт би нэгэн

тохиолдлыг ярьж өгье..

- Иезуитууд бол тун гайхалтай ард түмэн! гэж ноён Пауэр яриагаа эхлэв.
- Хамгийн гайхалтай зүйл бол бусад бүхий л шашны цол хэргэмтнүүд эрт орой нэгэн цагт сүйрэн унаж байсан бол, иезуитын бүлгийнхэн хэзээ ч үгүй гэж ноён Каннингем хэлэв.
- Тэд хэзээ ч уналтад орж байгаагүй юм.
- Үнэн гэж үү? хэмээн ноён Маккой асуув.
- Энэ бол баримт, түүх үүнийг өгүүлнэ гэж ноён Каннингем хэлэв.
- Тэдний сүм дуганыг хар л даа. Тэдний сүсэгтнүүд ямар гээч? хэмээн ноён Пауэр өгүүлэв.
- Иезуитууд бол хэзээний л язгууртнуудаас зуурч байдаг хүмүүс гэж ноён Маккой мэдэмхийрэв.
- Наадах чинь тодорхой шүү дээ! гэж ноён Пауэр хэлэв.
- Тийм ээ, гэж ноён Кернан өгүүлэв.
- Яагаад гэвэл би тэднийг хүндэтгэдэг. Тэд ямар нэгэн шашны төлөөлөгчид шиг өөртөө итгэлтэй бүдүүлэгхүмүүс биш...
- Тэд бүгд сайн хүмүүс гэж ноён Каннингем хэлэв.
- Ирландын шашны номлогчид хаа сайгүй хүндлэл хүлээж байдаг.
- Харах юмсан гэж ноён Пауэр уурлав.
- Манай тивийн зарим нэгэн улс орны шашны санваартнууд хажууд нь шал өөр шүү! гэж ноён Маккой хэлэв.
- Таны зөв ч байж мэднэ гэж ноён Кернан дуугаа зөөлрүүлэн өгүүлэв.
- Зөв байлгүй яахав гэж ноён Каннингем томров.
- Ийм их туршлагатай байж хүмүүсийг танихгүй байна гэж юу байх вэ? Тэд бие биедээ үлгэр дууриал үзүүлж дахин ууцгаав.

Ноён Кернан юу ч юм дотроо бодож сууна. Энэхүү яриа түүнд багагүй сэтгэгдэл төрүүлэв. Ноён Каннингем хүмүүсийг сайн мэддэг тухайд тэр өндөр сэтгэгдэлтэй байлаа. Тиймээс ч энэ талаар тэр улам дэлгэрэнгүй ярьж өгөхийг түүнээс хүсэв.

- Эцэг Пүблдом номлол айлдах болно гэж ноён Каннингем хэлэв.

- Тэрхүү сургаал нийтийг хамарсан байх болно. Бид чинь ажил ихтэй хүмүүс.

- Том, тэр бидэнд нэг их хатуурхахгүй биз гэж? ноён Пауэр болгоомжтойхон асуув.
- Эцэг Пүблдом уу? Эцэг Пүблдом уу? гэж өвчтөн бувтнана.
- Том, та түүнийг мэднэ шүү дээ гэж ноён Каннингем хэлэв.
- Амьдралын баяр баясгалантай тун дажгүй залуу. Нүгэлт бидний адил энэхүү хорвоогоос ангид нэгэн биш.
- Аан, тийм үү? Тэгвэл би түүнийгтаних байх. Өндөр, улаан царайтай нөхөр мөн үү?
- Тэр чинь яг мөн.

- Мартин, тэгвэл надад хэлээч... Тэр сайн номлогч уу?

- Танд юу ч гэж хэлмээр юм бэ дээ... Энэ бол жинхэнэ номлол биш юм аа. Зүгээр л бид нартай чин сэтгэлээсээ ярилцах гэж тэр. Ноён Кернан бодолд автав.

- Эцэг Том Бэрк1 жинхэнэ догь хүн байсан шүү! гэж ноён Маккой өгүүлэв.

1 Томас Николас Бэрк /1830-1883/. Ирландаас гадна Англи, Америк даяар алдартай уран илтгэгч. “Ирландыг удирдах Английн хор уршиг” гэх цуврал илтгэл нь түүнд ихээхэн нэр хүндийг авчирсан юм

- Тийм ээ, Эцэг Том Бэрк бол төрөлхийн уран илтгэгч байсан. Том, та урьд нь түүний илтгэлийг сонсч байсан уу? гэж ноён Каннингем асуув.

- Түүнийг би сонссон уу гэж үү? хэмээн өвчтөн гомдонгуй хэлэв. - Арай ч дээ, сонсолгүй яахав...

- Ингэхэд түүнийг Бурханы номлол айлдах тал дээрээ нэг их чадалтай биш байсан гэж ярих юм билээ хэмээн ноён Каннингем хэлэв.

- Үнэхээр тийм юм уу? гэж ноён Маккой асуув.

- Тэгэлгүй яахав. Гэхдээ арай ч нэг тартагтаа тулсан амьтан биш. Ямартаа ч түүний номлолд арай л өөр зүйл байдаг гэж ярилцах юм билээ.

- Тийм ээ... Тэр бол жинхэнэ хүн байсан гэж Маккой өгүүлэв.

- Түүнийг би нэг удаа сонсч байсан гэж ноён Кернан яриагаа үргэлжлүүлэв.

- Харин тэрхүү номлол юун тухай байсныг одоогоор санахгүй байна. Крофтон бид хоёр арын эгнээнд сууж байсан ч бил үү дээ...

- Хамгийн голын суудалд гэж ноён Каннингем хэлэв.

- Тийм ээ, хаалганаас холгүйхэн сууж байлаа. Тэр юун тухай ярьсныг ч мартчихаж... Тийм ээ, тэр Ромын пап болон бурхан болооч пап нарын тухай ярьж байсан. Одоо саналаа. Тун сайхан номлол байсан шүү. Дуу хоолой нь ямар байсан гэж санана. Бурхан өршөөг! Ёстой нэг биширмээр хоолой. Түүнийг тэр “Ватиканы хоригдол”<sup>1</sup> хэмээн нэрлэсэн. Биднийг гарч байх үед Крофтон I IX Пий папыг хэлж байна. (1792 онд төрж 1846-1878 онд шашны тэргүүнээр ажиллаж байв). Италийг нэгтгэхийн төлөө тэмцэл өрнөж байх үед Ромыг Вант улстай нэгтгэх асуудлаар эсэргүүцсэн байр суурь илэрхийлж байв

тэгж хэлж байсныг санаж байна...

- Гэхдээ Крофтон чинь оранжист I үзэлтэн биш гэж үү? хэмээн ноён Пауэр асуув.

- Тэр нь ч тийм. Дээр нь нэмээд тэр оранжист. Тэр үед бид Мурын гудамж дахь Батлерын уушийн газар очиход миний сэтгэл их хөдөлсөн, урьд нь тэгж хөдөлж байгаагүй билээ.

- Кернан, та бид хоёр янз бүрийн гонхонд мөргөдөг ч бидний шашин бол нэг юм гэж надад хэлж байсныг санаж байна. Үүнийг тэр ямар дажгүй хэлснийг сонсоод би тун их гайхсан шүү!

- Зөв зүйтэй үг байна гэж ноён Пауэр хэлэв.

- Эцэг Томыг номлол айлдаж байхад сүмд үргэлж л олон тооны протестант шашинтнууд цугладаг байлаа.

- Бидний хооронд тийм их ялгаа байхгүй гэж ноён Маккой хэлэв.

- Бид нэгэн зэрэг... Тэр хэсэгхэн зуур гацав. Тэгснээ,

- ... Ертөнцийн эзэнд итгэдэг. Хамгийн гол нь тэд Ромын пап болон Гэгээн Дарь-Эхэд үл итгэдэг юм.

- Гэхдээ мэдээж хэрэг манай шашин цорын ганц бодит, эртний гэгээн сүсэг бишрэл юм гэж ноён Каннингем тун тайвуухан, итгэл үнэмшилтэй өгүүлэв.

- Тэгж ярихын хэрэггүй гэж ноён Кернан нэлээд ширүүхэн хариу барив.

Унтлагын өрөөний хаалган дээр хатагтай Кернан ирж:

- Чам дээр зочин ирлээ гэж тэрээр мэдэгдэв.

- Хэн бэ?

<sup>1</sup> Оранжист гэдэг нь 1795 онд байгуулагдсан оранжистуудын бүлгэмийн гишүүн; оранжистуудын гол зорилго бол Ирланд, Их Британийн Вант улсын колончлолын холбоог улам бүр батжуулахын тулд оршиж байв

- Ноён Фогарти.

- Аан, тийм үү? Наашаа ороод ир!

Цонхигор, сувгаан царай өрөөний үүдний гэрэлд харагдав. Аятайхан, гайхширсан нүдэн дээр нумрах хөмсөгний шугам, доош унжих сахлын дугариг хэлбэртэй нь төстэй байлаа. Ноён Фогарти бол даруухан дэлгүүрийн эзэн. Цагтаа тэр Дублины нэгэн уушийн газрын эзэн байсан ч гагцхүү хоёрдугаар зэрэглэлийн дарс нэрэгч, шар айраг үйлдвэрлэгч нартай харьцах төдий санхүүгийн асуудлаас болж дамлуурахад хүрчээ.

Тиймээс тэр Гласневины зам дээр нэгэн багшаархан дэлгүүр нээж, тэндхийн эзэгтэй нарын сэтгэгдлийг эзэмдэж чадна гэдэгтээ найдаж байсан ажээ. Тэрбээр бага насны хүүхдүүдтэй үг хэлээ ололцож, тун удаан тасалдангуй ярина. Угтаа тэр нэлээдгүй соёлтой хүн байв. Ноён Фогарти хагас пинтын үнэ бүхий сайн чанарын виски бэлэг болгон авчирчээ. Тэрбээр ноён Кернаны эрүүл мэндийг эелдэгхэн асуугаад, авчирсан бэлгээ ширээн дээр тавьж тэнд байсан хүмүүстэй эн зэрэгцэхүйц гэдгээ мэдэрмэгц цугласан хүмүүстэй даруйхан нэгдэв. Ноён Кернан авчирсан бэлгийг ихэд хүндэтгэж үзэв. Хуучны тооцоогоор бол, ноён Фогарти түүнд хичнээнийг өгөх ёстой вэ гэдгийг сайтар санаж байлаа.

- Хөгшин минь, би хэзээ ч чамд эргэлзэж байгаагүй. Жэк, наадхаа зодолчихгүй юу гэж тэр хэлэв. Ноён Пауэр гэрийн эзний үүргийг дахин гүйцэтгэв.

Шилэн аягануудыг зайлж тус бүрт нь багахан виски аягалав. Одоо л нэг яриа өрнөж эхлэв. Ноён Фогарти сандлынхаа булан дээр сууж, тун хичээнгүйлэн сонсч байлаа.

- XIII Лев пап1 бол өөрийнхөө эрин үеийн хамгийн аугаа хүмүүсийн нэг байсан юм гэж ноён Каннингем хэлэв. Ромын католик шашныг Үнэн алдартны шашинтай нэгтгэсэн явдал нь түүний аугаа үйлийн эхлэл байсан юм. Энэ бол түүний амьдралын зорилго байлаа.

- Түүнийг Европын хамгийн соёлтой хүмүүсийн нэг байсан юм гэж би сонссон гэж ноён Пауэр өгүүлэв.

- Үүний сацуу тэр пап лам байлаа.

- Тийм ээ, хамгийн соёлтой хүн байсан шүү! гэж ноён Каннингем хэлэв.

- Пап ламын сэнтийд заларсан үеийн түүний уриа “Lux дээр Lux”

- “Гэрэл дээр гэрэл” байсан юм.

- Үгүй ээ, үгүй. Минийхээр бол та буруу ярьж байна. Түүний уриа нь “Tenebris дахь Lux” - “Харанхуй дахь гэрэл”2 байсан гэж ноён Фогарти тэсвэр алдан өгүүлэв.

- Тийм ээ, Tenebrae гэж ноён Маккой хэлэв.

- Надад зөвшөөрнө үү? Түүний уриа бол "Lux дээр Lux" байсан гэж ноён Каннингем эрсхэн өгүүлэв. Харин түүний өмнөх IX Пий пап ламын уриа бол “Сгух дээр Сгух”, энэ нь “Загалмай дээр загалмай”3 гэсэн үг. Үүнд л тэдний понтификатуудын4 хоорондын ялгаа оршиж байгаа юм.

- Залруулгыг хүлээж авлаа.

1 1810 онд төрж, (1878-1903 оны хооронд шашны тэргүүнээр сонгогдон ажиллаж байв). Тэрбээр орчин цагийн пап нарын түүхэнд ихээхэн нөлөө бүхий юм. Өмнөх IX Пий папын улс төр шашны мөрийн хөтөлбөрөөс тэр ухраагүй бөгөөд арай илүү уян налархай бодлого явуулж байжээ. Ирландын үндэсний чөлөөлөх хөдөлгөөнийг эсэргүүцэгч байснаас гадна зохиолчийн хувьд XIII Лев пап улс төр, шашны хэд хэдэн шастир мөн латин хэл дээр бичсэн шүлгүүдээрээ олонд танигдсан юм

2 Алдаа: XIII Лев папын уриа бол “Lumen in Coelo” буюу - “Тэнгэр дэх гэрэл” байсан юм

3 Оновчтой бус байдал: IX Пий папын уриа бол “Crux de Cruce” /латин/ буюу “Загалмайнаас үүдсэн зовлон” гэсэн үг

4 Католик шашинд Ромын папын засаглал ноёрхож байсан үе /латин/

- Лев пап ламыг эрдэмтэн, мөн яруу найрагч байсныг мэдэх үү? гэж ноён Каннингем яриагаа үргэлжлүүлэв.

- Тийм ээ, тун эрх чөлөөтэй хүн байсан даа! гэж ноён Кернан хэлэв.

- Тийм ээ, тэр латин хэл дээр шүлэг бичдэг байсан юм гэж ноён Каннингем ч бас нэмж дуугарав.

- Арай үгүй байлгүй дээ гэж ноён Фогарти өгүүлэв.

Ноён Маккой нэлээд сэтгэл хангалуун байдалтай виски шимж, энэхүү ундаанд хандах өөрийн хандлагыг мэдрэх мэт толгой сэгсрэв. Чингээд тэр найзынхаа хэлснийг тунгааж байснаа,

- Энэ бол тоглоом биш шүү! гэв.

- Том, манай сургуульд лав үүнийг заагаагүй! гэж ноён Маккойн жишээг даган ноён Пауэр хэлэв.

- За яахав. Нөхцөл байдал тэнд тийм сайнгүй гэлээ ч цөөнгүй ажил хэрэгч хүн тэндээс төрсөн юм гэж ноён Кернан сургамжтайхан өгүүлэв. - Хуучны тогтолцоо энгийн шударга хүмүүжлээрээ илүү дээр байсан юм. Орчин цагийнх, илүү дутуу юм байхгүй. Амар байж дээ.

- Тийм шүү! гэж ноён Пауэр дэмжив.

- Ямар ч илүү дутуу тансаг юм үгүй хэмээн Фогарти хэлэв.

Тэрбээр энэхүү үгэнд онцгой анхаарал хандуулж, тун чухал царайлан урдхаасаа балгав.

- Түүнийг би уншиж байснаа санаж байна. Лев папын бичсэн нэг шүлэгт лав гэрэл зургийг хэрхэн бүтээсэн талаар гардаг юм. Мэдээж латин хэл дээр бичсэн байсан гэж ноён Каннингем хэлэв.

- Гэрэл зураг гэнэ ээ? хэмээн ноён Кернан уулга алдан өгүүлэв.

- Тийм ээ. Тэр ч мөн өөрийн аяганаас хүртдэг байсан юм гэж ноён Каннингем хэлэв.

- Юу л гэж бодвол бод! Гэрэл зураг гэдэг гайхамшигтай зүйл биш гэж үү? хэмээн ноён Маккой хэлэв.

- Тэгэлгүй яахав ээ, суутнуудад ихэнхи зүйл нээлттэй байдаг шүү дээ! гэж ноён Пауэр айлдав.

- Найрагчийн хэлснээр бол: “Суут хүмүүсийн галзуурах нь амархан” гэж ноён Фогарти онцлон өгүүлэв.

Ноён Кернан ямар нэгэн зүйлд санаа зовнисон мэт байв. Тэрбээр хэл хугалчих гэсэн протестант шашны ямар нэгэн байдлыг эргэн санахыг оролдов. Эцэст ньтэр ноён Каннингемд хандан:

- Мартин, зарим пап нар мэдээж хэрэг одоогийнх шиг биш л дээ. Дээр үеийн пап лам нар тийм их дээшээ оргилд хүрсэн нь ховор байсан гэдэг үнэн биш гэж үү? Та энэ талаар юу хэлэх вэ? гэж асуув.

Нам гүм болмогц ноён Каннингем түүнд хандан:

- Тийм ээ, тэдний дунд хэнд ч хэрэггүй хүмүүс ч бас байсан нь мэдээж хэрэг... Хамгийн гайхалтай нь тэдний хэн нь ч гэсэн архичин байсан ч, хамгийн хогийн новшийн амьтан байвч ex cathedra гэх үгийг хэзээ ч хэлж байгаагүй юм. Энэ чинь гайхалтай биш гэж үү?

- Гайхалтай юм аа гэж ноён Кернан өгүүлэв.

- Тийм ээ, хамгийн гол нь пап ламыг ex cathedra гэж хэлбэл хэзээ ч алдас болдоггүй юм гэж ноён Фогарти тайлбарлав.

- Тийм ээ, гэж ноён Каннингем хэлэв.

1 Шууд буулгавал индэр гэсэн латин үг. Католик шашны номлолоор бол пап ламтан индэр дээрээс номлож байх үед тэр хэзээ ч нүгэлд автдаггүй аж. Энэ нь 1870 онд Ватиканы хурлаар батлагдсан байна.

- Харин би пап ламын алдаа гаргаж байсан тухай сонсч байсан юм. Тэгэхэд би залуухан байж дээ. Эсвэл энэ арай?..

Ноён Фогарти түүний яриаг таслав. Тэрбээр лонхтойг авч бүгдэд нь хийж өгөв. Бүгдэд нь хүрэхгүйг мэдмэгц, ноён Маккой эхний хийж өгснийг ч ууж амжаагүй байгаа гэдгээ итгүүлэхийг оролдов. Эхэндээ бухимдсан ч төдөлгүй бүгд шилэн аяганд хийж буй вискины аятайхан чимээг сэтгэл хангалуун сонсч, бүхнийг хүлээн зөвшөөрсөн байдалтай дуугүйхэн сууцгаав.

- Том, та ямар нэгэн юм хэлэх үү? гэж ноён Маккой асуув.

- Пап ламын алдаа гаргахгүй байх онолын тухай гэж ноён Каннингем хэлэв. - Энэ бол сүмийн түүхэн дэх хамгийн чухал хуудас байсан юм.

- Мартин, тэр чинь юунаас болсон юм бэ? гэж ноён Пауэр асуув.

Ноён Каннингем хоёр булцгар хуруугаа гозолзуулав.

- Кардиналууд, архиепископ болон епископ нарыг Гэгээн зөвлөлд байхыг бүгд зөвшөөрч байхад хоёрхон хүн эсрэг саналтай байлаа. Бусад нь бүгд л нэгэн дуугаар алдаа хийхгүйн төлөө саналаа өгөв. Үгүй ээ, үүнийг тэд гаргахгүй байхыг хүсч байв.

- За тийм байж гэж ноён Маккой хэлэв. Тэр хүн бол Немцийн кардинал Доллинг бил үү, Доулинг бил үү? тийм хүн байсан юм.

- Доулинг лав немц хүн байгаагүй гэж ноён Пауэр инээд алдан хэлэв. Нэг үгээр хэлбэл тэдний нэг нь Немцийн алдарт 1 Иоганн Доллингер /1790-1890/ бол 1870 оны Ватиканы хуралд оролцогч, мөн кардинал байгаагүй юм. Тэрбээр лам, улс төрийн зүтгэлтэн, шашны түүхч байснаас гадна пап ламын алдаа гаргахгүй байх онолын эсрэг тууштай тэмцэгч байв. Тиймээс 1871 онд тэр шашны сэнтийгээс огцорсон юм. Кардинал байсан хэн ч билээ дээ, байз. Харин нөгөөх нь бол Жон Мак-Хэйл байсан юм.

- Юу гэнэ ээ, ноён Кернан дуу алдан өгүүлэв.

- Арай, Туамын Иоанн биш биз?

- Та үүнд итгэлтэй байна уу? гэж ноён Фогарти эргэлзэнгүй асуув.

- Тэр бол ямар нэгэн итали юм уу, америк хүн байсан гэж би үргэлж боддог.

-Туамын Иоанн гэдэгхүн байсан юмхэмээн ноён Каннингем давтан өгүүлэв.

Түүнийг уумагц бүгд л дагалдав.

- Дараа нь ертөнцийн бүхий л өнцгөөс кардиналууд, епископ, архиепископ нар цугларсан байхад, өнөөх хоёр чинь байдгаараа зодолдож гарав. Пап лам сүмийн индэр дээр гарч ягшмал номлол айлдаж эхлэв. Энэ мөчид үүнийг олонтаа няцааж байсан Мак-Хэйл босч, “Credo” гэж аянга ниргэх мэт дуугаар чанга хашгирав.

- Итгэж байна! гэж ноён Фогарти хэлэв.

- Credo! гэж ноён Каннингем өгүүлэв.

- Энэ нь түүний сүсэг бишрэл хэр гүн гүнзгий болохыг харуулж байна. Пап ламыг ярьж эхлүүт тэр шуудхан үгэнд нь орж байна.

- Тэгвэл Доулинг яах вэ? Немцийн кардинал хараат байхаас татгалзаж сүмийг орхисон.



Каннингемийн хэлсэн үгс сонссон хүмүүсийн төсөөлөлд сүмийн хүчирхэг дүрийг бүтээсэн байна. Түүний намуухан сөөнгө хоолой хийгээд түүний айлдсан сүсэг бишрэлийн үгс,

1 Жон Мак-Хэйл /1791-1881/. Туамын Иоанн. Ирландын Туамаас гаралтай Ирландын архиепископ, эрх чөлөөнийхөө төлөө тэмцэж байсан ирландчуудын тэмцэлд оролцогч, пап ламын алдаа гаргахгүй байх тухай онолыг эсэргүүцэгч байсан ажээ.

хүлцэнгүй байдал зэрэг нь тэднийг байдгаар нь донсолгов. Хормогчиндоо гараа арчих зуур хатагтай Кернан өрөөнд орж ирээд тун ёслол төгөлдөр байдалтай нам гүмийн дунд яахаа ч мэдэхгүй болов. Энэ бүхнийг эвдэхээс эмээсэндээ тэр орны түшлэг тохойлдон зогсов.

- Нэгэн удаа би Жон Мак-Хэйлийг харж байсан гэж хатагтай Кернан хэлэв.

- Үүнийгээ би үхэн үхлээ ер мартаггүй.

Тэрбээр нотлох баримт хайх мэт эхнэртээ хандан:

- Би чамд ярьж өгч байсан биз дээ гэв.

Хатагтай Кернан толгой дохив.

- Энэ явдал ноён Жон Грэйнд дурсгалд зориулж босгосон хөшөөний нээлт дээр болсон юм. Эдмунд Двайэр Грэй ямар нэгэн дэмий юм ярих байдалтай гараа алдлан зогсч байсан бол, харин энэ өвгөн тэнд тун хэрцгий царайлчихсан сууж, өтгөн хөмсгөн доорхи нүдээрээ түүнийг өрөмдөх мэт харж байв.

Ноён Кернан хөмсөг зангидан тэргүүнээ гудайлгаж, галзуурсан бух лугаа адил эхнэрээ цоо ширтэв.

- Бурхан минь! гэж тэр өөрийнхөө царайг төлөв болгоод онцлон хэлэв.

- Энэ амьдралдаа би ийм харцтай хүн ер харж байсангүй. “Муу нусгай минь чамайг би нэвт харж байна шүү” гэж тэр хэлж байгаа мэт санагдана. Яг л шонхор гэсэн үг.

- Грэйныхний хэн нь ч сохор зоосны үнэгүй байлаа гэж ноён Пауэр хэлэв.

Эргээд нам гүм болов. Ноён Пауэр хатагтай Кернаны зүг 1875-1861 онд амьдарч байсан Ирландын алдарт, хэвлэн нийтлэгч төрийн зүтгэлтэн юм. Түүний хүү Эдмунд Двайэр Грэй /1845-1888 онд амьдарч байсан улс төрийн зүтгэлтэн эцгийн нэгэн адил буй мэт гомрулийн талыг баримтлагч. эргэн харснаа, гэнэтхэн тун хөгжилтэйгээр,

- Хатагтай Кернан, бид таны нөхрийг чин шударга, бурханд элгэмсүү католик шашинтан болгохоор шийдлээ гэж хэлэв.

Бүхий л хүмүүсийн зүг тэр гараараа зангав.

- Бид бүхэн бүгдээрээ нүглээ наминчлахаар шийдлээ. Аль эрт л ингэх хэрэгтэй байсан юм.

Үүнийг Бурхан харж байгаа.

- Надад татгалзах зүйл алга гэж ноён Кернан хэлээд нэлээд сандрангуй инээмсэглэв. Өөрийн таашаалыг нуух нь ухаалаг хэрэг болно гэж хатагтай Кернан шийдэв.

- Нүглээ наминчлахаар очих гэж байгаа тэр ламтанг би өрөвдөж байна гэж тэрээр хэлэв.

Ноён Кернаны царай хувьсхийн өөрчлөгдөв.

- Энэ бүхэн түүнд таалагдахгүй бол тэр өөр хаашаа ч юм явдаг юм байгаа биз гэж эрсхэн хэлэв.

- Би ганцхан өөрийнхөө гашуун түүхийг л түүнд ярих болно. Би тийм ч новшийн амыан биш шүү.

Ноён Каннингем тун чиг яарангуй ярианд оролцов.

- Бид үргэлж л буг чөтгөрөөс холхон байхыг хичээдэг. Гэвч түүний далдуур хөнөөх болон дур татах байдалыг хэзээ ч мартагдаггүй юм гэж тэр хэлэв.

- Чөтгөр минь надаас холд гэж ноён Фогарти бусад руугаа харан инээмсэглэсээр өгүүлэв.

Ноён Пауэр юу ч хэлсэнгүй. Бүх юм түүний бодож байснаар болж байна гэдгийг тэр мэдрэв. Тиймээс түүний царай дээр чинхүү таашаал илэрхий байлаа.

- Ямар их ажил вэ? гэж ноён Каннингем өгүүлэв.

- Хэсэг хугацааны дараа асаалттай лаа барин загалмайлах үеэр хүртсэн санваарыг ч шинэчлэх хэрэгтэй.

- Тийм ээ, Том. Хамгийн гол нь лааны тухай мартаж болохгүй шүү гэж ноён Маккой өгүүлэв.

- Юу гэнэ ээ? Би тэгээд лаа бариад зогсч байх болж байна уу? гэж ноён Кернан хэлэв.

- Тийм ээ гэж ноён Каннингем өгүүлэв.

- Арай ч тэгж болохгүй байх. Бүх юманд хязгаар бий! гэж ноён Кернан эгдүүцэнгүй хэлэв.

- Бүхий л дүрэмд зааснаар шаардлагатай бүхнийг би хийх болно. Нүглээ наминчилж, мөргөл үйлдэж, шаардлагатай бүхнийг хийнэ. Гэхдээ ямар ч лаа үгүй. Чөтгөр аваг гэж! Лаа байхгүй бол юу ч байсан яахав. Тэрбээр албархуу байдлаар толгой сэгсрэв.

- Үгүй ээ, чи зүгээр сонс л доо! гэж эхнэр нь хэлэв.

- Ойр хавийн хүмүүстээ онцгой сэтгэгдэл төрүүлснээ мэдмэгц лаа байхгүй бол юу ч байсан яахав гэж ноён Кернан дахин өгүүлэв.

Чингэхдээ тэр хоёр тийш толгой сэгсэрч байлаа. Задгай тоглох ший л биш бол юу ч байсан яахав! Нөхдүүд чин сэтгэлээсээ инээд алдацгаав.

- Май, үүнийг сонирхоцгоо. Хэлэх ч үг алга. Жинхэнэ үлгэр жишээ католик шашинтан.

- Ямар ч лаа үгүй! гэж ноён Кернан давтан өгүүлэв.

- Тийм л биш бол яахав.

Гардинерийн гудамждахь Иезуитын сүм барагл дүүрчихсэн байлаа. Түүнээс гадна хором бүр хажуугийн хаалга нээгдэж, хэн нэгэн сүмийн ажилтны хамт өлмий дээрээ орж ирэх агаад суудал олтлоо нааш цааш холхино. Бүх сүсэгтнүүд аятайхан хувцасласан байх агаад тун чиг албархуу байдлаар биеэ авч явцгаана. Сүмийн гэрэл, хар тэрлэг болон цагаан захан дээр тусч, тэдний дунд зузаан ноосон хослолууд толбо мэт сүүтэгнэнэ.

Орж ирсэн хүмүүс аюулгүй газар малгайгаа тавьцгааж, урт вандан сандал дээр өмднийхөө шуумгийг татан сууцгаана. Тэд төв гонхны өмнө өлгөөтэй байх тэртээх улаан дөл бүхий дэнлүү рүү биширсэн байдалтай харж, өөрт эвтэйхэн байрлал эзлэн сууцгаана.

Индрийн ойролцоох нэгэн вандан сандал дээр ноён Каннингем, Кернан нар сууж байлаа. Тэдний арын сандал дээр ноён Маккой ганцаар сууна; түүний ард ноён Пауэр, Фогарти нар сууцгаана. Ноён Маккой хэн нэгний дэргэд суудал олохыг хичээсэн авч ямар ч амжилт олоогүй бөгөөд бүх нөхөд нь байраа олон сууцгаажээ; тэдний сандал дээрээ цомцойн суух нь Христийн биен дээрх цовдлуулсан байдалтай ихэд адилхан санагдахыг тэр анзаарав. Түүний торгон мэдрэмжийг хүлээцтэйхэн тосч авсан тул дуугаа хураав. Тэр ч бүүхэл, эргэн тойронд ноёлж байсан үзэсгэлэнт байдал түүнд нөлөөлөв.

Ноён Каннингем Кернан болон Харфорд руу анхаарлаа хандуулж, дараа нь индрийн өмнө суугаа сонгуулийн хорооны нарийн бичгийн дарга ноён Феннинг рүү харав. Баруун талд нь гурван ч зээлийн кассны эзэн хөгшин Майкл Граймс, Цамхагт албан тушаал хүртэх учиртай байсан Дана Хогэны ач хүү нар сууж байв. Тэдний өмнө “Freeman” сэтгүүлийн сурвалжлагч ноён Хэндрик, ноён Кернаны эртний танил, хөөрхий муу 0’Кэрелл сууна. Танил хүмүүсийн дунд орж ирмэгцээ, ноён Кернан өөрийгөө улам бүр итгэлтэйгээр мэдрэв. Эхнэрийнх нь цэвэрлэж өгсөн бүрх малгай өвдгөн дээр нь хэвтэнэ. Нэг гараараа тэр үе үехэн ханцуйгаа татаж байсан бол, нөгөө гар нь бүрх малгайныхаа хүрэнээс чангахан атгаж байв. Индэр рүү хөтлөх шаг өөд цагаан нөмрөгтэй, нэлээд хүнд жинтэй хүн гарч ирэв. Сүсэгтнүүд суудлаасаа босч өмнө тавьсан нусны алчуур дээрээ өвдөг сөхрөн сууцгаав. Ноён Кернан ч мөн бусдын жишгийг дагав.

Эдүгээ ламтан индэр дээр нуруугаа цэхлэн зогсоно. Түүний биеийн гуравны хоёр хийгээд том улаан нүүр нь шатны бариулын цаанаас харагдана. Эцэг Пүблдом өвдөг сөхрөн сууж, улаан галын дөл бүхий дэнлүүний зүг эргэж, гарынхаа алгаар нүүрээ даран залбирал үйлдэж гарав. Хэсэг хугацааны дараа тэр гараа нүүрнээсээ авч босов. Сүсэгтнүүд ч мөн босч урьд нь сууж байсан суудал дээрээ тухалцгаав. Ноён Кернан бүрх малгайгаа авч өвдөг дээрээ тавиад номлогчийн зүг анхааралтай харж суулаа.

Номлогч нөмрөгнийхөө өргөн ханцуйг шалмагхан эргүүлж, тэнд сууж буй хүмүүсийн царайг алгуурхан ширтэв.

- Эдүгээ зууны хөвгүүд өөрийн төрөлд оршин буй хорвоогийн хөвгүүдээс улам илүү ухамсартай байна. Тиймээс би та бүхэнд хандан хэлэх зүйл бол, эд баялгаас илүү эрхэм нөхдийг олж авахад бүхнийг зориулах хэрэгтэй. Чингэх аваас та бүхнийг үгээгүй ядуу болсон цагт тэд мөнх амьдрал<sup>1</sup>-даа хүлээн авах болно гэж дараа нь тэр айлдав.

Эцэг Пүблдом эдгээр үгсийн утга санааг өөртөө итгэлтэй, тодхон дуугаар тайлбарлав. Энэ бол бүхий л номлолд байгаа хамгийн хүндхэн сургаалийн нэг юм гэж тэр хэлэв. Учир юун гэвээс түүнийг үнэн зөв, ойлгомжтой тайлбарлахад тун

1 Шударга бус захирагчийн тухай шастирт Есүсийн хэлсэн үг /Еванг. Лука, 16.8-9/)

хүндрэлтэй ажээ. Эхэндээ энэ бүхэн Есүс Христийн номлож байдаг дээд ёс суртахуунтай үл авцалдаж буй мэт санагдаж болох юм. Гэвч эдгээр нь энэ хорвоо дээр амьдрах хувь тавилантай бүх хүмүүс хийгээд энэ ертөнцийн хөвгүүд лугаа адил амьдрахыг үл хүсэгч бүхий л хүмүүст тусгайлан хандаж хэлсэн үгс бөлгөө гэж сүсэгтнүүдэд тэр хэлэв.

Эдгээр үгс бол ажил хэрэгч хүмүүст зориулагдсан юм. Хүмүүний байгалийн бүхий л сул талыг өвлөсөн ч хожим төгс байдалд хүрсэн Есүс Христын хувьд бүх хүмүүс Бурхан шүтэж амьдрах хувьгүй гэдгийг ойлгож байсан ч, тэдний ихэнх нь энэ хорвоод амьдрах тавилантай тул зарим тохиолдолд тэд ертөнцийн төлөө зүтгэх учиртай ажээ; эдгээр номлолоор тэр зөвлөгөө өгч, тэдний оюун санааны амьдралын ач тусын төлөө шунахай сэтгэлтнүүдийн тухай ярьж өгөхийг хүсэв.

Сүсэгтнүүдэд хандан хэлэхдээ тэр өнөөдөр биднийг айл гах юм уу, хэзээ ч биелэшгүй шаардлага тавихаар ирээгүй гэдгээ онцлон өгүүлж, энэ ертөнцийн эгэл нэгэн хүүгийн адил ахан дүүстэйгээ ярилцахаар ирсэн гэжээ. Ажил хэрэгч хүмүүстэй ярилцахаар ирсэн агаад тэдэнтэй ажил хэрэгч байдлаар ярилцана. Аливаа зүйлийг дүрслэн үзүүлэх шаардлага түүнд гарваас даруйхан тэдний оюун санааны тэтгэгч байх болно; иймээс тэд сүсэгтэн бүрийг өөрийн өмнө оюун санааныхаа ном судрыг дэлгэж, сэтгэлийнх нь тооцоо таарч байгаа эсэхийг шалгахыг хүсэв.

Есүс Христ бол өгөөмөр Эзэн. Тэр бидний нүглийг мэдэж байгаагаас гадна бидний нүгэлт орчны сул тал, хүмүүний амьдралын аливаа дур татам үйлийг сайн мэднэ. Бид бүхэн аливаа зүйлд татагдаж, нүгэлт явдлыг үйлдэж байсан тул бидний нүгэл хийсэн нь тодорхой билээ.

Гэвч тэр өөрийн сүсэгтнүүдэд хандан ганцхан зүйлийг захиж буйгаа хэлэв. Хамгийн гол нь тэд Бурханы өмнө эрэлхэг зоригтой хийгээд чин шударга байх учиртай ажээ. Хэрэв тэдний тооцоо бүхий л байдлаар яв цав нийлж байвал: “Өөрийнхөө тооцоог би шалгалаа. Бүх зүйл яв цав тохирч байна гэж хэлэх болтугай” гэнэ. Хэрэвзээ тэдний тооцоонд олон алдаа байх аваас тэд энэ бүхнийгээ хүлээн зөвшөөрч, жинхэнэ эр хүний хувьд, “Өөрийнхөө тооцоог би харж үзлээ. Түүнд их олон алдаа байна. Гэвч Бурханы хишиг хүртэнэ гэдэг гарцаагүй үнэн бөлгөө. Тиймээс би засрах болно. Өөрийнхөө тооцоог би ном журамд нь оруулах болно”.



## Үхэгсэд

Манаачийн охин Лилийн хөлд нь хий оржээ. Тэрээр доод давхрын албан газрын ард талын жижигхэн пинд хэн нэгэн зочныг оруулж, хувцсаа тайлахад нь туслаж амжаагүй байтал үүдний хаалганы жингэнэсэн хонхны дуу дахин дуугарна. Тиймээс тэр хоосон хонгилоор гүйхээрээ очиж, шинэ ирж буй зочинд хаалга тайлж өгнө.

Ямар ч байсан хатагтай нарыг халамжлахгүй байгаа нь яамай даа. Кэт, болон Жулия авхай нар энэ талаар бодолцож, эмэгтэйчүүдийн хувцас солих өрөөг дээд давхрын угаалгын өрөөнд байхаар зохицуулжээ. Тэр хоёр худал чалчин инээд алдацгааж, үе үехэн шат руу гүйн гарч ирж, хэн ирсэн талаар Лилигээс асууна. Энэ бол томоохон тэмдэглэлт үйл явдалд зүй ёсоор тооцогдох Морканы гурван охины жил бүр уламжлал болгон зохиодог үдшийн цэнгүүн байлаа.

Тэдний бүх танил, төрөл төрөгсөд, гэр бүлийн хуучин найз нөхөд, Жулия авхайн хамт дуулж байсан найрал дуучид, тухайн үед нас биед хүрсэн Кэтийн шавь нар, тэр ч бүү хэл, Мэри Жэйний ганц нэг шавь нар ч мөн хүрэлцэн иржээ. Тэрхүү цэнгүүн хэзээ ч муу болж байсангүй. Хэдэн жил ээлж дараалан болсон ч бүх талаар ярих юмгүй сайхан болж өнгөрнө; Пэт ахыг нас барсны дараа Кэт, Жулия нар өөрсдийн цорын ганц ач охин болох Мэри Жэйнийг өргөж авснаас хойш Стони Батгэраас нүүж, Ашэр Айлэнд дахь харанхуй байшингийн дээд давхрыг тэд талхны худалдаачин ноён Фүлгэмээс түрээслэж байсан ажээ. Энэ бүхэн тэртээх гучин жилийн өмнө болж өнгөрсөн явдал бөлгөө.

Богинохон даашинз өмсдөг байсан Мэри Жэйн охин энэ хугацаанд гэр бүлийн гол өмөг түшиг болжээ; тэрээр Хэддингтоны замд байрлах сүмд бадралт баг бишгүүр хөгжим дээр тоглодог байв. Мэри Академи төгссөнөөс хойш Энтъэнтийн концертын танхимд шавь нарынхаа тоглолтыг жил бүр зохион байгуулдаг болов. Шавь нарын олонхи нь Дублины язгууртны хороололд оршин суудаг хамгийн шилдэг гэр бүлээс гаралтай байжээ. Нагац эгч нар нас нэлээн явсан ч ажил эрхэлсээр байлаа. Жулиягийн хувьд, эдүгээ үс нь бууралтаж, хөгширсөн авч цагтаа тэрээр Адам ба Евагийн сүмд нэг дахь цээл хоолойт дуучин байсан бол, Кэтийн хувьд эрүүл мэндийн дорой байдлаас болж удаан явж чадахаа байсан тул гэрийнхээ хоолны өрөөн дэх хуучны дөрвөлжин төгөлдөр хуур дээр анхлан суралцагсдад зориулан хөгжим заадаг байжээ. Харин манаачийн охин Лили гэрийн үйлчлэгч хийнэ. Тэд даруухан амьдарч байсан ч хоол ундандаа хэзээ ч мөнгө татаж байсангүй; хамгийн сайн чанарын загасны мах, гурван шиллингийн үнэ бүхий байхуу цай, дээд зэргийн портер дарс хэрэглэнэ.

Лилийн хувьд заавар зөвлөмжийг ховорхон хольж хутгадаг байсан тул гурван эзэгтэйтэйг шаггүйхэн таарч, тохирч байв. Тэд дэмий зүйлийн төлөө сэтгэлээр унах хандлагатай байсан ч энэ нь нэг их том зовлон биш ажээ. Хамгийн гол нь тэд ямар нэгэн эсэргүүцсэн шийдвэрийг хэзээ ч хүлээн зөвшөөрдөггүй байв. Харин энэхүү үдэш шиг өдөр сэтгэл хөдлөх нь зүйн хэрэг билээ.

Нэгдүгээрт, оройн арван цаг өнгөрсөн ч Габриэл, эхнэрийн хамт ирээгүй байлаа. Хоёрдугаарт, Фрэдди Мэлинз халамцуухан ирэх вий гэхээс тэд үхэтлээ айцгаана. Мэри Жэйний хэн нэгэн шавь түүнийг тийм байдалтай байхыг нь харахыг тэд ердөө ч хүссэнгүй;

түүнийг халамцуухан байхад эвийг нь олох тун чиг амаргүй ажээ. Фрэдди Мэлинз үргэлжид хоцордог байвч харин Габриэлийг юунаас болж ингэж оройтсныг тэд ойлгож чадсангүй; тиймээс тэд хором бүр л шатан дээр гүйж гарч ирцгээн, Габриэл юм уу, Фрэдди хоёрын аль нэгийг ирсэн эсэхийг Лилигээс лавлана.

- Ай даа, ноён Конрой! гэж Габриэлд хаалга онгойлгох зуур Лили уулга алдав. - Кэт, Жулия авхай нар таныг ирэхгүй байх гэж бодсон шүү! Оройн мэнд, хатагтай Конрой!

- Тэднийг тэгж бодлоо гээд гайхах юу байхав! гэж Габриэл хэлэв. Бодвол манай эхнэр хувцсаа өмсөх гэж доод тал нь гурван цаг болдгийг тэд мартсан бололтой.

Тэрбээр галошныхаа цасыг цэвэрлэн шалны алчуур дээр зогсох зуур эхнэрийг нь Лили шат руу дагуулж очмогц:

- Кэт авхай, хатагтай Конрой ирчихлээ! гэж чангахан дуугаар дуудав.

Кэт, Жулия хоёр харанхуй шатаар доош гүйлдэцгээв. Тэд Габриэлийн эхнэрийг үнсч үнгээд хөөрхий Грэта, бодвол нэлээд даарсан байх гээд,

- Габриэл, ингэхэд хаана байна? гэж асууцгаав.

- Кэт эгч ээ, би энд байна. Тайван байж болно. Та нар дээшээ орж бай би одоохон очно гэж Габриэл харанхуйгаас дуугарав.

Хүүхнүүдийг инээд алдан шатаар өгсөх зуур тэр галошныхоо цасыг шалмагхан цэвэрлэж гарав. Цээживч адил зөөлөн цасан цацаг түүний хүрмэн дээр тогтсон байх агаад харин галош дээрх цас давхар хамар лугаа адил байдгаараа бөөгнөрч наалдсан байв. Хөлдсөн нүхэнд арайхийн товч нь орох үед цантсан илбэргэний нугалаа хийгээд хуниаснаас анхилуун, хүйтэн агаар сэнхийв.

- Ноён Конрой, арай дахиад цас орчихсон юм биш биз? гэж Лили асуулаа.

Түүний хувцсыг тайлахад туслахаар тэр урд нь гарч пин рүү оров. Гурван үетэй мэт түүний нэрийг дуудмагц, Габриэл түүний зүгхараад инээмсэглэв. Тэрээр туранхай цонхигор арьс, сүрлэн өнгө бүхий үстэй, биеийн хөгжил нь арай л гүйцээгүй шавилхан бүсгүй байлаа.

Пинд байх хийн дэнлүүний гэрэлд улам бүр цонхигор харагдана. Габриэл түүнийг бүр хүүхэд байхаас нь мэддэг байсан агаад тэрээр шатны доод гишгүүр дээр сууж, даавуун хүүхэлдэйгээ эрхлүүлэх дуртай нэгэн байж билээ.

- Тийм ээ, Лили. Дахиад л орж байна. Бодвол шөнөжингөө орох биз! гэж тэр хэлэв.

Дээд давхарт хөлийн чимээ гарах үед тэр тааз руу өнгийв; төдөлгүй төгөлдөр хуурын ая эгшиглэхийг сонсоод түүний хүрмийг авч, тавиур дээр нямбайлан тавьж буй бүсгүй рүү харав.

- Лили, чи сургуульдаа явсаар байгаа юу? гэж нөхөрсөг өнгөөр тэр асуув.

- Эрхэм ээ, юу гэж дээ! Би чинь бараг жилийн өмнө төгсчихсөн шүү дээ! гэж Лили хариулав.

- Тийм үү? Тэгвэл удахгүй чиний хуримыг хийх юм байна даа! гэж Габриэл хөгжилтэйхэн өгүүлэв. Бүсгүй мөрөн дээгүүрээ ширэв татуулан харснаа, тун их гомдсон байдалтай,

- Одоогийн эрчүүд бүсгүй хүнээс тойрч зугтахын тулд янз бүрийн л юм ярих болж дээ! гэв.

Габриэл ямар нэгэн эвгүй байдал гаргаснаа мэдэрсэн мэт байдгаараа улайж, Лили рүү огтхон ч харалгүй өмсч байсан галошоо тайлж хаяад, хүзүүний арчуурныхаа булангаар чийдсэн гутлаа зүлгэж гарав. Тэрбээр өндөр нуруутай, мяраалаг нэгэн байв. Хацрынх нь улаан дух руу нь тарж, цонхигор улаан, хэлбэр дүрсгүй толбо болон уусна. Мөлчийтөл сахлаа хуссан нүүрэн дээр нь тайвуухан гялалзах дугуй шил, цоо шинэхэн алтадмал нүдний шилний хүрээ зэрэг нь түүний муухан хараа, тайван бус нүдийг далдалж байлаа.

Арагшаа самнасан толигор хар үс чихнийх нь ардуур мушгиран орох ажээ. Гутлаа толийтол арчиж, биеэ барьсан хантаазаа доош татаад, нуруугаа тэгшлэв. Дараа нь халаасаа ухаж алтан зоос гаргаж ирэв.

- Лили, сонсч бай! Одоо чинь Зул сарын баяр болж байна шүү дээ. Тийм биз дээ? Тийм болохоор... Үүнийг чамд... гэсээр тэр түүний гарт өнөөх зоосоо атгуулав. Тэрбээр хаалга руу яаравчлав.

- Эрхэм ээ, хэрэггүй! гэж бүсгүй түүний араас ухасхийн ДУУДав.

- Зул сар! Зул сар! гэж бараг л гүйх шахам шатаар дээш өгсөх зуур Габриэл хэлнэ.

Түүнийг шатаар өгсч буйг харсан бүсгүй:

- Эрхэм ээ, танд гялайлаа! гэв.

Тэрбээр зочны өрөөний хаалган дээр вальс бүжгийн ая дуусахыг хүлээж, хаалга шүргэх банзал, хөлийн чимээг чих тавин сонсов. Бүсгүйн гэнэтийн бөгөөд ихэд гомдсон хариултад тэр бага зэрэг тээнэгэлзэж байлаа. Түүний сэтгэлд эвгүйхэн тунадас тогтсон тул одоо тэр ярьснаа мартагнаж, зангиа болон ханцуйгаа засав. Дараа нь тэр хантаазныхаа халааснаас бага зэрэг цаасны өөдөс гаргаж ирээд, хундагны үг хэлэхээр бэлтгэсэн тэмдэглэлээ уншив.

Роберт Браунингийн 1 хэлсэн үгнээс тэр ишлэл авахыг хүссэнгүй. Түүнийг сонсох хүмүүст тэр бүхэн арай л ахадмаар байлаа. Үүний оронд Шекспирийн алдарт “Аялгуу”-гаас 2 ямар нэгэн мөрийг сонгож авсан нь дээр биз ээ. Эрэгтэй хүний гутлын өсгийний бүдүүлэгхэн товор товор хийх чимээ, улных нь шүр шүр хийх дуун бусдаас түүнийг илүү хөгжилтэй болохыг сануулна. Хэрэв тэр тэдний ойлгох чадваргүй шүлгээс ишлэл татвал зөвхөн өөрийгөө л эвгүй байдалд оруулна.

Хэт их юм уншсан байдлаараа онгирохыг оролдож байна гэж тэд бодно. Дөнгөж саяхан бүсгүйтэй пинд учирсан шиг тийм л нэгэн алдаа гаргах болно. Тэрбээр өөрт тохироогүй ярианы өнгийг сонгов. Түүний айлдсан үг эхнээсээ аваад дуустал бөөн алдаатай бүтэлгүйтэл



болж хувирав. Энэ үеэр эмэгтэйчүүдийн хувцасны өрөөнөөс түүний нагац эгч нар, эхнэр нь гарч ирэв.

Нагац эгч нарын хувьд тун намхан биетэй, даруухан хувцасласан эмээ нар байлаа. Жулия эгч Кэт эгчээс арай бага зэрэг өндөр болов уу. Чих рүүгээ унжуулсан түүний үс саарал өнгөтэй мэт санагдана; үүний нэгэн адил өргөн, шолхойсон царай нь бас л тийм саарал өнгөтэй ажээ. Хэдийгээр тэр

1 Роберт Браунинг /1812-1889/ XIX зууны сүүлчээр гагцхүү сонгодог хүмүүэт ойлгогдохуйц “хүндхэн” зураач хэмээн тооцогдож байсан Английн яруу найрагч.

2 Томас Мурын “Ирланд аялгуу” хэмээх XX зууны эхээр Ирландад алдаршиж байсан шүлэг. нэлээд тарган эмэгтэй байсан ч сандарсан харц хийгээд амаа ангайсан байдал, одоо тэр хаана байгаа, чингээд юу хийх ёстойг сайн мэдэхгүй байгаа хүмүүний байдлыг санагдуулна.

Кэт эгчийн хувьд арай хөдөлгөөнтэй нэгэн байлаа. Түүний царай эгчийгээ бодвол арай эрүүл байвч яг л хорчийсон улаан алим шиг бүх нүүр нь үрчлээс болсон байх агаад хуучны загвараар үсээ янзалжээ. Габриэлийг тэд тал бүрээс нь үнсэв. Тэрбээр Усан зогсоолын удирдах газрын ажилтан Т.Ж.Конройн эхнэр асан, өдгөө талийгаач болсон тэдний том эгч Эллений хайртай ач хүү байлаа.

- Грэта, таныг Монкстаун руу эргэж ирэхгүйгээс гадна сүйх тэрэг захиалаагүй гэсэн шүү! хэмээн Кэт эгч хэлэв.

- Тийм ээ. Өнгөрсөн удаагийн явдал хангалттай биз дээ? гэж Габриэл эхнэр рүүгээ эргэн харж өгүүлэв.

- Кэт эгч ээ, Грэта тэгэхэд ямар их даарсныг санаж байна уу? Сүйх тэрэгний цонхны шил замын туршид чичирхийлж, Мэррионоор биднийг дайран өнгөрөх зуур дорно зүгийн салхи үлээж билээ. Хэлэх үггүй хөгжилтэй байсан шүү! Грэта арай л үхтлээ ханиад хүрсэнгүй.

Кэт эгч хөмсгөө зангидан түүнийг үг хэлэх бүрийд толгой дохино.

- Габриэлийн зөв. Болгоомжтой байдал хэзээ ч саад болдоггүй юм гэж тэрээр өгүүлнэ.

- Уг нь Грэта гэр рүүгээ явган явчихаж болох байсан. Өвдгөөр татсан цастай байсан ч гагцхүү түүнд явахыг зөвшөөрөөгүй юм гэж Габриэл хэлэв.

Хатагтай Конрой инээд алдав.

- Кэт эгч ээ, түүнийг бүү сонс! гэж тэр хэлэв.

- Үдэш орой Томыг ном уншихдаа малгай өмсч бай гэнэ, Еваг овъёосны зутан идүүлэхийн тулд, дасгал хийхийг түүнээс шаардсан гэнэ хэмээн үргэлж л тэр янз бүрийн юм зохиож байдаг золиг доо. Харин хөөрхий охин түүнийг харахаас дургүй нь хүрнэ... Одоо тэр намайг юу өмс гэж шаардаж байгааг мэдэх үү? Хэзээ ч мэдэхгүй дээ.

Тэрээр тас тас хөхөрч, түүний даашинзнаас царай хийгээд үсийг нь аз жаргалтай харцаар бахдангуй ажиглан зогсох эр нөхөр рүүгээ ширтэв. Габриэлийн халамжтай байдал тэрхүү гэр бүлийн байнгын тоглоом шоглоом болж байдаг тул нагац эгч нар ч мөн сэтгэлээсээ инээд алдацгаав.

- Галош! гэжхатагтай Конрой хэлэв.

-Түүний бодожолсон сүүлчийн арга. Бага зэрэг хүйтэрмэгц би галош өмсөх ёстой. Өнөөдөр ч мөн намайг галош өмсөхийг шаардсан ч би тас гүрийсэн. Удахгүй тэр надад шумбагчийн хослол авч өгөх л дутаад байгаа юм.

Габриэл ууртай ханинээв хийлээд өөрийгөө тайвшруулахын тулд зангиагаа засав. Харин тэрхүү наргиан түүнийг хэт их хөгжөөв үү яав, Кэт авхай элгээ хөштөл инээсээр байлаа. Төдөлгүй Жулия эгчийн нүүрэн дээр инээмсэглэл үгүй болж, түүний царай дээр ямар ч баяр баясгалан үгүй байдал дахин бий болов.

- Габриэл, галош гэж юу юм бэ? гэж тэрээр асуулаа.

- Жулия! Бурхан минь, чи арай галош гэдгийг мэдэхгүй байгаа юм биш биз дээ? Грэта, тэрийг чинь эсгий гутал дээр өмсдөг биз дээ? гэж түүний эгч орь дуу тавин хэлэв.

- Тийм ээ гэж хатагтай Конрой зөвшөөрөнгүй өгүүлэв.

- Гутал дээр өмсдөг тиймэрхүү эд байдаг юм. Одоо бидэнд нэг, нэг хос бий. Эх газар дээр бүгд л түүнийг өмсдөг гэж Габриэл ярьж байсан.

- Тийм ээ, тийм. Эх газар дээр гэж алгуурхан толгой дохих зуур Жулия бувтнав. Габриэл хөмсгөө ширэв татсанаа, нэлээд гомдсон байдалтай,

- Онцын гойд зүйл байхгүй. Гэвч энэ үг түүнд худалдааны захын дуучдыг санагдуулж байгаа тул Гретад инээдтэй байж мэднэ.

- Габриэл, чи сонс! Ингэхэд чи хоноглох буудлынхаа асуудлыг шийдсэн үү? Грэта хэлэхдээ... хэмээн Кэт эгч гэнэт ярианд оролцон сэдвийг өөрчлөв.

- Өрөөний хувьд бүх юм шийдэгдсэн. Би “Грэшэмд” өрөө захиалсан гэж Габриэл хэлэв.

- За тэгвэл болох нь тэр. Үүнээс илүү зүйл юу байх вэ? Грэта, ингэхэд чи хүүхдүүдийнхээ талаар санаа зовохгүй байна уу? гэж Кэт эгч асуув.

- Ганцхан шөнө шүү дээ! гэж хатагтай Конрой өгүүлэв.

- Тэгээд ч Бэсси тэднийг харж хандаж байгаа.

- За тэгвэл сайн байна. Найдвартай асрагчтай байна гэдэг азтай хэрэг шүү! гэж Кэт эгч давтан хэлэв.

- Сүүлийн үед манай Лили юу ч болоод байгаа юм. Тэр охин танихын аргагүй болтол өөрчлөгдөж байна.

Габриэлийг илүү дэлгэрэнгүй зүйл эгчээсээ асууж мэдэхийг завдсан ч өнөөх нь шат руу очиж, доош тонгойх эгчийнхээ араас санаа зовсон байдалтай харж дуугаа хураав.

- Энэ Жулия хаашаа явчихав аа? Надад хэлээд аль? гэж тэрээр нэлээд бачимдсан байдалтай өгүүлэв. -Жулия! Жулия!

Чи хаана байна аа?

Шатаар бууж байсан Жулия эргэж очоод,

- Фрэдди ирчихэж гэж тун товчхон хариулав.

Төгөлдөр хуур дээр тоглож байсан вальсийн ая энэ үеэр өндөрлөж буйг илтгэх мэт нижигнэсэн алга ташилтын чимээ хадав. Зочдын өрөөний хаалга нээгдэж, хэд хэдэн хос гарч ирэв. Кэт авхай Габриэлийг хажуу тийш нь дагуулж очоод,

- Хонгорхон Габриэл минь, чи доош очоод түүнийг ямар байгааг хараад ирээч! Хэрэв тэр халамцуу бол дээш нь оруулах хэрэггүй! шүү гэж чихэнд нь шивнэв

- Бодвол тэр согтуу байгаа биз дээ? Би мэдэрч байна.

Габриэл шатны бариул руу дөхөж чимээ чагнав. Хоёр хүний ярилцаж буй дуун пингээс сонсоно. Дараа нь тэр Фрэдди Мэлинзийн цангинасан инээдийг танив. Габриэл шатны уруу пижигнүүлэн гүйлээ.

- Габриэл энд байгаа нь ямар сайн хэрэг вэ? гэж Кэт авхай хатагтай Конройд хандан өгүүлэв.

- Түүнийг энд байхад би үргэлж тайван байдаг юм. Жулия, чи Дэйли, Паүэр авхай нарыг хоолны өрөөнд оруулж ямар нэгэн юмаар дайлаач! Дэйли авхай, ийм сайхан вальсын аяны чинь төлөө мянгантаа талархаж байна. Таны тоглосон аянд бүжиглэхэд үнэхээр сайхан байсан шүү!

Зочдын өрөөнөөс хатагтайн хамт гарч ирсэн буурал сахал, хөрслөг бор царайтай, өндөр нуруутай нэгэн эр,

- Моркан авхай, биднийг ч бас дайлах юм уу? гэж хэлэв.

- Жулия, ноён Браун, Фэрлинг авхай нар ч бас зоог барих байх гэж Кэт эгч бүгдэд нь хандан өгүүлэв.

- Жулия, Дэйли Паүэр авхай нарыг ч бас хоолны өрөөнд хүргэж өг!

- Харин би хатагтай нарыг халамжилж байя! гэж ноён Браун хэлээд байдгаар нь уруулаа жимийлгэн инээмсэглэхэд, нүүрнийх нь бүхий л үрчлээс тодров.

- Моркан авхай, надад тэд яагаад ингэтлээ их хайртай байдгийг танд би хэлэх үү... Кэт эгчийг холдон одсон учир тэр хэлэх гэсэн үгээажилж гурван хатагтайг дагуулан даруйхан хоолны өрөө тийш зүглэв.

Өрөөний голд залгаа хоёр ширээ зассан байх агаад Жулия эгч манаачийн хамт ширээний бүтээлгийг засна. Лангуун дээр янз бүрийн хоол унд, таваг ба шилэн аяга, овоолж тавьсан хутга, халбага, сэрээ тэргүүтэн өрөөстэй байв. Тэг дөрвөлжин төгөлдөр хуурын таг хаалттай байх хийгээд түүн дээр ч мөн элдэв дээдийн зууш, амттан өрж тавьжээ.

Булангийн арай жижиг лангууны дэргэд хоёр залуу зогсч шар айраг шимнэ. Ноён Браун хатагтай нарыг тийш дагуулж очсоноо:

- Эмэгтэйчүүдэд зориулсан халуун чихэрлэг дарс нэг нэг хундага уухгүй биз? гэж хуурсан янзтай асуув.

Тэд хэзээ ч хатуу юм уудаггүй гэх хариуг сонсуут, тэдэнд зориулж тэр гурван шил нимбэгний ундаа задлав. Дараа нь залуусын нэгнээс зай тавьж өгөхийг хүсээд араас нь лонхтой сархад авч, дөмөгхөн виски өөртөө хундаглав. Эхлээд нэг татсан даруйд залуус түүний зүг хүндэтгэлтэйгээр харцгаав.

- Бурхан өршөөг! гэж тэр инээмсэглэсээр өгүүлэв.

- Эмч надад үүнийг зөвшөөрсөн юм. Үрчгэр царай нь инээх бүрийд улам бүр мушилзаж, тэнд байсан гурван хатагтай ч бүхий л биеэ гунхалзуулж, мөрөө савчуулсаар түүний наргианд хөгжимлөг инээдээр хариу барив.

- Ай даа, ноён Браун иймэрхүү зүйл эмч танд уухыг зөвлөсөн гэдэгт би лав итгэхгүй гэж тэнд байсан хамгийн шударга эмэгтэй өгүүлэв.

Ноён Браун бас дахин нэг балгаснаа:

- Би алдарт Кассиди авхай шиг: “За Мэри Граймс, уумаар байсан ч гэсэн уухгүй байвал шахаж байгаад ч хамаагүй намайг заавал уулга. Яагаад гэвэл би уухыг маш их хүсч байна” гэж хэлсэн үг байдаг юм хэмээн нүүрээ мушилзуулан хэлэв.

Байдгаараа улаа бутарсан нүүрээ тэр тэдний зүг тонгойлгож, Дублины эгэл ард түмний яриаг хүндэлдэг нэгэн шиг хэнд ч хэрэггүй хөвөлдсөн үгсийг айлдана. Хатагтай нар бараг л үгссэн мэт түүний ярьсан зүйлд хариу дуугарсангүй.

Мэри Жэйнийн шавь нарын нэг болох Хэрлан бүсгүй, түүний тоглож байсан тэр аятайхан вальсын ая ямар нэртэй болохыг Дэйлигээс асуув. Харин ноён Браун түүнийг үл анхаарч буйг мэдрээд, яриаг нь сонсч байсан залуусын зүг сурмагхан эргэж харав. Хөх ягаан өнгийн хувцас, улаан нүүртэй залуухан эмэгтэй өрөөнд орж ирмэгц:

- Кадриль! Кадриль! гэж алга ташин хашгирав. Түүний араас мөр даган Кэт эгч яаравчилж,

- Мэри Жэйн, хоёр эр ба гурван хатагтай! гэж хашгирна.

- Энэ үед л ноён Бэргин, Кэрриган нар гарч ирнэ шүү дээ! гэж Мэри Жэйн хэлэв.

- Ноён Кэрриган, та Паүэр авхайг урина шүү! Фэрлон авхай, ноён Бэргиныг танд санал болгохыг зөвшөөрнө үү! Одоо бүх юм болж байна.

- Мэри Жэйн, гурван хатагтайг гэж Кэт эгч хэлэв. Залуус бүсгүйчүүдэд хандан бүжиглэх зөвшөөрөл хүсэхэд, Мэри Жэйн Дэйли авхайд хандан:

- Дэйли, та ганцхан удаа тус болооч! Та сүүлчийн хоёр бүжгийн аяыг тоглосон... Гэвч өнөөдөр манайд маш цөөхөн эмэгтэй байна.

- Моркан авхай, та санаа зоволтгүй. Надад татгалзах зүйл алга. Танд зориулж ч бас ая дууныхаа дээжийг өргөх байх шүү! бас зориулж цээл хоолойт дуучин ноён Бартэллд 'Арси хэмээх тун сонирхолтой залуу бий. Удахгүй тэр дуулж өгөх болно. Дүблин даяар түүнийг шүтэн биширч байна.

- Тун гайхашигтай хоолой! гэж Кэт эгч хэлэв.

Төгөлдөр хуурч хоёр ч удаа оршил хэсгийг эхэлсэн ч Мэри Жэйн шинээр тодорсон бүжигчдийг яаравчлан авч одов. Тэднийг дөнгөж гармагц, хэн нэгнийг мөрөн дээгүүрээ харсаар Жулия эгч өрөөнд орж ирэв.

- Жулия! Яасан бэ? Чамтай хамт хэн байгаа юм? гэж Кэт эгч эмээсэн дуугаар асуув.

Энгэртээ бөөн цаасан алчуур тэвэрчихсэн эгч рүүгээ эргэж харснаа, тэр ихэд хайнгадуухан:

- Тийм ээ, энэ бол Габриэл, Фрэдди хоёр гэж хэлэв. Үнэн хэрэгтээ Жулиягийн ард, Фрэдди Мэлинзийг шат өөд чирч яваа Габриэлийн царай үзэгдэв.

Чирүүлж яваа нөхөр нь дөч орчим настай, бие хаа, өндөр намаараа Габриэлтэй төстэй авч гагцхүү налуу мөртэй ажээ. Тэрбээр хавагнасан, шороон царайтай байхаас гадна чихнийх нь омог, балин хамрынх нь нүх хүрэнтэж үзэгдэнэ. Мохоо хамар, шалчгар налуу дух, чийглэг цорвогор уруул, эв хавгүй төрх бүхий хүндхэн хөмсөг доорхи нүд хийгээд сэглэгэр үс нь нойрмог байдлыг илтгэнэ. Шатаар өгсөх зуур тэр зүүн гараараа үргэлжид зүүн нүдээ нухаж байхдаа л Габриэлд ярьж эхэлсэн ямар нэгэн онигоог эргэж санаад цангинасан дуугаар чанга чанга инээж гарав.

- Фрэдди, оройн мэнд! Гэж Жулия эгч хэлэв. Фрэдди Мэлинз Моркан авхай нартай мэндлээд, лангууны дэргэд зогсох ноён Брауныг түүн рүү нүд ирмэж буйг олж харуут хөнгөхөн алхаагаа түүн рүү чиглүүлж, дөнгөж саяхан Габриэлд ярьж өгч байсан онигоогоо хагас өнгөөр дахин ярьж гарав.

- Тэр давгүй байна уу? гэж Кэт эгч Габриэлээс асуув.

Габриэл асуулт сонсмогц, гэнэтхэн түүний царай хувьсхийж,

- Зүгээр ээ, бараг юу ч мэдэгдэхгүй байна гэв.

- Энэ ч аймшигийн амьтан даа! гэж Кэт эгч хэлэв.

- Дөнгөж саяхан, шинэ жилийн өмнөхөн л архиа гудрахаа болино гэж эхдээ ам өгч байсан хүн. Габриэл, зочдын өрөөнд орцгооё! Өрөөнөөс гарахаас өмнө тэр хөмсгөө зангидаж ноён Брауны зүг харснаа, долоовор хуруугаа гозолзуулан сануулга өгөв.

Ноён Браун хариуд нь толгой дохиж, түүнийг гаруут,

- За Тэдди минь, одоо сэргэхийн тулд хүйтэн ундаа уух хэрэгтэй! гэж Фрэдди Мэлинзэд өгүүлэв.

Хамгийн сонирхолтой хэсгийг нь ярьж байсан Фрэдди Мэлинз тэсвэр алдан гараараа зангав. Гэвч ноён Браун түүний өмдний дэлгүүр онгорхой байгааг анзаармагц, дараа нь түүнд шилэн аяга дүүрэн нимбэгний ундаа хийж өгөв.

Фрэдди Мэлинзийн зүүн гар тэр даруй шилэн аягыг барьж авуут баруун гараараа өмссөн хувцсаа цэгцлэв. Нэлээд халамцсан ноён Браун байдгаараа мушилзан өөртөө виски хийх үед, онигоогоо ярьж дуусаагүй байсан Фрэдди Мэлинз хэдэнтээ бөгшүүлж ханиалгаснаа байдгаараа инээд алдав. Мэлтэлзтэл хийсэн шилэн аягатай ундаагаа тэр ширээн дээр тавьж, зүүн нүдээ зүүн гараараа нухаж гарав.

Нүдээ нухах үедээ тэр сүүлчийн хэлсэн үгээ давтан өгүүлэх зуур, инээдээ барьж ядан амьсгаадсаар байлаа.

Нам гүм байсан зочны өрөөний өмнө Мэри Жэйний дэглэсэн нэлээд хүндхэн зураглал дүүрэн мэргэжлийн жүжгийг Габриэл хүссэн, хүсээгүй ч сонсоход хүрэв. Тэрбээр хөгжимд дуртай байсан авч түүний тоглосон зүйлээс ямар ч аялгуу олж сонсоогүйдээ тун их эмзэглэв. Мэри Жэйнээс ямар нэгэн ая тоглож өгөхийг дэргэд байгаа хүмүүс хүссэн ч тэрээр ойлгохын аргагүй юм тоглосон нь энэ ажээ. Хоолны өрөөнөөс гарч ирсэн дөрвөн залуу төгөлдөр хуурнаас гарах аялгууг зочны өрөөний хаалган дээр чих тавин сонсч түр саатсан авч, хэсэг хормын дараа ар араасаа чимээгүйхэн цувран явж одоцгоов. Тэрхүү аялгууг гар нь даруул дээр гүйж асан Мэри Жэйн гагцхүү өөрөө л сонсч буй мэт санагдаж байсан бөгөөд хэн нэгэн хүмүүнд бөөгийн хараалыг илгээх мэт гараа дээш өргөн, түр завсарлага авах зуур, дэргэд нь зогсох Кэт эгч л түүний тоглох дэмжин сонсч, ноотных нь хуудсыг эргүүлж байлаа.

Хүндхэн гэрлийн бүрхүүл доорх гялалзтал лаагаар өнгөлсөн зүлгэсэн шал руу харахаас, залхсандаа ч тэр үү, Габриэлийн нүд төгөлдөр хуурын ард талын ханан дээгүүр гүйнэ. Тэнд “Ромео ба Жульетта” дуурийн тагтан дээр зогсч буй хэсгийг дүрсэлсэн уран зураг өлгөөстэй байна.

Харин дэргэд нь улаан, цэнхэр, хүрэн ноосон утсаар нэхсэн хивсэнцэр байх агаад түүн дээр дүрсэлсэн Таүүрт1 бүрлэгдсэн бяцхан хунтайж нарыг Жулия эгч жаахан охин байхдаа л оёж1 Английн ван III Ричард /1453-1485/ өөрийн ах IV Эдуардын хөвгүүдийг хаан суудалд суухад нь саад болсон учир алах тушаал өгчээ хатгасан гэдэг. Эгч, дүүсийн хүүхэд ахуй цагт сурч байсан сургуульд бүтэн жилийн турш тиймэрхүү уран үйлд сургадаг байсан биз ээ. Түүний эх урьд өмнө төрсөн өдөрт нь зориулж дугуй шилэн товч, хүрэн торгон оруулгатай хантааз оёж

бэлэг болгон барьж байжээ. Хэдийгээр Кэт эгч түүнийг Морканы гэр бүлээс төрсөн суут ухаантан хэмээн үргэлж нэрлэдэг байсан ч эх нь ямар ч хөгжмийн авьяасгүй байсан явдал ихээхэн гайхшрал төрүүлнэ. Тиймээс Жулия эгч болон тэр хоёр олонд нэр хүндтэй том эгчээрээ бахархаж байсан мэт санагдана. Түүний гэрэл зураг толины тавиур дээр байна. Өвдгөн дээрээ тэр нээлттэй ном барьж байх агаад хөл дор хэвтэх Константинд ямар нэгэн юм зааж харуулна.

Хөвгүүддээ тэр өөрөө нэр хайрлажээ. Гэр бүлийнхээ нэр хүндийг тэр ихэд боддог нэгэн байв. Түүний ачаар Константин<sup>1</sup> одоо Балбригэны ламтан болсон бөгөөд түүний хүчинд Габриэл Вангийн их сургуулийг<sup>2</sup> дүүргэжээ. Габриэлийн гэрлэлтэд тэр шуудхан хориг тавьж байсныг санахуйд царай нь хувьсхийв. Түүний хэлсэн цөөн хэдэн гомдлын үгс эдүгээ болтол тарчлаана; нэгэн удаа тэр “Грэта бол тосгоны зальжин охин” гэж хэлсэн нь худал болж таарав.

Грэта түүний Монкстаун дахь гэрт удаан хугацаанд өвдөх үед нь асарч, тойлж байсан билээ. Мэри Жэйний тоглож байсан ая дуусах дөхөж байсан тул эдүгээ эхлэл хэсгийн сэдвийг хэмнэл бүрийн ард дахин давгаж байлаа; тоглож дуусахыг нь хүлээж байх зуур дайсагнасан мэдрэхүй үгүй болсон ажээ.

1 Ламтан Захарийд Иоанн хүүг төрсөн тухай мэдээлсэн тэнгэрийн их элч Гаврилын гэгээн дурсгалд зориулж Габриэл хэмээн нэрийджээ. Константин гэдэг нь хатуу, тогтвортой гэсэн латин үг юм.

2 Дублины их сургуулийн коллежийг хэлж байна

Тэрхүү ая дээд өнгөн дээр дуусав. Түүнийг байдгаараа улайчихсан, ноотоо хуйлан, зочдын өрөөнөөс шурхийн гарах үед, бусдаас илүү дөрвөн залуу алга ташиж байсан бөгөөд нижигнэсэн алга ташилт Мэри Жэйнийг үдэв. Тоглолт эхлэхэд хоолны өрөө рүү явсан ч төгөлдөр хуурын эгшиглэх чимээ үгүй болмогц, тэд эргэн иржхаалган дээр зогсоцгоов. Лансье<sup>1</sup> бүжиг эхлэв.

Габриэл, Айворз авхайн хамт нэг хос болов. Тэрээр шийдэмгий хөдөлгөөнтэй, нэлээд яриасаг, залуухан эмэгтэй байлаа; хонин бор нүдтэй, хамаг нүүр нь сэвхтэй нэгэн аж. Айворз авхай задгай даашинзтай байгаагүйгээс гадна Ирландын бэлгэ тэмдэг<sup>2</sup> бүхий цамцны заханд нь томхон гоёлын зүү хатгаастай байв.

Тэднийг байраа эзлэх үед,

- Тантай би маргалдмаар байна! гэж тэрээр гэнэтхэн хэлэв.

- Надтай юу? гэж Габриэл гайхшрангуй асуув.

Тэрээр ширэв татан толгой дохино.

- Юунаас болж тэр вэ? гэж Габриэл инээмсэглэн асуув.

- Тэр Г.К. гэдэг чинь хэн юм бэ? гэж түүний царай руу ширтэх зуур Айворз авхай асуув.

Габриэл байдгаараа улайж, хөмсгөө өргөх гэсэн ч юу болж байгааг ер ойлгосонгүй.

- Ёстой гэмгүй царайлж байх шив дээ. Та чинь “Daily Express”-т зориулж юм бичдэг биз дээ? Ичихгүй байна уу? гэж дахин тэр хатгав.

1 Кадриль бүжгийн эртний хэлбэр.

2 Айворз авхай Ирландын Сэргэн мандлын талыг баримтлагч нэгэн байв.

- Яахлээрээ би ичдэг билээ? гэж Габриэл инээхчээн аядан өгүүлэв.

- Таны өмнөөс би ичиж байна! Ийм сонинд юм бичих ч гэж дээ. Таныг би Английг шүтэн бишрэгч гэж бодоогүй шүү! хэмээн Айворз авхай эрсхэн өгүүлэв.

Габриэлийн царай дээр гайхширсан байдал бий болов. Тэр үнэхээр “Daily Express”-ийн лхагва гарагийн дугаар бүрт утга зохиолын тойм бичиж өгөөд, шагналд нь арван таван шиллинг авдаг байжээ. Гэвч үүнээс болж түүнийг Английг шүтэн бишрэгч хэмээн тооцож болохгүй билээ. Мөн чанартаа тэр өчүүхэн төдий шагналаас илүү, түүнд хянуулахаар илгээж байсан номын эхэд юунаас илүү баярладаг байжээ.

Дөнгөж саяхан шинээр хэвлэсэн номын хуудас, хавтас сэлтийг нь барьж үзнэ гэдэг түүний дуртай ажлын нэг. Бараг л өдөр бүр коллежийн хичээл тарсаны дараа тэр голын эрэг дээрх Бечелор Уокийн Хикки юм уу, Үэбб, Астона голын эрэг дээрх Мэсси юм уу, 0'Клоиссийн нарийн гудамж дахь хуучин номын дэлгүүрээр орох дуртай байв.

Юунаас болж тэр дургүйцсэнийг нь ер ойлгосонгүй. Утга зохиол гэдэгс улс төрөөс илүү зүйл болохыг түүнд хэлэхийг хүсэв. Гэвч тэд эртний анд нөхөд байсан бөгөөд хамтдаа их сургуул ьд сурч, дараа нь хоёул багшилж байжээ; тиймээс түүнийг ийнхүү хэлэхэд нь тэр тун их гайхаж байв. Тэрбээр байдгаараа нүд ирмэж, инээхийг оролдож байсан ч улс төр, номын талаар санал шүүмжлэл бичихийн хооронд ямар ч холбоос байхгүй гэж эцэс сүүлд нь тун ойлгомжгүйхэн бувгнав.

Тэд дахин бүжиглэх үедээ учирмагц, тэр улам бүр гайхширч яахаа мэдэхгүй байв. Айворз авхай түүний гарыг авч дулаан гартаа атгаад,

- Одоо болно, би тоглосон юм. Хурдлаарай! Одоо хоёр тийш болох ёстой шүү! гэж тун зөөлөн, нөхөрсөг өнгөөр хэлэв. Тэд дахин учирмагц, тэрээр Их сургуулийн асуудлын 1 талаар ярьж гарахад, Габриэл өөрийгөө арай илүү эрх чөлөөтэй мэт мэдрэв. Найз нарынх нь Габриэлийн бичсэн Браунингийн шүлгийн талаарх шүүмжийг түүнд үзүүлсэн ажээ. Ингээд л тэр түүний нууцыг мэдсэн юмсанж; тэрхүү шүүмж Айворз авхайд ихэд таалагдсан байна.

- Тийм ээ, ингэхэд ноён Конрой та энэ зун Араны арлууд 2 руу аялал хийхгүй юм уу? Бид бүтэн сарын турш аялах болно. Задгай далайд гарахад ямар сайхан гээч! Та заавал явах хэрэгтэй. Ноён Клэнси, ноён Килкэлли мөн Кэтлин, Карни 3 нар явна. Грэта ч бас явбал



зүгээр байх. Тэр Коннахтынх4 байх аа?

- Тийм ээ, тэр тэндхийнх гэж Габриэл дурамжхан өгүүлэв.

- Тэгвэл явна гэж шийдэх үү? хэмээн түүний гарыг өөрийн дулаахан гараар атгах зуур Айворз авхай хэлэв.

- Уг нь би нэг тийшээ явахаар шийдчихсэн байсан юм! гэж Габриэл яриагаа эхлэв.

- Хаашаа тэр вэ? хэмээн Айворз авхай асуув.

- Жил бүр би хэдэн нөхдийн хамт унадаг дугуйгаар аялал хийдэг юм...

1 Англи ба Ирландын протестант, католик шашинтнуудын боловсролыг тэгшитгэх оролдлого хийсний улмаас буй болсон зөрчилдөөнийг хэлж байна

2 Ирландын баруун эргийн бүлэг арал. Ирландын Сэргэн мандлын талыг баримтлагчид өөрсдийн зохиол бүтээлд эдгээр арлын байгаль, тариачдынх нь амьдралын хэв маягийг магтан дуулдаг байжээ.

3 “Эх” өгуүллэгийн дүр

4 Ирландын баруун зүгт оршдог дөрвөн тосгоны нэг

- Хаашаа тэр вэ? гэж Айворз авхай лавлан асууна.

- Франц юм уу, Бельги, заримдаа Германаар гол төлөв аялдаг юм гэж Габриэл ичингүйрэн хэлэв.

- Та яах гэж Франц, Бельгид аялдаг юм бэ? Түүний оронд эх орноо сайн судлах хэрэгтэй шүү дээ гэж Айворз авхай омогтойхон өгүүлэв.

- Зарим талдаа хэл сурах шаардлага байна. Нөгөөтэйгүүр, орчноо сольж байх хэрэгтэй гэж Габриэл хэлэв.

- Тэгвэл та төрөлх ирланд хэлээ судлах шаардлагагүй гэж үү? хэмээн Айворз авхай байцааж гарав.

- Хэрэв тийм зүйл ярих гэж байгаа бол гэль хэл миний төрөлх хэл биш.

Хажуу дахь хос энэхүү байцаалтад чих тавьж эхлэв. Габриэл санаа зовсон байдалтай хоёр тийш харснаа, биеэ барихыг хичээсэн авч дух нь байдгаараа улайж эхлэв.

- Та эх орноо гүн гүнзгий судлахыг хүсэхгүй байна гэж үү? хэмээн Айворз авхай яриагаа үргэлжлүүлэв.

- Та чинь өөрийн эх орон, ард түмнээ нэг их сайн мэдэхгүй биз дээ?

- Үнэнийг хэлэхэд эх орноосоо би үнэхээр их залгаж байна.

- Яагаад тэр билээ? гэж Айворз авхай асуув.

Хэлсэн үгэндээ дэндүү их сэтгэл хөдөлсөндөө ч тэр үү Габриэл юу ч хариулсангүй.

- Яагаад тэр вэ? гэж Айворз авхай дахин шалгаана.

- Хатагтай нараа солих цаг болжээ! хэмээн Габриэлийг хэлэхэд

- Мэдээж хэрэг танд хэлэх юм олдохгүй байгаа биз? гэж

Айворз авхай түс тас буулгав.

Сэтгэлийнхээ хөдөлгөөнийг нуухын тулд Габриэл эгэл бус идэвх зүтгэл гарган бүжиглэж гарав. Айворз авхайн царайнаас бачимдсан байдлыг нь мэдэрмэгц, түүнтэй харц тулгарахаас зайлсхийв. Гэвч нийтийн хүрээнд тэд дахин учирмагц түүний гараас тэр тун чангахан атгаж буйг мэдрэв. Нэгэн мөчид тэрээр Габриэлийг инээмсэглэтэл тун зальжин харав. Дараа нь тэрхүү цуваа дахин хөдөлгөөнд ормогц тэр өлмий дээрээ зогсч,

- Муу Английг шүтэгч! хэмээн чихэнд нь шивнэв.

Лансье бүжиг дуусмагц Фрэдди Мэлинзийн эхийн сууж байгаа тэртээх булан руу Габриэл очив. Тэр бол тарган, байдгаараа бууралтсан үстэй, өвчтэй эмгэн байлаа. Хүүгийн нэгэн адил тэрээр мөн гацаж ярих аж. Фрэддийг энд байгаа тухай, түүнийг бараг эрүүл шахуу байгааг аль хэдийнэ дуулгажээ. Хөлөг онгоц дээр дажгүй явж ирсэн эсэх талаар Габриэл түүнээс асуув. Тэрээр Глазго дахь хүргэнийдээ амьдарч байгаа агаад жил бүр Дүблинд зочлохоор ирдэг байна. Хөлгийн ахмад түүнд ихээхэн анхаарал тавьж, сайнгүй явж ирлээ гэж тэрээр аядуухан дуугаар хариулав. Үүнээс гадна Глазго дахь охиныхоо гэрт тун сайхан амьдарч байгаа тухайгаа өгүүлж, олон арван танилтай болсноо ч бас дуулгав.

Түүнийг ярих зуур Габриэл, Айворз авхайтай өрнүүлсэн эвгүйхэн яриагаа мартахыг хичээнэ. Мэдээж хэрэг тэр бахархмаар бүсгүй юм уу, эмэгтэй байх. Гэхдээ л бүх зүйлд өөрийн гэсэн хэм хэмжээ гэж бий. Түүнд тэгж хариулах шаардлага байгаагүй ч байж мэднэ. Гэвч тэрээр тоглоом шоглоомоор ч гэсэн түүнийг олон нийтийн өмнө, Английг шүтэгч хэмээн хэлэх хэрэггүй байсан юм. Түүнээс тэр баахан юм байцааж, бүжингийн нүдээр цоо ширтэж байхдаа, олны өмнө түүнийг шившигтэй байдалд оруулахыг хүсчээ.

Бүжиглэж буй хосуудын дундуур эхнэр нь түүн рүү ирж буйг тэр олж харав. Тэрээр түүн дээр дөхөж ирмэгц,

- Габриэл! Чамайг урьдын адил шарсан галуугаа хөндөх юм уу? гэж Кэт эгч асууж байна. Дэйли авхай гуяны махыг зүсч, харин би цэлцэгнүүрийг нь хариуцахаар боллоо гэв.

- За тэгье! гэж Габриэл уриалагхан хэлэв.

Залуусыг эртхэн оройн зоог барихаар зохион байгуулснаар

бид үеийнхээ нөхдийн хамт байх болно гэж түүний эхнэр хэллээ.

- Чи бүжиглэв үү? гэж Габриэл асуув.

- Тэгэлгүй яахав. Чи намайг арай хараагүй юм биш биз? Юунаас болж чи Молли Айворзтой маргалдсан юм бэ?

- Маргалдана гэж бодоогүй. Чи яагаад тэгж бодох болов? Эсвэл тэр хэлсэн юм уу?

- Тийм ээ. Тиймэрхүү утгатай зүйл хэлсэн. Би тэр ноён д'Арсийг дуулж өгөөч гэж ятгаж байна. Үнэд ороод хэцүү юм

- Бид ерөөсөө маргалдаагүй. Хамгийн гол нь тэр намайг Баруун Ирланд руу аялахыг ятгасан юм. Харин би татгалзсан гэж Габриэл эгдүүцсэн дуугаар хэлэв.

Түүний эхнэр баярласандаа ч тэр үү, алгаа хавсарч алгадаад хөнгөхөн үсрэв.

- Габриэл! Явья л даа! Голуэйд би дахин очмоор байна! гэж тэр хөл нь газар хүрэхгүй өгүүлэв.

- Явмаар байгаа бол чи яв! гэж Габриэл хүйтнээр хариулав.

Хэсэг зуур тэр түүн рүү ширтэж байснаа, дараа нь хатагтай Мэлинз рүү эргэн харж,

- Хатагтай Мэлинз, манай нөхөр тун их халамжтай байгаа биз? гэж хэлэв.

Тэрээр яаралгүйхэн явж одоход, хатагтай Мэлинз ямар ч завсарлагагүйгээр, Шотландад ямар сайхан үзэсгэлэнт газарууд байдаг талаар түүнд үргэлжлүүлэн ярьсаар байлаа. Түүний хүргэн жил бүр тэднийг нуур руу аваачиж загас барьдаг гэнэ. Хүргэн хүү биширмээр загасчин аж. Нэгэн удаа тэр тун гайхамшигтай загас барьж, зочид буудлын тогооч түүнийг нь оройн зоог дээр шарж өгсөн гэнэ.

Түүний ярьж байгаа зүйлийг Габриэл дуртай дургүй сонсоно. Харин одоо үдийн зоог барихад тун бага хугацаа үлдсэн байх тул тэрбээр өөрийн хэлэх үг болон Браунингийн шүлгээс авсан ишлэлийн талаар эргэцүүлэн бодов. Фрэдди Мэлинзийг эх рүүгээ очиж байгааг харуут, түүнд тэр байраа тавьж өгөхөөр цонхны шагайвар руу оров. Өрөөнд бараг хүнгүй болж, хоолны өрөөнөөс хутга, тавагны харших чимээ сонсдож эхлэв.

Зочдын өрөөнд үлдсэн хүмүүс бүжиглэхээсээ залхаж, хэсэг бүлгээрээ шивэр авир ярилцана. Габриэлийн бүлээхэн, чичирхийлсэн хуруунууд цонхны хүйтэн шилэн дээр зөөлөн бөмбөрдөв. Гудамжинд бодвол тун сайхан байгаа даа. Голын эрэг дагуу ганцаар алхаж, дараа нь цэцэрлэгт хүрээлэнгээр явбал мөн ч сайхан байх буй заа. Моддын мөчирс тэр чигээрээ цасанд дарагдаж, Вэллингтоныг хөшөө ч мөн цасан цагаанг Фэниксийн цэцэрлэгт хүрээлэнгийн баруун хаалган дээр Вэллингтонд зориулсан хөшөө байдаг юм. Хэдийгээр Вэллингтон /1763-1852/ Ирланд үндэстэн байсан ч тухайн үед түүнийг Английн эрхшээлд орсон бэлгэ тэмдэг мэт үздэг байжээ.

Малгай духдуулжээ. Ширээний ард зочидтой хамт байснаас илүү сайхан байхсан биз ээ.

Ирландын зочломтгой чанар, гунигт дурсамжууд, гурван од, Парис, Браунингийн шүлгээс авсан ишлэл зэрэг өөрийн хэлэх үгний гол санаануудыг тэр хурдхан гүйлгэж харав. Тэрбээр өөрийн бичсэн шүүмж болох “Бодол санаагаар идэгдсэн хөгжмийг чи сонсч байна уу?” гэх хэсгээс дотроо давтан өгүүлэв.

Айворз авхай түүний бичсэн шүүмжийг ихэд сайшаав. Чин сэтгэлээсээ юу, эсвэл үгүй юу? Бүү мэд. Эдгээр олон үгнээс гадна ямар нэгэн хувийн амьдрал гэж байгаа болов уу? Энэ үдшийг болтол тэд хэзээ ч маргалдаж байсангүй. Түүний зүг тэр тохуурхсан харцаар харж, нэгэн ширээний ард үдийн зоог барина гэдэг тун эвгүйхэн санагдана.

Габриэлийг эвгүй байдалд орвол тэр баярлах болно. Гэнэт түүний толгойд өөрийг нь зоригжуулсан бодол зурсхийн орж ирэв. Тэрбээр Кэт, Жулия эгч нарт хандаж, “Ноёд, хагагтай нар аа! Биднээс холдон одож буй үеийнхэн бол мэдээж хэрэг, өөрийн сайн, муу талтай байсан ч миний бодлоор тэд зочломтгой, хошин шогийн торгон мэдрэмжтэй, эдүгээ үеийн зарим нэгэн хэт боловсролтой хүмүүст дутагдаж байж мэдэх хүн чанартай тийм л буянтнууд байсан юм” гэж айлдах болно.

Маш сайн хэрэг. Энэ бол Айворз авхайд зориулан шидэх чулуу. Мөн чанартаа түүний эгч нар бүдүүлэг эмээ нар байсан ч хэргийн гол нь энэ гэж үү? Зочны өрөөн дахь дуу чимээ түүний анхаарлыг татав. Ноён Браун, Жулия эгчийг хөтөлж хаалганы тэндээс ирж яваа харагдана. Ганц нэг сулхан алга ташилт төгөлдөр хуур руу тэднийг очих хүртэл үргэлжилсэн агаад Мэри Жэйнийг сандал дээр суумагц нам гүм болов. Харин Жулия эгч өөрийн дуу хоолойг улам илүү чанга сонсдоосой гэсэндээ зогсч буй байрлалаа бага зэрэг өөрчилж огт инээлгүй дэргэд нь зогсоно.

Габриэл ямар тоглолт болохыг шуудхан ойлгов. Энэ бол Жулия эгчийн байнга дуулж байдаг “Хуримын өмсгөлтэй байхад минь”<sup>1</sup> гэх хуучны дуу юм. Түүний хүчтэй, цэвэр хоолой тэрхүү аялгуутай яв цав тохирч, хүнд хэцүү хэсгийг нь бахдам сайхан авч арай л түргэн хэмнэлтэй дуулж байсан ч хөг аян дээр тэр алдаа гаргасангүй.

Тэрхүү дуучны царай руу хараагүйсэн бол, өөртөө нэлээд итгэлтэй, дээд өнгийг тун сайн эзэмшсэн хоолойг мэдэрч болохоор байлаа. Түүнийг дуулж дуусмагц, бусдын адил Габриэл алга нижигнүүлэн ташиж, тэртээх хоолны өрөөнд байсан сонсогчдод ч мөн нижигнэсэн алга ташилтын чимээ хүрсэн ажээ. Чин сэтгэлийн алга ташилт нижигнэж гармагц хуучирсан ноотны дэвтрээ тэр тавиур дээр тавихаар тонгойх үед Жулия эгчийн нүүрэн дээр хөнгөн улаа бутарчээ.

Фрэдди Мэлинз энэ бүхнийг улам сайн сонсохыг хичээн толгойгоо гилжийлгэн зогсч үргэлжлүүлэн алгаа таших зуур ямар нэгэн зүйл эхдээ хандаж өгүүлнэ. Эцэст нь тэр алга таших тэнхээгүй болсон уу, яасан Жулия эгчийн зүг яаравчлан гүйж очоод, хоёр гараараа гарыг нь атгаж, хэлэх үгээ олж ядан сэгсэрч гарав.

- Урьд өмнө таныг би ийм сайхан дуулж байсныг сонсч байгаагүй юм байна гэж би дөнгөж сая ээждээ хэллээ хэмээн<sup>1</sup> Винчэнцо Бэллинийн /1802-1835/ “Пүританчууд” хэмээх дуурийн

арийн хэсэг. тэрбээр өгүүлэв.

- Ямар сайхан ая вэ? Хэлэх ч үг алга... Хэзээ ч ийм юм сонсч байсангүй. Юу гэнэ ээ? Итгэхгүй байна уу? Ёстой үнэн шүү. Танд би андгайлъя! Тийм цэвэрхэн, тийм шинэлэг... Ийм юм хаана ч байхгүй!

Жулия эгч байдгаараа инээмсэглэж, түүний хэлсэн магтаалын талаар ямар нэгэн зүйл бувтнаад, гараа эвтэйхэн сугалж авав.

Ноён Браун тэнд байсан хүмүүст хандаж, байгалийн ямар нэгэн гайхамшигт бүтээлийг танилцуулах гэж буй мэт,

- Миний сүүлчийн нээлт бол Жулия Моркан авхай гэж хэлэв.

Тэрбээр өөрийнхөө хошигнолд бас элгээ хөштөл инээх үед Фрэдди Мэлинз түүн рүү эргэн харснаа:

- Иймэрхүү азтай нээлт байнга танайд тохиолдохгүй шүү гэдгийг ноён Браун танд хэлэхийг хүсч байна. Энэ олон жилийн хугацаанд түүнийг ингэж сайхан дуулахыг би хэзээ ч сонсч байгаагүй гэдгээ хэлж чадна. Энэ бол туйлын үнэн.

- Би ч бас сонсч байгаагүй. Түүний дуу хоолой урьдынхаасаа илүү сайн болсон байна гэхэд Жулия эгч мөрөө хавчин, ямар нэгэн бахархсан шинжгүй,

- Гучин жилийн тэртээд би муугүй л хоолойтой байсан гэв.

- Тэр найрал дуунд дэмий л цагаа алдаж байна даа гэж Жулияд би үргэлж хэлдэг юм. Намайг тэр ямар сонсох биш дээ хэмээн Кэт эгч хатуухан өгүүлэв.

Тэрээр ямар нэгэн хүүхдийн талаар маргалдах гэж буй хүн шиг зочид руу эргэн харав. Харин Жулия эгч урд байснаа л харж байв. Түүний царай дээр инээмсэглэл тодорч буйгаас харвал тэрээр залуу насаа дурсч байгаа ажээ.

- Тийм ээ, тэр хэний ч үгийг сонсохгүй. Өглөөнөөс орой болтол тэр найрал дуутайгаа л тарчлах юм даа. Тэр ч бүү хэл, шөнө дөлөөр ч мөн адил гэж Кэт эгч яриагаа үргэлжлүүлэв.

- Зул сарын эхний өдөр өглөөний зургаан цагаас эхэлж байна гээд та нар бодоод үз дээ. Энэ ер нь хэнд хэрэгтэй юм бэ? хэмээн дахин хэллээ.

- Кэт эгч ээ, Бурхан тэнгэрт сайн үйл хийхийн төлөө. Тийм биш гэж үү? хэмээн сандал дээрээ бүтэн эргэх зуур Мэри Жэйн инээмсэглэсээр өгүүлэв.

- Мэри Жэйн. Энэ чинь тун сайн хэрэг. Бурхан тэнгэрийн төлөө зүтгэлгүй яахав дээ. Үүнийг би өөрөө ч сайн мэдэж байна гэж Кэт эгч ач охиндоо хандан ууртайхан өгүүлэв.

- Сүмийн найрал дуунаас эмэгтэйчүүдийг хөөх явдал Пап ламд ямар ч сайн нэрийг авчрахгүй. Угтаа тэд бүхий л амьдралаа энэ үйл хэрэгтээ зориулсан хүмүүс юм шүү дээ. Бас

тэгээд угжнаасаа салаагүй банди нарыг тэднээс илүүд үзэхийг нь яана. Пап лам ингэж шийдсэн л бол, энэ нь сүмийн буяны төлөөх ариун үйл гэж ойлгох хэрэгтэй. Мэри Жэйн. Гэхдээ энэ бол шударга бус явдал. Энэ бол тун буруу зүйл гэлээ.

Тэрээр байдгаараа уурлаж, эгчийгээ өмөөрөхийн тулд хэдэн ч цаг хамаагүй ярьж мэдэхээр байлаа. Учир нь энэ түүний хөндүүр сэдэв юм. Гэвч Мэри Жэйн бүх бүжигчдийг зочны өрөөнд эргэн ирж буйг харснаа:

- Кэт эгч ээ, та шашин шүтдэггүй ноён Брауны толгойг эргүүлж байна шүү гэв.

Кэт эгч ноён Браун руу эргэн харж, түүний шашин шүтлэгийн хандлагыг сануулсан тул дотроо ямар нэгэн зүйлийг эргэцүүлэн бодсоноо:

- Пап ламын зөв гэдэгт эргэлзэж байна гэж бүү бодоорой! Би бол зүгээр л тэнэг эмгэн. Хэзээ ч тийм зүйл хийхгүй байсан. Гэхдээ л энэ ертөнц дээр эгэл жирийн хүндлэл хийгээд талархал гэсэн ойлголтууд байсаар л байна. Би Жулиягийн оронд байсан бол Эцэг Хилид энэ талаар шуудхан мэдэгдэх байсан...

- Кэт эгч ээ, үүнээс гадна тэд хоол идэхийг хүсч байна. Харин хүмүүс хоол идэхийг хүсч байгаа цагт маш хурдан хэрүүл маргаан өрнүүлдэг юм гэж Мэри Жэйн хэлэв.

- Хүмүүс юм уухыг хүссэн үедээ ч гэсэн хурдан хэрэлдэхэд хүрдэг юм гэж ноён Браун ёжтойхон нэмж өгүүлэв.

- Тиймээс эхлээд оройн хоолоо идэцгээе. Харин дараа нь наад маргааныг чинь үргэлжлүүлбэ гэж Мэри Жэйн хэлэв.

Зочдын өрөөний хаалган дээр Габриэл өөрийн эхнэр Мэри Жэйн нартай тулгарав. Тэд Айворз авхайгаас хамтдаа зоог барихыг хүсч, ятгаж байсан ажээ. Гэвч Айворз авхай малгай, хүрмээ өмсчихсөн байсан тул үлдэхийг хүссэнгүй. Тэрбээр юу ч идэхийг хүсэхгүй байна гээд нэлээдгүй оройтсон байна гэв.

- Молли, арван хором ч гэсэн ядаж суу л даа! Энэ тийм хүндрэлтэй гэж үү? хэмээн хатагтай Конрой ятгана.

- Та бага зэрэг амсхийсэн нь дээр байх аа, маш их бүжиглэлээ шүү дээ гэж Мэри Жэйн хэлэв.

- Үгүй ээ, би чадахгүй нь! гэж Айворз авхай өчив.

- Манай гэрт танд уйтгартай байсан юм уу? гэж Мэри Жэйн гомдонгуй асуув.

- Та юу ярина вэ? Харин ч эсрэгээрээ! Одоо та намайг

явуулах хэрэгтэй! гэж Айворз авхай хэлэв.

- Ингэхэд та чинь гэр рүүгээ яаж ганцаараа явах юм бэ? гэж хатагтай Конрой өгүүлэв.

- Голын эргээр жаахан алхаад л хүрчихнэ.

Г абриэл хэсэг зуур эргэлзсэнээ:

- Айворз авхай, таныг зөвшөөрвөл би хүргэж өгье! гэв.

Гэвч Айворз авхай гараараа зангав.

- Сонсохыг ч хүсэхгүй байна. Та нар явж хоолоо идэцгээ, надад санаа зовсоны хэрэггүй. Би ганцаараа дажгүй яваад хүрчихнэ.

- Молли, та чинь ямар сонин хүн бэ? гэж хатагтай Конрой сэтгэлээсээ хэлэв.

- Beannacht libhl гэж Айворз авхай шатаар уруудах зуур инээмсэглэн хашгирав.

Мэри Жэйн түүний араас харав. Тэрээр тун их гомдсон байлаа. Харин хатагтай Конрой шатны бариул дээгүүр тонгойж, үүд хэзээ хаагдахыг чих тавин сонсов. Энэхүү гэнэтийн явалтын учир шалтгаан нь түүнээс үүдэлтэй биш байгаа хэмээн Габриэл дотроо бодов. Үгүй ээ, тэрээр явахдаа инээж байсан. Ямар ч уурласан шинж анзаарагдаагүй.

Хоолны өрөөнөөс гэнэт Кэт эгч гарч ирээд яаран явах зуур бүдэрч унах шахав.

- Габриэл хаана байна аа? гэж тэрээр асууна.\

- Бүх гэгээнтний нэрийг барин асууя! Габриэл хаашаа явчихав аа? Бүх хүмүүс ширээний ард суучихсан. Галууны маханд хүрдэг амьтан алга.

- Кэт эгч ээ, би энд байна. Таныг хүсвэл бүхэл бүтэн галуун

1 Баяртай. /гэль үг/ цуваа ч байсан хамаагүй огтлоод өгье гэж гэнэт амь орсон мэт Габриэл хашгирав.

Тарган галууны шарсан мах ширээний нэг өнцөгт байх агаад харин нөгөө өнцөгт нь нугачмал цаасан дэвсгэр дээр яншуй, талхны үүрмэг цацсан томоос том гуяны мах тавьжээ. Дэргэд нь хачиртай шарсан мах байна. Эдгээр аятайхан идээ будааны хажуугаар бүхий л ширээгээр хоёр зэрэгцээ эгнээ болгон амтат зууштай тавагнууд өрөөстэй байх аж. Улаан, шар өнгийн царцмагаар хийсэн хоёр бяцхан цамхаг, дөрвөлжилж хэрчсэн бүйлсний царцмаг, улаан бүржмэл чихэр бүхий хавтгай таваг, навчин хэлбэртэй том ногоон цар дээр хар, хүрэн өнгийн усан үзэм, арилгасан бүйлс овоолсон байхаас гадна бас нэгэн тавган дээр хоорондоо наалдсан чихэртэй инжир байв. Задийн нунтаг самар цацсан цөцгийтэй сүмсний сав, жижигхэн шилэн савтай, алтлаг, мөнгөлөг цаасанд ороосон олон төрлийн чихэр, шоколад ч мөн байна. Мөн цоохор майлзны хэд хэдэн урт иш цухуйх нарийхан шилэн ваар харагдана. Ширээний голд тавьсан царны хажуу бөөрөнд амтат жүрж, алим өрж хийсэн пирамид сүндэрлэх агаад манаанд гарсан харуул мэт эртний хоёр болор галуун хүзүүт лонхнууд номхон зогсоно. Нэгэнд нь үзэмний дарс, нөгөөд нь цагаан дарс байх ажээ.

Төгөлдөр хуурын хаалттай таган дээр өөрийн ээлжийг хүлээх мэт том шар тавган дээр

цэлцэгнүүр байх агаад усан үзэмний дарс, сархад, рашаан устай гурван эгнээ лонх өрөөстэй харагдана. Тэр бүгдийг мөрдөсний өнгөөр сонгож авсан бөгөөд эхний хоёр хар нь улаан хүрэн шошготой, сүүлчийнх нь нэг их олон биш авч цагаан, ногоон ташуу зураастай байв.

Габриэл өөртөө итгэлтэйхэн ширээний толгойд очиж байраа эзлээд, хутганы ир рүү нэг харснаа, шийдэмгий гэгн нь сэрээ авч галууны маханд хатгав. Одоо түүнд тун сайхан мэдрэмж төрнөм. Шарсан галууны махнаас гайхалтай чадварлаг зүсэхийн сацуу тэр энэ хорвоо дээр элдэв амттан өрсөн ширээний толгойд суухыг юунаас ч илүү эрхэмд үздэг байжээ.

- Фэрлонг авхай, та юу авах вэ? Далавч уу, цээжний мах уу?

- Цээжний махнаас маш бага авъя.

- Хигинс авхай, та юу авах вэ?

- Ноён Конрой, надад юу ч байсан яахав.

Габриэл болон Дэли авхай нар тавагтай галууны мах, гуяны мах болон давтаж шарсан махнаас тэнд байсан хүмүүст дамжуулж байх зуур, Лили бүх зочдын урд дахь тавган дээр цагаан цаасанд ороосон чанасан халуун төмс тавьжээ. Энэ бол Мэри Жэйний санаа байв. Тэрээр галууны махан дээр алимны сүмс хийхийг хүссэн ч, Кэт эгч насан туршдаа ямар ч алимны сүмсгүй галууны мах идээд болоод л байсан гэж загнасан юмсанж.

Мэри Жэйн шавь нараа дайлж, тэд нарт аль болох гайгүй мах таарах эсэхийг анхаарч байсан бол Кэт, Жулия эгч нар төгөлдөр хуурын дэргэд зогсчихсон шилтэй лонхнуудыг ар араас нь задалж, ширээ рүү дамжуулна.

Хүмүүсийн яриа, хутга, сэрээ харших дуун, галуун хүзүүт лонх шилэн аяганд шүргэх, бөглөө мултрах чимээ зэрэг маш их үймээн, инээд наргиан, чимээ шуугиан гарна. Бүх зочдод галууны мах хүртээсний дараа, Габриэл өөрийнхөө тавган дээр юу ч тавиагүй байж хоёр дахь удаагийн хувийг хүртээхээр тэр даруйхан зүсч гарав. Үүнийг олон хүн эсэргүүцсэн тул Габриэл портэр дарснаас нэг сайн балгаад, галуугаа хэрчих ажилд ханцуй шамлан оров.

Мэри Жэйн одоо тайван сууж, үдийн зоог барьж байсан бол Кэт, Жулия эгч нар бие биетэйгээ шүргэлцэж, ширээний ойролцоо эргэлдэж, хэн хэндээ янз бүрийн заавар тушаал өгөх авч тэдний хэн нь ч нэгнийхээ үгийг тоож сонсохгүй байлаа. Ноён Браун тэднийг ширээний ард суухыг гуйж, энэ талаар Габриэлиэс ч мөн хүссэн авч түүний урилгыг тэд хүлээж авсангүй.

Эцэст нь Фрэдди Мэлинз босч Кэт эгчийг барьж аваад, олны инээд хөөр дор хүчээр түүнийг ширээнд суулгав. Бүх хүмүүс хоолоо авсан хойно Габриэл инээмсэглэх зуур,

- За одоо өөр хоол аваагүй хүн байвал гомдол мэдүүлж болно шүү! гэв.

Тэнд байсан хүмүүс хоолоо идэхийг шаардсан тул түүнд зориулж хадгалсан гурван ширхэг



төмсийг Лилли авчирч өгөв.

- За ойл голоо! гэж хэлээд Г абриэл дарс балгав.

- Эрхэмсэг ноёд, хатагтай нар аа! Намайгэнд байгаа гэдгийгхэсэгхэн зуур мартахын хүсч байна.

Тэрбээр бусдын ярианд оролцолгүй хоолоо идэж эхэлсэн бөгөөд энэ үеэр Лилли бохир тавгуудыг ширээнээс хурааж байлаа. Эдүгээ ярианы гол сэдэв бол Вангийн театрт айлчлан тоглолт хийж буй дуурийнхны тоглолт байв. Цээл хоолойт дуучин ноён Бартэлл д'Арси нэг дэх цөлх хоолойт дуучныг магтаж байсан бол Хэрлонг авхай түүний дуулахыг ер таалсангүй.

Мюзик-холлын хоёрдугаар үзэгдэлд гардаг хар арьст хаан тун гайхалтай цээл хоолойгоор дуулж байна лээ гэж Фрэдди Мэлинз хэлэв. Энэ бол түүний амьдралдаа сонсч байсан хамгийн шилдэг дуучин юмсанж.

- Та түүнийг сонссон уу? гэж ширээний цаанаас тэр ноён Бартэлл д'Арсид хандан асуув.

- Үгүй ээ гэж ноён Бартэлл д'Арси тоомжиргүйхэн хариулав.

- Та ойлгож байна уу? Таны сэтгэгдлийг сонсох нь надад чухал байна. Миний бодлоортэр гайхалтай чадалтайхоолойтой хүн шиг санагдсан гэж Фрэдди Мэлинз тайлбарлаж хэлэв.

- Тэдди үргэлж л ямар нэгэн шинэ нээлт хийж байдаг юм гэж ширээнд суусан хүмүүст хандаж ноён Браун нөхөрсгөөр өгүүлэв.

- Яагаад тэр сайн хоолойтой байж болдоггүй юм бэ? гэж Фрэдди Мэлинз эрсхэн асуув.

– Эсвэл тэр хар арьстан болоод тэр гэж үү?

Хэн ч хариулсангүй. Мэри Жэйн ярианы сэдвийг сонгодог дуурь руу чиглүүлэв. Шавь нарынх нь нэг түүнд “Миньон”<sup>1</sup>-ыг үзэх тасалбар олж өгчээ.

Тун гайхамшигтай тоглолт болсон. Гэвч хөөрхий Жоржина Бэрнсийг тэр санахгүй байж чадсангүй. Дүблин, Тьэтьэнст хүрэлцэн ирж байсан Ильмэ дэ Мүрзка, Кампанини, аугаа Трэбэлли, Жульини, Равэлли, Арамбуро нарын Италийн хуучны хамтлагуудын талаарх гэгээн дурсамжаа ноён Браун дахин сэргээв.

Тийм ээ, жинхэнэ дуу гэж юу байдгийг тэгэхэд л Дүблинд сонсох боломжтой байсан юм гэж тэр хэлэв. Хуучны Вангийн театрын<sup>2</sup> танхимд үдэш

1 “Миньон” /1866/ XIX зуунд хамгийн их алдаршсан франц дуурийн нэр.

2 1890 онд шатсан бөгөөд түүний суурин дээр Вангийн шинэ театрыг байгуулжээ.

бүр битүү үзэгчидтэй байж, нэгэн удаа Италийн цээл хоолойт дуучин “Эр цэрэг шиг би эрэлхэгээр үхэх болно”<sup>1</sup> хэмээх арийг таван удаа дахиулан дуулж байсан тухай ч тэр бас

ярьжээ. Тэгвэл одоо яагаад "Динора", "Лүкрэций Боржиа"2 зэрэгхуучны алдартай дуурийг тавихгүй байгаа юм бэ? Яагаад гэвэл тэднийг дуулах тийм мундаг хоолойтой хүн байхгүй учраас л тэр.

Миний бодлоор одоо ч гэсэн тэр үеийн дуучдаас муугүй хүмүүс байгаа гэж би бодож байна хэмээн ноён Бартэлл д'Арси хэлэв.

- Хаана байгаа юм бэ? гэж ноён Браун асуув.

- Лондон, Парис, Миланд гэж ноён Бартэлл д'Арси омогтойхон хариулав. - Жишээлбэл, Карузо гэхэд таны нэрлэсэн хүмүүсээс хавьгүй илүү дуучин.

- Магадгүй л юм. Гэвч би эргэлзэж байна гэж ноён Браун хэлэв.

- Ай даа, Карузог сонсохын төлөө би юугаа ч хайрлахгүй шүү! гэж Мэри Жэйн өгүүлэв.

- Миний хувьд таалагддаг цээл хоолойт дуучин ганцхан байсан юм гэж Кэт эгч яс мөлжих зуур хэлэв.

- Гэхдээ та нар түүний нэрийг сонсоогүй байх аа.

- Моркан авхай, тэр чинь хэн юм бэ? гэж ноён Бартэлл д'Арси эелдэгхэн асуув.

- Паркинсон гэж Кэт эгч хэлэв. - Би ид цэцэглэж явахдаа түүнийг сонсч байсан юм. Түүнээс илүү цэвэр дуулдаг ганц ч эрэгтэй цээл хоолойт дуучин байхгүй гэдгийг та нарт хэлэх

1 У.В.Уоллэсын "Маритана" дуурийн арийн хэсэг.

2 "Динора" Жакомо Мэйэрберийн /1791-1864" хошин дуулалт жүжиг. "Лүкрэций Боржиа" /1833/ В.Хюгогийн жүжгээс сэдэвлэж Фэличэ Романийн бичсэн итали дуурь байна.

- Сонин л юм. Түүний тухай би ер сонсч байгаагүй юм байна гэж ноён Бартэлл д'Арси хэлэв.

- Үгүй ээ, үгүй. Моркан авхайн зөв. Одоо би саналаа. Би өвгөн Паркинсоныг сонсч байсан юм байна. Гэхдээ хүнийхээ хувьд тэр миний ой тойнд үлдээгүй юм гэж ноён Браун хэлэв.

- Тун гайхалтай, цэвэрхэн, энхрий зөөлөн, жинхэнэ англи маягийн цээл хоолой гэж Кэт эгч бахдангуй өгүүлэв.

Габриэлийг халуун хоолоо зооглож дуусмагц, ширээн дээр томоос том цэлцэгнүүр авчирч тавив. Дахиад л халбага, сэрээ түчигнүүлж гарав. Габриэлийн эхнэр тавагтай цэлцэгнүүр тараана. Мэри Жэйн замд нь тэднийг тосч аваад бага зэрэг бөөрөлзгөнө, амтат жүржийн царцмаг, бүйлсний царцмаг, бүржмэл чихэр зэргийн аль нэгийг дээр нь нэмж хийнэ. Тэрхүү цэлцэгнүүрийг Жулия эгч хийсэн бөгөөд эдүгээ бүхий л талаас нь түүнд хандан магтаалын үг урсгаж эхлэв. Санасныг бодвол арай л нэг гоё, хүрэн улаан өнгөтэй болсонгүй гэж тэрээр даруухан загнав.

- За, Моркан авхай. Тийм тохиолдолд тантай би санал нэг байна; үүнээс чинь илүү би хүрэн улаан өнгөтэй болсон юм биш үү? гэж ноён Браун егөөдөв.

Габриэлиэс бусад эрчүүд Жулия эгчид таалагдахын тулд бага зэрэг цэлцэгнүүр амсацгаав. Харин Габриэл хэзээ ч чихэрлэг юм иддэггүй байсан тул түүнд гагцхүү цоохор майлз үлдээжээ.

Фрэдди Мэлинз ч мөн цоохор майлзны ишнээс барьж, цэлцэгнүүртэй хольж идэв. Цоохор майлз нь цус багатай үед ач тустай гэдгийг тэр сонсч байсан бөгөөд одоо тэр цус багадсанаас болж эмчилгээ хийлгэж байгаа аж. Хатагтай Мэлинз үдийн зоог барихдаа ганц ч үг ганхийгээгүй авч түүний хүү ганц хоёр долоо хоногийн дараа Мэллэрэй1 уул руу явахаар шийдсэн тухай үг унагав. Тэр үед бүгд л Мэллэрэй уулны талаар яриа өрнүүлж, тэндхийн агаарын сайхныг шагшиж, гэлэнмаа нарынх нь зочломтгой чанарыг магтаж, тэнд очсон гийчдээс хэзээ ч тэд төлбөр мөнгө нэхдэггүй тухай ярьцгааж байлаа.

- Тэгвэл та тийшээ очоод, яг л зочид буудалд байгаа юм шиг амьдарч болно гэж хэлэх гээд байна уу? Дараа нь тэгээд ямар ч төлбөр төлөхгүй юм биз дээ? гэж ноён Браун итгэж ядан асуув.

- Мэдээж хэрэг тэнд очсон хүмүүс буцахдаа ямар нэгэн юм сүмд хандивлаж л таарна гэж Мэри Жэйн хэлэв.

- Протестантуудын хувьд тиймэрхүү үйл ажиллагаа явуулдаг газар байна гэдэг муугүй л хэрэг гэж ноён Браун сэтгэлээсээ өгүүлэв.

Гэлэнмаа нар хэзээ ч үл ярихаас гадна авсанд унтаж, шөнийн хоёр цагт босдог тухай сонсоод тэр ихэд гайхжээ. Энэ талаар тэр сониучирхан асуув.

- Энэ бол тэндхийн сүм хийдийн дүрэм гэж Кэт эгч хатуухан хэлэв.

- За тийм байж. Гэхдээ ямар хэрэгтэй юм бэ? гэж ноён Браун шалгаасаар байв.

- Тийм л дэг жаягтай. Өөр хэлэх юм алга гэж Кэт эгч давтан өгүүлэв.

1 Ирландын өмнөд хэсэгт орших Мэллэрэй уулан дээр траппистуудын сүм байдаг юм.

Ноён Браун үргэлжлүүлэн тээнэгэлзэж гарав. Эх газар дээр нүгэл үйлдсэн хүмүүсийн нүглийг наминчлахын тулд гэлэнмаа нар ийм зан үйл хийдэг юм гэж Фрэдди Мэл инз чадах ядахаараа түүнд тайлбарлав. Түүний тайлбарласан зүйл тодорхой бус байсан уу, яасан ноён Браун ялимгүй жуумалзав.

- Тун сонин санаа байна. Хамгийн хачирхалтай нь, пүршгэй гудасны илүү авсанд унтсан нь хавьгүй тохилог байна гэж байх уу? хэмээн асуув.

- Авс гэдэг нь тэдний хувьд үхэх цаг ирнэ гэдгийг байнга сануулж байдаг дохио юм гэж Мэри Жэйн хэлэв.

Ярианы сэдэв бараан тал руугаа хазайж ширээний ард нам гүм ноёлмогц хатагтай Мэлинз тун ойлгомжгүй намуухан дуугаар,

- Тэр гэлэнмаа нар чинь маш их үнэнч, нэр хүндтэй хүмүүс байдаг юм гэж хажуугийн хүндээ хандаж хэлэв.

Эдүгээ ширээн дээр байсан усан үзэм, бүйлс, инжир, алим, амтат жүрж, шоколад болон чихрийг дамжуулж, Жулия эгч бүх хүмүүст хандан усан үзмийн дарс, цагаан дарсны аль нэгийг уухыг санал болгоно. Ноён Бартэлл д'Арси эхэндээ татгалзсан ч хажууд нь суугаа хүн түүнийг тохойгоороо ёворч, ямар нэгэн юм шивнэсний дараа тэр шилэн аягандаа дарс хийхийг зөвшөөрөв. Шилэн аяганууд дүүрэх бүрийд яриа хөөрөө улам бүр намжина.

Гагцхүү дарсны бүль-бүль хийх дуун, сандлын хяхтнах чимээг эс тооцвол нам гүм болжээ. Тэнд байсан Моркан авхай нар ширээний бүтээлэг рүү харцгаана. Хэн нэгэн найтаахад, эрчүүдийн нэг нь дуугаа аядахыг уриалж ширээ рүү зөөлөн тогшив. Нам гүм болсны эцэст, Габриэл сандлаа холдуулан босов. Тэр үед энэ бүхнийг зөвшөөрсний дохио болж, тэрхүү тогших чимээ улам чангарснаа, дараа нь огцом чимээгүй болов. Габриэл салгалж буй арван хуруугаараа ширээ тулж зогсоод, тэнд байсан хүмүүст хандан инээхчээн аядав.

Түүний нүд өөр рүү нь харах хүмүүсийн харцтай тулгарсан тул чийдэнгийн бүрхүүл өөд харц шилжүүлэв. Зочны өрөөнд вальс бүжгийн ая тоглох агаад хаалганд шүргэх банзлын чимээг Габриэл дахин сонсох шиг болов. Цонхон дор зогсч буй хүмүүс гэрэлтэй цонх руу харцгааж, тэнд тоглож асан вальсийн аяыг сонсч байсан ч байж мэднэ.

Тэндхийн агаар цэвэр, тунгалаг байлаа. Арай цаана нь орших цэцэрлэгт хүрээлэнгийн модод цагаахан гоёлоо өмссөн байх авай. Вэллингтоны хөшөө гялтганасан цасан малгайтай байх агаад тэрхүү цас Арван таван Акрын<sup>1</sup> цав цагаахан орон зай дээр баруун зүг чиглэн эргэлдэнхэн орном.

- Эрхэмсэг ноёд, хатагтай нар аа! Өнөөдөр урьд өмнөх жилүүд шиг миний хувьд нэлээд хүндхэн үүрэг оногдсон нь уран илтгэх чадвар муутай надаас чамгүй авьяас шаардсан хэдий ч угтаа энэ нь маш хүндтэй, нэр төрийн хэрэг юм гэж яриагаа тэр эхлэв.

- Та юу ярина вэ? гэж ноён Браун хэлэв.

- Ямартаа ч та бүхнийг миний хэлсэн үгнээс өө хайхын хэрэггүй хэмээн гэж хүсэхийн сацуу хэдхэн хором анхаарлаа нааш хандуулж, хэлэх гэсэн үгийг минь сонсохыг хүсч байна.

- Ноёд, хатагтай нар аа! Бид энэхүү зочломтгой айл гэрт нэг бус удаа хуран цуглаж, энэхүү баярын ширээний ард олонтаа сууцгааж байгаа билээ. Нэг бус удаа бид олны танил

<sup>1</sup> Фэниксийн цэцэрлэгт хүрээлэнгийн төв хэсэг. эдгээр хүмүүсийн зочломтгой байдлын золиос болж байсан гэж хэлэхэд буруутсан болохгүй байх аа. Тэрбээр агаар дээр тойрог зурж, хэсэг азнасхийв.

Зарим нэг хүн инээд алдаж, зарим нь Кэт, Жулия эгч ба Мэри Жэйний зүг харж

ИНЭЭМСЭГЛЭНЭ.

-Жил ирэх бүр би манай орны ёсзаншлын доторзочломтгой ёс заншлаас илүү эрхэм нэр хүндтэй, цаашид уламжлан хад- галах шаардлагатай ийм ёс заншил үгүй гэдгийг улам бүр мэдэрч байна. Европын олон оронд би очиж үзсэн авч, гагцхүү манай орон л энэхүү ёс заншлыг хадгалсаар ирсэн билээ. Энэ бол магтан дуулах ёстой эрхэм зүйл гэдгийг сул тал хэмээн буруутгах нэгэн ч таарах биз ээ. Гэвч миний бодлоор, энэ нь тун өгөөмөр сул тал юм. Тиймээс энэ бүхэн манай оронд он удаан жилийн туршид хадгалагдана гэдэгт би найдаж байна. Энэ гэрийн дээвэр дор дээр нэр дурдсан гурван хүн амьдарч байгаа цагт, тэдэнд зориулж би он удаан жил амьдрахыг чин сэтгэлээсээ хүсэн ерөөж, өвөг дээдсээс минь бидэнд өвлүүлж үлдээсэн баяр баясгалантай, чин сэтгэлийн, ирланд хүний зочломтгой зан чанарыг бид өөрсдийн үр хүүхдэд өвлүүлж үлдээх учиртай гэдэгт миний бие итгэл дүүрэн байна гэдгээ хэлэхийг хүссэн юм.

Ширээний ард энэ бүхнийг хүлээн зөвшөөрөх мэт дургүйцсэн байдал өрнөв. Айворз авхай зочдын дунд байхгүй, аль эрт явсан гэдгийг Габриэл гэнэт санаад, өөртөө итгэлтэйхэн яриагаа үргэлжлүүлж гарав.

- Ноёд, хатагтай нар аа! Шинэ үзэл санаагаар амьсгалж, шинэ зарчмыг номлож буй нэн шинэ үе өсөн хүмүүжиж байна. Тэд бол тун хариуцлагатай, урам зориг дүүрэн үеийнхэн бөгөөд эдгээр шинэ үзэл санаа нь учир дутагдалтай байж, хий дэмий хүч зарцуулсан байлаа ч, миний бодлоор тэрхүү хүсэл тэмүүлэл чин сэтгэлийнх мэт санагдана.

Гэвч бид үл итгэгч бодол санаанд идэгдсэн эрин үед амьдарч байна. Тиймээс энэхүү боловсролтой хийгээд дэндүү боловсорсон үед, зочломтгой зан чанар, эелдэг даруу байдал, өгөөмөр сэтгэл зэрэг хуучин цагийн хүмүүсээс дутмаг зүйл байгаа гэхээс заримдаа би айж, имээхэд хүрнэ. Өнөө цагт өнгөрсөн үеийн аугаа дуучдын нэрсийг сонсч байхад, түүнээс дугуугүй бид өгөөмөр эрин зуунд амьдарч байгаа гэдгийг ухамсарлах хэрэгтэй гэж бодном.

Тэдгээр өдрүүдийг өгөөмөр өдрүүд гэж ямар ч хэтрүүлэггүйгээр нэрлэж болно. Хэрэв тэд эргэж буцалтгүйгээр биднээс холдон одсон бол, ямар ч байсан өнөөдрийн нэгэн адил тиймэрхүү хурал цуглаанд тэднийг бид баяр бахдал хийгээд хайр хүндэтгэлтэйгээр эргэн дурсах болно.

Үүнээс гадна алдар, нэрийг нь хорвоо ертөнц хэзээ ч мартахгүй насан хутгыг олсон аугаа хүмүүсийн дурсгалыг зүрх сэтгэлдээ хадгалж явах болно.

- Сонсоцгоо! Сонсоцгоо! гэж ноён Браун хэлэв.

- Үүнээс гадна гунигтай бодлууд ч бас бий, тэр бүхэн биднийг үргэлж өнөөдрийн нэгэн адил хурал цуглаан дээр эзэмдэхээс гадна өнгөрсөн үе, залуу нас, өөрчлөлт хийгээд бидэнтэй хамт байхгүй найз нөхдийн талаарх бодол ч бас бий гэж Габриэл дуугаа арай зөөлрүүлж үргэлжлүүлэн ярив.

- Бидний амьдралын харгуй тиймэрхүү дурсамжаар дүүрэн бөлгөө; хэрэв бид үргэлж тэр бүхнийг санаж явах аваас эгэл хүмүүсийн дунд үргэлжлүүлэн хөдөлмөрлөх эр зоригийг

олохгүй байсан билээ.

Харин бидэнд амьтай бүхэнд хандах үүрэг гэж бий, үүнээс гадна дотносол гэж бий. Амьдрал ч мөн өөрийн гэсэн хууль ёсны эрхтэй бөгөөд ихэнх хэсгийг өөртөө өгөх тал дээр биднээс шаардах эрх ч түүнд бас бий. Тиймээс би өнгөрсөн бүхнийг удаан дурсахгүй. Өөрийн хэл яриаг би уйтгарт номлол болгон хувиргахыг хүсэхгүй байна. Энд бид өдөр тутмын шуугиан хийгээд эмх замбараагүй байдлаас богинохон хугацаанд ч гэсэн холхон байхыг хүсч цугларсан билээ.

Энд бид эв найрамдлын мэдрэхүйгээр нэгдсэн ажил хэрэгч анд нөхдийн хувьд хуран цугларсан билээ. Бид жинхэнэ “camaraderie”-г сэтгэлээр нэгдэж, хэрэв тэгж хэлж болдог бол, энд бид зочны нэгэн адил Дублины хөгжмийн ертөнцийн гурван одтой хамт байна.

Эдгээр үгсийг сонсмогц бүгд инээд хөөр болж, алга ташиж гарав. Жулия эгч Габриэлийн хэлсэн зүйлийг хажууд байгаа хүмүүсээс нэгд нэгэнгүй асуув.

- Жулия эгч ээ, биднийг тэр гурван од гэж байна! хэмээн Мэри Жэйн хариулав.

Жулия эгч юу ч ойлгоогүй ч яриагаа үргэлжүүлэх Габриэлийн зүг инээмсэглэн харав.

- Ноёд, хатагтай нар аа! Өнөөдөр би Парисын дүрийг бүтээхийг хүсэхгүй байна. Тэдний хооронд би ямар нэгэн сонголт хийхийг оролдохгүй. Энэ бол талархал үгүй бодлого. Тиймээстүүнийг би хүчрэхгүй. Сайхан сэтгэлтэй, эелдэг гэрийн эзэгтэйг таньдаг бүх хүмүүс нь сайн мэднэ; дуулсан дуу нь өнөөдөр бидний хувьд чин сэтгэлийн бэлэг байлаа. Мөнхийн 1 Нөхөрлөл /франц/ залуу насаар шагнагдсан түүний эгчид хандах уу, эсвэл гэрийн эзэгтэй нарын бага нь болох авьяаслаг, хөдөлмөрч, үргэлж инээж явдаг хамгийн хайртай ач нарын ал ийг нь хүндлэх ёстойг эрхэмсэг ноёд, хатагтай нарын өмнө би хэлж чадахгүй гэдгээ өөрийн эрхгүй хүлээн зөвшөөрч байна.

Габриэл авга эгч нарын зүг хармагц, Жулия эгчийн нүүрэн дээр инээмсэглэл тодорч, Кэт эгчийн нүднээс нулимс дусалж буйг хараад яриагаа бушуухан өндөрлөхөөр болов. Түүнийг шилэн аягатай дарсаа дээш өргөхөд зочид ч мөн урд дахь шилэн аягатайгаа гартаа барьцгаав.

- Энэ гурвын төлөө үүнийг тогтооцгооё! Тэдэнд эрүүл энх, эд баялаг, урт удаан нас, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе; тэд өөрийн мэргэжилдээ томоохон байр суурийг он удаан жил эзэлж, бидний зүрх сэтгэлд үргэлжхайр хүндэтгэлийг хүлээж явах болно.

Бүх зочид гартаа шилэн аягаа барин босцгоож, суугаа үлдсэн гурван эзэгтэйд хандан ноён Брауны аялж эхэлсэн дууг хамтдаа түрж, Тэднийг дажгүй залуус гэдгийг Тэднийг дажгүй залуус гэдгийг Тэднийг дажгүй залуус гэдгийг Хэн ч ердөө үгүйсгэж чадахгүй хэмээн дуулж гарав.

Кэт эгч ичиж зоволгүй алчуураар нүдээ арчихад, Жулия эгч ч мөн сэтгэл нь хөдөлсөн харагдана. Фрэдди Мэлинз хэмнэлийн дагуу сэрээгээр бөмбөрдөж, харин дуулж буй хүмүүс өөр хоорондоо зөвлөлдөх мэт өөд өөдөөсөө харцгааж,

Ямар нэгэн юм болоход

Яаж ч худал хэлэхийн аргагүй... хэмээн дуулцгаана.

Дараа нь тэд эзэгтэй нарын зүг эргэн харж,

Тэднийг дажгүй залуус гэдгийг

Тэднийг дажгүй залуус гэдгийг

Тэднийг дажгүй залуус гэдгийг

Хэн ч ердөө үгүйсгэж чадахгүй хэмээн уянгалуулж гарав. Фрэдци Мэлинзийг сэрээгээ дээш өргөн удирдаачийн үүргийг гүйцэтгэж байх зуур, хоолны өрөөний хаалганы цаана байсан бусад зочид ч мөн тэд нар дээр нэгдэж, нижигнэсэн алга ташилт үргэлжилсээр байлаа.

Өглөөний хүйтэн агаар танхимд орж ирмэгц,

- Хэн нэгэн хаалга хаагаач! Хатагтай Мэлинз даарчих гээд байна! гэж Кэт эгч хашгирав.

- Кэт эгч ээ! Тэнд Браун байгаа гэж Мэри Жэйн хэлэв.

- Тэр нөхөр хаа сайгүй л явж байх юм гэж Кэт эгч дуугаа намсган өгүүлэв.

Мэри Жэйн инээд алдав.

- За тэр ямар сэрэмжтэй юм бэ? гэж тэрээр ёжтойхон хэлэв.

- Тийм ээ, манай энэ нусгай хаа сайгүй л амжуулах юм даа! гэж Кэт эгч өнөөх л дуугаар хэлэв.

Чингэхдээ тэр сэтгэлээсээ инээд алдаж,

- Мэри Жэйн! Түүнийг дотогш орж, хаалгаа хаа гэж хэл! Намайг тэр сонсоогүй гэдэгт найдаж байна хэмээн яаравчлан нэмж хэлэв.

Энэ мөчид хаалга нээгдэж, үнхэлцгээ хагарахаас наахна хөхөрсөөр ноён Браун довжоон дээр гарч ирэв. Тэрбээр хиймэл каракүлин зах болон нударгатай урт ногоон хүрэм өмсч, толгой дээрээ дугуй арьсан малгай духдуулжээ. Тэртээ

холоос урт удаан, цангинан шүгэлдэх чимээ сонсдож, өвч цасаар бүрхэгдсэн голын зүг тэр гараараа заана.

- Тэдди тэнд Дублины бүх сүйх тэргийг цуглуулж байна! гэж тэр хэлэв.

Албан өрөөний арын пингээс Габриэл гарч ирээд, явуут дундаа хүрмээ өмсөх зуур

- Грэта гарч ирээгүй юм уу? гэв.

- Габриэл, тэр хувцсаа өмсч байна гэж Кэт эгч өгүүлэв.

- Тэнд хэн тоглож байгаа юм бэ? хэмээн Габриэл асуув.

- Хэн ч байхгүй, бүгд явчихсан.

- Үгүй ээ, Кэт эгч ээ, Бартэлл Д'Арси, О'Каллаган авхай арай яваагүй байгаа гэж Мэри Жэйн хэлэв.

- Ямар ч байсан хэн нэгэн тэнд төгөлдөр хуур балбаж байна гэж Габриэл өгүүлэв.

Мэри Жэйн, Габриэл болон ноён Брауны зүг харж мөрөө хавчсанаа,

- Өөрийгөө ингэтлээ бөөцийлсөн хүмүүсийг харахаас дургүй хүрэх юм. Би лав та нарын оронд байхыг хүсэхгүй байна. Ийм хүйтэн байхад явах гэж байгаа юм уу? хэмээн тэр хэлэв.

- Миний хувьд одоо хамгийн аятайхан зүйл бол, хотоос зайдуухан хурдан морь унаж давхихыг л мөрөөдөж байна.

- Урьд цагт манайх нэг сайхан морьтой байж билээ гэж Жулия эгч гунигтайхан өгүүлэв.

- Хэзээ ч мартагдашгүй Жонни! гэж Мэри Жэйн инээмсэг- лэсээр хэлэв.

Кэт эгч, Габриэл нар ч мөн инээд алдав.

- Ингэхэд Жонни юугаараа тийм алдартай байсан юм бэ? гэж ноён Браун асуув.

- Манай өвөө Патрик Моркан амьдралынхаа сүүлийн жилүүдэд мужааны цавуу хийдэг байсан юм гэж Габриэл тайлбарлав.

- Габриэл, чи Бурханаас айхгүй байна уу? Тэр хүн чинь цардуулын үйлдвэртэй байсан шүүдээ! гэж Кэт эгч инээмсэглэн өгүүлэв.

- Цавуу, цардуул хоёрын алийг нь хийж байсныг мэдэхгүй. Гэвч хөгшин эрд Жонни хэмээх хочтой морь байсан гэж Габриэл хэлэв. Жонни хөгшин эрийн үйлдвэрт зүтгэж байсан бөгөөд тээрмийн чулуу буталдаг байв. Бүх зүйл маш сайхан байжээ. Гэвч хожим нь нэгэн золгүй явдал болсон гэдэг. Нэгэн сайхан өдөр хөгшин эр дээдсийн хүрээнийхний хамт хувийнхаа сүйх тэргээр цэцэрлэгт хүрээлэнд очиж, цэргийн жагсаал үзэж сонирхохоор шийдсэн юмсанж.

- Бурхан минь! Түүний сүнсийг өршөөж хайрла! гэж Кэт эгч гуниглангуй хэлэв.

- Аминь! гэж Габриэл өгүүлэв. - Хөгшин эр Жоннийг хоёр дугуйт тэргэндээ хөллөж, хамгийн сайхан цомбон малгайгаа өмсч, шилдмэл торгомсог зангиагаа зүүж, байдгаараа гоёчихсон амьтан Бэкийн шугам дахь өвөг дээдсийнхээ өвлүүлж үлдээсэн байшингаас хөдөлсөн гэдэг.



Хатагтай Мэлинз болон тэнд байгсад бүгд инээд алдав.

- Габриэл ээ! Чи чинь юу ярина вэ? Тэр хэзээ ч Бэкийн шугам дээр амьдарч байгаагүй, тэнд чинь зөвхөн үйлдвэр байсан юм гэж Кэт эгч залруулав.

- Өвөг дээдсийнхээ өвлүүлсэн байшингаас тэр Жоннигоо унаад л гарч өгч дээ Габриэл үргэлжлүүлэн ярьж гарав.

- Билли ванд I зориулсан хөшөөг Жонни олжхартал бүх юм сайхан байж. Билли вангийн унасан морь түүнд таалагдаагүй юу яасан, эсвэл тэр дахиад л үйлдвэр дээрээ байна гэж хий юм үзсэн үү, нэг их удаан бодолгүй хөшөөг тойрон явж гарсан гэдэг. Энэ баримлыг протестант шашинтнууд хүндлэн дээдэлж, католик шашинтнууд үзэн яддаг байсан агаад тэд бүхий л талаар хөшөөг хорлон сүйтгэх гэж доромж үг бичиж, будаг цацдаг байжээ.

Галошоо өмссөн Габриэл тэнд байсан хүмүүсийн инээд хөөр дундуур танхимаар алгуурхан явна.

- Чингээд тэр тойроод л яваад байж! хэмээн Габриэл хэлэв.

- Харин байдгаараа маадайсан хөгшин эр тун их эгдүүцсэн байдалтай: “Чүү, чүү! Урагшаа эрхэм ээ! Эрхэм ээ! Та яачихав аа! Жонни! Жонни! Ямар сонин зан гаргаад байна аа! Энэ морь яачихсан юм бэ?” гэж орь дуу тавина.

Зогсоо зайгүй сонсдох инээд хаалга балбах чимээнээр тасалдахад хүрэв. Мэри Жэйн хаалга руу гүйж очин онгойл гоход Фрэдци Мэлинз орж ирэв. Фрэдди Мэлинзийн бүрх малгай дагзан дээрээ гарчихсан, гадаах хүйтнээс болж байдгаараа даарчихсан, хичээнгүй ажлынхаа дараа тэр амьсгаагаа дарж ядан зогсоно.

- Би ганцхан сүйх тэрэг олж ирлээ! гэж тэр хэлэв.

- Голын эрэг дээрээс дахиад олдоно оо! гэж Габриэл хариу барив.

- Тийм ээ, хатагтай Мэлинзийг дааруулчихалгүй хурдан явж үз! гэж Кэт эгч яаруулав. I Вильгельм Оранский /1650-1702/ ванд зориулж Коллеж-Гринд босгосон баримлыг хэлж байна.

Ноён Браун, Фрэдди хоёр хатагтай Мэлинзийг шатаар сугадан буулгаж, хүндхэн хөдөлгөөн хийсний дараа сүйхтэргэнд түүнийг чихэж оруулав. Дараа нь Фрэдди Мэлинз тийш орж, эвтэйхэн байрлалд түүнийг суулгах гэж нэлээдгүй ноцолдох үед, ноён Браун дэргэд нь зогсчихсон зөвлөгөө өгч байлаа. Эцэст нь түүнийг аятайхан суулгаад, ноён Браунаас сүйх тэргэнд суухыг Фрэдди Мэлинз хүсэв.

Хэн нэгэн юу ч юм ярина. Үүний дараа ноён Браун сүйх тэргэнд оров. Сүйх тэрэгний улаач хөлөө хучлагаар ороож, доош тонгойсноо хаашаа явахыг асуув. Бүгд л дахин яриа өрнүүлэхэд, сүйх тэрэгний хоёр талын цонхоор Фрэдди Мэлинз, ноён Браун нарын нэгэн зэрэг өгөх тушаалыг улаач эр хүлээн авав. Асуудлын гол нь ноён Брауныг ямар газар буулгахад оршино;

Кэт, Жулия эгч ба Мэри Жэйн нар тэрхүү маргаанд оролцож, хаалган дээр зогсохдоо зарим нэг саналыг дэмжиж, бусдыг нь үгүйсгэх зуур байнга л инээд алдан, хөгжилдөн зогсоцгооно. Фрэдди Мэлинз элгээ хөштөл инээснээс болж ярьж ч чадахгүй байв.

Тэрбээр байсхийгээд л толгойгоо цонхоор цухуйлгаж, эсвэл эргэж нааш цааш болсоор хайран бүрх малгайгаа яйран болгож, тэрхүү маргааны өрнөлийн талаар эхнэртээ мэдээлж байтал, эцэс сүүлд нь ноён Браун олны инээдийг түр сааруулж,

- Тринити коллеж хаана байдгийг мэдэх үү? гэж улаачид хандан хашгирав.

- Тийм ээ, эрхэм ээ! гэж улаач хариулна.

- Байдаг хурдаараа тийшээ давхи!

- Ойлголоо эрхэм ээ! гэж улаач хэлнэ.

Тэрбээр мориндоо ташуур өгмөгц, сүйх тэрэг голын эрэг дагуу давхин одов. Габриэл гадагш гарсангүй. Тэрбээр танхимд зогсч шат өөд харна. Бараг хамгийн дээд давхарт нэгэн эмэгтэй сүүдэрт зогсоно. Тэрбээр түүний царайг огт хараагүй бөгөөд харанхуйд гагцхүү хар, цагаан мэт санагдах банзал дээрх улбар шар, түлсэн наанги шороон өнгө бүхий судлыг нь ялгаж чадах төдий гэрэлтэй байлаа.

Тэр эмэгтэй эхнэ нь ажээ. Грэта шатны бариул тохойлдож, ямар нэгэн юм чих тавин сонсоно. Түүний хөдөлгөөнгүй байдал Габриэлийг гайхшралд хүргэж, эхнэрийнхээ чагнаж буй зүйлийг тэр ч мөн сонсохыг оролдов. Гэсэн ч довжоон дээр маргалдан зогсох хүмүүсийн чимээ шуугиан, инээд хөөрөөс өөр зүйл гэвэл, төгөлдөр хуурын хэд хэдэн эгшиг, хэдэн ноотноос илүү зүйл ер олж сонссонгүй. Бүрэнхийд тэр хэн нэгний дуулж буй аялгууг сонсохыг хичээн эхнэр рүүгээ харав.

Тэрээр ямар нэгэн зүйлийн бэлгэ тэмдэг байсан мэт түүний бие галбирт уян налархай байдал, эрхэмсэг нууц оршино. Тэрхүү харанхуй шатан дээр зогсч буй эмэгтэй чухам ямар юмны бэлгэ тэмдэг байсныг тэртээд дуулдах хөгжмийг чагнах зуур өөрөөсөө асууна. Хэрэв тэр зураач байсан бол түүнийг яг л ийм байрлалд зогсч буйгаар дүрслэх байсан биз ээ. Цэнхэр эсгий малгай нь харанхуй дэвсгэр дээрх үснийх нь хүрэл өнгийг сүүдэртүүлж, банзлынх нь хар, цайвар судал өнгө хорших ажээ. Хэрэв тэр зураач байсан бол “Холын аялгуу” гэж энэхүү зургаа нэрлэх байсан болов уу...

Орох үүд хаагдмагц, Кэт ба Жулия эгч, Мэри Жэйний хамт эргэн орж ирцгээв.

- Фрэдди бол тэвчихийн аргагүй хүн гэж Мэри Жэйн хэлэв.

- Тэвчихийн аргагүй юм даа.

Габриэл юу ч хэлэлгүй эхнэрийнхээ зогсч буй шат өөд заав. Хаалга хаагдмагц, төгөлдөр хуурын чимээ хийгээд дуулж буй хүний хоолой улам тод сонсдов. Габриэл дуугүй байхыг уриалж, гараа дээш өргөв. Тэр дуу эртний ирланд дуу байсан ч түүнийг дуулж буй дуучин зөв

хэллэг, хоолой хоёртоо итгэлгүй нэгэн байлаа. Тэртээ цаана сонсдох сөөнгө хоолой дууны үгийг улам бүр гунигтай болгосон санагдана.

Хонгорхон үс минь бороонд хорохуйд

Хүйтэн шүүдрийн ус нүүрийг минь норгоно.

Хүүгийн минь бие аль хэдийнэ хөрчээ...

- Бурхан минь! Энэ чинь Бартэлл д'Арси дуулж байна шүү дээ! гэж Мэри Жэйн орь дуу тавин хэлэв. -Өнөөдөр тэр яагаад ч дуулахыг хүсээгүй шүү дээ! Тэгвэл түүнийг явахаас өмнө дуулахыг шаардана даа.

- Мэри Жэйн! Наад хүндээ дуул гэж хэл! хэмээн Кэт эгч үүрэгдэв.

Мэри Жэйн хүмүүсийн дэргэдүүр шат чиглэн гүйсэн авч гишгүүрээр түүнийг өгсөхөөс өмнө тэрхүү дуун нам гүм болж, төгөлдөр хуурын таг хүчтэйхэн хаагдав.

- Ямар харамсалтай юм бэ? Грэта, тэр доош бууж байна уу? гэж тэрээр асуув.

Эхнэр нь “тийм” хэмээн хариулсныг Габриэл сонссон бөгөөд түүнийг шатаар бууж байгааг олж харав. Түүнээс хэдхэн алхмын ард ноён Бартэл д'Арси, 0'Каллаган авхай нар явцгаана.

- Ноён Арси! Ингэж болно гэж үү? Бид таны дууг чих тавин сонсч байлаа шүү дээ! гэж Мэри Жэйн өгүүлэв.

- Түүнээс би оройжингоо л гуйлаа гэж 0'Каллаган авхай хэлснээ, хатагтай Конрой ч мөн гуйсан гэв. Хоолой нь өвдсөн тул тэр дуулж чадахгүй гэсэн.

- Ай даа, ноён д'Арси! Та янз бүрийн юм зохиож ярихаасаа ичихгүй байна уу? гэж Кэт эгч өгүүлэв.

- Миний хоолой бүр сөөчихсөн байгааг та сонсохгүй байна уу? гэж ноён д'Арси бүдүүлэгхэн дуугарав.

Тэрбээр агуулах руу яаравчлан орж хүрмээ өмсч гарав. Түүний бүдүүлэг байдалд тээнэгэлзсэн хүмүүс хэлэх үгээ олсонгүй. Кэт эгч хөмсгөө зангидаад энэ тухай дахин ярихгүй байхыг дохио зангаагаар ойлгуулав. Ноён д'Арси хоолойгоо сайтар боож, хөмсөг зангидав.

- Энэ цаг агаараас л болж байгаа юм гэж дуугүй байсны эцэст Жулия эгч өгүүлэв.

- Тийм ээ, бүгд л хоолой нь өвдөж байна гэж Кэт эгч хэлсэн үгийг нь өлгөж авав.

- Иймэрхүү цас ойрын гучин жил лав ороогүй гэж ярих юм билээ. Өнөөдөр Ирланд даяар цас орсон тухай би сониноос уншсан хэмээн Мэри Жэйн өгүүлэв.

- Би цасанд дуртай! гэж Жулия эгч уйтгартайхан хэлэв.

- Би ч бас, Зул сарын баяр цасгүй бол баяр биш шүү дээ гэж О'Каллаган авхай өгүүлэв.

- Хөөрхий ноён д'Арси цасанд дургүй юм билээ гэж Кэт эгч инээмсэглэн хэлэв.

Ноён д'Арси энгэр заамаа байдгаар нь товчилж, нүүр амаа ороолтоор боочихсон агуулахаас гарч ирээд, ханиад хүрсэн тухайгаа тэд нарт ч мөн дуулгав. Бүгд л түүнд янз бүрийн зөвлөгөө өгч, болгоомжтой явахгүй бол шөнийн агаар хоолойд тун муу гэдгийг хэлж, ярьж байлаа.

Габриэл ярианд үл оролцох эхнэр рүүгээ харав. Тэрээр орох үүдний дэргэд дахь цонхны эсрэг талд зогсох агаад, хийн дэнлүүний гэрэл гялалзаж буй хүрэл үсээр нь тоглоно; хэд хоногийн өмнө тэр үсээ угаасны дараа задгай зуухны өмнө хэрхэн хатааж байсныг Габриэл эргэн санах. Өдгөө тэр шатан дээр байсан шиг тэрхүү байрлалыг авч, хажууд нь хүмүүс юу ярихыг огт сонсохгүй байгаа мэт санагдана. Эцэст нь тэр эргэн харахуйд, хацарт нь улаа бутарч, нүд нь гэрэлтэхийг Габриэл олж харав.

Гэнэт тэрбээр баяр хөөрт автав.

- Ноён д'Арси таны дуулсан дуу ямар нэртэй вэ? гэжтэрээр асуулаа.

- “Аугримаас ирсэн бүсгүй”<sup>1</sup> гэдэг нэртэй. Харамсалтай нь би сайн мэдэхгүй л дээ. Яасан, та энэ дууг сонсч байсан юм уу? гэж ноён д'Арси асуув.

- “Аугримаас ирсэн бүсгүй”. Нэрийг нь би санах гээд чадахгүй байна гэж тэрээр давтан өгүүлнэ.

- Маш сайхан аялгуутай юм гэж Мэри Жэйн хэлэв.

- Харамсалтай нь та өнөөдөр өвдчихсөн байна.

- Мэри Жэйн! Ноён д'Арсид битгий саад хий! Түүнд би саад хийхийг зөвшөөрөхгүй шүү! гэж Кэт эгч өгүүлэв. Бүгд хувцсаа өмссөн байсныг харуут, тэднийг тэр хаалга руу үдэж өгөхөөр дөхөж салах ёс хийцгээв.

- Кэт эгч ээ! Тун сайхан үдэшлэг зохиосонд тань баярлалаа. Тавтай сайхан нойрсоорой.

- Габриэл, сайхан амраарай! Грэта сайхан нойрсоорой!

<sup>1</sup> Ирланд ардын дуу. Аугрим-Ирландын баруун зүгт орших жижигхэн хот.

- Кэт эгч ээ, танд их баярлалаа! Сайхан амраарай! Жулия эгч ээ сайхан нойрсоорой!

- Грэта минь сайхан амраарай! Чамайг би анзаарсангүй

шүү!

- Ноён д' Арси сайхан амраарай! О'Каллаган авхай сайхан амраарай!

- Моркан авхай сайхан нойрсоорой!

- Дахин дахин сайхан амраарай!

- Бүгдээрээ сайхан амраарай! Сайн явж хүрээрэй!

- Сайхан нойрсоорой. Сайхан нойрсоорой!

Бүрий харанхуй байлаа. Бүүдгэр шар гэрэл энд тэндхийн байшин, голын дээр тусна; газар тэнгэр нийлэх гэж байгаа юм шиг санагдана. Хөл дор бөөн шавхай, гагцхүү цас л мөр татуулсаар байшингийн дээвэр, голын эрэг дагуух хашааны суурь, төмөр хайс дээр зөөлөн будрана. Өтгөн агаар дахь дэнлүүнүүд улаан гэрлээр анивчиж, голын цаадах Дөрвөн танхимын ордон<sup>1</sup> бүүдгэр тэнгэр өөд догшин байдалтай сүндэрлэнэ. Тэр цаасанд боосон шаахайгаа сугандаа хавчуулсаар ноён Бартэлл д' Арсийн хамт урд явах агаад нөгөө гараараа банзлынхаа хормойноос өргөж явна.

Одоо тэр ямар ч уян налархай бус харагдавч Габриэлийн нүд улам бүр аз жаргалаар гэрэлтэнэ. Судсаар нь цус түргэн гүйж, түүний толгойд бардам, баяр бахдалтай, энхрийхэн, зоримог бодол эргэлдэнэ. Тэрээр хөнгөхөн алхалсаар урд явах тул, араас нь чимээгүйхэн гүйж очин мөрнөөс нь барьж аваад, чихэнд нь ямар нэгэн инээдтэй, энхрийхэн үгс шивнэхийг хүсэв.

## 1 Дублины шүүх байгууллага

Тэрээр тун хэврэгхэн нэгэн мэт санагдаж байх ахул, Грэтаг ямар нэгэн зүйлээс хамгаалж, дараа нь түүнтэй хоёулахнаа байхыг хүснэ. Хамтын амьдралын нууцлаг мөчүүд одод лугаа адил ой тойнд нь гэрэлтэв.

Ширээн дээрх аяганы дэргэд хэвтэх хөх ягаан дугтуйг тэр гараараа илбэв. Ороонго өвсөнд дотор шувууд жиргэж, хөшиг дээрх нарны тор шалан дээр тусна; тэрбээр юу ч идэж чадсангүй. Галт тэрэгний буудал дээр тэд үймсэн олны дунд зогсоцгоож, түүний халуухан алганд тэр тасалбар атгуулна. Түүний хамт тэсгим хүйтэнд зогсохдоо, халуу шатам зуухны дэргэд шил үлээж буй хүн рүү тортой цонхоор харна. Тун хүйтэн байлаа. Хүйтэн агаарт түүний анхилам царай Габриэлийн нүүрэнд тун ойрхон байтал, гэнэт тэр зуухны дэргэд зогсч буй хүнд хандан,

- Эрхэм ээ, наад гал чинь халуун уу? гэж хашгирав.

Гэвч тэр хүн түүний хэлснийг сонссонгүй. Сонсоогүй нь ч болж дээ. Тэгсэн бол тэр доромжлох байсан биз. Арай илүү оргилох баяр баяслын давалгаанд тэр өртөж, хамаг судсаар нь халуун урсгал гүйв. Оддын энхрийхэн дөл лугаа адил тэдний бэлгийн амьдралын талаар хэн ч мэдэхгүй, хэзээ ч мэдэхгүй бөгөөд гэнэтхэн түүний оюун санаанд гэрэл цацруулсан билээ. Тэрхүү агшны талаар түүнд сануулахыг мөрөөсч, хамтын амьдралынхаа баргар он жилүүдийг мартаж, гагцхүү эдгээр баяр баясал дүүрэн хормыг л санахыг хүсэв.

Он жилүүд тэдний зүрх сэтгэлийг эзэмдэж чадахгүй мэт санагдсаныг тэр мэдэрч байв. Түүний бүтээл болохүрхүүхдүүд, эхнэрийнх нь ар гэрийн ажил, хоёр хосын зүрх сэтгэл дэх энхрийхэн дөлийг унтрааж чадсангүй. Нэгэнтээ тэр ханьдаа бичсэн захидалдаа: “Энэ бүх үгс юуны учир надад ийм хүйтэн, бүүдгэр мэт санагдана вэ? Чамайг гэж нэрийдэх тийм энхрий нэр байхгүй учраас тэр гэж үү?” хэмээн урсгаж байжээ.

Алсад сонсдох аялгуу мэт олон жилийн тэртээд бичсэн өнгөрсөн амьдралын тэдгээр үгс харвасан сум шиг толгойд нь орж ирэв. Түүнтэй тэр хоёулахнаа байхыг хүснэ. Бүх хүмүүс явсан цагт, тэд хоёулахнаа зочид буудлын өрөөнд үлдсэн цагт тэр хайртдаа хандан:

- Грэта минь! гэж энхрийхнээр дуудах болно.

Тэрээр шуудхан сонсохгүй ч байж магад. Бүсгүй хувцсаа тайлна. Дараа нь ямар нэгэн хэлсэн үг түүнийг гайхшралд оруулна. Грэта түүн рүүэргэн харна....

Уайнтавэрны гудамжинд сүйх тэрэг тааралдав. Дугуйн хяхтнах чимээ ярихад нь саад болж буйд тэр баяртай байлаа. Тэрээр цонх руу хармагц, ихэд ядарсан байх ажээ. Барилга байшин энд тэндгүй сүүмэлзэж, харилцан яриа нэг сонсдож, нэг намсана... Өглөөний бүүдгэр тэнгэр дорхуучирч салгалсан хайрцаг араасаа чирч яваа морь сулхан цогиж, бал сарыг угтан хөлөг онгоцны зогсоол руу тэднийг хүргэж явах үед, өөрийгөө болон түүнийг сүйх тэргэнд явж байхыг Габриэл дахин олж харав.

Сүйх тэрэг 0'Коннеллийн гүүрээр давах үед 0'Каллаган авхай тэдэнд хандан,

- 0'Коннеллийн гүүрийг давах үед заавал ч үгүй цагаан морь харагддаг юм гэсэн гэж хэлэв.

- Энэ удаа би цагаан өмсгөлтэй хүн л харж байна гэж Габриэл ёжлонгуй өгүүлэв.

- Хаана тэр вэ? гэж ноён Бартэлл д'Арси асуув.

Габриэл цасанд дарагдсан хөшөөний 1 зүг заав. Дараа нь нөхөрсөг байдлаар гараараа дахин даллав.

- Дэн, сайхан нойрсоорой! гэж тэр хөгжилтэйхэн хэлэв.

Зочид буудлын өмнө сүйх тэрэг зогсоход, Габриэл сүйх тэрэгнээс буумагц улаачид мөнгө төлөв. Цайны мөнгө гэж нэг шиллинг өгөв. Улаач эр гартаа малгайгаа тоссоор,

- Эрхэм ээ, шинэ оноо сайхан угтаарай! гэв.

- Та ч бас гэж Габриэл чин сэтгэлээсээ хариу барив.

Тэрээр сүйх тэрэгнээс буух үедээ түүний гараас сугадаж, дараа нь тэд бусад хүмүүстэй салах ёс гүйцэтгэн гудамжинд зогсоцгоов. Хэдэн цагийн тэртээ Грэта түүнтэй бүжиглэж байсан шиг тун хөнгөхөн гараас нь сугадна. Тухайн үед тэр тун чиг аз жаргалтай хийгээд бардам байлаа; тэр түүнийх гэдэгт ихэд бардамнаж, эхнэр нь ямар уян налархай, эмэгтэйлэг болохыг бахархангуй харав.

Гэвч тэдгээр дурсамж агаарт замхарсан даруйд, дуулах мэт сонин, анхилуун үнэрт түүний биед хүрэхүйд хүчтэйхэн дур хүсэлд гэнэтхэн автав. Түүнийг дуугүй байхад гарыг нь тас атгаж, зочид буудлын хаалганы өмнө зогсч байхдаа тэр өөрсдийн амьдрал, эцэг эхийн үүргээс зугтаж, гэр орон хийгээд анд нөхдийн ямар нэгэн шинэхэн үйл явдлын зүг баяр хөөр болон угтахаар явж байгаа бүхнээс оргон зугтсан мэт тун сонин байдлыг мэдрэв.

Үүдний өрөөний том, зөөлөн сандал дээр нэгэн өвгөжөр эр хурхирна. Тэрбээр тасалгаанд лаа асааж, тэдний өмнө гарч шатаар өгсөв. Тэд ч түүнийг даган араас нь зөөлөн гишгэлсээр, 1 Даниэл 0' Коннолын /1775-1847 он/ хөшөөг хэлж байна. Хожим нь Габриэл түүнийг Дэн хэмээн нэрийднэ. Ирландын үндэсний чөлөөлөх хөдөлгөөний удирдагч. зузаан хивсээр өвч бүрхсэн шат өөд дагалдана. Хаалгачийг даган шатаар өгсч байхдаа тэр толгойгоо гудайлгаж, түүний хэврэгхэн мөр ямар нэгэн хүнд юм өргөсөн мэт ялимгүй бөгтийж, бэлхүүснийхээ бүсийг байдгаар нь чанга бүслэсэн ажээ. Грэтаг тэвэрч, байдгаар нь өөртөө наахыг хүсэвч, түүний гар тэрхүү тачаангуй хүслээс болж байдгаараа салгална.

Гагцхүү алгандаа хумсаа шигтгэж байж гэмээнэ, энэхүү дур хүслээ тэр зогсоож чадсан билээ. Хаалгач өвгөн урсч буй лаагаа засахаар шатан дээр түр зогсов. Тэд ч бас ард нь зогсоцгоов. Тэрхүү нам гүмд хайлсан лаа хэрхэн цар дээр дусалж буй чимээг сонсмогц, зүрх нь хэрхэн цээжинд цохилж буйг ч бас мэдрэв. Хаалгач тэднийг хонгилоор дагуулж явсаар нэгэн хаалга онгойлгов. Дараа нь тэр жижигхэн ширээн дээр нарийн лааг тавьж хэдэн цагт тэднийг сэрээх тухай асуув.

- Найман цагт гэж Габриэл хэлэв.

Хаалгач ханан дээрх цахим унтраагуур руу зааж, ямар нэгэн зүйлийн төлөө уучлалт эрэн бувтнаж гармагц, Габриэл түүний яриаг таслан,

- Үгүй ээ, бидэнд гэрэл хэрэггүй! Гудамжны гэрэл байхад л хангалттай! гэв.

- Үүнийг яах вэ? гэхэд,

- Наад юмаа ч бас аваад яв! гэж тэр хэлэв.

Хаалгач лаа авч гарах үедээ ийм сонин тушаал авсандаа туйлын их гайхширч байлаа. Дараа нь тэр,

- Сайхан амраарай! гэж хэлсээр гарч одов.

Г абриэл цоожин зоолттой түлхүүрийгэргүүлэв. Хий үзэгдэл мэт гудамжны дэнлүүний урт нарийн тусгал цонхноос хаалга тийш туснам. Габриэл хүрэм болон малгайгаа вандан ор руут шидлээд өрөөн дундуур цонхны зүг явав. Тэрбээр гудамж руу харан зогсч, түүний сэтгэлийн хөдөлгөөн бага зэрэг намжихыг хүлээнэ. Дараа нь тэр эргэн харж, хувцасны шүүгээ рүү тонгойв. Тэрээр малгай, хүзүүний алчуураа авч тавиад хавтастай том толины өмнө зогсч цээживчээ тайлна.

Габриэл түүнийг ажиглан хэсэг зуур хүлээсний эцэст,

- Грэта! гэж дуу алдан хэлэв.

Толины өмнөөстэр алгуурхан эргэн харахуйд цонхны гэрэл түүн дээр тусав. Бүсгүй бодолд автан гиюүрч, ихэд ядарсан царайтай байх тул, Габриэлийн хэлсэн үг уруул дээр нь царцах шиг болов. Үгүй ээ, одоо цаг нь биш.

- Чи их ядарсан харагдаж байна гэж тэр хэлэв.

- Би бага зэрэг ядарчээ гэж тэрээр хариулна.

- Чиний бие таагүй байна уу? Дотор чинь муухайрав уу?

- Үгүй ээ, зүгээр л ядарчихаж.

Тэрээр цонх руу дөхөж очин гудамж руу ширтэн зогсов. Габриэл бага зэрэг хүлээзнэснээ, санаа зовнисон байдал түүнийг эзэмдэж буйг мэдэрмэгц,

- Ингэхэд Грэта! гэж гэнэтхэн дуу алдав.

- Юу гэнэ ээ?

- Тэр Фрэдди Мэлинз бол... гэжхурдхан хэлэв.

- Тэгээд?

- Тэр тийм ч найдваргүй хүн биш юм билээ. Надаас зээлсэн нэг соверенээ<sup>1</sup> эргүүлж өгсөн шүү. Би ч тэр мөнгийг эргүүлж авна гэж найдаагүй юм. Тэр цаг үргэлж л Браунтай хамт байгаа нь харамсалтай хэрэг. Уг нь тэр дажгүй залуу байгаа юм.

Габриэл гомдсоноосоо болж байдгаараа чичирхийлнэ.

<sup>1</sup> Ирландын зоосон мөнгө.

Яагаад тэр ийм хөндий байна вэ? Тэрбээр юунаас эхлэхээ ч мэдсэнгүй. Эсвэл тэр ямар нэгэн зүйлд гомдсон юм болов уу? Грэта түүний зүг эргэн харж, өөрөө ирээсэй! Бүсгүй хүнийг ийм байдалд байхад хүчээр эзэмдэнэ гэдэг дэмий хэрэг. Эхлээд тэр ханийнхаа нүднээс ямар нэгэн хариуг даруйхан олж харах учиртай. Түүний хол хөндий байдлыг тэр ялан дийлэхийг хүсч байв.

- Хэзээ чи түүнд соверен өгсөн юм? гэжжаал дуугүй байсны эцэст тэрээр асуув.

Хөлчүү Мэлинзийг түүнд өгсөн соверений хамт чөтгөр рүү нь тонилгохгүйн тулд Габриэл нэлээдгүй тэвчээр заажээ. Тэрбээр байгаа байдлаараа түүнд татагдаж, энгэртээ нааж, эзэмдэхийг л хүснэ.

- Зул сарын баярын өмнөхөн түүнийг Хэнрийн гудамжинд Зул сарын баярын ил захидлын наймаа хийх үед нь гэж тэр хэлэв.



Уур хилэн хийгээд хүсэл тачаал нэгэн зэрэг түүнийг эзэмдэж, чичрэг өвчтэй хүн шиг байж суух газраа олж ядна. Түүнийг цонхноос холдсоныг тэр анзаарсангүй. Хэсэгхэн хугацаанд Грэта түүний өмнө зогсч гайхшрангүй харав. Дараа нь өлмий дээрээ зогсч, түүний мөрөн дээр гараа тавьж зөөлөн үнсэв.

- Габриэл, чи тун эелдэг хүн шүү! гэж тэрээр хэлэв.

Энэхүү санаандгүй үнсэлт хийгээд түүний хэлсэн сонин содон үгсийг сонсуут, Габриэлийн хувьд баярлах, гайхах хоёр зэрэгцэн байдгаараа чичирхийлж, бүсгүйн үс толгойг энхрийлэн таалж гарав. Нойтон үс нь тун зөөлөн хийгээд торгомсог ажээ. Түүний зүрх сэтгэл аз жаргалаар бялхана. Энэ мөчийг тэр маш их хүлээж байсан агаад тэрээр өөрөө түүн дээр хүрч ирэв. Магадгүй бидний бодол санаа нэгэн зүгт урсч байсан байж мэднэ. Нөхрийнхөө тэсвэрлэшгүй хүслийг мэдэрч байсан тул, түүнд тэр эзэмдүүлэхийг ч хүссэн байж болох юм. Харин одоо тэр хөнгөхөн арагш ухрах үед урьд өмнө тэр юунаас болж ийнхүү эргэлзэж байснаа ер ойлгож чадсангүй.

Түүний толгойг тэр хоёр гараараа тэврэн зогсч байлаа. Дараа нь түүнийг нэг гараараа тэвэрч өөртөө хандуулснаа,

- Хонгорхон Грэта минь! Чи юун тухай бодно вэ? гэж намуухан асуув.

Түүнд тэврүүлсэн хэдий ч тэр юу ч хариулсангүй дуугүйхэн л байлаа.

- Грэта! Чи яагаа вэ? Яасныг чинь би мэдэж байгаа юм шиг байна. Грэта! Би мэдэж байгаа юу? гэж Габриэл дахин аядуухан асуув. Тэрээр юу ч хэлсэнгүй.

Дараа нь гэнэт байдгаараа цурхиран уйлж,

- Би тэр “Аугримаас ирсэн бүсгүй” хэмээх дууны тухай бодож байна! гэж орь дуу тавин хэлэв.

Тэрээр түүнээс холдож, ор руу гүйж очоод, орны толгойноос гараараа барьж аваад нүүрээ нуув. Габриэл гайхснаасаа болж хэсэг зуур чулуун хүн шиг зогссоноо дараа нь түүн рүү дөхөж очив. Хавгастай толинд тэр өөрийгөө чигээр хальт харах үед, цамцных нь өргөн, товгор цээживч үргэлж түүнийг гайхшруулж байсан царай нүдний шилнийх нь гялалзсан алтан хүрээ зэргийг олж харав. Тэрбээр түүнээс хэдэн алхмын зайд зогсч,

- Юу болсон бэ? Чи яагаад уйлаад байгаа юм? гэж асуув.

Тэрээр толгойгоо өндийлгөн, хавдсан нүдээ хүүхэд шиг гараараа арчина. Түүний дуу хоолой улам бүр зөөлөн сонсдож байлаа.

- Грэта! Яасан бэ?

- Аль дээр үед энэ дууг дуулж байсан нэг хүний тухай би бодсон юм.

- Тэр чинь хэн юм бэ? гэж Габриэл инээмсэглэсээр асуув.

- Намайг эмээгийнд байхад Голуэд амьдарч байсан нэг хүн гэж тэрээр хэлэв.

Габриэлийн царай дахь инээмсэглэл үгүй болов. Учир битүүлэгүүр хилэн зүрхнийх нь гүнд хуримтлагдаж, судсан дахь учир битүүлэг дур хүслийн дөл хорсолтойхон бөхөж эхлэв.

- Чи түүнд дурланихсан байсан юм уу? гэж тэр ёжтойхон асуув.

- Тэр бол миний үерхэж байсан хөвгүүн. Түүнийг Майкл Фюрэй гэдэг байсан юм гэж тэрээр хариулав. “Аугримаас ирсэн бүсгүй” хэмээх энэ дууг тэр үргэлж дуулдаг байсан юм. Тэр тун муу биетэй хөвгүүн байсан.

Габриэл дуугүйхэн зогсов. Тэрхүү бие муутай хөвгүүнийг тэр сонирхож байна гэж бүү ойлгоосой! хэмээн тэр хүсч байлаа.

- Одоо би түүнийг амьд байгаа юм шиг л харж байна гэж хормын дараа тэрээр хэлэв.

- Тэр тас хар, дүрлэгэр нүдтэй байсан. Түүний харц ямар байсан гэж санана.

- Чи одоо болтол түүнийг хайрлаж явдаг юм уу? гэж Габриэл асуув.

- Голуэйд амьдарч байхдаа бид үргэлж л хамтдаа зугаалдаг байсан юм гэж тэрээр өгүүлэв.

Габриэлийн толгойд гэнэтийн бодол зурсхийн орж ирэв.

- Магадгүй үүнээс болж чи Айворзтой хамт Голуэй рүү явахыг хүссэн юм уу? гэж тэр хүйтнээр асуув.

Грэта түүн рүү гайхшрангүй харснаа,

- Яах гэж? хэмээн асуув.

Түүнтэй харц тулгармагц Габриэл эвгүй байдалд орсноо мэдрэв. Тэрбээр мөрөө хавчсанаа,

- Би юугаа мэдэхэв дээ? Түүнтэй уулзахын тулд л... гэж өгүүлэв.

Тэрээр эргэн харж цонхоор нэвт тусах гэрлийн зүг харж зогсов.

- Тэр нас барчихсан гэж эцэст нь тэр хэлэв.

- Дөнгөж арван долоон настайдаа нас барсан юм. Тийм залуугаараа нас барна гэдэг аймшигтай явдал биш гэж үү?

- Тэр чинь хэн байсан юм гэж Габриэл улам бүр ёжлонгуй асуув.

- Тэр хийн үйлдвэрт ажилладаг байсан юм гэж тэрээр хариулав.

Үхэгсдийн дундаас тэрхүү хийн үйлдвэрт ажиллаж байсан хөвгүүний дүрийг Грэтагийн зүрх сэтгэлд амилуулж, харсан явдлыг тэр хошигнож ярьсан нь талаар нэг болсонд Габриэл

өөрийгөө дорд орсон мэт мэдрэв. Тэрбээр нууцлаг хамтын амьдралынхаа талаар дурсамж дүүрэн байхдаа, энхрийлэл, баяр баясгалан, дур хүсэлдээ шатаж байсан тэр үед Грэта түүнийг бусадтай харьцуулан бодож байсан аж. Одоо тэр өөрийгөө тун эргэлзсэн байдалтай хөндлөнгөөс харж байв.

Эгч нарынхаа угжнаас гараагүй жаалхүү, хошин шогийн баатар, сайн санаа дүүрэн нялуун, хийрхүү амьтдын өмнө уран илтгэгч, араатны дур хүслээ магтан дуулагч, өөдгүй хээнцэр хүн бүхий ийм л дүр зургийг тэр дөнгөж саяхан толинд

хальтхан харж билээ.

Түүний царай дээрх ичингүйрлийн өнгийг харчих вий гэхээс имээсэндээ тэр гэрлийн эсрэг нуруугаа харуулж зогсов. Хүйтэн байцаалтын өнгийг тэр хадгалахаар оролдсон ч түүний хоолой ярих үед нь тун чиг бүүдгэр, дорд орсон мэт сонсдоно.

- Майкл Фюрэйд чи дурланихсан байсан юм уу? гэж Габриэл асуув.

- Надад тэр тун эрхэм нэгэн байсан гэж тэрээр өгүүлэв.

Түүний хоолой бөглүү хийгээд уйтгартай байлаа.

Урьдын адил сайхан ааш зан бий болохгүй гэдгийг Габриэл мэдэрмэгцээ,

- Грэта, тэр чинь яагаад тийм залуугаараа нас барчихсан юм? Чичрэг өвчин тусчихсан юм уу? гэж түүний гарыг илэх зуур гуниглангуй асуулаа.

- Тэр надаас болж үхсэн байх хэмээн тэрээр хэлэв.

Ямар ч тооцоо үгүй айдас гэнэт Габриэлийг нөмрөв. Бүх юм ойрхон байсан тэр цаг үед түүний эсрэгямар нэгэн өшөө авагч, нүдэнд өртөхгүй амьтан сөрж зогсоод, ямар ч үржил шимгүй ертөнц дээр түүнтэй тэмцэхийн тулд байдаг чадлаа шавхана. Гэвч энэхүү айдсыг тэр сэтгэлийн хат гарган дарж, гарыг нь илэв. Одоо тэр ямар ч асуулт тавьсангүй. Учир нь түүнийг бүх юмаа ярьж өгнө гэдгийг тэр мэдэрнэ. Түүний гар дулаахан, чийглэг байлаа; биед хүрэхэд ямар ч хариу барьсангүй, эрт цагийн хаврын нэгэн өглөө түүнд илгээсэн анхны захидлыг эргэн дурсч түүнийг үргэлжлүүлэн таалсаар байв.

- Энэ явдал өвөл болсон юм. Намайг Дүблин дэх сүмийн сургуульд элсэхээр эмээгийнхээс явдаг жилийн өвлийн эхэн сард... гэж тэрээр хэлэв.

- Харин тэр энэ бүх хугацаанд Голуэй дахь өрөөндөө өвчтэй хэвтэж, түүнд гадагш гарахыг зөвшөөрдөггүй байжээ; Оутэрард дахь хамаатнуудад нь ч өвчнийх нь талаар аль хэдийнэ мэдэгдсэн гэдэг. Түүнийг чичрэг өвчин туссан юм уу, энэ төрлийн өвчтэй хэмээн ярьцгааж байлаа. Одоо болтол би ямар өвчин туссаныг нь сайн мэдээгүй Тэрээр хэсэгхэн дуугүй байснаа санаа алдав.

- Хөөрхий хөвгүүн гэж хэлэв.

-Надад тэр маш их хайртай байснаас гадна энхрийхэн нэгэн байсан юм. Габриэл, хамтдаа бид олон цагаар зугаалдаг байлаа. Уушгинд нь сайн гээд тэр дуу дуулж сурч байсан юм. Хөөрхий амьтан! Маш сайн хоолойтой байсан даа...

- Тэгээд дараа нь яасан бэ? гэж Габриэл асуув.

- Дараа нь Голуэйгаас би сүмийн сургууль руу явахаар болсон. Тэгээд түүний бие муудаж, намайг түүн рүү оруулахаа больсон. Би Дүблин рүү явах гэж байна, зун ирэхэд түүнийг эдгэрчихсэн байна гэдэгт найдаж байгаа талаар захиа бичиж байлаа.

Тэрээр яриагаа тасалж, хоолойгоо эзэмдэх гэж оролдов.

- Явахын өмнөх шөнө Нанз-Айлэнд дахь эмээгийн байшинд хувцас хунараа янзалж байтал, хэн нэгэн цонх руу жижиг чулуу шидэхийг би сонссон юм. Цонх дэндүү их цантсан байсан тул би юу ч олж харсангүй. Тиймээс доош гүйж дан ганц даашинзтайгаа цэцэрлэг рүү харсан арын хаалгаар гүйж гарахад, цэцэрлэгийн буланд тэр зогсчихсон, байдгаараа чичирч байсан юм гэж тэр яриагаа үргэлжлүүлэв.

- Түүнд чи гэр рүүгээ яв гэж хэлээгүй юм уу? хэмээн Габриэл асуув.

- Тэр даруй би түүнээс явахыг гуйж, хэрэв бороон дор удаан зогсох аваас үхнэ гэж хэлсэн. Гэвч тэр надад амьд явах хүсэлгүй байгаагаа хэлсэн. Би одоо амьд байгаа юм шиг түүний нүдийг тодхон санаж байна. Тэрбээр хашааны дэргэд дахь модны дор зогсч байсан.

- Тэгээд гэр рүүгээ явсан уу? хэмээн Габриэл асуув.

- Тийм ээ, гэр рүүгээ явсан. Харин намайг сүм рүү явснаас хойш долоо хоногийн дараа нас барсан байна лээ. Чингээд түүнийг хамаатан садан нь амьдарч байсан Оутэрардад оршуулсан юм билээ. Түүнийг нас барсан гэдгийг мэдсэн тэр өдөр ямар байсан гээч!

Тэрээр нулимсандаа хахаж цацан дуугүй болсноо, өөрөө өөртэйгөө тэмцэх чадваргүй болсон хойно, ор руу үсэрч гэдэргээ харан хэвтээд, хучлаганд нүүрээ нууж ихэр татан уйлав. Габриэл түүний гарыг шийдэмгий бус байдалтай хэсэг хугацаанд барив; дараа нь түүний сэтгэл ийн зовлонд орол цохыг үл хүсч гарыг нь болгоомжтойхон тавьж, чимээгүйхэн цонх руу очив. Тэрээр бат бөх нойрсч байлаа. Габриэл ямар ч дайсагнасан зүйлгүй түүний ширэлдсэн үс, хагас онгорхой ам руу харж, гүн гүнзгий амьсгааг нь чих тавин сонсоно. Тэгэхлээр түүний амьдралд энэхүү гэгээхэн дурсамж оршиж байжээ. Түүнээс болж тэр хүү нас барсан юм байна. Одоо тэр ямар ч санаа зовох юмгүй Грэтагийн амьдралд эр нөхрийн өрөвдмөөр дүрд тоглож байснаа бодов.

Тэд хэзээ ч эхнэр, нөхөр байгаагүй мэт тийм л мэдрэхүй өвөрлөн нойрсч буй бүсгүй рүү тэр ширтэнэ. Габриэл түүний царай хийгээд үс рүү тун удаан, сониучирхан харав; түүнийг охин насандаа ямар гоо үзэсгэлэнтэй нэгэн байсан талаар тэр бодолд авгав. Чингэхэд тун хачирхалтай нь нөхөрсөг түүнийг өрөвдөх сэтгэл төрөв. Залуу насны гоо үзэсгэлэнгээ алдсан гэдгийг тэр хүлээн зөвшөөрөхгүй байлаа; энэ бол Майкл Фюрэйн үхлээс айлгүй дурлаж явсан тэрхүү царай одоо биш гэдгийг тэр сайтар мэдэж байлаа.

Магадгүй тэр бүгдийг нь яриагүй ч байж мэднэ. Габриэл түүний хувцсаа тайлж тавьсан сандал руу харц чулуудав. Дотуур банзлынх нь уяа шал руу унжина. Нэг гутал нь зүгээр зогсч байвч, нөгөөх нь хажуу тийш унасан байв. Ямар их мэдрэхүйн хар салхи цагийн өмнө түүний дотор шуурч байсныг тэр гайхсан байдалтай эргэн санах. Энэ бүхэн чухам юунаас болов?

Авга эгч нарын дунд барьсан оройн зоог, түүний айлдсан хэнд ч хэрэггүй үгс, дарс хийгээд бүжиг, тэнэглэл ба инээд наргиан, голын эрэг дагуу цасан дээр алхаж явахад авсан таашаал зэргийн аль нь юм бол оо? Хөөрхий муу Жулия эгч. Патрик Моркан болон мориных нь нэгэн адил удахгүй тэр ч бас сүүдэр болно. “Хуримын өмсгөлтэй байхад минь” гэж дуулах үед түүний царайнаас тэр энэхүү хоосон байдлыг олж харсан юм. Удахгүй тэр тэдний зочны өрөөнд хар өнгийн хоололтой, өвдгөн дээрээ цомбон малгайгаа барьчихсан сууж байж ч мэднэ.

Хөшиг буулгасан байхаас гадна, Кэт эгч дэргэд нь сууж нус, нулимсаа арчиж, Жулияг хэрхэн нас барсан тухай түүнд ярьж өгөх болно. Тэрбээр түүнийг тайвшруулах үгс хайж ядах авч гагцхүү хүчин мөхөс, хэнд ч хэрэггүй үгс л толгойд нь орж ирнэ. Мөр нь хөшсөн энэ үед өрөөнд ямар хүйтэн байх юм бэ? Тэрбээр эхнэрийнхээ дэргэд дахь орны даавууг сөхөж болгоомжтойхон хэвтэв. Нэг нэгнийхээ араас цувран тэд бүгд л сүүдэр болно. Үүний оронд өөр ертөнц рүү явахдаа, он цагийн аясаар өрөвдмөөр байдалд орж, гундахын оронд зоригтойхон алхам хийсэн нь хавьгүй дээр ажээ. Би амьдрахыг хүсэхгүй байна гэж хэлж байсан хайртай хүнийхээ харцыг он удаан жил зүрх сэтгэлдээ тээж явсан тэр л бүсгүй түүний дэргэд нойрсоно.

Өрөвчхөн сэтгэлийн нулимс Габриэлийн нүдийг бүрхэв. Хэзээ ч түүнд иймэрхүү мэдрэмж төрж байсангүй бөгөөд ямар ч эмэгтэй ийнхүү сэрээж байсангүй; гэвч тэрхүү мэдрэхүй нь хайр сэтгэл болохыг тэр мэдэж байлаа. Түүний нүдэнд нулимс бүрхэжхаруй бүрийд нэгэн хөвгүүн модны дор зогсч байхыг тэр харж буй мэт санагдав. Бусад сүүдэр нь түүнд зай тавьж өгнө. Түүний сэтгэл үй түмэн үхсэн хүний оршиж буй тэр л ертөнцөд шингэжээ. Тэрбээр хүрч чадахгүй ч гэсэн тэдний эрүүл бус, сүүмэлзэх ахуйг мэдэрч байлаа.

Өөрийн гэсэн “би” гэх үзэл бидний саарал нүдэнд үл үзэгдэх тэр л ертөнцөд ууснам; тэдгээр үхэгсдийн урьд өмнө бүтээн байгуулж амьдарч асан тэрхүү эд баялгийн ертөнц миний нүдний өмнө юу ч үгүй хайлав. Цонхны шил зөөлөн тогших чимээ гарахуйд тэр зүгт харав. Дахиад л цас орж байна. Мөнгөлөг хийгээд бараан цасан ширхэгүүд гудамжны дэнлүүний гэрэлд ташууран хийсч буйг тэр зүүрмэглэх төдий ажиглана. Цаг нь болсон тул нар жаргасан зүгт өөрийн заасан замаар явах цаг болжээ. Тийм ээ, сонингуудын зөв байж. Ирланд даяар цас орж байлаа. Тэрхүү цас харлан үзэгдэх тал газар, халзан толгод хийгээд Аллэны1 намаг дээр аядуу зөөлөн

1 Дублинээс 25 бээрийн зайд орших намгархаг газар. Шаннон-368 км үргэлжлэх Ирландын хамгийн том гол. хаялж, тэртээх Шанноны хар бараан үймсэн давалгаа гээд хаа сайгүй л сэвсийн орох ажгуу. Тэрхүү цас Майкл Фюрэйн нойрсч буй өнчин булш бүхий толгой дээр ч мөн орж байлаа. Эвдэрч яйжийсан загалмай, хөшөө дурсгал, нэг их өндөргүй төмөр хайс, үүргэнийн нүцгэн бутнууд дээр өтгөн цагаан цас малгайлан орох авай.

Түүний сэтгэлийн гал цасны шархирах чимээн дор алгуурхан унтарч, тэрхүү цасан ертөнц

даяар хаялан орж, үхэгсэд хийгээд эгэл хүмүүс дээр амьдралын сүүлчийн мөчийг ойртуулан зөөлөн бударч байлаа.

## Харчу овогт Ононгийн Чинбаяр



Дублин дэх Ж.Жойсийн гэрийн үүдэнд.  
Яруу найрагч Ж.Батбаатарын хамт. 2003 он.

### Орчуулсан бүтээлүүд:

Дээрхийн Гэгээн XIV Далай лам Данзанжамц

“Шинэ мянганы хүмүүн төрөлхтний ёс зүй” /2000 он/

“Амар тайван амьдрахуйн зурлага” /2001 он/

“Аз жаргалтай амьдрахуйн урлаг” /2002 он/

“Нигүүлсэхуйн амьдрал” /2004 он/

“Утга учиртай амьдралд хүргэх зам” /2006 он/

“Шилмэл бүтээлүүд” /2006 он/

“Улс тор, монго, амьдрал” /2008 он/

“Өдөр тутмын 365 бясалгал” /2009 он/

“Хайр сэтгэлийг хэрхэн бэлэглэх вэ?” /2009 он/

“Сонгомол бүтээлүүд” /2009 он/

“Ганихан чамдаа” яруу найргийн түүвэр /1997 он/

“Нобелийн шагналтнуудын айлдсан онч мэргэн үгс” /2003 он/

Г.Г.Маркес “Хурандаад хэн ч бичихгүй” тууж /2003 он/

“Бүх үеийн бизнесийн алтан зарчим” /2005 он/

Оскар Уайлд “Дориан Грейн хорог” роман /2006 он/

Франц Кафка “Шүүх ажиллагаа” роман /2007 он/

Жэймс Жойс “Үлсс” роман /2009 он/